

ХҮНИЙ ЭРХИЙН ТОВЧ ТАЙЛБАР



DDC
323
A-213

Ерөнхий редактор:
Ж.БЯМБАДОРЖ (Ph.D)

Редактор:
Г.АГАР-ЭРДЭНЭ
Ч.АЛТАНГЭРЭЛ
Б.БОЛОРСАЙХАН

Зохиогчид:
Г.АГАР-ЭРДЭНЭ
Ч.АЛТАНГЭРЭЛ
Т.АРИУНАА
Б.БОЛОРСАЙХАН
Ж.БЯМБАДОРЖ (Ph.D)
Ж.ДАШДОРЖ
Х.МӨНХЗУЛ
П.ОЮУНЧИМЭГ (Ph.D)
Б.ХИШИГСАЙХАН
А.ЭНХТӨР

Эмхэтгэн бэлтгэсэн:
Б.НАНДИНЦЭЦЭГ

Улаанбаатар 2012 он

© Г.Агар-Эрдэнэ, Ч.Алтангэрэл, Т.Ариунаа,
Б.Болорсайхан, Ж.Бямбадорж, Ж.Дашдорж, Х.Мөнхзул,
П.Оюунчимэг, Б.Хишигсайхан, А.Энхтөр
© Хавтасны чимэглэлд Предраг Стакичийн зурсан хүний
эрхийн логог ашиглав.

ISBN:978-99962-3-388-3

АГУУЛГА

ТАЛАРХАЛ.....	4
ӨМНӨХҮГ	5
1.ХҮНИЙХУВИЙНЭРХ,ЭРХЧӨЛӨӨ.....	7
2.УЛСТӨРИЙНЭРХ,ЭРХЧӨЛӨӨ.....	43
3. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХ,ЭРХЧӨЛӨӨ.....	78
4.БҮЛГИЙНЭРХ.....	138
5.ХҮНИЙЭРХИЙНМЕХАНИЗМ.....	152
6.ХҮНИЙЭРХИЙНЗАРИМНЭРТОМЬЁО.....	198
7.ХАВСРАЛТ.....	240
8. ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ БОЛ ЭДИЙН ЗАСГИЙН АМЖИЛТ, НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫНБАТАЛГААМӨН.....	243

ТАЛАРХАЛ

“Хүний эрхийн товч тайлбар” номыг бичиж, хэвлүүлэх зардлыг бүрэн санхүүжүүлж гүн туслалцаа үзүүлсэн ХБНГУ-ын Конрад Адэнауэрын Сангийн Монгол улс дахь Суурин төлөөлөгч, ноён Йоханнес Д.Рай Танд Монгол улсын Хүний эрхийн Үндэсний Комисс гүн талархал илэрхийлж байна.

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд, ажилтнууд Монголд анх удаа хүний эрхийн товч тайлбарыг гаргаж, өргөн олон уншигч, хэрэглэгчиддээ толилуулж байна.

Хүний эрх гэдэг ойлголт нь товчхондоо хүн болж төрсний хувьд заяагдсан, ямар нэгэн ялгаатай байдлаас үл хамааран эдэлвэл зохих эрх, эрх чөлөөг хэлдэг байна. Хүний эрх нь хүнийг нэр төртэй, үнэ цэнэтэй амьдрах наад захын хэрэгцээ шаардлага, оршихуйн үндэс юм. Хүний эрх нь ялгаварлалгүй, салшгүй, хуваагдашгүй, харилцан хамааралтай, хүн бүрт түгээмэл байдаг. Хүний эрх, эрх чөлөө нь төрөөс иргэддээ өгч байгаа буян хишиг биш, харин олон улсын эрх зүйн хэм хэмжээ, тухайн улсын үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор хүн бүр эрх, эрх чөлөөгөө бүрэн дүүрэн эдлэх боломж, нөхцлийг баталгаажуулдаг байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих бүрэн эрхийнхээ хүрээнд энэхүү товч тайлбарыг гаргалаа. Товч тайлбарыг гаргахдаа хүний эрх, эрх чөлөөний ерөнхий ангиллын дагуу хийж, энэ ангилалд багтахгүй хэсгийг тусгай

- ХҮНИЙ ЭРХИЙН ТОВЧ ТАЙЛБАР -

бүлэг болгов. Мөн хүний эрхийн талаарх олон улсын баримт бичиг, эх сурвалжийн жагсаалтыг хавсаргалаа.

Товч тайлбарыг анх удаа гаргаж байгаа болохоор алдаа дутагдал бий гэдэгт эргэлзэхгүй байна. Хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллага, ажилтнууд, мэргэжилтнүүд, хүний эрхийн төлөө тэмцэгчид, хамгаалагчид, өргөн олон уншигчид Та бүхэн info@mn-nhrc.org хаягаар саналаа ирүүлнэ үү. Бид та бүхний үнэтэй саналыг дахин хэвлэхдээ онцгойлон анхаарч, бололцоотой засварыг хийх болно.

Ж.Бямбадорж

- I -

ХҮНИЙ ХУВИЙН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ INDIVIDUAL RIGHTS AND FREEDOMS

АМЬД ЯВАХ ЭРХ RIGHT TO LIFE

“Хүн бүр амьд явахэрхтэй”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 3 дугаар зүйл)

“Хүн бүр амьд явах салшгүй эрхтэй. Энэ эрхийг хуулиар хамгаална. Хэний ч амь насыг дур мэдэн бусниулж болохгүй.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 6 дугаар зүйлийн 1 дэх заалт)

“...амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэтжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх заалт)

Хүний хамгийн үнэ цэнэтэй чухал эрхийн нэг нь амьд явах эрх юм. Амьд явах эрх бол байгаль дэлхийгээс хүн гэгч оюун ухаант бодгалд заяасан ганц олдох эрхэм дээд эрх мөн. Амьд явах эрхийг явцуу, өргөн хоёр утгаар тайлбарладаг.

Амьд явах эрх гэдэг нь явцуу утгаараа хүний амь насыг аливаа дур зоргын халдлагаас хамгаалах,

амь насыг нь аврахын тулд зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулахад чиглэгдсэн эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогц мөн бөгөөд хүн бүрийн амьд байхыг илэрхийлдэг. Амьд явах эрхийг хүний эрхийг бодитойгоор эдлүүлэх тухай хүн төрөлхтөн ярьж эхэлсэн тэр үеийн анхдагч эрхүүдийн нэг гэж үздэг. Энэхүү эрхийг эрх зүйн баримт бичигт тусгаад зогсохгүй хүний амь насыг эсрэг чиглэсэн аливаа халдлагаас төр хамгаалах үүрэгтэй юм. Үндсэн хууль батлагдсаны 20 жилийн ойн босгон дээр 2012 оны 1 дүгээр сарын 05-ны өдөр Монгол Улсын Их Хурал Цаазаар авах ялыг устгахад чиглэгдсэн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар нэмэлт протоколыг соёрхон баталсан хууль гаргаж, энэ цаг мөчөөс эхлэн Монгол Улс цаазын ялгүй орон болсон юм. Ингэснээр Үндсэн хуулийн дээрх заалтын сүүлийн хэсгийн "...хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно." гэснээс бусад нь түүхэн үүргээ гүйцэтгэж халагдсан гэж үзэж болно.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 6 дугаар зүйлд цаазаар авах ялыг цаашид хориглохыг зөвлөсөн бөгөөд хүчингүй болгосон улс орнуудад үүнийг эргэж сэргээхийг хориглосон болно. Амьд явах эрхийн өргөн утгад хүний наад захын хэрэгцээг хангахад чиглэгдсэн хоол хүнс, хувцас, орон байр, аюулгүй орчин зэргийг хамруулан ойлгоно. Хүн энэ хэрэгцээгээ өөрөө хангаж чадахгүй болсон тохиолдолд төрөөс зайлшгүй хангах, нөхцлийг бүрдүүлэх ёстой байдаг. Асрах хүнгүй өндөр настан, хүүхдийн болон сэтгэцийн өвчтэй хүмүүсийн асрамжийн газар байгуулах зэрэг арга замаар энэхүү эрхийн хэрэгжилтийг хангаж байна.

**БООЛЧЛОЛ, БООЛЫН ХУДАЛДААНД ӨРТӨХГҮЙ БАЙХ ЭРХ
FREEDOM FROM SLAVERY AND SERVITUDE**

“Хэнийг ч боолчлох буюу бусдын эрхшээлд байлгах ёсгүй. Аливаа төрлийн боолчлол болон боолын худалдааны бүх төрлийг хориглоно”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 4 дүгээр зүйл)

“Хэнийг ч боол болгож болохгүй, аливаа төрлийн боолчлол болон боолын худалдааны бүх төрлийг хориглоно.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 8 дугаар зүйлийн 1 дэх заалт)

Хүний хувийн халдашгүй дархан байх эрхэд эн тэргүүнд заналхийлдэг аюул бол боолчлол юм. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтийн тусгай илтгэгч байсан Манфред Новак боолчлолыг “өөрийн ижил хүмүүсийн хувийн шинж чанар, нэр төрийг үл тоон шууд халдах замаар илрэлээ олдог хүн төрөлхтний эрх мэдлийн хамгийн ноцтой илэрхийлэл” гэж тодорхойлсон. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэм, олон улсын гэрээнд заасны дагуу хүний үнэ цэнэ, нэр төрд чиглэсэн аливаа халдлагыг хориглосон ба шинээр бий болсон өрийн төлөөс болгох, хүүхэд эмэгтэйчүүдийг худалдаалах, мөлжих зэрэг орчин цагийн боолчлолын хэлбэрүүдийг олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс буруушаадаг.

1926 онд Үндэстнүүдийн Лигийн баталсан Боолчлолын тухай конвенцийг хожим Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан 1953 оны протоколоор өргөжүүлсэн билээ.

Боолчлол, боолын худалдаа бол хүн төрөлхтөний нэн

эртний түүхээс улбаатай ойлголт бөгөөд одоогоос 11 мянган жилийн тэртээд эзэн, боолын харилцааны үндэс тавигдсан гэж үздэг. Дэлхий дахинаа боолчлол, боолын худалдааг халахад олон жил шаардагдсан бөгөөд хамгийн сүүлд 1981 онд Мавритани Улс боолчлолыг албан ёсоор халах шийдвэр гаргаж байв.

Үндэстнүүдийн Лигийн дээрх конвенцийн 1 дүгээр зүйлийн дагуу боолчлол гэдэгт өмчлөх эрхийн үүднээс бусдын эрх мэдэлд байгаа хүний нөхцөл байдлыг ойлгохоор заасан байна. Тус байгууллагын хичээл зүтгэл дээр тулгуурлан, Нэгдсэн Үндэстний Байгууллага уг үзэл санааг улам дэлгэрүүлсэн гэж болно. Тухайлбал Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей 1949 онд Хүн худалдаалах, бусдын биеийг үнэлүүлэн мөлжихийг хориглох тухай конвенц баталж, хүн худалдаалах, биеийг үнэлүүлэх нь хүний үнэ цэнэ, нэр төртэй харшлах талаар заасан. Гэхдээ энэ баримт бичиг нь 1904 оны Цагаан боолын худалдааг зогсоох тухай олон улсын хэлцэл, 1910 оны Цагаан боолын худалдааг зогсоох тухай олон улсын конвенц, 1921 оны Эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалахыг зогсоох тухай олон улсын конвенц, 1933 оны Бүх насны эмэгтэйчүүдийг худалдаалахыг зогсоох тухай олон улсын конвенц зэрэг өмнөх олон улсын гэрээний үзэл санааг нэгтгэн тусгасан онцлогтой.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей, Эдийн засаг, нийгмийн зөвлөлөөс боолчлолтой төстэй аливаа үйл ажиллагааг үгүйсгэн, олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс таслан зогсооход бүхий л анхаарлаа хандуулдаг. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтын бүхий л хэлбэрийг устгах тухай конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенц

зэрэг олон баримт бичигт хүн худалдаалах, эдийн засгийн болон бэлгийн зорилгоор мөлжих, албадан хөдөлмөрлүүлэх, хуурамчаар үрчлэх, хүүхдийг гэрлүүлэх, бэлэвсэн эмэгтэйг өөр хүнд дамжуулах явдлаас хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар заасан. Гэсэн хэдий ч Интерполоос хүн худалдаалах гэмт хэргийг хамгийн ашигтай олон улсын зохион байгуулалттай гэмт хэргийн нэгт тооцсон хэвээр байна.

Монгол Улсын хувьд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд боолчлох, албадан хөдөлмөрийг хориглосон ба 2008 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлээс гадна 2012 онд батлагдсан Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3, 5 дугаар зүйлд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгайлан зохицуулсан болно.

**ГЭМ БУРУУГУЙД ТООЦОГДОХ ЭРХ
RIGHT TO BE PRESUMED INNOCENT
UNTIL PROVED GUILTY ACCORDING TO LAW**

“Гэмт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өтгөөлөх бүх боломжоор хангагдсан нээлттэй шүүх хурлаар гэм буруутайг нь хуулийн дагуу тогтоох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг)

“Эрүүгийн хэрэгт буруутгуулж буй хэн боловч гэм буруу нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрхтэй”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 2 дахь заалт)

“...Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт)

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэмт хэрэг үйлдсэн гэх гэм буруутайг гагцхүү шүүхээр хуулийн дагуу нотолж шийтгэх тогтоол гаргасан нь хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл түүнийг гэм буруутай хэмээн тооцож нийтэд зарлахгүй хуулиас гадуур аливаа албадлага хэрэглэхгүй, гэм буруугүйн асуудлыг өөрөөр нь нотлуулахаар шаардах буюу эрүүдэн шүүхгүй байж өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлүүлэх эрхээ бүрэн хэрэгжүүлэх боломж олгон, гэм буруутай нь нотлогдсон эсэх талаар гарсан үндэслэл бүхий эргэлзээг түүнд ашигтайгаар шийдвэрлэх явдлаар илэрхийлэгдсэн эрх зүйн ойлголтыг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны гэм буруугүйд тооцох зарчим гэнэ.

Гэм буруугүйн зарчим нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрхийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хамгаалах ардчилсан зарчмуудын нэг мөн.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хангалттай нотлох баримтын үндсэн дээр уг зарчим жинхэнэ агуулгаараа хэрэгжих бүрэн боломжтой болдог. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлд “Шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй. Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн

гэм буруутай эсэхэд түүнчлэн Эрүүгийн хууль болон энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ” гэж заасан нь байцаан шийтгэх ажиллагааны гол оролцогч нарын эрхийг хамгаалахад үр дүнтэй заалт болсон. Гэм буруугүйн зарчим нь эрүүгийн хэрэг үүсгэснээс эхлээд тухайн этгээдийн гэм буруугийн асуудал нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэлх хугацаанд үйлчилнэ.

ИРГЭНИЙ ХАРЬАЛАЛТАЙ БАЙХ ЭРХ RIGHT TO A NATIONALITY

“Хүн бүр иргэний харьяалалтай байх эрхтэй. Аливаа хүний иргэний харьяалал болон харьяаллаа өөрчлөх эрхийг дур лэдэн цуцлах ёсгүй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 15 дугаар зүйлийн 1 дэх заалт)

“Хүүхэд бүр иргэний харьяалалтай болох эрхтэй.”

(Иргэний улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 24 дүгээр зүйлийн 3 дахь заалт)

“Монгол Улсын иргэний харьяалал хийгээд харьяат болох, харьяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтооно. Монгол Улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван тавдугаар зүйл)

Иргэний харьяалал бол хүн эрх зүйн этгээд байх урьдчилсан нөхцөл бөгөөд иргэн, тухайн улсын төр хоорондын эрх зүйн харилцаа юм.

Хүний эрхийн хороо XVII дугаар Ерөнхий зөвлөмждөө оролцогч улсууд нь “хүүхэд бүр төрмөгц иргэний харьяалалтай байх явдлыг хангах чиглэлээр дотооддоо болон бусад улс орнуудтай хамтран зохистой бүх арга хэмжээг авах” үүрэгтэй гэж үзсэн байна.

Иргэний харьяаллын асуудлыг улс бүр өөрийн тогтоосон зарчмаар тогтоодог. Монгол Улсын тухайд төрснөөр, Монгол Улсын харьяат болсноор, харьяаллыг сэргээн тогтоосноор, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан үндэслэлээр тус тус харьяат болохоор зохицуулсан. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа бөгөөд эцэг, эх нь хоёулаа тогтоогдоогүй хүүхдийг Монгол Улсын харьяат байхаар зохицуулсан нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлж буй нэг хэлбэр юм.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Монгол Улсын Үндсэн хуулиар иргэний харьяалалтай байх эрхийг баталгаажуулахын зэрэгцээ Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалд иргэний харьяалал болон харьяаллаа өөрчлөх эрхийг дур мэдэн цуцлахыг хориглож, Үндсэн хуульд Монгол Улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглосон. Гэвч хүн төрөлхтөний эсрэг, олон улсын гэмт хэрэг үйлдсэн этгээдийг Олон улсын шүүхэд шилжүүлэн өгөх шаардлага олон улсын гэрээгээр гарч болохыг үгүйсгэхгүй. Тухайлбал, Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенцийн 7 дугаар зүйлд хэрэгтнийг шилжүүлж болох тухай заасан. Мөн Олон улсын Эрүүгийн шүүхийн тухай Ромын дүрэмд ч энэ асуудал туссан билээ.

Тухайн улсын нутаг дэвсгэрт байгаа хүмүүс иргэн,

гадаадын иргэн, харьяалалгүй байхаас үл хамаарч тухайн улстайгаа эрх зүйн тодорхой харилцаа үүсгэдэг. Гэвч тодорхой улсын харьяат иргэний эдлэх эрх, хүлээх үүрэг нь тухайн улсад оршин сууж байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнээс ялгаатай зохицуулдаг. Тухайлбал, Монгол Улсын иргэний эдлэх эрх, эрх чөлөөг Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд шууд заасан бол гадаадын иргэн, харьяалалгүй хүний эдлэх эрх, эрх чөлөөг Монгол Улсын Үндсэн хууль, тухайн улстай байгуулсан гэрээ, олон улсын гэрээгээр тогтоохоор заасан. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан эрх, эрх чөлөөг гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн тухайд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зохих хязгаарлалт тогтоож болохоор зохицуулсан юм. Олон улсын хүний эрхийн эрх зүйд ч зарим хүний эрхийг тухайн улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүсийн тухайд ялгавартай тогтоож болохыг хүлээн зөвшөөрдөг. Тухайлбал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 25 дугаар зүйлд заасан сонгох, сонгогдох, төрийн жинхэнэ алба хаших эрхийг тухайн улсын иргэн л эдлэхээр ялгавартай тогтоож өгсөн. Гэсэн хэдий ч гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүсийг зохих хязгаарлалт бүхий байдлаар төрийн алба хаах, сонгох эрхээ эдлэхийг үгүйсгээгүй. Жишээ нь, орон нутгийн сонгуульд оролцож сонгох эрхээ эдлэх, тодорхой төрийн албыг хаших зэргийг дурьдаж болох юм. Монгол Улсын иргэн цэргийн алба хаах, татвар төлөх нь тэдний хүлээх үндсэн үүрэг бол гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүсийн хувьд энэ үндсэн

үүргийг хүлээгээгүй болно.

**МАТЕРИАЛЛАГ БОЛОН ЁС СУРТАХУУНЫ ЭРХ
АШГАА ХАМГААЛУУЛАХ ЭРХ
RIGHT TO THE PROTECTION
OF THE MORAL AND MATERIAL INTERESTS**

“Хүн бүр өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээлийн материаллаг болон ёс суртахууны эрх ашгаа хамгаалуулах эрхтэй”
(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 27 дугаар зүйлийн 2 дахь хэсэг)

Хүн бүр ямарваа нэгэн шинжлэх ухааны, утга зохиолын, урлагийн бүтээлийг туурвигчийн хувьд ёс суртахууны болон материаллаг эрх ашгаа хамгаалуулан, ашиг хүртэх эрхийг Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос хүний эрх хэмээн хүлээн зөвшөөрч, хүний салшгүй нэр төр, үнэ цэнээс үүдэлтэй гэж тайлбарласан байна. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (с) заалтаар баталгаажуулж оюуны өмчийг хамгаалах олон улсын эрх зүйн бусад баримт бичгүүдэд тусгасан байна. Хүний эрх нь салшгүй, суурь шинжтэй учраас оюуны өмчийн эрхийг ч гэсэн улс бүр нэн тэргүүнд чухалчлан хангаж, бүтээлч, урам зоригтойгоор бүтээн туурвих, шинийг санаачилсан бүтээгдэхүүн бий болгох, түгээх, соёлын онцлог шинжийг шингээн хөгжүүлэх, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийг нийгмийн тусын тулд цогцоор хамгаалахад анхаарах ёстой.

Гэхдээ оюуны өмчийн эрх нь гол төлөв түр зуурын шинжтэй буюу хэн нэгэнд хамаарч, гэрчилгээ олгож,

цуцлах, хүчингүй болгох боломжтой байдаг. Оюуны өмчийн эрхийг цаг хугацаа, хүрээний хувьд хязгаарлаж, худалдаж, өөрчилж бүр эрхийг хасах боломжтой бол хүний эрх нь цаг хугацаанаас үл хамааран тухайн хүн салшгүй байдлаар суурь шинжтэйгээр эдлэх жишээтэй. Ямар нэг шинжлэх ухааны, утга зохиолын, урлагийн бүтээлийг туурвигчийн хувьд ёс суртахууны болон материаллаг эрх ашгаа хамгаалуулан ашиг хүртэх эрх нь туурвигч буюу зохиогч болон өөрийн бүтээлийн хоорондын холбоо, мөн бусад хүмүүстэй харилцах холбоо хамаарал, хамтын соёлын өв зэргийг сахин хамгаалахын зэрэгцээ тухайн зохиогч амьдралын зохистой түвшинд амьдрах, оюуны өмчийн аж ахуйн, хувийн хэвшлийн шинжтэй ашиг сонирхол, хөрөнгө оруулалтыг хамгаалах зэрэг наад захын хэрэгцээг баталгаажуулж өгдөг.

Мөн зохиогчийн ёс суртахууны болон материаллаг эрх ашгаа хамгаалуулах хүрээг үндэсний хууль тогтоомж эсвэл олон улсын гэрээнд заасан оюуны өмчийн эрхтэй холбоотой заалтаар шууд хязгаарлах нь учир дутагдалтай. Дээрх пактын 15 дугаар зүйлд баталгаажуулсан хүний эрхийг оюуны өмчийн эрхтэй тэгшитгэн ойлгож болохгүй. Зохиогчийн ёс суртахууны болон материаллаг эрх ашгаа хамгаалуулан ашиг хүртэх эрхийг бусад олон улсын гэрээнд ч тусгайлан заасан. Жишээлбэл, Хүний эрх, үүргийн тухай Америкийн тунхаглалын 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт, Хүний эрхийн тухай Америкийн конвенцийн Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хүрээний талаарх 1988 оны Нэмэлт протоколын ("Сан Сальвадорын протокол") 14 дүгээр зүйлийн 1 (с) хэсэгт, 1952 оны Хүний эрхийн тухай Европын конвенцийн Нэгдүгээр протоколын 1 дүгээр зүйлд тус тус баталгаажуулсан байна.

Ямарваа нэгэн шинжлэх ухааны, утга зохиолын, урлагийн бүтээлийг туурвигчийн хувьд ёс суртахууны болон материаллаг эрх ашгаа хамгаалуулан ашиг хүртэх эрх нь шинжлэх ухаан, урлагийн салбарын зохиогч, бүтээгч, туурвигчдад төдийгүй нийгэмд хувь нэмэр оруулахыг идэвхтэй дэмждэг. Энэ утгаараа дээр дурдсан Пактын 15 дугаар зүйлд заасан соёлын амьдралд оролцох, шинжлэх ухааны дэвшлийн үр дүнг ашиглах, түүнийг хэрэглэх, шинжлэх ухааны судалгааны болон уран бүтээлийн үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардлагатай бусдын эрх чөлөөг хүндэтгэх зэрэг эрхүүдтэй шууд холбогддог. Эдгээр эрхийн харилцаа нь нэгэн зэрэг хоёр биенээ дэмжсэн, харилцан хамааралт шинжтэй байна.

Үүний зэрэгцээ тухайн туурвигч этгээдийн шинжлэх ухааны судалгааны болон уран бүтээлийн үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардагдах эрх чөлөөг сахин хамгаалж, өөрийн ажил мэргэжлийг чөлөөтэй сонгох, зохистой цалин хөлс авах, зохистой түвшинд амьдрах зэрэг эрхийг эдлэх ёстой. Тодруулбал, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, бүх төрлийн мэдээлэл, санааг хүлээн авах, хайх, түгээх эрх чөлөө, хувь хүнийг өв тэгш хөгжүүлэхэд чиглэсэн эрх, соёлын амьдралд оролцох зэрэг Хүний эрхийн билл болон бусад олон улсын гэрээнд баталгаажуулсан эрхийг эдлэхийг орхигдуулж болохгүй.

НЭР ТӨР, АЛДАР ХҮНДЭЭ ХАМГААЛУУЛАХ ЭРХ RIGHT TO PRIVACY AND ITS PROTECTION BY LAW

*“Хэний ч... нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй.
Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар
хамгаалуулах эрхтэй.”*

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 12 дугаар зүйл)

“Хэний ч... нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно. Хүн бүр тийл оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйл)

“...нэр төр, алдар хүнд...-ийг хангах зорилгоор задруулж үл болох,... хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалт)

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын нэгдүгээр зүйлийн “dignity”(достоинство), арванхоёрдугаар зүйлийн “honour” (честь) гэсэн үгийг монгол хэлэнд нэр төр хэмээн адил утгаар орчуулжээ. Улмаар Монгол Улсын Үндсэн хуульд энэ хоёр ойлголтыг нэгтгэж “нэр төр” гэдэг томъёоллыг хэрэглэсэн байна. Гэтэл эдгээр нь үзэл баримтлал болон хууль зүйн хувьд ялгаатай ойлголтууд юм. Нэр төр, алдар хүнд гэсэн ойлголтууд нь хоорондоо нягт уялдаатай боловч бие даасан агуулгатай байдаг. Хүний нэр төр (dignity) гэдэг нь хүнд төрсөн цагаас нь заяасан төрөлхийн үнэ цэнэ, эрхэм чанар юм. Нөгөө талаас хувь хүний өөрийн гэсэн үнэт зүйлээ эсвэл өөрийгөө чухал гэж мэдрэх мэдрэмж бөгөөд зохих байдлаар хүндэтгэхийг хүсэх буюу хүндэтгүүлэхийг хэлнэ. Нэр төр (honour) нь иргэний зан суртахуун, ёс зүй, ажил үйлс, мэргэжлийн шинжийн талаарх эерэг үнэлгээ юм.

Алдар хүнд нь тухайн хүнд нийгэм, найз нөхөд, хамт олон бусад харилцагч, түншлэгчээс өгч байгаа

үнэлгээнд үндэслэсэн тухайн иргэний өөрийнх нь хувийн үнэлэмж юм.

Аливаа улс хүний нэр төр, алдар хүндийг хамгаалж, доромжлон гутаахыг хүний эрхийн хэм хэмжээ, зарчмуудаар хязгаарладаг. Шаардлагатай тохиолдолд үндэсний болон олон улсын хүний эрхийн механизмын холбогдох байгууллагуудад хандаж, эрхээ хамгаалуулах боломжтой.

НЭРТЭЙ БАЙХ ЭРХ RIGHT TO HAVE A NAME

“Хүүхэд төрсөн даруй бүртгэгдэж, нэртэй болох ёстой.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт)

Хүн болгон өөрийн нэртэй байх нь хувийн салшгүй эрх юм. Хүний нэр гэдэг нь тухайн улсын ард түмний уламжлал, зан заншлын дагуу хүнийг төрөхөд нь өгч, олон улсын болон үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулан түүнийг бусдаас онцгойлон ялгаж байгаа илэрхийлэл юм.

Иргэн нэртэй байхыг хуулиар баталгаажуулж байгаа нь түүнийг эрх зүйн харилцаанд оролцох нэг нөхцөлийг хангаж байгаа хэрэг юм.

Иргэн өөрийн нэрээр эрх эдэлж, үүрэг хүлээдэг. Хүүхэд төрсний дараа эцэг, эх эсхүл эрх бүхий этгээд хүүхэддээ нэр өгч, хуулийн дагуу тодорхой хугацааны дотор бүртгүүлж, баримт бичиг олгоно. Хүүхдэд нэр өгөх, овог сонгох, хүүхдийн эцэг, эхийн нэр авахтай холбогдсон маргааныг шүүх шийдвэрлэнэ.

Хуульд заасан үндэслэлээр иргэн зохиомол нэр

хэрэглэх, нэрээ солих эрхтэй. Тухайлбал, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд “зохиогч нь бүтээлээ өөрийн болон зохиомол нэрээрээ эсхүл нэргүйгээр нийтийн хүртээл болгох эрхтэй.” гэж зааснаас гадна Иргэний бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан журмын дагуу иргэн нэрээ солих эрхтэй. Гагцхүү сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдол, хорих ял эдэлж байсан хүний овог, эцгийн нэр, нэр өөрчлөхийг хориглодог байна.

ӨМГӨӨЛӨХ БА ӨМГӨӨЛҮҮЛЭХ ЭРХ RIGHT TO RECEIVE LEGAL ASSISTANCE

“Гэтт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өмгөөлөх бүх боломжоор хангагдсан...”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 11 дүгээр зүйлийн 1 дэх заалт)

“...өөрийгөө биечлэн өмгөөлөх буюу өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх ... эрхтэй”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 3(d) заалт)

“...өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах... эрхтэй.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт)

Гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагч, хэргийн оролцогч хэн боловч өөрөө өөрийгөө өмгөөлөх болон эрх бүхий байгууллагаас эрх авсан мэргэжлийн өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй. Энэ эрхээ хэрэгжүүлэхийн тулд өөрт нь тулгаж

байгаа хэрэг маргаан, эд материалын хариуцлага болон бусад нөхцлүүдийг цагаатгах, хөнгөрүүлэх, өөрийн гэм бурууг үгүйсгэх нотлох баримтыг гаргах, цуглуулахыг шаардах, хуулийн зүйл заалтыг өөрт ашигтайгаар тайлбарлах зэрэг үйл ажиллагааг явуулна. Мэргэжлийн өмгөөлөгч нь тухайн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо өмгөөллийн туслалцаа үзүүлж буй өмгөөлүүлэгчийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавихаас гадна мэргэжлийн өндөр ёс зүйтэй байхыг шаарддаг. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт зааснаар сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өмгөөлөгчөө өөрөө сонгох эрхтэй бөгөөд нэг этгээд хэд хэдэн өмгөөлөгчтэй байж болохоор хуульчилжээ. Энэ эрхийг баталгаатай эдлүүлэхийн тулд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өмгөөлөгчөө сонгон аваагүй бол түүний хүсэлтээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох боломжийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх хангах бөгөөд өмгөөлөгчөө сонгоход нь тодорхой хүний нэр зааж болохгүй гэсэн хориглосон заалтыг мөн хуульчилсан байна.

**УЛСЫНХАА НУТАГ ДЭВСГЭРТ ЧӨЛӨӨТЭЙ ЗОРЧИХ,
ТҮР БУЮУ БАЙНГА ОРШИН СУУХ ГАЗРАА
СОНГОХ, ЭХ ОРНОО ОРХИН ЯВАХ, ОРШИН СУУХ,
ЭХ ОРОНДОО БУЦАЖ ИРЭХ ЭРХ
RIGHT TO FREE MOVEMENT IN AND OUT OF THE COUNTRY**

*“Хэн боловч улсынхаа дотор чөлөөтэй зорчих,
оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй.”*

*“Хэн боловч аливаа улс орныг, түүний дотроо эх
орноо орхин явах, эх орондоо эргэж очих эрхтэй.”*

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 13 дугаар зүйл)

“Аль нэг улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор байгаа аливаа хүн тухайн нутаг дэвсгэрийн дотор чөлөөтэй шилжин явах, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй.

Хүн бүр аливаа улсыг, түүний дотор эх орноо орхин явах эрхтэй...

... Хэний ч эх орондоо ирэх эрхийг дур мэдэн хасч болохгүй.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 12 дугаар зүйл)

“Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв жуфтыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 18 дахь заалт)

Энэхүү эрх нь чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох, эх орноо орхин явах, эх орондоо буцан ирэх гэсэн бүрэлдэхүүнтэй. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 12 дугаар зүйлд заасан эрхийн хязгаарлалтыг Хүний эрхийн хороо “чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох, улс орныг тэр дундаа эх орноо орхин явах эрх нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахуун, бусад хүний эрх,

эрх чөлөөг хамгаалах үүднээс л хязгаарлаж болно.” хэмээн тайлбарласан. Харин Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын иргэн чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийг аливаа хязгаарлалтгүй эдлэхээр заасан нь олон улсын хүний эрхийн наад захын хэм хэмжээнээс давуу байдалтай зохицуулалт болсон байна. Энэ нь иргэдийн чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхэд хууль тогтоомж, захиргааны бусад шийдвэрээр хязгаарлалт тавих ёсгүй гэсэн үг юм. Гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүсийн хувьд энэ эрхийг эдлэхэд Монгол Улсын иргэдээс ялгаатай нь үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлалтыг тогтоож болно.

Монгол Улсын иргэн гадаадад явах, оршин суух эрхээ эдлэхэд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар хязгаарлаж болохоор заасан нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакттай ижил зохицуулсан байна. Үндсэн хууль, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын аль аль нь энэ эрхийн хязгаарлалтыг гагцхүү хуулиар тогтоох ёстой хэмээн үзсэн. Хэдийгээр Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийг хууль ёсоор оршин суугаа хүн бүр эдлэхээр заасан ч тухайн улсын иргэн биш хүмүүсийн хувьд хязгаарлалт нь ялгавартай байж болохыг үгүйсгээгүй. Гэвч оролцогч улсууд Пактын хэрэгжилтийн тайланг Хороонд илгээхдээ харьяат, харьяат бус хүмүүсийн хооронд ялгавартай хязгаарлалт тогтоосон бол үүнийгээ тайлбарлах ёстой.

Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хамгаалах хүрээнд хийх хязгаарлалт Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын аль алинд туссан бол Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад “эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөө болон Пактаар хүлээн зөвшөөрсөн бусад эрхийг хамгаалах”, Үндсэн хуульд “хүн амын аюулгүй байдлыг хамгаалах” хэмээн хязгаарлалт тавих үндэслэл нь ялгаатай тусчээ. Чөлөөтэй зорчих эрхийн хүрээнд дүрвэгсэд, улс төрийн орогнол хүсэгчид, цагаачид, дотоодын дүрвэгсэд, цагаач ажилчид, оюутнуудын эрхийг хэрхэн тусгасан, ямар хязгаарлалт тогтоосон, энэ нь зайлшгүй эсэхэд онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Ялангуяа тухайн улсын харьяат биш хүний тухайд ялгаварлан гадуурхуулахгүй байх, хүнлэг бус харьцаанаас хамгаалуулах, гэр бүлтэй болоход нь хүндэтгэлтэй хандах асуудлыг анхаарч үзэх зайлшгүй шаардлагатай юм. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 12 дугаар зүйлийн 12.3 заалтын дагуу гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүсийн чөлөөтэй зорчих эрхийг тухайн улсын иргэнээс ялгаатай хүлээн зөвшөөрч болох хэдий ч хязгаарлалт нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад заасан бусад эрхтэй нийцсэн байх, үүний зэрэгцээ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 12 дугаар зүйлийн 12.4 дэх заалтын дагуу оролцогч улсууд хэнийг ч өөрийн орон руугаа буцахад нь саатуулах, дур зоргоор хориглох, эсвэл өөр орон руу хүчээр гаргах ёсгүй. Зарим бүлгүүдийн хувьд чөлөөтэй зорчих эрхийн хэрэгжилтийн хүрээнд орчны хүртээмжийн асуудал мөн яригдана. Тухайлбал, орчны хүртээмжгүй байдал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн чөлөөтэй

зорчих эрхэд учирч байгаа саад бөгөөд үүнийг арилгах чиглэлээр төрөөс тодорхой арга хэмжээг дэвшилттэйгээр авч хэрэгжүүлэх үүрэг хүлээх ёстой.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын оролцогч улсууд нь төрийн зүгээс чөлөөтэй зорчих эрхийг зөрчихөөс хамгаалахын зэрэгцээ, хувь хүмүүс, төрийн бус оролцогчийн зүгээс энэ эрхийг зөрчихөөс мөн хамгаалах үүрэгтэй юм.

ХАЛДАШГҮЙ БАЙХ ЭРХ RIGHT TO PRIVACY

“Хэний ч ... орон байрны халдашгүй байдал, захидал харилцааны нь нууц, эсвэл нэр төр, алдар хүндэд нь дураар халдах ёсгүй. Тийм оролцоо, халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 12 дугаар зүйл)

“Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур тэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журтаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 1 дэх заалт)

“....Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журтаас гадуур дур тэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, төрдөн төшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэргийг хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй.”

(Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт)

Хүний халдашгүй эрх гэдэг нь өөрийн жам ёсны шинж чанараас үүдэлтэй бөгөөд хуулиар баталгааажсан, хэн боловч хөндлөнгөөс дур мэдэн халдаж үл болох туйлын агаад салшгүй эрхийн цогцолбор мөн.

Олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн хуулиар тогтоосон үндэслэл, журмаас гадуур аливаа хэлбэрээр эрх, эрх чөлөөгөө хязгаарлуулахгүй байх нь халдашгүй байх эрхийн үндсэн агуулга юм. Тус эрхийг хөндлөнгөөс ямар ч этгээд дур мэдэн зөрчиж болохгүй туйлын эрх юм. Энэхүү эрхийг баталгаатай хангахын тулд хувь хүний нэр төр, алдар хүнд, бие сэтгэл, эд хөрөнгө, хувийн ба гэр бүлийн нууц, захидал харилцаа, орон байрны халдашгүй байдлыг онцгойлон авч үздэг.

Халдашгүй байх эрхийг ангилбал:

- эрх чөлөөтэй байх,
- бие махбодийн халдашгүй байх эрх,
- орон байрны халдашгүй байдал,
- нууцын халдашгүй байх эрх,
- нэр төрийн халдашгүй байх эрх,
- өмчийн халдашгүй байх эрх
- захидал харилцааны халдашгүй эрх зэрэг болно.

ХОХИРЛОО НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ЭРХ RIGHT TO COMPENSATION

“Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх тэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 8 дугаар зүйл)

“Хууль бусаар баривчлагдаж буюу цагдан хоригдож, хэлмэгдсэн хүн бүр хохирлоо нөхөн төлүүлэх

нэхэтжлэл гаргах эрхтэй.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг)

“..Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ халгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт)

Монгол Улсын Иргэний хуульд хохирлын талаар тусгахдаа иргэний хуулийн 52 дугаар бүлэгт гэм хор учруулснаас үүсэх үүргийг тодорхойлжээ. Эндээс үзэхэд хохирол нь дараах төрөлтэй байна.

- Амь насанд учруулсан хохирол
- Бусдын эрх, эрх чөлөөнд учруулсан хохирол
- Эрүүл мэндэд учруулсан хохирол
- Нэр төр алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учруулсан хохирол
- Эд хөрөнгөд учруулсан хохирол
- Сэтгэл санаанд учруулсан хохирол

Иргэний хуулиар бусдын амь насыг хохироосон буюу бусдын эрхийг зөрчсөн тохиолдолд хохирлыг нөхөн төлнө гэсэн зохицуулалттай. Хохирогч нас барснаас учирсан гэм хорыг арилгахдаа “Нас барагчийн авч байсан дундаж цалингаас өөрт нь болон түүний асрамжинд байсан хөдөлмөрийн чадвартай бөгөөд төлбөр авах эрхгүй этгээдэд оногдох хэсэг, тэжээгчээ алдсаны тэтгэврийг хассан хэмжээгээр олгоно” гэж заажээ. Бусдын эрүүл мэнд (бие эрхтэнд)-д учирсан хохиролд: Хохирогч хөдөлмөрийн чадвараа алдсанаас

дутуу авсан цалин хөлс түүнтэй адилтгах бусад орлого, Эрүүл мэндэд нь гэм хор учруулсантай холбогдон гарсан сувилах, нэмэгдэл хоол өгөх, хиймэл эрхтэн хийлгэх, сувиллын газар асарч сувилуулах зэрэг зайлшгүй бүх зардал орно гэж тодорхойлжээ.

Эд хөрөнгөнд учруулсан хохирлын талаар Иргэний хуулийн 510 дугаар зүйлд: Бусдын эд хөрөнгөнд гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг арилгахдаа гэм хор учруулахаас өмнө байсан байдалд нь сэргээх (адил нэр төрөл чанарын эд хөрөнгө өгөх, гэмтсэн эд хөрөнгийг засах зэргээр) буюу учирсан хохирлыг мөнгөөр нөхөн төлнө гэж заажээ.

Түүнчлэн эд хөрөнгийг үндэслэлгүйгээр олж авсан этгээд тухайн эд хөрөнгийг буцаан өгөх, буцаан өгөх боломжгүй бол үнийг төлөх, үүнтэй холбоотой гарсан зардал, олох ёстой байсан орлого, үр шимийг төлөх үүрэгтэй гэж тодорхойлжээ. Эд хөрөнгийн тухайд эд хөрөнгийг үндэслэлгүйгээр олж авах, эд хөрөнгөнд хохирол учруулах гэсэн 2 тохиолдлыг бусдын хууль бусаар учруулсан хохирол гэж үзэж болохоор байна.

Мөн хуулийн эдийн бус гэм хорыг арилгах гэсэн хэсэгт “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол учирсныг үл харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож төлүүлнэ” гэж заажээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хохирогч болон иргэний нэхэмжлэгчийн эрх үүргийг ялган зааглаж тус бүрд нь тодорхойлжээ. Хохирогч нь гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй харин иргэний нэхэмжлэгч нь нэхэмжлэлтэй холбогдсон өөрт байгаа баримт сэлтийг хэрэг бүртгэгч мөрдөн байцаагчийн шаардсанаар гаргаж өгөх

үүрэгтэй гэж заасан байна.

Хууль бусаар буюу үндэслэлгүйгээр эрүүгийн хэрэгт шалгагдсан, эрх, эрх чөлөө нь хязгаарлагдсан этгээдийн үндсэн эрхийг сэргээх, түүнд учирсан гэм хорыг арилгуулах, нөхөн төлөх талаар Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлэгт тодорхой заасан байна.

Иргэнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан, албадан эмчлэх арга хэмжээ хэрэглэсний улмаас учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгахаар заажээ.

Мөн дараах тохиолдолд хохирол нөхөн төлүүлэх эрх үүсэхээр хуульчилсан байна. Үүнд:

- баривчлагдсан буюу цагдан хоригдсон этгээд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс суллагдсан;
- тухайн иргэнийг цагаатгасан шүүхийн тогтоол гарсан, тухайн хэрэг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, эсхүл тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон;
- эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн хууль бус тогтоолыг хүчингүй болгосон зэрэг болно.

ХУУЛЬ, ШҮҮХИЙН ӨМНӨ ЭРХ ТЭГШ БАЙХ RIGHT TO BE EQUAL BEFORE THE LAW

“Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчилалгүй хуулиар адилхан хатгаалуулах эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 7 дугаар зүйл)

“Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт нь тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан, эрх тэдэл бүхий, хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дугаар зүйл 1 дэх заалт)

“Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт)

Монгол Улсын иргэд, манай улсын хуулийн нөхцөл, шаардлагыг ханган түр буюу удаан хугацаагаар оршин сууж байгаа харьяалалгүй хүн, гадаадын иргэд, түүнчлэн зорчигчийг хууль ёсоор оршин суугаа хүн гэдэгт хамруулдаг. Хууль бусаар оршин суугаа хүн гэдэгт Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчин оршин суугаа зөвхөн гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хамруулна. Хуулийн өмнө эрх тэгш байна гэдэг нь хэн боловч Монгол Улсын хуулиар хүлээсэн үүргээ адилхан биелүүж, эрх, эрх чөлөөгөө ялгаваргүйгээр эдэлнэ гэсэн үг юм. Гэхдээ гадаадын иргэн, харьяалалгүй хүний хувьд хүний салшгүй эрхээс бусад зарим эрх, эрх чөлөөг (тухайлбал сонгох, сонгогдох эрх гэх мэт) хуулиар хязгаарлаж болдог. Харин Монгол Улсад байгаа хэн боловч шударга шүүхээр хэрэг маргаанаа эрх тэгш шийдвэрлүүлэх ёстой. Энэхүү эрхийг эдлэхэд ямар нэгэн ялгаварлал байж таарахгүй.

**ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУС, НЭР ТӨРИЙГ
ДОРМЖЛОН ХАРЬЦАХ БУЮУ ШИЙТГҮҮЛЭХЭЭС
АНГИД БАЙХ ЭРХ
THE FREEDOM FROM CRUEL INHUMANE
OR DEGRADING TREATMENT OR PUNISHMENT**

“...хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй.”
(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 5 дугаар зүйл)

“...хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно.”
(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйл)

“... хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй.”
(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт)

Хүнлэг бус гэдэг нэр томъёог анх Германы түүхч, философич Самуэль вон Пуфендорф 1673 онд гаргаж ирсэн байна. Тэрээр хэлэхдээ “Байгалийн ямар ч шалтгаан, нөхцөлөөс илүүтэйгээр хүнлэг бус үйл ажиллагааг хүн өөрөө хийдэг” гэжээ.

Хүнлэг бусаар хандах нь аливаа хүнд хийсэн гэмт хэрэг зөрчилтэй нь холбоогүйгээр хүнлэг бусаар хандахыг ойлгодог бол, хүнлэг бусаар шийтгэх нь урьд өмнө хийсэн гэмт хэрэг, зөрчилтэй нь холбогдуулан шийтгэх зорилгоор хийсэн хүнлэг бус үйлдлийг ойлгоно. Бие махбод, сэтгэл санааг шаналган зовоох нь хүнийг тамлан зовоохоос хөнгөн үйлдэл боловч энэ хоёр үйлдлийг нэг хэмжээнд адилтган үзэж олон улсын

түвшинд хориглосон байдаг.

Хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх гэдэгт хүнийг айлган сүрдүүлэх, тарчлаах, эрхшээлдээ оруулах зорилгоор доромжлох, бие махбод, сэтгэл санааг нь хүчтэй шаналган зовоон шийтгэхийг хэлнэ. Хэрцгийгээр хандах гэдэгт төрийн зүгээс аливаа хүнд хүнлэг бусаар гэмтэл, шаналал учруулахыг ойлгодог. Хэрцгийгээр шийтгэх гэдэгт аливаа хүнийг хийсэн эрүүгийн гэмт хэргийн төлөө залхаан цээрлүүлэх зорилгоор төрийн зүгээс хийж буй үйлдлийг ойлгодог. Хүнлэг бус харьцах, эрүүдэн шүүх гэсэн ойлголтын дунд нарийн зааг байхгүй боловч хүнлэг бус харьцсан нөхцөл байдлаас эрүүдэн шүүх үйлдэл илрэн гарахад хялбар бөгөөд эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэхдээ хүнлэг бус харьцахаас урьдчилан сэргийлэх ёстой. Иймээс хүнлэг бус харьцах үйлдлээс урьдчилан сэргийлэх явдлыг ямар ч тохиолдолд төр үгүйсгэж, татгалзаж болохгүй.

ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ ЭРХ RIGHT TO LIBERTY

“Хүн бүр ... эрх чөлөөтэй байх ... эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 3 дугаар зүйл)

“Хүн бүр эрх чөлөөтэй, ... байх эрхтэй. Хэнийг ч дур тэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журтаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг)

“... чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл,

журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, төрдөн төшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт)

Аливаа хүн эрх зүйн үүднээс хуульчлагдан баталгаажсан боломжийг элдэв ялгавар, хориг, шахалт дарамтгүйгээр ухамсар, хүсэл зоригийнхоо дагуу хэрэгжүүлэх нь эрх чөлөөтэй байх гол үндэс юм. Ямар ч үед хувийн болон гэр бүл, ахуй амьдралын хүрээний өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа нь хөндлөнгийн аливаа хяналтаас ангид оршиж байж эрх чөлөө бүрэн утгаараа хэрэгждэг. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хүний эрх чөлөөнд хэн ч байсан дур мэдэн халдаж, хүсэл зоригийг нь алдагдуулж эрхшээлдээ оруулж болохгүй.

ШУДАРГААР ШҮҮЛГЭХ ЭРХ RIGHT TO A FAIR TRIAL

“Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 10 дугаар зүйлийн 1 дэх заалт)

“...Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэтжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 1 дэх заалт)

“...шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт)

Шударгаар шүүлгэх эрх болон шударга шүүхээр шүүлгэх эрх нь нэг ойлголт бөгөөд олон улсын гэрээ, пактуудад “шударгаар шүүлгэх эрх”, харин Монгол Улсын Үндсэн хуульд “шударга шүүхээр шүүлгэх эрх” хэмээн тодорхойлжээ.

Шударга шүүхээр шүүлгэх эрх нь шүүх ажиллагаа шударга байх, хуулийн дагуу байгуулагдсан, бүрэн эрх бүхий шүүхээр хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх үндсэн эрх болно. Тодруулбал, энэхүү эрх нь хувь хүнийг шударга бусаар яллах, шийтгэхээс хамгаалах урьдач нөхцөл болдог. Аливаа хэрэг, маргааныг шийдвэрлэх шүүх нь юун түрүүнд, эрх мэдэл бүхий, бие даасан, хараат бус, хамгийн гол нь хуулийн дагуу байгуулагдсан байх шаардлагатай. Энэ нь өөрөө шүүхийн шударга үйл ажиллагааны баталгаа болдог. Ийм ч учраас бие даасан, хараат бус шүүхээр шүүлгэх эрхийг Хүний Эрхийн Хорооноос “салгаж болшгүй хүний туйлын эрх”-ийн үндэс суурь гэж үзжээ.

Харин дээрх нөхцөл бүрдсэний дараа шударгаар шүүлгэх эрхийн тухай асуудлыг хөнддөг. Шударгаар шүүлгэх нь шүүх хуралдааны өмнө болон шүүх хуралдааны үед, шүүх хуралдааны дараа эдлэх цогц эрхүүдийг багтаасан өргөн хүрээтэй ойлголт бөгөөд үүнд, шүүх хуралдаанаас өмнө эрх зүйн зөвлөгөө авах, өмгөөлөгч сонгох, эрүү шүүлтэд өртөхгүй байх, шүүх хуралдааныг шударгаар хийлгэх (талууд адил

тэгш мэтгэлцэх, шүүх хуралдаан нээлттэй байх), гэм буруутай нь нотлогдоогүй тохиолдолд гэм буруугүйд тооцогдох, хэргийг цаг алдалгүй шийдвэрлүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг мэдэх зэрэг олон эрхийг нэрлэж болно.

Шүүх нь төрийн үйл ажиллагааны механизм болохын хувьд гэм буруутай этгээдийг олж тогтоох, түүнд зохих хариуцлагыг хүлээлгэх үүрэгтэй. Гэхдээ ямар ч тохиолдолд шүүх ажиллагаа шударгаар явагдаж, түүний шийдвэр нь шударга, зөв гарах ёстой. Эс бөгөөс шүүх ажиллагаа илт шударга бус эсвэл шударга бус хэмээн ойлгогдож, шүүх тогтолцоо өөрийн шударга байх чанараа алдана.

ШҮТЭХ, ЭС ШҮТЭХ ЭРХ ЧӨЛӨӨ FREEDOM OF RELIGION

“Хүн бүр... шашин шүтэх, эс шүтэх эрхтэй. Энэхүү эрхэд шашин буюу шүтлэгээ өөрчлөх эрх чөлөө, бие даан буюу бусадтай халтран нийтийн өмнө болон хувийн журтаар хичээл заах, хурал төргөл хийх, шашны хийгээд зан үйлийн ёслол үйлдэх зэргээр шашин буюу шүтлэгээ номлох эрх чөлөө багтана.”
(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 18 дугаар зүйл)

1. Хүн бүр ... шашин шүтэх, эс шүтэх эрхтэй. Энэхүү эрхэнд өөрийн сонгосон шашин буюу шүтлэгтэй байх эсхүл тийл шашин буюу шүтлэгтэй болох эрх чөлөөний зэрэгцээ ганцаар буюу бусадтай халтран олон нийтэд буюу хувийн журтаар хичээл заах, хурал төргөл хийх, шашны болон зан үйлийн ёслол үйлдэх зэргээр шашин буюу шүтлэг номлох эрх чөлөө багтана.

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 18 дугаар зүйл)

“шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй;”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 15 дахь заалт)

Шашин, итгэл үнэмшлийн тухай асуудал нь өргөн хүрээг хамардаг. Итгэл бишрэл нь ямар нэгэн зүйлийг үнэн эсвэл оршин байгаа зүйл хэмээх мэдрэмж бөгөөд ямар нэгэн шүтлэгтэй, шүтлэггүй, бурхангүйн үзэлтэн эсэхээс үл хамааран өөрийн итгэл үнэмшлийг ертөнцийг үзэх үзлээ болгох явдлыг ойлгоно.

Шашин шүтэх эс шүтэх эрх нь хувь хүний салшгүй эрхүүдийн нэг бөгөөд энэ эрхийг ямар нэг хэлбэрээр хязгаарлах, тулгах, шахах, үл хүндэтгэх, шүтлэгээр нь далимдуулан доромжлох, гутаах зэргийг ардчилсан нийгэмд ноцтой хэрэг хэмээн үздэг.

Шүтэх эс шүтэх эрх нь тухайн хувь хүний оюун санааны чөлөөт илэрхийлэл, өөрийн итгэл үнэмшил дээрээ тулгуурлан хэнээс ч хараат бусаар өөрийн сонголт дээрээ тулгуурлан эдлэх эрхүүдийн нэг юм.

Олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс уламжлалт болон уламжлалт бус, шинээр үүсч бий болсон зэргээр ялгаварлан гадуурхах, итгэл үнэмшлээр хяхан хавчих, давамгайл байдалтай шашны зүгээс дарамтлах, түрэмгийлэх, хүчирхийлэх зэрэг үйлдэл гарахаас урьдчилан сэргийлж, харилцан хүндэтгэлтэй, хүлцэн тэвчиж зэрэгцэн оршихыг уриалдаг.

**ЭРХ ЗҮЙН ЧАДВАРТАЙ ГЭДГЭЭ ХҮЛЭЭН
ЗӨВШӨӨРҮҮЛЭХ ЭРХ**

RIGHT TO RECOGNITION AS A PERSON BEFORE THE LAW

“Хүн бүр хаана ч байсан эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 6 дугаар зүйл)

“Хүн бүр хаана ч эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 16 дугаар зүйл)

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд “Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэж энэ эрхийн агуулгыг тодорхойлсон байна. Эрх зүйн чадвар гэдэг нь тухайн хүний хуулиар баталгаажсан эрх болон хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх боломж юм.

Эрх зүйн чадвар нь эрх зүйн бие даасан ойлголт бөгөөд эд хөрөнгө өмчлөх, өв залгамжлах, өвлүүлэх зэрэг хуулиар хориглоогүй аливаа ажил үйлчилгээ явуулах эрх эдлэх нь эрх зүйн чадвараар илэрхийлэгддэг. Өөрөөр хэлбэл эрх зүйн чадвар нь дээр дурдсан эрхийг эдлэх хуулиар олгогдсон боломж юм. Хүн төрснөөр эрх зүйн чадвартай болж, нас барснаар дуусгавар болдог. Гэвч нас барагчийг нас барснаас хойш тодорхой хугацааны дараа төрсөн хүүхдийг хууль ёсны өвлөгчөөр тогтоодог тохиолдол байдаг. Энэ нь ураг эрх зүйн чадвартай байна гэсэн үг биш юм. Харин хүүхэд төрмөгц нас барагчийн хүүхэд болохын хувьд эд хөрөнгө өвлөх, тэжээгчээ алдсаны тэтгэмж авах зэргээр эрх зүйн харилцаанд оролцох боломжтой болдог.

Хүн бүр эрх зүйн бүрэн чадамжтай байдаггүй. Ийм учраас иргэний эрх зүйн чадамжийг бүрэн, хязгаарлагдмал, чадамжгүй гэж ангилна. Бие бялдар,

оюун ухааны хувьд өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадварыг иргэний эрх зүйн бүрэн чадамж гэнэ.

Иргэний эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай хүнд насанд хүрээгүй хүмүүс хамаарна. Эрх зүйн чадамжгүй хүнд сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг хамруулдаг. Эрх зүйн хязгаарлагдмал болон бүрэн чадамжгүй этгээдийг хуульд заасны дагуу эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч төлөөлнө.

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС АНГИД БАЙХ ЭРХ FREEDOM FROM TORTURE

“...Хэнд ч эрүү шүүлт тулган шийтгэх ёсгүй ... хориглоно.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 5 дугаар зүйл)

“Хэнд ч эрүү шүүлт тулгахыг ... хориглоно. Тухайлбал, өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр хэн дээр ч элнэлгийн буюу шинжлэх ухааны туршилт хийж болохгүй.”

(Иргэний болон улс төрийн эрхийнх тухай олон улсын пактын 7 дугаар зүйл)

“...Хэнд боловч эрүү шүүлт тулгаж ... болохгүй.”

(Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт)

Эрүү шүүлт нь төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж байгаа этгээдүүдийн үйл ажиллагаа болон түүний өдөөн хатгалт буюу ил далд зөвшөөрлөөр

үйлдэгддэг.

Эрүү шүүлт тулгах үйл ажиллагааг мэдүүлэг авах төдийгүй хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл, мэдээ сэлт авахын тулд хийдэг.

Эрүү шүүлтийг тулгаж болох субъект нь төрийн эрх бүхий албан тушаалтан байна. Өөрөөр хэлбэл эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж, албадлага хэрэглэх эрх бүхий төрийн тусгай албан тушаалтан байх ёстой. Хуулиар тогтоож өгсөн тэрхүү эрх, үүргийг зөвхөн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг эрхлэгчид хэрэгжүүлэх ёстой.

Эрүү шүүлт тулгах гэдэг нь мэдээ сэлт, мэдүүлэг авахын тулд уг эх сурвалжийг мэдэх буюу гаргуулан авах этгээдийн бие махбод, сэтгэл санааг шаналган зовоох үйлдлийг хэрэглэх, янз бүрийн давтамжтайгаар санаатай хийгдэж байгаа үйлдлүүдийг илэрхийлэх учиртай. Ер нь эрүү шүүлт тулгах нь тодорхой зорилго, сэдэлтэйгээр тодорхой хугацаанд, бусдыг ялгаварлан гадуурхах үндэслэл бүхий, төлөвлөсөн үйлдэл, эс үйлдлийн бодит илрэл болж өгдөг. Эрүү шүүлт тулгах гэдэгт гэмт хэргийг мөрдөн шүүх эрх бүхий албан тушаалтан буюу албан үүрэг гүйцэтгэж байгаа этгээд гэмт хэрэгт холбогдон мөрдөгдөж буюу шүүгдэж байгаа хүнээс буюу гэрч, шинжээч, бусад хүнээс үйлдсэн буюу үйлдсэн гэж сэжиглэн шалгаж байгаа хэргийн талаар мэдээлэл авах, хэргийг хүлээлгэх, ял шийтгэхийн тулд сэтгэхүйн болон биеийн хүч хэрэглэж айлгаж, албадах, санаатайгаар хүчтэй өвтгөх буюу бие махбод, сэтгэл санааны хувьд тарчлаан зовоосон аливаа үйлдлийг ойлгоно. Өөрөөр хэлбэл хүнээс өөрийн хүссэн мэдээлэл, мэдүүлэг гаргуулахын тулд хэрэглэдэг эрүү шүүлт нь хүний биеийг зовоох (зодох, өвтгөх), хэл амаар зовоох (аашлах, загнах),

сэтгэл зовоох (айлгах, шаналгах, сүрдүүлэх) гурван аргын аль нэгээр буюу нийлбэрээр илэрч болгодог онцлогтой.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг олон улсын конвенц зэрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь болон бусад төрлийн олон баримт бичгүүдэд бусдыг эрүүдэн шүүх ажиллагааг шууд хориглосон заалтыг олноор оруулж баталсан байна. Үүний зэрэгцээгээр бүс нутгийн хүний эрхийн олон улсын гэрээ, баримт бичгүүдэд ч энэ асуудал мөн тусгалаа олсон байдаг.

Америкийн улсуудын Хүний эрхийн тухай конвенц (1969 он), Хүний болон улс төрийн эрхийн тухай Африкийн Харти (1981 он) Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенц (1950 он), Хүний эрхийн тухай Арабын конвенц (1994 он одоо болтол хүчин төгөлдөр болоогүй) зэрэг баримт бичгүүдэд эрүүдэн шүүх, хүнлэг бус харьцааг хориглосон байна. Бие махбод, сэтгэл санааг хүчтэй өвтгөх, эсхүл тарчлаан зовоох үйлдлүүд нь эрүү шүүлтийн түгээмэл хэлбэрүүд юм. Эрүү шүүлт нь зөвхөн бие махбодыг өвтгөхөөр хязгаарлагдахгүй бөгөөд өвтгөх, зовоох үйл ажиллагаа нь нэг удаа бус олон давтагдсан, тарчлаах шинжтэй байхыг ойлгодог. Нэг удаа өвтгөсөн тарчлаан зовоосон тохиолдлыг эрүү шүүлт гэж ойлгохгүй бөгөөд харин энэ нь зүй бус, хэрцгий, хүнлэг бус харьцаа юм. Эдгээр үйл ажиллагааны гол шинж бол зориуд санаатай үйлдэгддэг болохоор санамсаргүй өвтгөж, зовоосон үйлдэл нь эрүү шүүлтэд тооцогдохгүй.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг

- ХҮНИЙ ЭРХИЙН ТОВЧ ТАЙЛБАР -

нь доромжлохыг хориглосон заалтыг хуульчилсан бөгөөд сэжигтнээс мэдүүлэг өгөхийг шаардах, түүнтэй хүнлэг бус, хэрцгий харьцах, нэр төрийг нь гутаан доромжлохыг хориглосон билээ.

- II -
УЛС ТӨРИЙН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ
POLITICAL RIGHTS

АРД ТҮМЭН ӨӨРТӨӨ ЗАСАН ТОХИНОХ ЭРХ
RIGHT TO SELF-DETERMINATION

“Бүх ард түмэн өөрөө засан тохинох эрхтэй. Энэхүү эрхийнхээ дагуу тэд улс төрийн статусаа чөлөөтэй тогтоож, эдийн засаг, нийгэм, соёлоо чөлөөтэй хөгжүүлнэ.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт)

“Бүх ард түмэн өөрөө засан тохинох эрхтэй. Энэ эрхийнхээ дагуу тэд улс төрийн байдлаа чөлөөтэй тогтоож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлөө чөлөөтэй хангана.”

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт)

Ард түмний өөртөө засан тохинох эрх нь тухайн ард түмэн улс төрийн статусаа өөрсдөө тодорхойлох, эдийн засаг, соёл, нийгмийн хөгжлийн чиглэлээ бие даан сонгох боломж бөгөөд энэ нь бусад улсын хандлага үйл ажиллагаанаас үл шалтгаална гэсэн үг юм. Мөн өөрөө засан тохинох гэдэгт колонийн дэглэм дор амьдарч байсан хүмүүсийн эдэлбэл зохих эрхийг ойлгоно.

Тодруулбал, энэ нь ард түмэн хувь заяагаа бие даан тодорхойлох эрх юм. Амьд явах эрх, эрх чөлөөтэй

халдашгүй байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, өмч хөрөнгөтэй байх төрөлхийн эрх нь хувь хүнд хамаардаг бол ард түмний өөртөө засан тохинох эрх нь бүлэг этгээдэд хамаарах хамтын эрхийн нэг хэлбэр юм. Энэ эрхийг нэр бүхий пактуудад улс төрийн зорилгоор тусгайлан оруулсан гэж үздэг бөгөөд энэхүү эрхийг бий болгосноор үндэстэн, ард түмнийг хүлээн зөвшөөрөх явдал хууль зүйн үндэслэлтэй болж иржээ. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1966 онд баталсан Хүний эрхийн биллийг бүрдүүлэгч хоёр пактын 1 дүгээр зүйлд “Бүх ард түмэн өөрөө засан тохинох эрхтэй. Энэхүү эрхийнхээ дагуу тэд улс төрийн статусаа чөлөөтэй тогтоож, эдийн засаг, нийгэм, соёлоо чөлөөтэй хөгжүүлнэ” гэж заасан. Үүнээс шалтгаалан тус хоёр пакт нэг зүйлийг илэрхийлсэн үү, эсвэл тусдаа хоёр зүйл байсан уу гэдэг талаар маргаан өрнөж байжээ. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад колончлолын эрин үед ард түмэн тэмүүлж байсан тусгаар тогтнол зэрэг улс төрийн бие даасан байдалтай байх эрхийг илэрхийлсэн гэдэг. Нөгөө талаас Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад улс төрийн бие даасан байдлаас илүүтэйгээр соёлын буюу эдийн засгийн бие даасан байдлыг чухалчилсан гэж эрдэмтэд үздэг.

Өөрөө засан тохинох эрхийн хувьд, Европ тивийн зүүн хэсгийн улс орнуудад коммунист дэглэм нуран унах үеэр хувьсгалын дараах төрийн зүгээс авсан эхний алхамуудын нэг бол бүх нийтийн санал асуулга, бүх ард түмний санал хураалт, сонгуулийн замаар улс төрийн шинэ дэглэмийг үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөх явдал байсан. Нэгдүгээрт, ард түмэн ямар шинэ төртэй байхаа өөрөө тодорхойлж байгаа, хоёрдугаарт ийнхүү ардчилсан төрийг эмхлэн байгуулах нь тухайн шинэ

дэглэмийг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөх урьдач нөхцөл билээ. Учир нь шинэ дэглэм тогтох хүртэл тухайн улс, эрх мэдэлтнийг ямагт де факто хэлбэрээр, хожим зохимжтой тохиолдолд де юре хэлбэрээр хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ орчин үед де юре, де факто хэлбэрээр заагтай хүлээн зөвшөөрөх нь ховор болсон.

Де юре (de jure) нь тухайн улсын тусгаар тогтнолыг бусад улс орнууд бүрэн хэмжээгээр, ямар нэгэн эргэлзээгүйгээр хүлээн зөвшөөрөх явдал юм. Харин де факто (defacto) нь тухайн улсыг хангалттай бүрэн бус хэмжээгээр хүлээн зөвшөөрөх явдал бөгөөд де юре хүлээн зөвшөөрөхийн өмнөх бэлтгэл гэж ойлгогдоно. Үндсэндээ ард түмний өөртөө засан тохинох эрхийн дээд хэлбэр нь тусгаар тогтнол юм.

Дээр дурдсан олон улсын пактуудын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт эдийн засгийн хувьд өөрөө засан тохинох эрхийн гол үндсийг тодорхойлж, оршин тогтнох хэрэглүүрээ сахин хамгаалах, байгалийн баялгаа хараат бусаар эзэмших эрхүүдээр өргөжүүлсэн. Хүний эрхийн хорооны 12 дугаар зөвлөмжөөр өөрөө засан тохинох эрхийн эдийн засгийн агуулгыг цохон тэмдэглэж, үүнийг гишүүн улс бүрийн хүлээх үүрэг болохыг онцолсон байна. Эдийн засгийн хувьд өөрөө засан тохинох явдлыг дотоодоо өөрөө засан тохинохтой холбоотой гэсэн маргаан өрнөдөг. Гэхдээ өөрийн эдийн засаг, нийгэм, соёлоо чөлөөтэй хөгжүүлэх эрхийг олон улсын гэрээнд хүлээн зөвшөөрч, хөгжих эрх гэж тодорхойлсон. Улс төрийн үүднээс авч үзвэл, эдийн засгийн хувьд өөрөө засан тохинох эрх нь бусад улсын зүгээс хөндлөнгөөс оролцохгүй чөлөөтэй байх гэсэн санааг илэрхийлнэ. Үүнийг байгалийн баялаг, эх нөөцөө чөлөөтэй эзэмших эрхийн хүрээнд

тайлбарлах боломжтой. Жишээлбэл, Номхон далайн аралд амьдрах Науручууд фосфатын уул уурхайн компанийн эсрэг гомдол гарган, өөрөө засан тохинох зарчмыг зөрчсөн гэжээ. Науру Австрали Улсын эсрэг хэргийг Олон улсын шүүхэд шийдвэрлэх болсон ч өөрөө засан тохинох асуудлын талаар ямар нэгэн шийдвэр гараагүй. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1962 оны Байгалийн баялгийг захиран зарцуулах байнгын бүрэн эрхийн тухай 1803 (XVII) дугаар тогтоолд байгалийн баялгаа чөлөөтэй эзэмших эрхийн талаар дурдсан байна.

Мөн өмнө дурдсан пактуудад ард түмнийг ямар ч тохиолдолд оршин тогтнох хэрэглүүрээс нь салгаж үл болохыг тусгайлан заасан. Энэ нь илэрхий эдийн засгийн ойлголтыг агуулах ба орон сууц, хоол хүнсээр хангагдах, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, бүр амьд явах эрхтэй хамаатай. Эдийн засгийн хувьд өөрөө засан тохинохыг зорьж байгаа бүлэг этгээдийн хувьд тулгарч байгаа гол асуудал бол улс төрийн болон эдийн засгийн шинжээс нь ялгаж салгах юм. Жишээлбэл, уугуул хүмүүс өөрийн газар нутгийг шаардахад тухайн газар нутагт байгалийн баялаг их байвал яах вэ гэдгээс тод харагдана.

Өөрөө засан тохинох эрх нь колонийн эрх мэдлээс татгалзаж буй улсуудын хувьд илрэх боломжтой. Харин тухайн улсын нутаг дэвсгэрт дангаар амьдраагүй угсаатны, соёлын, шашны бүлэг этгээдийн хувьд засан тохинох нь хүндрэлтэй. Орчин цагийн улсууд колончиллыг халахаас бусад тохиолдолд өөрөө засан тохинох эрхэд сайнаар ханддаггүй. Жишээлбэл, Африк тивийн колоничлолыг халсан цөөнгүй улсууд соёлын болон угсаатны нэг ишт үндэсгүй тул өөрөө засан тохинох нь ирээдүйд ямар ч гүйцэтгэх үүрэггүй

болно гэж үздэг. Мөн газар нутгийн бүрэн бүтэн байдлыг дурдахгүй өнгөрч болохгүй.

Зарим улс өөрөө засан тохинохтой холбоотой шинэ хувилбар гаргаж ирсэн. Жишээлбэл, Австрали Улс зарим уугуул хүмүүстээ өөрөө засан тохинох эрхийг эдлэх нөцлийг хялбаршуулж өгсөн. Зарим улсын хувьд үндэсний хууль тогтоомжоороо уламжлан эзэмшиж ирсэн хүмүүсийн газар өмчлөх эрхийг хүлээн зөвшөөрч, баталгаажуулсан. Олон улсын хүний эрхийн эрх зүйн үүднээс авч үзвэл, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих байгууллагууд “ард түмэн” гэж хэнийг үзэх, дотоодын бүрэн эрхийг халах нөхцөл байдлыг тодорхойлох нь асуудалтай тулгарч болзошгүй.

Нэгэнтээ колоничлолыг халсан өнөө үед өөрөө засан тохинох асуудлыг дахин тодорхойлох нь зайлшгүй билээ. Цөөнхийн болон уугуул хүмүүсийн эрхийн талаарх асуудал маргаантай байгаа үед бүх “ард түмэн”-ий эдлэх эрх улам маргаан үүсгэх боломжтой. Мөн газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх явдал нь колони байсан буюу гадаад улсын хараат байсан бүх газар нутгийг хэсэг хүн эзэмших явдалтай зөрчилдөх болно. Энэхүү хандлагаар хагас улс төрийн өөртөө засан тохинох хэлбэр гарч ирсэн нь XXI зууны өөрөө засан тохинох эрхийн хувьсан өөрчлөгдсөн дүрийн нэг билээ.

ИТГЭЛ ҮНЭМШИЛТЭЙ БАЙХ ЭРХ ЧӨЛӨӨ FREEDOM OF THOUGHT AND CONSCIENCE

“Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл

өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.”

“Энэ эрхэд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан алаар, бичгээр, эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар, эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.”

“Энэ эрхийг бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах зорилгоор хязгаарлаж болно.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 3 (a,b) заалт)

“итгэл үнэмшилтэй байх... эрх чөлөөтэй.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалт)

Үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх, өөрийн үзэл бодолтой байх эрх нь туйлын шинжтэй тул хянах боломжгүйд тооцдог. Гэсэн хэдий ч дэлхийн зарим хэсэгт “дахин боловсрол олгох” хөтөлбөрөөр дамжуулан, нийгэм дэх хувь хүмүүсийн эсвэл тодорхой бүлгийн “тархи угаадаг” гэх шүүмжлэл байдаг. Хүний эрхийн эрх зүйн хувьд үзэл бодол, байр сууриа олон нийтийн өмнө илэрхийлсэн тохиолдолд үйлчилж эхэлдэг болохыг Нэгдсэн Үндэстний Байгууллагад өргөн барьсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний илтгэлд дахин баталгаажуулсан. Өөрийн улс төрийн үзэл баримтлалын улмаас хоригдсон “үзэл санааны хоригдол”-той холбоотой тохиолдол өсөх хандлагатай

байна. Ялангуяа уг хорих явдал нь халдашгүй чөлөөтэй байх эрх, хүнлэг бус харьцаанаас ангид байх эрхийг ч давхар зөрчдөг. Жишээлбэл, хүний эрхийн хорооноос Мутеба Бүгд Найрамдах Конго Улсын эсрэг хэргийг дурдаж болно. Тухайн хэрэгт холбогдох хохирогчийг баривчилж, хорьж, хүнлэг бусаар харьцан, шударга шүүхээр шүүлгэх, өөрийн баривчлах үндэслэл хууль зүйн үндэслэлийг шүүхээр тодорхойлуулах эрхийг зөрчсөн ажээ. Түүнийг улсын дотоод, гадаад аюулгүй байдалд халдсан, улс төрийн нууц нам байгуулсан гэж ялласан байна. Хүний эрхийн хорооны дийлэнх гишүүдийн хувьд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийг зөрчсөн гэж дүгнэсэн.

Үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар ямар нэгэн тайлбар хийсэн эсвэл хязгаарлалт агуулаагүй эрх гэж болно. Тухайн хүн өөрийн чөлөөтэй сонгосон үндэслэлийн дагуу хэзээ ч, ямар ч байдлаар санаа бодлоо өөрчлөх боломжоор ойлгоно. Улс төрийн, шинжлэх ухааны, түүхийн, ёс суртахууны, шашны шинжтэй аливаа хэлбэрийн үзэл бодлыг хүндэтгэж хамгаална. Мөн үзэл бодлыг эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцох, баривчлах, хорих, дарамтлах, шүүх, цагдах явдал хаана ч байж болохгүй.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын төслийг боловсруулагчид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дотоодын болон олон улсын түвшинд мэдээллийг бүрэн дүүрэн солилцох явдлыг хамгаалсан арга хэрэгсэл гэж үзэж байсан. Үүнтэй уялдан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлд хил хязгааргүйгээр

мэдээлэл буюу санаагаа солилцох явдлыг хангасан гэх үндэстэй. Хүмүүс бусадтай мэдээллийг солилцох, хүлээн авах, түгээхийн зэрэгцээ уламжлалт харилцаа холбооны хэрэгслээс гадна орчин үеийн технологийн ололт амжилтыг ашиглах бүрэн боломжтой. Харин төрийн зүгээс энэхүү эрхийг хязгаарлах асуудлыг нарийвчлан зохицуулдаг туршлагатай. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дан ганц үгээр өөрийн санааг хэлэх төдийгүй хэвлэл, пайзан дээр бичсэн үгсээр, зураг, бүжиг, жүжиг зэрэг урлагийн төрлөөр илэрхийлэх хамаарах ба ямарваа бүтээлч шинжтэй бодол, үйл хөдлөл байх боломжтой.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний нэг талыг мэдээллийн эрх гэж болно. Мэдээллийн эрх чөлөө бол ардчилалд ус агаар мэт чухал байдаг нь хүмүүс өөрийн амьдралтай холбоотой шийдвэрийг мэдэж байх боломжийг бүрдүүлдэгтэй холбоотой. Төрийн зүгээс мэдээллийг өөртөө бус, харин олон нийтийн төлөө хадгалж, нийтийн байгууллагаар дамжуулан мэдээлэлд нэвтрэх боломжийг хангах хэрэгтэй гэсэн чиглэлийг олноороо хүлээн зөвшөөрч байна. Үүнтэй уялдан дэлхий дахинд мэдээлэлд нэвтрэх асуудлыг дагнан зохицуулсан хуулиудыг маш хурдацтайгаар батлан мөрдөх болсон юм.

Одоогийн байдлаар 90 гаруй улсад хувь хүмүүс нийтийн байгууллагын мэдээлэлд нэвтрэх эрхийг баталгаажуулан, нийтийн байгууллагын зүгээс хувийн санаачилгаар мэдээллийн гол төрлийг ил гаргах үүрэг ногдуулсан. 1990 онд уг хуулийг зөвхөн 13 улс баталсан байжээ. Дэлхийн банк зэрэг ихэнх олон улсын санхүүгийн байгууллагууд, бүс нутгийн хөгжлийн банкууд, засгийн газар хоорондын байгууллагууд мэдээллийг нээлттэй байлгах бодлогыг баталж эхэлсэн.

Мэдээлэлд нэвтрэх асуудлыг зохицуулсан хууль тогтоомж нь засгийн газар өөрийн иргэдэд үйлчлэхэд чиглэсэн үйл ажиллагаатай нягт холбоотой. Үүнтэй уялдан мэдээлэл авах эрхийг илүү өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөх, бодит үйл хэрэг болгоход анхаарах болжээ.

Мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “19 дүгээр зүйл” төрийн бус байгууллагаас “Мэдээлэл бол ардчиллын хүчилтөрөгч бөгөөд бүхий л шатанд амин чухал. Хүмүүс өөрийн амьдралд нөлөөлөхүйц шийдвэр гаргахад идэвхтэй оролцох ур чадвар нь мэдээллээс шууд хамаардаг. Ялангуяа олон улсын эрх зүйд тодорхойлсны дагуу “хүмүүсийн хүсэл зориг нь төрийн эрх мэдлийн суурь болно” гэсэн сонгууль ямарваа нэгэн мэдээлэлгүй, өөрийн гэсэн байр сууриа тодорхойлох боломжийг олгоогүй бол хэзээ ч хууль ёсны гэж үзэхгүй” гэж онцолсон байна. Мөн ардчилал нь хариуцлага, үр нөлөөтэй удирдан залах асуудалд анхаардаг.

Олон нийтийн зүгээс өөрийн улсын удирдагчдыг үйл ажиллагааг шүүмжлэх, нээлттэй чөлөөтэй байдлаар мэтгэлцэх эрхтэй. Төрийн зүгээс авсан арга хэмжээг үнэлэх боломжтой байх нь улс орны эдийн засаг, нийгмийн тогтолцоо, олон нийтийн анхаарлыг хандуулсан бусад асуудлын талаарх мэдээлэлд нэвтрэхээс шууд хамаарна.

Тухайн улсыг үр нөлөөгүй удирдан залж байгааг онцлох хамгийн идэвхтэй арга бол сайтар мэдээлэлтэйгээр мэтгэлцэх явдал юм. Нөгөө талаас мэдээлэл авах нь авлига, зүй бус үйлдэлтэй тэмцэх гол арга хэрэгсэл болно. Эрэн сурвалжлах чиглэлээр ажиллаж байгаа сэтгүүлчид, хоточ нохойны буюу төрийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтын үүрэг

гүйцэтгэгч – төрийн бус байгууллагууд мэдээлэл авах эрхээр дамжуулан зүй бус үйлдлийг илчлэн, таслан зогсооход дэмжлэг үзүүлдэг. АНУ-ын Дээд шүүхийн шүүгч Луис Брандейс “Өчүүхэн төдий нарны гэрэл ч маш сайн ариутгах үйлчилгээтэй” гэжээ.

Мэдээлэл авах эрхийг хуулиар баталгаажуулснаар нийгэмд цөөнгүй чухал үүргийг гүйцэтгэдэг. Жишээлбэл, хувийн мэдээлэлдээ нэвтрэх эрх нь өөрийн нэр төрийг хүндэтгэхийн зэрэгцээ өөртэйгээ холбоотой шийдвэр гаргахад гол үүрэг гүйцэтгэх боломжийг олгодог. Эмнэлгийн эмчилгээний бүртгэлтэйгээ танилцах нь эмчилгээний талаар шийдвэр гаргах, санхүүгээ тооцох давуу талыг хүмүүст бүрдүүлдэг.

Мөн мэдээллийн үндсэн дээр хамгийн идэвхтэй бизнесийн үйл ажиллагааг явуулж болно. Олон тооны улсуудад хувийн аж ахуй эрхлэгчид маш ихээр мэдээлэл авч, ашигладаг. Төрийн байгууллагууд дахь эдийн засгийн асуудлаарх мэдээлэл, тоо баримт нь хувийн хэвшлийн салбарт өөрийн үйл ажиллагааг явуулахад маш чухал.

Олон улсын стандартуудын хувьд, Нэгдсэн Үндэстний Байгууллага, Америкийн Улсуудын Байгууллага, Европын Зөвлөл, Африкийн Холбоо зэрэг цөөнгүй тооны олон улсын байгууллагууд нэгэн дуугаар чөлөөтэй мэдээлэл авах эрхийн суурь, эрх зүйн мөн чанар болон тухайн эрхийг бодит амьдралд хууль тогтоомжоор баталгаатай хүндэтгэн сахих хэрэгцээг хүлээн зөвшөөрсөн.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хариуцсан Тусгай илтгэгч 1997 оноос хойш өөрийн жил бүрийн илтгэлдээ мэдээллийн эрх чөлөөний асуудлыг ямагт онцолсоор ирсэн. Тухайн асуудлаар 1997 онд тайлбар гаргасны дараа Хүний

эрхийн комисс уг Тусгай илтгэгчид “мэдээлэл хайх, хүлээн авах эрхийн талаарх өөрийн тайлбарыг улам боловсруулах, харилцаа холбооноос үүдэлтэй өөрийн ажиглалт, зөвлөмжийг өргөжүүлэх” хүсэлт тавьсан.

Үүнтэй уялдан Тусгай илтгэгч өөрийн 1998 оны жил бүрийн илтгэлдээ төрийн хадгалж буй мэдээлэлд нэвтрэх эрх нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд багтахыг тодорхой дурдаж, “мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрх нь мэдээлэлд, ялангуяа хадгалалтын бүхий л төрлийн хэлбэрээр Засгийн газарт хадгалагдаж байгаа мэдээлэлд нэвтрэх боломжийг баталгаажуулах эерэг үүргийг Төрд оноодог” гэжээ. Хүний эрхийн комиссын зүгээс Тусгай илтгэгчийн байр суурийг сайшаан хүлээн авсан болно. Тусгай илтгэгчийн 2000 онд Хүний эрхийн комисст өргөн барьсан илтгэлдээ мэдээллийн эрх чөлөөний тухай өөрийн тайлбарыг улам өргөжүүлж, ардчилал, эрх чөлөө төдийгүй оролцох эрх, хөгжих эрхийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтойг тэмдэглэсэн байна.

Мөн тэрээр “угаас хүмүүст хамаарах мэдээллийг тэдэнд өгөхөөс татгалзах гэсэн Засгийн газрын болон төрийн байгууллагуудын чиг хандлага”-ыг дахин онцолсон. Үүний зэрэгцээ Тусгай илтгэгч мэдээлэл авах эрхийн агуулгыг нарийвчлан гаргасан юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллага, Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Америкийн Улсуудын Байгууллагын 2004 онд гаргасан Хамтын тунхаглалдаа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаарх гурван тусгай бүрэн эрхийг тэмдэглэсэн. Төрийн байгууллагын хадгалж буй мэдээлэлд нэвтрэх эрхийг хүний суурь эрхэд тооцон, үндэстний түвшинд бүрэн дүүрэн хуульчлахын зэрэгцээ дээд зэргээр нээлттэй байлгах зарчмыг удирдлага болгосон байна.

Хүний эрхийн Америк, Европ, Африкийн бүс нутгийн тогтолцоонд албан ёсоор мэдээллийн эрх чөлөөг хүний эрх гэж хүлээн зөвшөөрсөн ажээ.

“19 дүгээр зүйл” төрийн бус байгууллагаас “Олон нийтийн мэдэх эрх: Мэдээллийн эрх чөлөөг хуульчлах тухай зарчмууд” боловсруулаж, мэдээллийн эрх чөлөөг хуульчлах шилдэг стандарт тогтоосон гэж болно. Үүнд:

- Дээд зэргээр нээлттэй байлгах: “Мэдээллийн эрх чөлөөний хууль нь дээд зэргээр нээлттэй байх зарчмыг удирдлага болгоно.”

- Хэвлэн нийтлэх үүрэг: “Төрийн байгууллагууд нь гол мэдээллийг хэвлэн нийтлэх үүрэг хүлээнэ.”

- Нээлттэй засгийн газрыг хөхиүлэн дэмжих: “Төрийн байгууллагууд нь нээлттэй засгийн газрыг хөхиүлэн дэмжих ёстой.”

- Тайлбар хийх хязгаарлагдмал хүрээ: “Мэдээлэлд нэвтрэх эрхийг тайлбарлахдаа маш тодорхой, нарийвчлан зохицуулах ба “хор хөнөөл”, “нийтийн ашиг сонирхол”-ыг анхаарна.”

- Нэвтрэх боломжийг хялбарчлах үйл явц: “Мэдээлэл авах хүсэлтийг шуурхай, шударгаар шийдвэрлэж, ямар нэгэн татгалзах үндэслэлийг хараат бусаар гаргана.”

- Зардал: “Мэдээлэл авах хүсэлт гаргасан хувь хүнээс хэтэрхий өндөр зардал нэхэж, саад хийж болохгүй.”

- Нээлттэй уулзалт: “Төрийн байгууллагуудын уулзалт нь олон нийтэд нээлттэй байна.”

- Нээлттэй байхыг чухалчлах: “Дээд зэргээр нээлттэй байлгах зарчимтай нийцэхгүй байгаа хуулийг өөрчлөх буюу хүчингүйд тооцно.”

- Шүгэлчдийг хамгаалах: “Зүй бус үйлдлийн талаарх мэдээллийг задалсан хувь хүмүүс — шүгэлчдийг хамгаалах ёстой.”

Монгол Улсын хувьд, иргэний нийгмийн идэвх санаачилгаар олон жил асуудлыг хэлэлцсэний эцэст 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг баталсан. Үүнтэй уялдан төрийн байгууллагын ил тод байлгах мэдээллийн төрлийг нарийвчлан тодорхойлж, иргэдэд үйлчлэх хэм хэмжээг тусгайлан зааж өгсөн байна.

ХЭВЛЭН НИЙТЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ FREEDOM OF PRESS

“Энэ эрхэд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан алаар, бичгээр, эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар, эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйл)

“... хэвлэн нийтлэх ... эрх чөлөөтэй.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалт)

Цензургүй буюу хяналтгүй мэдээллийн хэрэгсэл нь эрх мэдэл бүхий төрийг чөлөөтэй, нээлттэй шүүмжлэх, үндэсний эсвэл бүс нутгийн ашиг сонирхлын талаар мэтгэлцэх чөлөөт нийгмийн тулгуур болдог. Сонин, сэтгүүл, ном зэрэг цаасан хэлбэрээс гадна цахим орчинд блог, цахим хуудас, олон нийтийн сүлжээг ашиглан өөрийн үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, бусадтай хуваалцах нь нээлттэй нийгмийн үндэс юм. Төрийн эзэмшил бүхий мэдээллийн хэрэгслээр

дамжуулан үзэл бодол, оюун санаагаа чөлөөтэй илэрхийлэх боломжийг боомилохын зэрэгцээ өөрийн байр сууринаас аливаа асуудлыг харах сөрөг талтай. Үүнтэй уялдан төрийн эзэмшлийн мэдээллийн хэрэгсэл мэдээллийг дангаар буюу монополь шинжтэйгээр хянах тохиолдолд хэвлэлийн эрх чөлөөнд шууд сөргөөр нөлөөлнө.

Өмнө дурдсанчлан Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 19 дүгээр зүйлд заасны мэдээллийг хил хязгаараас үл хамааран солилцох хэрэгтэйг онцолсон. Энэ ойлголт нь Европ дахь шүүхийн үйл ажиллагааны талаар хил дамнуулан мэдээлэл түгээхтэй шууд холбоотой. Мөн цөөнхийн бусадтай харилцах асуудлыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1992 оны Үндэстний, угсаатны, шашны, хэлний цөөнхөд хамаарах хүмүүсийн эрхийн тухай тунхаглалын 2 дугаар зүйл, Бүс нутгийн буюу цөөнхийн хэлний талаарх Европын харти, Үндэстний цөөнхийн талаарх хүрээг тодорхойлсон конвенцийн заалтуудад тусгайлан заасан. Ялангуяа төрийн зүгээс цөөнх бүлгийн бусад бүлэгтэй харилцаа холбоо тогтоох хэрэгцээг ямагт хөхиүлэн дэмжихийг онцолсон юм. Учир нь эдгээр хүмүүсийн соёлыг хадгалахад чухал ач холбогдолтой гэж үздэг. Мөн хүний эрхийн боловсролтой нягт холбоотой. Дэлхий дахиныг хамарсан байдлаар мэдээллийг түгээхээс хүний эрхийн боловсрол шууд хамаарах болсныг эрдэмтэн судлаачид хүлээн зөвшөөрсөн байна.

Захидал харилцааны хувийн эрх чөлөөг үзэл бодлоо илэрхийлэх чөлөө, мөн тодорхой тохиолдолд хувийн нууцтай байх эрхтэй холбож үздэг. Гэсэн хэдий ч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах зэрэг шаардлагатай тохиолдолд эрх нь хязгаарлагдсан, нийгмээс тусгаарлагдсан хүмүүсийн хувьд буюу

ялтан, хоригдлын захидал харилцааг хянахыг хүлээн зөвшөөрдөг. Харин дур зоргоор захидал харилцаанд хөндлөнгөөс оролцох, саад хийх, устгах үйлдлийг хориглож, хууль зүйн туслалцаа авах, шударга шүүхээр шүүлгэх, гомдол гаргах зэрэг боломжийг хязгаарлахгүй байвал зохино. Ихэнх улсуудын хувьд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу "... дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараахь шаардлагаас үүдэн гарсан байх ёстой:

- бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх;
- үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах"-аар тус эрхийг хязгаарладаг.

Гэхдээ тус пактын "Аливаа улс, бүлэг буюу хувь этгээд энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн аливаа эрх, эрх чөлөөг үгүй хийх буюу тэдгээрийг түүнд зааснаас илүү хэмжээгээр хязгаарлахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах буюу үйлдэл хийх эрхтэй мэтээр энэхүү Пактын заалтуудыг мушгин тайлбарлаж болохгүй" гэсэн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг ямагт удирдлага болгох нь чухал.

**ӨРГӨДӨЛ, ГОМДЛОО ГАРГАЖ,
ШИЙДВЭРЛҮҮЛЭХ ЭРХ
RIGHT TO SUBMIT A PETITION OR A COMPLAINT**

"Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх

үүрэгтэй.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь заалт)

Энэ нь нэг талаас иргэд төрийн байгууллага болон түүний албан тушаалтнуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, алдаа дутагдал, зөрчил гажуудлыг арилгах, нөгөө талаас өөрсдийн зөрчигдсөн эрхийг төрөөр хамгаалуулах, эцэст нь хууль ёс, нийгмийн дэг журмыг чанд сахиулах олон талын ач холбогдолтой иргэн, төр хоёрын харилцан тэгш эрх эдэлж, үүрэг хүлээх зарчмыг хангах үндсэн хэрэгсэл юм.” хэмээн Г.Совд нарын Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар номонд дурьдсан байна. Төрийн байгууллагад хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч бүх байгууллагыг хамруулсан бөгөөд албан тушаалтанд эдгээр байгууллагад сонгууль буюу томилолтоор, байнга буюу түр ажиллаж байгаа, улс төрийн, тусгай, төрийн захиргааны албан тушаал эрхэлж байгаа бүх хүмүүсийг хамруулан ойлгоно. Монгол Улсын иргэн, Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаадын иргэн, харъяалалгүй хүн өргөдөл, гомдол гаргах этгээд байхаар зохицуулсан. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 25 дугаар зүйлд иргэд төрийг удирдах хэрэгт шууд буюу сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй хэмээн заасан байдаг. Төрийг удирдах хэрэгт оролцох нэг хэлбэр нь төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гаргаж шийдвэрлүүлэх явдал юм. Тухайлбал, иргэд төр, нийгмийн болон иргэдийн нийтлэг эрх ашигт хохирол учруулахаар оршин байгаа зөрчил, дутагдлыг арилгуулах буюу нийгмийн хэв журам, хууль зөрчсөн асуудлын

талаар өргөдөл гаргахаар заасан. Энэхүү өргөдлийг шийдвэрлэх, хариу өгөх үүргийг төрийн байгууллага, албан тушаалтан хуулиар хүлээсэн.

Эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн тохиолдолд гомдол гаргаж, шийдвэрлүүлэхээр заасан нь иргэд эрхээ шаардах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх нэг арга зам болж байна. Монгол Улс нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн орны хувьд хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн тохиолдолд эрхийг сэргээх, хохирлыг барагдуулах үр дүнтэй механизмыг бий болгох үүргийг олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн. Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүс эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн тохиолдолд гомдол гаргаж, шийдвэрлүүлэх эрхийг баталгаажуулсан нь дээрх үүргээ хэрэгжүүлж байгаа нэг хэлбэр юм. Энэ нь өөрөө бие даасан эрх бөгөөд зөрчигдсөн тохиолдолд хохирогч эрхээ шаардах боломжийг Монгол Улсын Үндсэн хуулиар олгосон байна. Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх асуудлыг тусгайлсан хуулиар зохицуулж өгсөн нь энэхүү эрхийг хэрэгжүүлэх хууль зүйн баталгаа юм.

СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХ RIGHT TO ELECT AND TO BE ELECTED

“Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэлзориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хууралч бус сонгуулиар илэрлээ олно.”

(Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 21 дүгээр зүйлийн 3 дахь заалт)

“Сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох эрх эдэлнэ.”
(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 25 дугаар зүйл 9(b) заалт)

“Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй.”
(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт)

Сонгох эрх гэж парламентын гишүүн, ерөнхийлөгч, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бүрдүүлэхэд саналаа өгч оролцохыг, сонгогдох эрх гэж дээрх байгууллагад сонгогдохоор зохих журмын дагуу нэрээ дэвшүүлэн оролцох, улмаар сонгогдож төрийн энэхүү албан тушаалтан болохыг тус тус хэлнэ. Сонгууль гэдэг үгийг жирийн иргэнээс авахуулаад хуульчид, эрдэмтэд, улс төрчид андахгүй мэдэх боловч уг ойлголтын агуулга, мөн чанарыг нарийвчлан судлах нь онолын төдийгүй практикийн чухал ач холбогдолтой билээ. Энэ ойлголтын хэл зүйн утгыг Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар”-таа “депутат, хариуцлагатай албан тушаалтан, байгууллагын гишүүдийг олноороо хэлэлцэж шилэн томилох” гэж тайлбарлажээ. Улс төрийн утга зохиолд ч энэ утгаараа ойлгогдож хэвшжээ.

Сонгууль нь иргэдийн улс төрийн чухал эрхийн нэг болох сонгох, сонгогдох эрхийг хангах гол боломжийг

бий болгодог.

Сонгууль нь нийтийн засгийн байгууллагыг бүрдүүлэх гол арга хэрэгсэл юм. Парламент, төрийн тэргүүн, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг, зарим цөөхөн оронд шүүх, Засгийн газрыг сонгуулиар байгуулдаг. Ардчилсан оронд төрийн дээрх байгууллагыг бүрдүүлдэг сонгуулиас өөр арга байдаггүй байна.

Сонгууль улс төрийн амьдралын тухайн үеийн нөхцөл байдлыг илэрхийлдэг барометр (хэмжүүр) болдгоороо нийгэмд чухал үүрэгтэй. Сонгуулийн явцад улс төрийн хүчнүүдийн ашиг сонирхол, үзэл бодол ямар байгаа нь харагддаг төдийгүй тэдэнд ард түмний зүгээс тодорхой үнэлэлт өгч улс төрийн амьдралын цаашдын чиг хандлага тодорхойлж, улс төрийн удирдлагыг өөрийн үнэлэмжид нийцүүлэн солих боломжийг ард түмэнд олгодог.

Сонгуульд оролцох бүхий л эрхийг иргэдэд хуулиар олгодог боловч, амьдрал дээр бүх хүнийг сонгуульд оролцуулах боломж байдаггүй. Хуулиар зайлшгүй зарим хязгаарлалт тогтоодог.

Сонгуульд зөвхөн тодорхой насанд хүрсэн хүн оролцох ёстой. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9-д заасны дагуу сонгох эрхийг 18 наснаас эдлэх ба сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтоодог. Тухайлбал, Ерөнхийлөгчид 45, Улсын Их Хурлын гишүүнээр 25 нас хүрсэн иргэнийг сонгоно.

1992 онд дэлхийн 150 оронд явуулсан судалгаанаас (уг нь 186 орон хамрагдах ёстой байжээ) үзэхэд 109 улс 18 нас, Бразил, Куба, Иран, Никарагуад 16 нас, бусад цөөхөн улс 19-21 насанд хүрсэн иргэнд сонгох эрхийг олгожээ.

Дэлхийн ихэнх улсад, түүний дотор манай улс сонгох, сонгогдох эрхийг зөвхөн өөрийн улсын иргэнд эдлүүлдэг. Иргэдийн улс төрийн аливаа эрх, эрх чөлөө нь тэр улсын тусгаар тогтнол бүрэн эрхтэй холбоотой байдаг болохоор энэ нь ч зүйн хэрэг юм.

Эмнэлгийн дүгнэлт, шүүхийн шийдвэрээр ухаан солиотой болох нь нотлогдсон бол насанд хүрсэн ч гэсэн сонгуульд оролцох эрхгүйг хуулиар заасан юм. Өөрөөр хэлбэл, улс төрийн энэ чухал үйл ажиллагаанд өөрийгөө жолоодож, ухамсартайгаар хандаж чадах иргэн оролцох ёстой.

Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу хорих газар ял эдэлж байгаа иргэн сонгуульд оролцохгүй. Ийм практик олон оронд байдаг бөгөөд гэмт хэрэг үйлдсэний улмаас хүний салшгүй эрхээс бусад эрх, эрх чөлөөгөө хязгаарлуулсан байдаг болохоор сонгуулийн эрхийг ч мөн тэр хугацаагаар эдлэх боломжгүй болдог байна.

УЛС ОРНОО УДИРДАХАД ОРОЛЦОХ ЭРХ

“Хүн бүр улс орноо удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй.”

(Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 21 дүгээр зүйлийн 1 дэх заалт)

“Төрийн хэргийг явуулахад шууд болон чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрх эдлэнэ.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 25 дугаар зүйл (а) заалт)

“Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа

уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй.
(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт)

Хүн бүр нийгмийн гишүүн, ард түмний нэг эс учраас төр, нийгмийн амьдралд идэвхтэй байр суурь эзэлж, улсаа хөгжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулах боломжийг төр бүрдүүлэх ёстой. Иргэн энэ эрхээ өөрийн биеэр шууд, эсвэл тодорхой байгууллага албан тушаалтнаар төлөөлүүлэн хэрэгжүүлдэг. Иргэн төрийг удирдахад шууд оролцох дараах хэлбэрүүд байдаг.

- Парламент, ерөнхийлөгч, нутгийн удирдлагын байгууллагыг сонгоход оролцох
- Ард нийтийн санал асуулгад оролцох
- Хууль, төрийн чухал шийдвэрийг гаргахад саналаа өгөх
- Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны талаар санал, гомдол гаргах
- Төрийн алба хаших

Иргэн төрийг удирдахад оролцох төлөөллийн хэлбэр гэж тодорхой байгууллага тухайлбал, парламент, нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтан тухайлбал, ерөнхийлөгч, нутгийн удирдагчийг сонгож, өөрийн мандатыг шилжүүлэх замаар төрийн удирдлагыг хэрэгжүүлэхийг хэлнэ.

**ӨӨРИЙН ҮЗЭЛ БОДОЛТОЙ БАЙХ, ТҮҮНИЙГЭЭ
ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ
FREEDOM OF OPINION AND EXPRESSION**

“Хүн бүр чөлөөтэй бодож сэтгэх... эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 18 дугаар зүйл)

“Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй.”

“Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан агаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.”

“Энэ эрхэд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан агаар, бичгээр, эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар, эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.”

Энэ эрхийг бусдын нэр төрийг хүндэтгэх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах зорилгоор хязгаарлаж болно.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйл)

Хүн бүр ямар ч хорио саадгүйгээр өөрийн үзэл бодолтой байх түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх нь хүний бусад эрхийг хэрэгжүүлэх гол нөхцөл төдийгүй ардчилсан нийгмийн үндэс суурь болдог.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь аман, урлагийн, биеэр, улс төрийн байр суурь, өөрийн тайлбараар, хүний эрхийн тухай хэлэлцүүлэг, сонгууль, сэтгүүл зүй, хичээл, шашны зан үйл, арилжааны сурталчилгаа гэх мэт маш

олон төрлийн хэлбэрээр илэрхийлэх боломжтой байдаг. Эрхүүд харилцан уялдаа холбоотой байх шинжийн дагуу тус эрх чөлөө нь тайван замаар эвлэлдэн нэгдэх, хэвлэлийн эрх чөлөө, хувийн нууцтай байх, төрийн зүгээс шуудан харилцаа, хувийн өмчид хөндлөнгөөс халдахаас ангид байх эрх зэрэг олон эрхүүдтэй нягт уялдаа холбоотой. Үзэл бодол, итгэл үнэмшил нь хэвлэлийн болон академик түвшний буюу судалгаа шинжилгээний эрх чөлөөнөөс гадна шашны эрх чөлөөг давхар агуулдаг. Мөн төрийн алба хаах, санал өгөх, сонгох, сонгогдох эрхтэй холбогдох боломжтой.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь орчин үед дэлхийг хэрсэн аалзны шүлс буюу интернэтийн хэрэглээтэй уялдан хөгжин дэвшиж, мөн бэрхшээлтэй тулгарсаар байна. Дэлхий дээр олон нийтэд зориулсан интернэт үйлчилгээгүй улс орон маш цөөхөн болсон. Мэдээллийг боловсруулах, дахин бэлтгэх, түгээх үйл явц төсөөлөхийн аргагүй хурдтай явагдаж байна. Үүний жишээгээр компьютерын вирус, гинжин хэлбэртэй цахим шууданг нэрлэж болно. Мэдээллийн технологи нь олон улсын хүний эрх болон хүний амьдралд цөөнгүй бэрхшээлийг тулгасан. Хэргийн харьяалал тогтоох, интернэтээр дамжуулан арьс өнгөөр үзэн ядах, хүүхдийн бэлгийн мөлжлөгт турхирах, өдөөн хатгах, бодит амьдрал дээрх хүний эрхийн эсрэг чиглэсэн зүй бус үйлдлийн талаарх мэдээлэлд олон сая нэвтрэх боломжийг хаах, далдлах, устгах гэх мэт.

Тус эрх чөлөө нь бусад эрх эрх чөлөөнөөс ялгаатай зүйл нь босоо болон хөндлөн түвшинд үйлчилдэг. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь төрөөс болон бусад этгээдээс хувь хүнийг дур зоргын аливаа үйлдлээс хамгаалдаг. Улсууд үндэсний болон олон улсын хэм хэмжээгээр уг эрх чөлөөг сахин хамгаалж, зөрчигдсөн тохиолдолд

нөхөн сэргээх, хохирол барагдуулах үүрэг хүлээдэг. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулаагүй үндсэн хуультай улс цөөхөн бөгөөд мэдээлэл түгээх, хүмүүсийн хүсэл зоригийг илэрхийлэх, санаа бодлоо уралдуулах зэрэг чиг үүрэг гүйцэтгэдэг болно.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хүрээ хувьсан өөрчлөгдөж байна. Мэдээллийн технологийн эрин зуунд мэдээллийг хурдан, хялбар дамжуулахын зэрэгцээ олон нийтийн сүлжээгээр Их наймын уулзалт, Дэлхийн эдийн засгийн чуулган зэрэг арга хэмжээ болон тухайн улсын төрийн үйл ажиллагааг шүүмжлэх, эсэргүүцэх, үзэл бодлоо илэрхийлэх явдал төрөл бүрийн хэлбэрээр өргөжин тэлж байна. Мөн Номхон далайн жижиг улсуудыг онлайн орчинд бүрдсэн педофил бүлгэм, хүүхдийн порнограф мэдээллийн сангийн бааз болгон ашигласаар байна.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө нь хувь хүнийг бүрэн дүүрэн хөгжихөд чиглэсэн салгаж үл болох нөхцөл байдлыг бүрдүүлдэг. Ямар ч нийгэмд чухал бөгөөд чөлөөт, ардчилсан нийгмийн тулгын чулуу юм. Энэхүү хоёр эрх чөлөө нягт холбоотой төдийгүй үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь санаа бодлоо солилцох, хөгжүүлэх арга хэрэгслийн үүрэг гүйцэтгэдэг гэж тодорхойлох боломжтой. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахад амин судас болсон ил тод байдал, хариуцлагын зарчмыг бодит үйл хэрэг болгох чухал ач холбогдолтой.

ЧӨЛӨӨТЭЙ, ТАЙВАН ХУРАН ЦУГЛАХ ЭРХ RIGHT TO FREEDOM OF PEACEFUL ASSEMBLY

“Тайван хуран цуглах эрхийг хүлээн зөвшөөрнө.

Энэхүү эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, эсхүл бусдын эрх эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуулийн дагуу тогтоосноос өөр хязгаарлалт хийж болохгүй.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 21 дүгээр зүйл)

“...тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалт)

Тайван хуран цуглах гэдэг нь нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг алдагдуулахгүй, эмх замбараагүй байдал үүсгэхгүй, хвчирхийлэл халдлага, вймээн самуун дэгдээхгүй гэсэн санааг илэрхийлдэг. Энэ нь бид хврээлэн буй орчин тойронд болж буй аливаа шударга бус вйлдэлд санаа бодлоо ухаалаг, тайвнаар илэрхийлэх арга зам бөгөөд ингэснээр ойлголцол, дэмжлэгийг бий болгож чадна.

Чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрх нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хамт ардчилсан, нээлттэй нийгмийн цөм билээ. Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт зэрэг хүний эрхийн үндсэн гэрээнүүдээс гадна бүс нутгийн хүний эрхийн гэрээ, улсуудын үндсэн хуульд тодорхой заасан байдаг. Хувь хүмүүс тодорхой үзэл бодол, үнэт зүйлээрээ нийлэн, нийтлэг ашиг сонирхлоо хамтын байдлаар илэрхийлэх, шаардах, хамгаалахад чиглэсэн байдаг тул хүний эрх, улс төрийн эрх чөлөө, иргэний эрх чөлөө гэж нэгэн зэрэг хүлээн зөвшөөрдөг. “Эрх

чөлөөний өргөө” хэмээх төрийн бус байгууллагын 2008 оны тайланд чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхийг үл ойшоосоор байгаа бөгөөд хэрцгий төрийн улмаас уг эрхийг хязгаарлах, олон улсын хүний эрхийн стандартуудыг зөрчих явдал өсөн нэмэгдсээр байна.

Дэлхий дахин Араб, Ойрхи Дорнод дахь 2011 оны бослогуудад мэдээлэл олж авах, хуваалцах зориулалттай онлайн тоон хэмжээст арга хэрэгсэл өргөнөөр ашигласныг харсан билээ. Эдгээр хөдөлгөөнөөр олж авсан хүмүүсийн хүч чадал, арга хэрэгсэлтэй зэрэгцэн цөөнгүй тоталитар дэглэм нуран унасан. Үүнээс чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхийг интернэтэд, мэдээллийн харилцаа холбооны технологиудыг ашиглах замаар хэрхэн эдэлсэн болохыг анхаарах нь чухал. Хэдийгээр интернэт, мэдээллийн харилцаа холбооны технологиуд эрхээ эдлэх шинэ боломжийг олгож байгаа ч дарамтлах арга хэрэгсэл болгон ашиглах боломж бий.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар заасан эрх нь бусад олон улсын хүний эрхийн гэрээнд заасны дагуу маш олон төрлийн байдлаар эвлэлдэн нэгдэх, хуран цуглах арга замыг хамгаалсан бөгөөд үүнийг олон нийтийн газар (нийтийн хурдны зам, явган зам, цэцэрлэгт хүрээлэн, нийтийн эзэмшлийн газар гэх мэт) гэсэн уламжлалт ойлголтоор тодорхойлж болохгүй. Мөн хүмүүс уулзаж, санаа бодол, мэдээлэл солилцох, мэтгэлцэх онлайн орон зайг ч хамруулдаг. Уг эрхийг гагцхүү хуульд заасны дагуу үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журам, бусдын эрхийг хамгаалахын тулд л хязгаарлах боломжтой. Гэхдээ интернэт дэх чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрх нь харилцан адилгүй хэлбэртэй тул тэр бүр

олон улсын хүний эрхийн стандарттай нийцдэггүй. Иймээс тодорхой цахим хуудас, онлайн арга хэрэгсэлд шүүлтүүр хийх, хаах, интернэт хэрэглэгчийн нэвтрэх эрхийг цуцлах зэрэг байдлаар хязгаарлах жишээтэй. Харин хуульд заасны дагуу гол төлөв оюуны өмчийг хамгаалах, хүүхдийн порнограф мэдээллээс урьдчилан сэргийлэх зорилготой байдаг.

Түүнчлэн АНУ-ын Төлөөлөгчдийн танхимын гишүүн Ламар С.Смитийн санаачилсан Зохиогчийн эрхийг онлайнаар зөрчих явдлыг зогсоох тухай хуулийн төсөл, Эдийн засгийн бүтээлч байдалд онлайнаар бодитой аюул заналхийлэх, оюуны өмчийг хулгайлахаас урьдчилан сэргийлэх тухай хууль зэрэг эрх зүйн эх сурвалжийн эсрэг дэлхийн дахины хэмжээнд үй оlnыг хамарсан эсэргүүцэлд бодит ертөнц дээрх шиг заавал төлөөлөл байх шаардлагагүй болсон онцлогтой. Дээрх пактын 22 дугаар зүйлд заасны дагуу гагцхүү тайван замаар хуран цугласан бол хамгаалдаг.

ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ RIGHT TO FREEDOM OF ASSOCIATION

“Хүн бүр бусадтай эвлэлдэн нэгдэх, түүний дотор өөрийн эрх ашгийг хамгаалах үүднээс үйлдвэрчний эвлэл байгуулах буюу түүнд элсэх эрхтэй.”

“Энэ эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, эсхүл бусдын эрх эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуулийн дагуу тогтоосноос өөр хязгаарлалт хийж болохгүй. Зэвсэгт хүчний болон цагдаагийн бүрэлдэхүүнд багтах этгээдэд

энэхүү эрхийг хэрэгжүүлэхэд хууль ёсны хязгаарлалт тогтооход энэ зүйл саад болохгүй.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 22 дугаар зүйлийн 1.2 дахь заалт)

“...тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалт)

Чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрх нь улс төрийн нам байгуулах, ажлын байрандаа хамтын шинжтэй зохион байгуулалт хийх эрхтэй холбоотой. Нийгмийн хаана ч энэ хоёр эрхийг эдлэх ба чөлөөт байдлаар эвлэлдэн нэгдэхийг хүлээн зөвшөөрнө.

Эвлэлдэн нэгдэх эрх нь иргэдийн сайн дурын үндсэн дээр өөрийн итгэл үнэмшил, эрх ашиг, үзэл бодлын нийтлэг сонирхолд нийцсэн бөгөөд нам, эвсэл, холбоо, эвлэл, зөвлөл, нийгэмлэг гэх мэт янз бүрийн нэртэй нэгдэл, байгууллагыг үүсгэн байгуулах, элсэн орох хэлбэрээр илэрдэг.

Иргэдийн эвлэлдэн нэгдсэн байгууллагууд нь ямар нэртэй байснаас үл хамааран эцсийн зорилго нь улс орны нийгэм, эдийн засгийн амьдралд идэвхитэй оролцох буюу эсхүл тухайн эвлэлдэн нэгдсэн хамт олон, хэсэг бүлэглэлийн ашиг сонирхлыг хамгаалахад оршино.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхийг боломж олгодог бол эвлэлдэн нэгдэхдээ нийтийн санаа бодолд хүргэхийг зорьж байгаа ойлголтоо сайтар боловсруулах, хүргэх буюу мэдээлэл авах, хайх, түгээх эрхийг эдэлдэг. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн хамгаалагчдын тухай 1998 оны

тунхаглалаар хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих хувь хүмүүсийн ур чадварын ач холбогдлыг хүлээн зөвшөөрсөн билээ. Үүнтэй уялдан интернэт нь хүний эрхийн хамгаалагчдын үйл хэрэгт чухал хэрэгсэл болж, олон улсын хүний эрхийн стандартуудыг үндэслэн төрийг шахах боломжийг олгож байна.

Тайван эсэргүүцэлд оролцох нь чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, төрийн үйл хэрэгт оролцох эрхээ эдлэх чухал хэлбэрт тооцож болно. Мөн иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, соёлын эрхээ бүрэн дүүрэн биелүүлэхэд хувь нэмэр оруулах боломжтой боловч олон нийтийн тайван эсэргүүцэлд оролцохдоо сайн дурын үндсэн дээр ямарваа нэгэн албадлагагүй байх ёстой. Гэмтэх, бэртэх, зодуулах, дур зоргоор баривчлах, хорих, эрүү шүүлт тулгах, амь насаа алдах, хүчээр сураггүй алга болох вий гэж айлгүй олон нийтийн эсэргүүцлээр дамжуулан, өөрт таагүй санагдсан зүйлийг буюу шаардлагаа тайван замаар илэрхийлэх боломжийг хүн бүрт олгох шаардлагатай. Төрийн зүгээс тайван эсэргүүцлийг аюул занал гэхээс илүүтэйгээр түүний учир шалтгааныг нээлттэй, татан оролцуулсан байдлаар үндэслэлтэй харилцан тохиролцох замаар шийдвэрлэхэд анхаарна. Энэхүү тайван замаар тэмцэгч хүмүүс болон холбогдох эрх мэдэл бүхий байгууллага гэсэн хоёр талын харилцаанд хүний эрхийн үндэсний байгууллага, эвсэл, хөдөлгөөн, төрийн бус байгууллага зэрэг иргэний нийгмийн төлөөлөл хөндлөнгөөс оролцон, цаашдын үйл ажиллагааг хялбаршуулахад чухал үүрэг гүйцэтгэж болно.

Харин төрийн зүгээс тайван эсэргүүцлийн үед ямагт хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах, ялангуяа

шүүхээс гадуур, дур зоргоор баривчлах, хорих, хүчээр сураггүй алга болгох, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий харилцах, шийтгэх, эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчих зэрэг хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хариуцлага хүлээхийн зэрэгцээ аль болох хүч хэрэглэхээс татгалзах, зайлшгүй тохиолдолд хэтрүүлсэн эсвэл ялгаварласан байдлаар хүч хэрэглэхгүй байхад онцгой анхаарах ёстой.

Чөлөөтэй үг хэлэх тухай ойлголтын үндсийг XVII зуунаас буюу 1688 оны Английн Эрхийн жагсаалт зэрэг баримт бичигт парламентын үйл ажиллагааны хүрээнд хууль тогтоогчид чөлөөтэй үг хэлэх боломжийг олгосон. Иймээс парламентын мэтгэлцээний үеэр хэлсэн ямар нэгэн зүйлээсээ болж парламентын гишүүнийг эгүүлэн татах боломжгүй болсон юм. Энэ туршлагыг өнөөдөр олон орны хууль тогтоох байгууллага бодлого болгон ашиглаж байна. XVIII зууны үед Скандинавын орнуудад үг хэлэх эрх чөлөөг хуулиар хамгаалж, зууны сүүлээр Франц, АНУ-ын хуульд тусгалаа олсон. Жон Стюарт Милл үг хэлэх эрх чөлөөг сонгодог байдлаар ухаалаг тайлбарласан нь одоог хүртэл АНУ-ын шүүхүүдэд эшлэсээр байгаа билээ.

УХРАХ ЭРХ (ҮҮРГЭЭС ТАТГАЛЗАХ ЭРХ) RIGHT TO DEROGATION

"Улс үндэстний амьдралд аюул занал тулгарч, энэ тухай албан ёсоор зарлаж нийтийг хамарсан онц байдал тогтоосон үед энэхүү Пактад оролцогч улс уг Пактаар хүлээсэн үүргээсээ тухайн нөхцөл байдлын хурцадтал шинжид дүйх хэмжээгээр ухарсан арга хэмжээ авч болох бөгөөд тэр нь олон

улсын эрх зүйгээр хүлээсэн бусад үүрэгт нь харшлах ёсгүйгээс гадна арьс үндэс, хүйс, хэл, шашин шүтлэг, нийгмийн гарлаар алагчилах явдалд хүргэхгүй байх ёстой.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 4 дүгээр зүйлийн 1 дэх заалт)

Онц байдлын үед, тодруулбал, дайн байлдаан болон нийгмийн аюулгүй байдалд аюул занал бодитойгоор оршиж буй нөхцөлд улс орнууд хүний эрхийн талаар хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй байдал олонтаа үүсдэг. Эрх зүйн хэм хэмжээнээс хазайх (татгалзах) асуудлыг ийнхүү нэрлэх бөгөөд хүний эрхийн конвенциудын онц байдлын зүйл заалтад хамааруулан авч үздэг.

Хүний амьд явах, эрүү шүүлтээс ангид байх, чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх зэрэг салшгүй эрхүүдийг ямар ч үед хязгаарлаж болохгүй.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Улс үндэстний амьдралд аюул занал тулгарч, энэ тухай албан ёсоор зарлаж нийтийг хамарсан онц байдал тогтоосон үед энэхүү Пактад оролцогч улс уг Пактаар хүлээсэн үүргээсээ тухайн нөхцөл байдлын хурцадмал шинжид дүйх хэмжээгээр ухарсан арга хэмжээ авч болох...” тухай заасан нь Европын Хүний эрх, суурь эрх чөлөөг хамгаалах тухай конвенцийн 17 дугаар зүйл, Америкийн улсуудын Хүний эрхийн тухай конвенцийн 27 дугаар зүйлийн үндэс болсон.

Хүний эрхийн хорооны зүгээс дээрх 4 дүгээр зүйлийг хүний эрхийг хамгаалах тогтолцоонд “маш чухал ач холбогдол”-той гэж тус хорооны 29 дүгээр Ерөнхий Зөвлөмжийн 1 дэх догол мөрт тодорхойлсон байна.

Цөөнгүй тооны олон улсын болон бүс нутгийн шинжтэй олон улсын гэрээнд зэвсэгт мөргөлдөөн, эсвэл нийтийг хамарсан бусад онцгой байдлын үед үүргээс татгалзахыг зөвшөөрдөг. Тухайн холбогдох нөхцөл байдал нь маш ноцтой шинжийг агуулахын зэрэгцээ олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс анхаарч энх тайван тогтоох, аюулгүй байдлыг бий болгоход чиглэсэн асуудал байх хэрэгтэй тул үндэсний хэмжээний онцгой байдал бүрийг тооцдоггүй. Аливаа үүргээс татгалзах явдал нь тухайн нөхцөл байдлын “хурцадмал шинж”-ээр хязгаарлагдах ба зорилгодоо хүрэхийн тулд 29 дүгээр Ерөнхий Зөвлөмжийн 4 дэх догол мөрт заасны дагуу “үргэлжлэх хугацаа, газар зүйн хамрах хүрээ, бодит хэмжээ” гэсэн шаардлагыг хангах ёстой. Үүргээс татгалзах хууль ёсны эрхээ эдлэхдээ тухайн олон улсын гэрээнд заасан хязгаарлалтыг мөрддөг.

Үүргээс татгалзах эрхийг олон улсын ямар ч гэрээнд бүх талаар хүлээн зөвшөөрдөггүй онцлогтой. Жишээлбэл, амьд явах эрх, эрүү шүүлт, боолчлол, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөнөөс эсвэл буцаан хэрэглэсэн эрүүгийн хуулийг хэрэглэхгүй байхаас татгалзаж болохгүй. Хэрэв ямар нэгэн түрэмгийлэл гарлаа гэж бодоход Женевийн болон Гаагын конвенцуудыг хүмүүнлэгийн эрх зүйн хэм хэмжээний нэгэн адил удирдлага болгож байлдагч, энгийн иргэдийн эрхүүдийг өргөжүүлэх болно. Хүний эрхийн эрх зүйд татгалзаж үл болох эрхүүдийн суурийг тавихдаа эдгээр эрхүүд бусад эрхүүдээс ямар нэгэн байдлаар илүү гэж тодорхойлон, шатлан захирсан шинжийг тусгасан гэж зарим судлаачид үздэг. Хүний эрхийн хорооноос гаргасан 29 дүгээр зөвлөмжийн

дагуу Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 4 дүгээр зүйлд заасан татгалзаж үл болох эрхүүдийн жагсаалтыг өргөжүүлсэн. Тус хорооны зүгээс эрх чөлөө нь хязгаарлагдсан хүн бүрийг хүндэтгэн, хүнлэг харьцах, барьцаанд авах, хулгайлах, гэр бүлийнхэнд нь мэдэгдэлгүйгээр хорихгүй байх, цөөнхийн эрхийн хувьд салшгүй гэж болох төрлөөр устгахгүй, ялгаварлан гадуурхахгүй байх, нутаг заах буюу хүн амыг тодорхой газар нутагт хүчээр шилжүүлэхгүй байх, үндэсний эсвэл угсаатны шинжтэй, шашнаас үүдэлтэй үзэн ядахыг дэмжих буюу сайшаахгүй байх нь олон улсын эрх зүйн татгалзаж болшгүй зарчмуудад тулгуурласан тул мөн чанарын хувьд татгалзаж болохгүй гэж дээрх зөвлөмжийн 13 дахь догол мөрт заажээ.

Тодорхой эрхүүдээс татгалзаж болохгүй бодитой үндэслэл бас бий. Жишээлбэл, эрх зүйд захирагдах ёс (rule of law) нь ямар нэг нийтийг хамарсан онцгой нөхцлөөс үл хамааран ухрах үйлдлийг тусгайлан тогтоосон байх ёстой. Түүнчлэн үзэл бодлын эрх чөлөө зэрэг тодорхой эрхүүдийг чухамдаа хязгаарлах боломжгүй. Бусад тохиолдолд хууль ёсны төрийн хяналт нь эрхүүдийг эдлэхэд шууд нөлөөлөхгүй ба төрийн эрх мэдэлд аюул заналхийлсэн буюу эргэлт гарсан учраас үүргээс татгалзсан гэж зөвтгөж болохгүй. Ухрах эрхийн тухай заалтгүй олон улсын гэрээний нэг бол Африкийн Хүний болон ард түмний эрхийн тухай Харти юм. Үүнийг Африкийн улс орнуудад болсон ХХ зууны түүхэн үйл явдалтай холбон үзэх боломжтой төдийгүй эдгээр нөхцөл байдлыг олон улсын бусад хүний эрхийн гэрээнд заасан үүргээс татгалзах заалтаар зохицуулж болно. Африк тив хүний эрхийн хуваагдашгүй байдлыг хүлээн зөвшөөрсөн

учраас улсуудын хүлээх хариуцлага нэмэгдсэн байна. Хүний болон ард түмний эрхийн Африкийн шүүх байгуулснаар одоо хүртэл нүүр тулгарч байгаа нийтийг хамарсан онцгой байдалд зарим талаар уян хатан хандах нөхцөл бүрджээ.

Хүний эрхийн хорооны зүгээс өөрийн 5 дугаар Ерөнхий Зөвлөмждөө Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 4 дүгээр зүйлийг хүлээн зөвшөөрч, улмаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар уламжлан мэдэгдэх, ухрах болсон тухайн нөхцөл байдлын талаар нээлттэй байхыг улсуудаас шаардсан нь нэлээдгүй улсын хувьд эсэргүүцэлтэй тулгарсан байна. Хүний эрхийн хорооны зааснаар, бүх ухрах үйлдэлдээ тухайн улсын зүгээс тайлбар бүхий илтгэл илгээж, Хороо үр нөлөөтэй эсэхийг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх ёстой. Тус 4 дүгээр зүйлийг иш татсан нь тухайн улсын илтгэл илгээх үүргээс чөлөөлөхгүй.

Ухрах эрх нь эцэс төгсгөлгүй ойлголт биш. Улсууд аливаа ухрах үйлдлээ дахин нягталж, үргэлжлүүлэх хэрэгцээ байгааг тогтмол үнэлэх хэрэгтэй. Зарим улс Үндсэн хуульдаа дээрх хяналтын тухай заалтыг тусгасан байдаг. Улс орны зарим хэсэгт, эсвэл бүхэлдээ, бүх хүмүүст, эсвэл зарим хүнд нөлөөлсөн тодорхой нөхцөл байдлын хүрээнд ч хүндэтгэлтэйгээр ухрах эрхээ эдэлж болно. Жишээлбэл, алан хядах үйл ажиллагааны аюул заналыг урьдчилан илрүүлсэн тохиолдолд сэжигтнийг баривчлахдаа халдашгүй байх эрхийн олон салшгүй хэсгийг эдлүүлэхгүй ухрахыг хичээдэг. Гэхдээ энэ тохиолдолд ч гэсэн хувь хүний халдашгүй байх эрхийг хүндэтгэж, дур зоргоор баривчлахгүй байх, хууль ёсны дагуу хүний эрхийг хязгаарлаж, хорьж байгааг хөндлөнгөөс хянаж байх

- ХҮНИЙ ЭРХИЙН ТОВЧ ТАЙЛБАР -

ёстой. Аливаа ухрах үйлдлийг ямар нэгэн байдлаар үйлдэхэд олон улсын, эсвэл бүс нутгийн шинжтэй этгээд мониторинг хийх, хөндлөнгийн хяналт тавих бөгөөд бүх олон улсын гэрээнд ухрах үйлдлийг зөвшөөрөөгүй болохыг анхаарвал зохино.

- III -

**ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ,
СОЁЛЫН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ
ECONOMIC, SOCIAL AND CULTURAL RIGHTS**

**АДИЛ ХӨДӨЛМӨРТ АДИЛ ХЭМЖЭЭНИЙ
ШАН ХӨЛС АВАХ ЭРХ
RIGHT TO EQUAL PAY FOR EQUAL WORK**

“Хүн бүр ямар ч алагчлалгүйгээр адил хэмжээний хөдөлмөрт адил хэмжээний шан хөлс авах эрхтэй.”
(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 23 дугаар зүйлийн 2 дахь заалт)

“Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүр хөдөлмөрийн шударга, таатай нөхцлөөр хангагдах эрхийг хүлээн зөвшөөрөх бөгөөд (а) бүх хөдөлмөр эрхлэгчдэд цалин хөлсийг шударгаар тогтоох, аливаа ялгаваргүйгээр адил үнэлгээтэй хөдөлмөрт тэгш цалин хөлс олгох, чингэхдээ, тухайлбал, эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс доргүй хөдөлмөрлөх нөхцлийг бий болгох, тэдний адил хөдөлмөрт нь тэгш цалин хөлс олгоно.”

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйлийн 7.a.i болон 7.a.ii заалт)

Адил үр дүн бүхий ажилд адил хэмжээний цалин хөлс авах нь хөдөлмөрийн харилцааны суурь эрх бөгөөд олон улсын болон үндэсний эрх зүйгээр хүлээн зөвшөөрч хэрэгжүүлдэг. Энэхүү эрх нь “аливаа цалин хөлсний хэмжээ, түвшин нь ажиллагчийн хүйс болон хувь хүний бусад шинж чанараас шалтгаалахгүй,

харин хийж гүйцэтгэсэн ажлын бодит үнэлгээнд тулгуурлана” гэсэн зарчмыг илэрхийлдэг.

Адил ажил мэргэжил, салбар, ур чадварын түвшинд хэн нэгний цалин хөлс нөгөө хүнийхээс доогуур байх нь цалин хөлсний ялгаварлан гадуурхал юм. Өөрөөр хэлбэл, энэхүү эрх нь хөдөлмөрийн харилцаанд нас, хүйс, хөгжлийн бэрхшээл зэргээр ялгаварлан гадуурхах зөрчлийг шийдвэрлэхэд чиглэдэг. Адил хөдөлмөрт адил хэмжээний цалин хөлс авах эрхийг Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын 1919 оны Конвенцэд анх хүлээн зөвшөөрсөн бөгөөд улмаар уг асуудлыг хөндсөн тусгай баримт бичиг болох Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын Тэгш шан хөлсний тухай 1951 оны 100 дугаар Конвенц, 90 дүгээр Зөвлөмж тус тус батлагдан хэрэгжиж байна. Мөн цагийн ажлын тухай 1994 оны 175 дугаар Конвенц, 182 дугаар Зөвлөмж, Жендэрийн тэгш байдал, тэгш цалин хөлс, эхчүүдийг хамгаалах тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 2004 оны Тогтоол зэрэг нь энэхүү эрхийг хангах олон улсын эрх зүйн баталгааг бүрдүүлж байна.

Статистик судалгаанаас харахад хүйсийн хооронд цалингийн ихээхэн ялгаа байдаг нь тогтоогджээ. Гэвч олонх улс оронд цалингийн ялгааг хэмжин тодорхойлох статистик аргачлал байдаггүй байна. Тиймээс адил хөдөлмөрт адил цалин хөлс олгох нь төр болон нийгмийн түншүүдийн хамтран хүлээх хариуцлага юм. Иймд адил цалин хөлсний зарчмыг хэрэгжүүлэхийн тулд ажлын байранд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгодог. Үүнд:

- Ажлын ангилал, цалингийн сүлжээ нь тухайн ажлыг хийж буй хүний хувийн шинж байдлаас үл шалтгаалсан, бодит шалгуур дээр тулгуурласан байх;
- Цалин хөлсийг тогтоохдоо цалин, шагналын сүлжээ,

эрүүл мэндийн даатгал болон бусад тэтгэмжийг шалгуур болгох, өөр шаардлагагүй шинж байдал заахгүй байх;

- Цалин хөлсийг тэгш бусаар олгож буй тохиолдол бүрт залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

- Ажилтнууд, ялангуяа удирдах ажилтнуудад хэн уг ажлыг хийж байгаад биш, харин хийж буй ажлын үнэ цэнэд суурилан цалин хөлс олгох талаар ойлголт өгөх;

- Цагаар ажиллагчдад ажлын бүтэн өдрөөр ажиллагчидтай адил тэгш цалин хөлсийг ажилласан цагт нь дүйцүүлэн олгох зэрэг болно.

АЖИЛ ХАЯХ ЭРХ RIGHT TO STRIKE

“... ажил хаях эрхтэй бөгөөд түүнийгээ тухайн улсын хуульд нийцүүлэн эдлэнэ.”

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 8 дугаар зүйлийн 1(d) заалт)

Ажил хаях эрх нь үйлдвэрчний эвлэлийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн эрхийн нэг бөгөөд үндэсний болон олон улсын хөдөлмөрийн тухай хууль тогтоомжоор байгууллага, бүлгийн төлөөлөгчдийн ажил хаях эрхийг баталгаажуулсан байдаг.

Ажил хаях эрх нь хамт олноороо буюу бусадтай хамтран үзэл бодлоо илэрхийлэх эрхийн нэг хэлбэр хэмээн үздэг байна. Нөгөө талаас энэ нь хөдөлмөрийн хамтын маргаан шийдвэрлэх арга хэрэгсэл гэж үздэг. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд “ажил хаялт” гэж хөдөлмөрийн хамтын маргааныг шийдвэрлэх зорилгоор ажилтнаас үүрэгт ажлаа сайн дурын үндсэн дээр тодорхой хугацаагаар бүрэн буюу

хэсэгчлэн зогсоохыг хэлнэ гэж тодорхойлсон байдаг. Ажил хаях эрхийн талаар Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактаас гадна Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 87 дугаар конвенц, 1957 оны Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенц болон 1951 оны Сайн дурын эвлэрүүлэх ажиллагаа болон арбитрийн тухай 92-р зөвлөмжид тус тус заасан байдаг. 105 дугаар конвенцийн 1 дүгээр зүйлд ажил хаялтад оролцсоных нь төлөө ажилтнаар бүх төрлийн албадан хөдөлмөр хийлгэхийг хориглосон байна.

Монгол Улсын хувьд Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.9-т хууль тогтоомжид заасан журмаар жагсаал цуглаан, ажил хаялт зохион байгуулах эрхийг баталгаажуулж өгсөн байна. Ажил хаялтыг зохион байгуулах нөхцөл, журмыг Хөдөлмөрийн тухай хуулийн 119-124 дүгээр зүйлүүдээр зохицуулж ажил хаях шийдвэр гаргах, хугацаа, оролцох хүн, ажил хаялтыг зогсоох тухай тодорхой заасан байдаг.

Ажил хаях эрхээ эдлэхийн тулд хамтын шийдвэр гаргах шаардлагатай. Үүнд:

- Ажил хаях тухай шийдвэрийг ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагын гишүүдийн буюу нийт ажилтны хурлаас гаргана.

- Хуралд оролцогчдын олонхи (талаас илүү) нь ажил хаяхыг дэмжсэн бол ажил хаялт зарлаж болно.

Ажил хаях шийдвэртээ дараах асуудлыг заавал тусгах зарчмыг баримталдаг. Үүнд:

- ажил хаяхад хүргэсэн санал зөрүүтэй асуудал;

- ажил хаялт эхлэх он, сар, өдөр, цаг, ажил хаялтын үргэлжлэх хугацаа, оролцох хүний урьдчилсан тоо;

- ажил хаялтыг зохион байгуулж удирдах этгээд,

маргаан шийдвэрлэхэд оролцох төлөөлөгчдийн бүрэлдэхүүн;

- ажил хаялт зохион байгуулах үед хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон ажлын жагсаалт зэрэг болно.

Ажил хаялт үргэлжилж байх үед талууд хөдөлмөрийн хамтын маргааныг эвлэрүүлж зохицуулах арга хэмжээ авах үүрэгтэй. Ажил хаялтыг зохион байгуулсан буюу ажлын байрыг түр хаасан тал эдгээр арга хэмжээг бэлтгэх болон үргэлжлэх хугацаанд нийгмийн дэг журам, хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдал, эд хөрөнгө хамгаалах ажиллагааг холбогдох үүрэг бүхий төрийн байгууллагын туслалцаатай хийхээр зохицуулдаг.

Түүнчлэн ажил хаялтад оролцогсдын эрхийг хамгаалах зорилгоор “Хөдөлмөрийн хамтын маргаан шийдвэрлэхэд оролцсон ажилтны ажлын байранд гаднаас ажилтан авч ажиллуулсан, хэлэлцээ хийхэд оролцсон ажилтны төлөөлөгчдөд сахилгын шийтгэл ногдуулсан, ажлаас нь өөрчилсөн, халсан албан тушаалтанд хариуцлага тооцдог механизмууд байдаг. Ажил хаях эрхийг зэвсэгт хүчин, цагдаагийн байгууллагын ажилтан, төрийн тодорхой албан хаагч болон тусгай үйлчилгээний ажилтнуудын хувьд хязгаарлаж болохыг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 87 дугаар конвенцид заасан байдаг. Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлд “Батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах, нийгмийн дэг журам сахиулах үүрэг бүхий байгууллагад ажил хаялт зохион байгуулахыг хориглоно.” гэжээ. Цахилгаан, дулааны эрчим хүч, нийтийн усан хангамж, хотын нийтийн тээвэр, олон улс, хот хоорондын болон хотын цахилгаан холбоо, төмөр замын хөдөлгөөний албаны аж ахуйн нэгж, байгууллага ажил хаях нь улс

орны аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг хохироох тул тэдгээр байгууллагын ажилтан, албан хаагчийн ажил хаях эрхийг хязгаарладаг байна.

**АЖЛЫН ЦАГАА ЗОХИСТОЙГООР
ТОГТООЛГОХ ЭРХ
RIGHT TO REASONABLE LIMITATION OF WORKING HOURS**

“Хүн бүр ажлын цагаа зохистойгоор хязгаарлуулах, цалинтай ээлжийн амралт эдлэх эрхийг оролцуулан амрах, зав чөлөөтэй байх эрхтэй.”
(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 24 дүгээр зүйл)

“амрах, зав чөлөөтэй байх, ажлын цагийг зохистойгоор хязгаарлах, ээлжийн амралтыг цалин хөлстэйгээр эдлүүлэх, баярын өдөрт цалин хөлс олгохыг хатаарна”
(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйлийн 7(d) заалт)

Ажил хөдөлмөр цаг хугацаагаар хэмжигддэг. Тухайн хүний хөдөлмөрлөсөн цагийг ажлын өдөр, ажлын цаг гэж нэрлэнэ. Ажиллагсдын амьдралд ихээхэн нөлөө үзүүлэх ажлын нөхцлийн нэг элемент бол ажлын цаг юм. Ажлын цагийн үргэлжлэх хугацаанд хөдөлмөрийн эрчимжилт, үйлдвэрлэлийн технологи, шат дамжлага, ажилгүйдлийн түвшин зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж байдаг. Ажлын цагийн үргэлжлэл хэдийгээр олон янзын хэмжигдэхүүнтэй боловч ажлын цаг хязгаартай байх нь ажиллагсдын гол эрх юм. Тиймээс ажлын цагийн хэмжээ нь ямагт Олон улсын хөдөлмөрийн байгууллагын анхаарах гол асуудал байсаар ирсэн билээ. Ажлын цагийн хязгаарыг долоо хоногт 48 цаг,

өдөрт 8 цаг байхаар Ажлын цагийн (Үйлдвэрлэл) тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1 дүгээр конвенцид (1919) анх тогтоосон байдаг. Улмаар Ажлын цагийн (Арилжаа ба оффис) тухай 1930 оны 30 дугаар Конвенц, Ажлын дөчин цагтай долоо хоногийн тухай 1935 оны 47 дугаар Конвенц, Ажлын цагийг хорогдуулах тухай 1962 оны 116 дугаар Конвенциор өнөөгийн хөдөлмөрийн стандартыг тогтоон долоо хоногийн ажлын цагийг дөч болгосон байна.

Аливаа ажилтан нь хоногийн 24 цагийн турш ажиллах бололцоогүй. Учир нь унтаж амрах, хоол унд идэх зэрэг хөдөлмөрлөх чадвараа нөхөн сэргээх зайлшгүй шаардлагатай тул түүний үргэлжлэх дээд хязгаарыг тодорхойлдог. Мөн ажиллах цаг хязгаартай байх нь эмэгтэй, эрэгтэй хүмүүст гэр орны болон асран халамжлах ажилд цаг зарцуулах боломж олгодог тул хүйсийн тэгш байдлыг хангах нэгэн арга хэрэгсэл гэж үздэг.

Ихэнх улс орнууд нэг өдрийн болон 7 хоногийн ажлын үргэлжлэх хугацааг хязгаарлаж, нийтээр амрах амралтын болон баяр ёслолын өдрүүд, жил бүрийн ээлжийн амралтыг тогтоож өгдөг. Үүний адилаар Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулиар долоо хоногийн ажлын цагийг 40 хүртэл, ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг, ажлын дараалсан хоёр өдрийн хоорондох тасралтгүй амралт нь 12 цагаас багагүй байхаар, долоо хоногийн бямба, ням гаригт нийтээр амрахаар тогтоосон байна. Шөнийн болон амралтын өдрүүдэд ажиллуулахыг аль болох хязгаарлах бодлого баримталж, жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлэх зарчмыг хөдөлмөрийн харилцаанд мөрдөж байна.

Гэр бүлийн үүрэг хариуцлагыг анхаарч тооцоогүй ажлын цагийн хуваарь нь гэр бүлтэй ажиллагчдыг

ажлын байран дахь үйл ажиллагаанд оролцоход нь садаа болж, улмаар ажил мэргэжилдээ өсч хөгжих боломжийг нь хаадгаараа шууд бус ялгаварлалын шинжийг агуулдаг.

АМРАХ, ЗАВ ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ ЭРХ **RIGHT TO REST, LEISURE**

“Хүн бүр ажлын цагаа зохистойгоор хязгаарлуулах, цалинтай ээлжийн амралт эдлэх эрхийг оролцуулан амрах, зав чөлөөтэй байх эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 24 дүгээр зүйл)

“...амрах, зав чөлөөтэй байх...”

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйлийн 7(d) заалт)

“... амрах .. эрхтэй.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт)

Аливаа хөдөлмөр эрхэлж буй хүн бүрийн ажлын цагийг хязгаарлаж, үр хүүхэд, гэр бүлийн гишүүддээ анхаарал халамж тавих, өөрийгөө хөгжүүлэх, эрүүл мэндээ хамгаалах боломж олгох зорилгоор чөлөөт цагийг бий болгож, эдлүүлэхийг амрах эрх гэж ойлгоно. Ихэнх улс орнууд нэг өдрийн болон 7 хоногийн ажлын үргэлжлэх хугацааг хязгаарлаж, нийтээр амрах амралтын болон баяр ёслолын өдрүүд, жил бүрийн ээлжийн амралтыг тогтоож өгдөг.

Монгол Улсын хувьд амрах, зав чөлөөтэй байх эрхийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгаж өгсөн байдаг. Хөдөлмөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу хамтын гэрээгээр ажил, амралтын цагийн

горим тогтоохоор заалт байдаг. Хөдөлмөрийн тухай хуулиар долоо хоногийн ажлын цагийг 40 хүртэл, ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг, ажлын дараалсан хоёр өдрийн хоорондох тасралтгүй амралт нь 12 цагаас багагүй байхаар, долоо хоногийн бямба, ням гаригт нийтээр амрахаар тогтоосон. Шөнийн болон амралтын өдрүүдэд ажиллуулахыг аль болох хязгаарлах бодлого баримталж, жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлж, ээлжийн амралтын үндсэн хугацаа нь 15 ажлын өдөр, 18 насанд хүрээгүй, хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байхаар тогтоосон. Хөдөлмөрчин хүний эрхийг хамгаалах зорилгоор хөдөлмөрийн харилцаанд олон төрлийн зохицуулалт, эрхийн хамгаалалт хийж өгсөн байдгийн нэг нь ээлжийн амралтыг цалин хөлстэйгээр эдлүүлэх, баяр ёслолын өдөрт цалин хөлс олгох асуудал бөгөөд энэ нь бусад олон эрхийн хамт хүний эрхийн баримт бичгүүдэд тусгагдаж баталгаажсан байдаг.

Ажлын цагийн тухай 1919 оны 1 дүгээр Конвенц, Долоо хоногийн амралтын (Үйлдвэрлэл) тухай 1921 оны 14 дүгээр Конвенц, Ажлын цагийн (Арилжаа ба Оффис) тухай 1930 оны 30 дугаар Конвенц, Цалинтай амралтын (Хөдөө аж ахуй) тухай 1952 оны 101 дүгээр Конвенц, Ажлын цагийг хорогдуулах тухай 1962 оны 116 дугаар Конвенц, Цалинтай амралтын (хянаж шинэчилсэн) тухай 1970 оны 132 дугаар Конвенц, Гэр бүлийн үүрэг хариуцлага бүхий ажиллагчдын тухай 1981 оны 156 дугаар Конвенц, Шөнийн ажлын тухай 1990 оны 171 дүгээр Конвенц, 178 дугаар Зөвлөмж зэрэг конвенц, зөвлөмжүүдээр ажлын цагийг зохистойгоор хязгаарлах, ээлжийн амралтыг цалин хөлстэйгээр эдлүүлэх, баярын өдөрт цалин хөлс олгох зэрэг

харилцааг зохицуулдаг байна.

Үндэсний хууль тогтоомжуудад ажлын болон амьдралын үндсэн нөхцөлүүдийг муутгахгүйгээр ердийн ажлын цаг, илүү цагийн зохицуулалт, амралт завсарлагааны хугацаа зэргийг хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд тодорхой заах ёстойг үүрэг болгосон байдаг.

**БИЕ БЯЛДРЫН БОЛОН СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД
ДЭЭД ТҮВШИНД ХҮРСЭН БАЙХ ЭРХ
RIGHT OF EVERYONE TO THE ENJOYMENT OF THE HIGHEST AT-
TAINABLE STANDARD OF PHYSICAL AND MENTAL HEALTH**

“Энэхүү пактад оролцогч улсууд хүн бүрийн бие бялдрын болон сэтгэцийн эрүүл мэнд дээд түвшинд хүрсэн байх эрхийг хүлээн зөвшөөрнө.”

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 12 дугаар зүйлийн 1 дэх заалт)

“эрүүл мэндээ хамгаалуулах, этнэлгийн тусламж авах эрхтэй...”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 6 дахь заалт)

Хүн бүр хүний зэрэгтэй аз жаргалтай амьдрах болон бусад эрх, эрх чөлөөгөө эдлэхэд зайлшгүй шаардлагатай эрх бол “Бие бялдрын болон сэтгэл санааны хувьд хүрч болох дээд түвшинд эрүүл байх эрх юм. Энэхүү эрхийг Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт, Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Хүүхдийн эрхийн конвенц, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц болон бусад хүний эрхийн олон

улсын хууль тогтоомжоор баталгаажуулсан байдаг. Бие бялдрын болон сэтгэл санааны хувьд хүрч болох дээд түвшинд эрүүл байх эрхийн утга санааг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн гуравдугаар Хороо анх боловсруулан гаргахдаа ямар нэгэн өвчин зовлон болон насны доройтолгүйгээр бие бялдар, сэтгэл санааны хувьд эрүүл төгс байж, нийгэмдээ сайн сайхан амьдрах” гэсэн тодорхойлолтыг хэрэглэхээс татгалзсан байдаг. Учир нь “Бие бялдрын болон сэтгэл санааны хувьд хүрч болох дээд түвшинд эрүүл байх” гэдэг ойлголт нь хувь хүний биеийн биологийн онцлог болон нийгэм эдийн засгийн утгар нөхцөл түүнчлэн тухайн орны нөөц боломжийн аль алинаас хамаардаг байна. Тухайлбал, улс нь хувь хүн бүрийг өвчин тусах шалтгаан болгоноос хамгаалаад байж чадахгүй. Энэ нь хувь хүний удмын онцлог, өвчлөмтгий байдал, эрүүл бус эрсдэл ихтэй амьдралын хэв маягаар амьдрах зэрэг эрүүл мэндэд нөлөөлөх олон хүчин зүйлсээс шалтгаалж байдаг. Тэгэхээр “бие бялдрын болон сэтгэл санааны хувьд хүрч болох дээд түвшинд эрүүл байх” эрхийг Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн Хорооны 14 дүгээр зөвлөмжид дараах байдлаар тайлбарласан байна. Энэ эрх нь:

- Эрүүл мэндийн зохистой үйлчилгээгээр цаг хугацаанд нь үйлчлүүлэх, төрөл бүрийн эмчилгээний тоног төхөөрөмж, эм, эмнэлэг, үйлчилгээний нөхцлөөр хангагдсан байх, эрүүл байх боловсрол мэдээлэл авах боломж, эрүүл мэндтэй холбоотой шийдвэрт хүн амыг оролцуулах асуудлууд багтаж байна.

- Зөвхөн эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах эрхээр хязгаарлагдахгүй, хүмүүсийн эрүүл амьдрах орчинг бүрдүүлэх өргөн хүрээний нийгэм эдийн засгийн хүчин

зүйлс болох эрүүл байхын угтвар нөхцөлүүд: хоол хүнс, орон байр, ундны цэвэр усаар хангагдсан байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан орчин, аюулгүй, эрүүл ажлын байр, хүрээлэн байгаа байгаль орчны эрүүл байгаа зэргийг оруулдаг болохыг илэрхийлсэн.

Иймд бие бялдрын болон сэтгэл санааны хувьд хүрч болох дээд түвшинд эрүүл байх эрхийг зөвхөн эрүүл байх явцуу утгаар ойлгож болохгүй. Эрүүл байх эрхэд хувь хүний эрх чөлөө болон эрх мэдэл хоёулаа багтаж байна. Эрүүл байх эрхээ эдлэх эрх чөлөөтэй байна гэдэг нь хувь хүний биеийн эрүүл мэндээ хянах, бэлгийн болон нөхөн үржихүйн эрх чөлөөгөө эдлэх, эрүү шүүлт, тохиролцоогүй эмнэлгийн үйлчилгээ, туршилт зэрэг хөндлөнгийн оролцооноос чөлөөтэй байхыг хэлнэ. Харин эрх мэдэлтэй байна гэдэг нь хүмүүсийн хүрч болох дээд түвшинд байхын тулд тэгш боломжоор хангадаг эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах эрхтэй байхыг хэлнэ.

Үүнээс үзэхэд бие бялдрын болон сэтгэл санааны хувьд хүрч болох дээд түвшинд эрүүл байх эрх нь эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах боломжийг илэрхийлэхийн зэрэгцээ хүмүүсийн хүрэлцээтэй, хүртээмжэй, нийцтэй, чанартай эрүүл амьдрах орчинг бүрдүүлэх, эрүүл байх нөхцлөөр хангах асуудал юм.

Манай улсын хууль тогтоомжид энэ эрхийг шууд утгаар томъёолоогүй ч Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2-т “эрүүл, аюулгүй орчинд амьдрах”, мөн зүйлийн 6-д “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй хэмээн баталгаажуулж, Эрүүл мэндийн тухай хуульд иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Эдгээрээс үзэхэд манай улс хууль тогтоомждоо

“хүрч болох дээд түвшинд эрүүл байх эрх”-ийг Эдийн засаг, нийгэм, соёлын хорооны зөвлөмжийн утга агуулгын түвшинд баталгаажуулсан байна.

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛИЙГ СОНГОХ ЭРХ RIGHT TO CHOOSE THE KIND OF EDUCATION

“Хүүхдэдээ олгох боловсролын чиглэлийг сонгоход эцэг эх давуу эрх эдэлнэ.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 26 дугаар зүйлийн 3 дахь заалт)

“Энэхүү пактад оролцогч улсууд эцэг эх болон зохих нөхцөлд хууль ёсны асран хамгаалагчаас хүүхэддээ төрийн байгууллагаас байгуулсан сургууль төдийгүй, боловсрол олгох талаар улсаас тогтоосон буюу баталсан наад захын шаардлагыг хангаж байгаа бусад сургуулийг сонгох, өөрийн итгэл үнэмшлийн дагуу шашин шүтлэг, болон ёс суртахууны боловсрол олгох боломжийг хангана.

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 13 дугаар зүйлийн 3 дахь заалт)

Боловсролын чиглэлийг сонгох эрх нь эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч харгалзан дэмжигчээс хүүхэддээ боловсрол олгох олон хувилбараас сонгох, сонголт хийх эрх чөлөө, боломжийг олгож буй явдал юм. Өөрөөр хэлбэл эцэг эхэд хүүхдээ ямар төрлийн боловсролын байгууллагад сургах (ашгийн болон ашгийн бус), шинжлэх ухааны ямар чиглэлийг сонгох, түүнчлэн өөрсдийн хувийн үзэл бодлын дагуу шашны болон ёс суртахууны хүмүүжил олгох эрх чөлөөг олгож байгаа нь энэ эрхийн нэг онцлог юм. Хэдийгээр

энэхүү эрх чөлөөг эцэг эхэд олгож, тэдний чөлөөт сонголтыг дэмжсэн ч Эдийн засаг нийгэм соёлын эрхийн хорооны 13 дугаар зөвлөмж ёсоор дараах шаардлага тавигддаг.

Нэгдүгээрт, Тухайн эцэг эхийн сонгосон боловсролын байгууллага нь төрөөс тогтоосон стандартын шаардлагыг хангасан байх.

Стандарт гэдэг ойлголтод элсэлтийн шалгалт, сургалтын хөтөлбөр, боловсролын гэрчилгээний хүлээн зөвшөөрөгдөх байдал зэрэг орох бөгөөд энэ нь боловсролын зорилгод нийцэх ёстой юм. Энэ эрх нь төрөөс тогтоосон стандартын шаардлагыг хангасан хувийн сургуульд төлбөртэйгээр хүүхдээ суралцуулах эцэг эхийн сонголт хийх эрх чөлөөг хангаж байгаа болохоос үнэ төлбөргүй боловсрол эзэмших эрхийг зөрчиж байгаа явдал биш юм.

Хоёрдугаарт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 18 дугаар зүйлийн 4-т оролцогч улс эцэг эхийн болон зохих тохиолдолд хууль ёсны асран хамгаалагчдын үр хүүхдэдээ хувийн итгэл үнэмшлийнхээ дагуу шашны болон ёс суртахууны хүмүүжил олгох эрх чөлөөг хүндэтгэх тухай заасан. Гэхдээ энэхүү хүмүүжлийг олгож буй байгууллага нь тодорхой нэг шашин шүтлэг, итгэл үнэмшил дээр тулгуурлан сургалтын үйл ажиллагаа явуулж болохгүй юм. Түүнчлэн тухайн сургалтын үйл ажиллагаа нь шашин болон үндэс угсааны талаар аль нэг талыг барьж түүхийг гуйвуулахгүй, бодит үнэнд тулгуурласан байх ёстой.

Үүнээс үзэхэд Боловсролын чиглэлийг сонгох эрхэд нэг талаар эцэг эх хүүхдийнхээ боловсролын чиглэлийг сонгох давуу эрх, нөгөө талаар хүүхдийнхээ сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэхэд эцэг, эхийн үүрэг хариуцлага багтана.

**ГЭРЛЭХ ЭРХ
RIGHT TO MARRY**

“Насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс арьсны өнгө, үндэс, яс үндэс, шашин шүтлэгтэй холбогдсон аливаа хязгаарлалтгүйгээр гэрлэх, өрх тусгаарлах эрхтэй. Тэд гэрлэхдээ, гэрлэсний дараа болон гэрлэлтээ цуцлуулах үед тэгш эрх эдлэнэ.”

“Нөхөр, эхнэр болон хоёр хүн чөлөөтэй, харилцан бүрэн зөвшөөрсөн нөхцөлд гэрлэж болно.”

“Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж төн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 16 дугаар зүйл)

“...гэрлэгсэд чөлөөтэй, харилцан зөвшөөрөлцсөний үндсэн дээр гэрлэнэ.”

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 10 дугаар зүйлийн 1 дэх заалт)

“... улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх заалт)

“Гэр бүл гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх,

үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг ойлгоно” гэж Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд заасан байдаг. Гэр бүл нь нийгмийн үндсэн нэгж бөгөөд гэр бүл, эх нялхас, хүүхдийн эрх ашгийг төр хамгаалах үүрэгтэй.

Харин тухайн орны хуульд заасан насанд хүрсэн, эрх зүйн чадамжтай эрэгтэй, эмэгтэй хүмүүс арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, хувийн байдалтайгаа холбогдсон аливаа хязгаарлалтгүйгээр өөрсдийн сайн дурын үндсэн дээр эхнэр, нөхрөө чөлөөтэй сонгож хамтран амьдрахыг гэрлэх эрх гэнэ. Монгол Улсын тухайд зөвхөн эрэгтэй, эмэгтэй хүмүүс хоорондоо гэрлэх эрхтэй байдаг бол зарим улс орнууд ижил хүйстнүүд хоорондоо гэрлэхийг зөвшөөрдөг болсон. Гэр бүл болох, болсны дараа, гэрлэлтээ цуцлуулах үед эрэгтэй эмэгтэй хоёулаа тэгш эрх эдэлдэг.

Улс болгон гэрлэлтээ баталгаажуулах насыг өөр өөрөөр зааж өгсөн байдаг. Ихэнх улс орны хуульд 18 нас гэж заажээ. Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын иргэн улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасан бол Гэр бүлийн тухай хуульд “... харшлах шалтгаангүй бол 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн эрэгтэй, эмэгтэй хоёр буюу Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй харилцан зөвшөөрөлцсөнөөр Монгол Улсад гэрлэж болно” гэж заасан байдаг. Харин өмнөх гэрлэлт хүчинтэй байгаа, гэрлэгчид хоёулаа, эсхүл хэн нэг нь хуульд заасан насанд хүрээгүй, төрөл, садангийн хүмүүс хоорондоо,

харгалзан дэмжигч, дэмжүүлэгч хоёр гэрлэх, үрчлэгч, үрчлүүлэгч хоёр гэрлэх, гэрлэгчдийн хэн нэг нь, эсхүл хоёулаа удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй бол гэр бүл болохыг хуулиар хориглодог.

Гэр бүлээ хамгаалуулах эрхийг гэрлэхийг хүсэгч этгээдүүд болон гэр бүл, эцэг эх, хүүхдүүд эдлэх эрхтэй. Гэр бүлээ хамгаалуулах эрх нь маш өргөн ойлголт бөгөөд гэр бүлээ төлөвлөх, оршин суух газар, эрхлэх ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хуваарьт эд хөрөнгөтэй байх, дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах, материалын болон сэтгэл санааны хохирлоо буруутай этгээдээс гаргуулах зэрэг олон асуудлыг хамаардаг байна.

Мөн гэрлэгчид нь бие биедээ үнэнч байх, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүд нь бие биеэ халамжлах, хүндэтгэх, тэжээн тэтгэх, туслах, гэр бүлд шаардагдах эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх, хэн нэгнийхээ эрхийг зөрчихгүй, бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх, угийн бичиг хөтлөх үүргийг хүлээдэг.

**ЗОХИХ ДЭЭД ШАТНЫ АЖИЛД ДЭВШИХ АДИЛ
БОЛОМЖИЙГ ХҮН БҮРТ ОЛГОХ
EQUAL OPPORTUNITY FOR EVERYONE TO BE PROMOTED IN
HIS/HER EMPLOYMENT**

“Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүр хөдөлмөрийн шударга, таатай нөхцлөөр хангагдах эрхийг хүлээн зөвшөөрөх бөгөөд тухайлбал:(с) гагцхүү ажилласан хугацаа, мэргэшилд үндэслэн зохих дээд шатны ажилд дэвших адил боломжийг хүн бүрт олгох;

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйлийн 7(с) заалт)

Ажил мэргэжлийн хүрээнд тэгш боломж олгон, тэгш хандах гэдэг нь ажил мэргэжлийн хувьд албан тушаалаар болон хүйсээр ялгаварлан тусгаарлахыг таслан зогсоохыг хэлнэ. Тэгш боломж олгох, тэгш хандах асуудал нь хөдөлмөр эрхлэлт дэх тэгш байдлыг хангахад харилцан бие биеэ дэмжин нөлөөлдөг хоёр хүчин зүйл юм.

Тэгш боломж олгох гэдэг нь тухайн ажилд орохоор өргөдлөө өгөх, боловсролоо дээшлүүлэх, сургалтад суух, зарим мэргэшил эзэмших, ажиллагч гэж тооцогдох, түүнчлэн аль нэг хүйс давамгайлдаг болон бусад бүхий л ажил мэргэжилд ахиж дэвших тэгш боломжтой байна гэсэн үг юм. Харин тэгш хандах гэдэг нь цалин хөлс, ажлын нөхцөл, баталгаатай ажил, ажил ба гэр бүлийн амьдралыг уялдуулах, нийгмийн хамгаалал зэрэгт тэгш эрх эдлэх гэсэн үг юм.

Ялгаварлан гадуурхахаас хамгаалуулах асуудал нь зөвхөн ажиллагчдад төдийгүй хувиараа хөдөлмөр эрхлэгч, үйлдвэрлэл эрхлэгч, гэр бүлд цалин хөлсгүй ажиллагч зэрэг хүмүүст ч мөн адил хамаардаг байна. Хөдөлмөр эрхлэлт дэх тэгш байдлыг хөхиүлэн дэмжих нь ялгаварлан гадуурхахыг хориглохын хамт түүнээс илүү идэвхтэй, эерэг хандлага баримтлах явдал гэж үздэг. Үүний тулд байнгын хүчин чармайлт, түүний дотор тодорхой, зохих хөрөнгө нөөц бүхий арга хэмжээ, явцын тогтмол хяналт, үнэлгээг тогтмол хийж байх шаардлагатай.

ЗОХИСТОЙ ХООЛ, ХҮНСЭЭР ХАНГАГДАХ ЭРХ RIGHT OF AN ADEQUATE STANDARD OF FOOD

“хүн бүр хоол хүнс ... оролцуулаад өөрийн болон

ал бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 25 дугаар зүйл)

“Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн болон түүний өрх гэрийн хүрэлцээтэй хоол хүнс, хувцас, орон сууцыг оролцуулан, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, амьдралынхаа нөхцлөө байнга сайжруулах эрхийг нь хүлээн зөвшөөрнө.”

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 11 дүгээр зүйлийн 1 дэх заалт)

Дэлхийн улс орон, ард түмэн бүр өөрийн гэсэн онцлог, үндэсний соёл, зан заншлаас шалтгаалан их, бага харилцан адилгүй хоол, хүнс хэрэглэдэг. Гэхдээ хүн бүр зохистой хоол хүнсээр хангагдах эрхтэй бөгөөд ямар ч тохиолдолд хоол хүнс хүрэлцээтэй түвшинд байх асуудал нэн тэргүүнд тавигддаг. Түүнчлэн хоол хүнс аюулгүй, шим тэжээлтэй байх ёстой бөгөөд чанар, хүртээмж нь тухайн хүний өдөр тутмын хэрэгцээг хангахуйц байхыг шаарддаг.

Зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг тодорхойлбол, хүн амьдралынхаа туршид өөрийн хэрэгцээг бүрэн хангахуйц хоол хүнсээ олж авах бие бялдар болоод эдийн засгийн чадвартай байх явдал юм.

Нөгөө талаас төр хүнсний аюулгүй байдлыг хангах, хүн амын эрүүл мэнд, аж амьдрал доройтохуйц нөхцөл байдалд оруулахгүй байх үүргийг хүлээх ба хүн өөрөөс үл хамаарах шалтгаанаар тэжээлийн дутагдал, хүнсний хомсдол зэргээс ангид байхыг ойлгоно.

Монгол Улсын Үндсэн хуульд хүнсний эрхийн талаар шууд тодорхойлсон заалт байхгүй ч хүн бүрийн амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ

хамгаалуулах эрх нь хоол хүнсээр хангагдах эрхтэй шалтгаант хамааралтай юм.

Итали улсын Ром хотноо 1992 онд болсон Олон улсын хоол тэжээлийн бага хурлаас гаргасан тунхаглалд дурдсанаар “Хүнсний зохих нөөц хүрэлцээтэй байгаа манай гаригт өлсгөлөн, өлөн зэлмүүн байдал гарах учиргүй бөгөөд тэжээллэг, чанар, аюулгүй хүнс хэрэглэх явдал хүн бүрийн эдлэх эрх мөн” гэжээ.

Зохистой хоол, хүнсээр хангагдах эрх нь хүнсний эрх гэх ерөнхий ойлголтод багтдаг бөгөөд хүнсний эрхэд мөн өлсгөлөнгөөс ангид байх, усаар хангагдах зэрэг эрхүүд хамаардаг байна.

НАМ, ОЛОН НИЙТИЙН БАЙГУУЛЛАГАД ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ FREEDOM OF ASSEMBLY AND ASSOCIATION

“Хүн бүр чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй.

Хэнийг ч аливаа эвлэл холбоонд албадан оруулах ёсгүй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 20 дугаар зүйл)

“Тайван хуран цуглах эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, эсхүл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуулийн дагуу тогтоосноос өөр хязгаарлалт хийж болохгүй.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 21 дүгээр зүйл)

“Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалт)

Эвлэлдэн нэгдэх эрх нь зарим тохиолдолд улс төр, соёл, зугаа цэнгэл, спорт, нийгэм, хүмүүнлэгийн тусламж зэрэг өргөн хүрээг хамрах нь бий. Судлаач Жереми МакБрайд “жинхэнэ ардчилал” бий болгохын тулд нийгмийн бүхий л түвшинд эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг эдлэх, нөгөө талаас эрх мэдэл бүхий этгээдийн зүгээс тус эрх чөлөөг хүндэтгэх шаардлагатайг онцолсон. Тэрээр төрийн бус байгууллагууд байгуулах нь иргэний нийгэмд маш чухал төдийгүй эдгээр байгууллага бол “эвлэлдэн нэгдсэн үйл ажиллагааны үр жимс” гэжээ. Үүний зэрэгцээ ямарваа нэгэн байдлаар нам, олон нийтийн байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө ялгаварлан гадуурхах, доромжлох, зүй бусаар харьцах явдлыг хориглодог нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг давхар хүндэтгэж байгаагийн илрэл юм.

Иргэний нийгэм гэдэгт нийтлэг ашиг сонирхол, зорилго, үнэт зүйлсийн үндсэн дээрх сайн дурын хамтын үйл ажиллагааны талбарыг ойлгоно. Онолын хувьд, бүтэц байгуулалтын хэлбэр нь төр, гэр бүл, зах зээлийн хэлбэрүүдээс ялгаатай ч бодит амьдрал дээр төр, иргэний нийгэм, гэр бүл, зах зээлийн хоорондын хил зааг нь нийлсэн, тодорхой бус, холилдсон шинжтэй байдаг. Иргэний нийгэм нь дүрэм журам, бие даасан

байдал, эрх мэдлийн түвшингээр ялгаатай ба орон зай, үйл ажиллагаа, бүтэц байгуулалтын төрөл бүрийн хэлбэрүүдийг агуулдаг. Иргэний нийгэмд хууль ёсоор бүртгэгдсэн асрамжийн газар, төрийн бус байгууллага, олон нийтийн бүлэг, эмэгтэйчүүдийн байгууллага, итгэл үнэмшилд суурилсан байгууллага, мэргэжлийн холбоо, үйлдвэрчний эвлэл, хувь хүмүүсийн нэгдэл, иргэний хөдөлгөөн, бизнесийн холбоо, санаачлага, нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг бүлэг зэрэг харилцан адилгүй байгууллагууд багтдаг.

НИЙГМИЙН ХАНГАМЖ ЭДЛЭХ ЭРХ RIGHT TO SOCIAL SECURITY

“Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн хангамж эдлэх, ...эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 22 дугаар зүйлд)

“Энэхүү Пактад оролцогч улсууд нийгмийн даатгалыг оролцуулан, хүн бүрийн нийгмийн хангамжинд хамрагдах эрхийг хүлээн зөвшөөрнө.”

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйл)

“... өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, төнгөний тусламж авах эрхтэй.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалт)

Нийгмийн хангамжийг илүү боловсронгуй хэлбэрээр анх Ромын эзэнт гүрний үед, тодруулбал, МЭ 98-117 онд төр барьж байсан Траянус Август хааны үед

хөгжүүлсэн гэж үздэг бол Монголын эртний хууль цаазын бичиг “Их засаг” зэрэг түүхэн эх сурвалжид өтгөс буурал, ядуус, өнчин иргэдийг энэрэн тэтгэх тухай зохицуулалт байжээ.

Хувь хүн өндөр наслах, өвчлөх, хөдөлмөрийн чадвараа алдах, хүүхэд төрүүлэхдээ төрөөс тусламж дэмжлэг авах эрхийг нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдах эрх гэнэ. Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалд хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн хангамж эдлэх, түүнчлэн нэр төрөө хадгалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ улс бүрийн бүтэц, нөөц бололцоотой уялдуулан үндэсний хүч чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны замаар хэрэгжүүлэх эрхтэй гэж заасан.

ОРОН БАЙРААР ХАНГАГДАХ ЭРХ RIGHT TO HOUSING

“...Хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ал бүлийнхээ эрүүл тэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй. Ажилгүйдэх, өвчлөх, тахир дутуу болох, бэлэвсрэх, өтлөх, эсхүл өөрөөс үл халаагах бусад шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэлж авах эрхтэй.”

(Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 25 дугаар зүйл)

“... Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн болон түүний өрх гэрийн хүрэлцээтэй хоол хүнс, хувцас, орон сууцыг оролцуулан, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, амьдралынхаа нөхцлөө

байнга сайжруулах эрхийг нь хүлээн зөвшөөрнө. Оролцогч улсууд энэ талаар чөлөөтэй зөвшилцөлд үндэслэсэн олон улсын хамтын ажиллагаа чухал ач холбогдолтойг хүлээн зөвшөөрч, энэ эрхийн хэрэгжилтийг хангах зохистой арга хэмжээ авна.”
(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 11 дүгээр зүйлийн 1 дэх заалт)

Орон сууцаар хангагдах эрх нь эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хоол хүнс, хувцас, нийгэм ахуйн үйлчилгээ зэргийн хамт амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийг бүрдүүлдэг байна. Эдгээрээс гадна олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн баримт бичгүүдэд уг эрхийн тухай асуудлыг баталгаажуулж, эрхийн хэрэгжилтэд ахиц гаргахыг гишүүн улс орнуудад даалгасан байдаг. 1991 онд НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын хорооноос Орон сууцаар хангагдах эрхийн талаар Ерөнхий зөвлөмж 4-ийг боловсруулж, энэхүү эрхийн талаарх хууль зүйн болон агуулга, зохицуулалтын талаар албан ёсны тайлбарыг өгсөн байна.

**ОРЧНЫ БОХИРДОЛ, БАЙГАЛИЙН ТЭНЦЭЛ
АЛДАГДАХААС ХАМГААЛУУЛАХ ЭРХ
RIGHT TO BE PROTECTED AGAINST ENVIRONMENTAL
POLLUTION AND ECOLOGICAL IMBALANCE**

“Энэхүү Пактад оролцогч улсууд энэ эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардагдах дараахь арга хэмжээг авна:

“гадаад орчны болон үйлдвэрлэлийн эрүүл ахуйг бүх талаар сайжруулах;”

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон

улсын пактын 12 дугаар зүйлийн 2(b) заалт)

“... орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй,”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь заалт)

Эдийн засгийн хөгжлийн үр дүнгээс шалтаалан байгаль орчны тогтвортой байдал алдагдах, сүйрэх үйл явцыг байгалийн тэнцэл алдагдах гэж үздэг. Тодруулбал, амьтай болон амьгүй биетийн хоорондын үл нийцлээс шалтгаалж байгалийн тэнцэл алдагддаг бөгөөд эдгээр нь цөм хүний үйл ажиллагаанаас хамааралтай байдаг. Хүний амьд явах эрхийг хангах үндсэн баталгаа нь эрүүл, аюулгүй орчин бөгөөд орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдах явдлаас төр иргэнээ хамгаалах үүрэг хүлээдэг. Төр энэхүү үүргээ хэрхэн биелүүлж байгаагаас хамааран амьд явах эрхийн хэрэгжилт хангагдах, эс хангагдах тухай асуудал яригдана.

Орчны бохирдол гэдэгт агаарын, усны, хөрсний гэх мэт органик шинжтэй бохирдлоос гадна дуу чимээний, хог хаягдлын, гэрлийн гэх мэт хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй органик бус бохирдлыг хамааруулдаг хэдий ч хүний амьдрах тайван бөгөөд таатай орчинд нөлөөлөх бусад олон хүчин зүйлс бий.

ӨВ ЗАЛГАМЖЛУУЛАХ ЭРХ RIGHT TO INHERITANCE

“...өв залгамжлуулах эрхтэй.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт)

Эрх зүйн сонгодог онолд өв залгамжлуулах эрхийг ойлгохдоо тухайн өмчлөгч этгээдийн эрх дуусгавар болохгүйгээр, түүний өмчлөх эрхийг өөр нэг этгээд түүний нэрийн өмнөөс хэрэгжүүлэх боломж гэж үздэг. Монголчуудын эрт үеэс уламжилж ирсэн өмч хөрөнгө өвлөх заншил ёсоор өрхийн тэргүүн бүх өв хөрөнгийн эзэн гэж тооцогддог ба түүнийг нас бармагц ахмад хүүд эцгийн өв хөрөнгийг залгамжлах эрх үүсдэг. Тэрээр эцгийн өв хөрөнгийн тэн хагасыг өмчилж, дүү нар нь үлдсэн хэсгийг хувааж өмчилдөг байв. Өрх гэрийн гал голомт, бурхан шүтээн, биет бус зүйлс отгон хүүд өвлөгдөх заншил ч бий.

Монгол Улсын Үндсэн хуульд өмчлөх эрх, өв залгамжлуулах эрхийг нэг заалтад, хамт баталгаажуулсан нь өмчлөх эрх, өв залгамжлуулах эрхийн хоорондын хамаарлыг илэрхийлсэн шинжтэй юм. Монгол Улсад өмчлөгч нь өөрийн эд хөрөнгөө хуульд заасны дагуу болон гэрээслэлээр өв залгамжлуулан үлдээж болдог. Өв залгамжлалын харилцаа нь өвлүүлэгч, өвлөгч гэсэн субъектийн хооронд явагддаг бөгөөд эрх зүйн харилцаанд тухайн иргэний хэрэгжүүлж байгаа эрх, үүрэг, хариуцлагыг өөр этгээдэд шилжүүлэх факт бий болсон, тодруулбал, өмчлөгч нас барах, нас барсанд тооцогдсон үед хэрэгжинэ. Гэрээслэгч-өвлүүлэгч, өв залгамжлагчийн эрх, үүрэг нь өвийн замаар шилжих бөгөөд өмчлөх эрх хэрэгжих хэлбэрүүдийн нэг чухал илэрхийлэл болдог байна.

Хуульд зааснаар өв залгамжлах эрх нь хууль тогтоогчийн тогтоосон нөхцөл журмын дагуу өв залгамжлахыг хэлдэг. Энэ нь өв залгамжлуулагчийн хүслийг илэрхийлдэггүй бөгөөд гэрээслэл үйлдээгүй, эсвэл үйлдсэн гэрээслэл нь хүчин төгөлдөр буст тооцогдсон, устаж үгүй болсон, гэрээслэлд заасан өв

залгамжлагч байхгүй болсон зэрэг нөхцөл бүрдсэн үед хэрэглэгддэг. Энэ тохиолдолд эд хөрөнгийг субъектүүдэд адил хэмжээгээр өвлүүлэх бөгөөд эдгээр субъект нь нас барагчийн нөхөр, эхнэр, төрүүлсэн болон үрчилж авсан, түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, нас барагчийн төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх болно.

Гэрээслэлээр өв залгамжлах эрх нь гэрээслэлийн тусламжтайгаар өв залгамжлуулагчийн тодорхойлсон нөхцөл журмын дагуу өв залгамжлагчид өв шилжихийг хэлдэг. Өв залгамжлуулагч гэрээслэлдээ өв залгамжлагчаа тодорхой заахаас гадна түүний эрх, үүргийг тодорхойлж өгдөг. Иргэний эрх зүйн үүднээс авч үзвэл гэрээслэл нь нэг талын хэлцэл бөгөөд гэрээслэлд зөвхөн гэрээслэгчийн хүсэл зориг илэрхийлэгдэх ёстой.

ӨЛСГӨЛӨНГӨӨС АНГИД АЖ ТӨРӨХ ЭРХ RIGHT OF EVERYONE TO BE FREE FROM HUNGER

“Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн өлсгөлөнгөөс ангид аж төрөх үндсэн эрхийг хүлээн зөвшөөрч, тодорхой хөтөлбөр хэрэгжүүлэхийг оролцуулан, дангаараа буюу олон улсын хамтын ажиллагааны хэлбэрээр шаардлагатай арга хэлжээг ...авна.”

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 11 дүгээр зүйлийн 2 дахь заалт)

Хүн бүр эрүүл саруул өсөж хөгжих, амьдрахад шаардагдахуйц хэмжээний хоол хүнсээр хангагдах, олж авах боломжтой байхыг өлсгөлөнгөөс ангид аж

төрөх эрх гэнэ. Өлсгөлөнгөөс ангид байх эрх нь нэг талаас төрөөс, нөгөө талаас хувь хүнээс өөрөөс нь хамаарна. Төрөөс иргэдээ зохистой хоол хүнсээр хангах бодлогыг хэрэгжүүлж, хүнд зайлшгүй хэрэгцээтэй хоол хүнсний нөөцийг бий болгох ёстой. Харин хувь хүн өөрөө ажил, хөдөлмөр эрхэлж, орлого олж, хоол хүнсээ олж авах эрхтэй.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалд “Хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй”, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактад “хүн бүр өлсгөлөнгөөс ангид байх үндсэн эрхтэй” гэж заасан байдаг. Энэ эрх нь дээрх Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын эрхтэй салшгүй холбоотой юм. Зохистой хоол хүнсээр хангагдах эрх гэдэг нь хүн бүр хүрэлцэхүйц хоол хүнсээ олж авах болон түүнд нийцсэн бие бялдар болон эдийн засгийн чадвартай байхыг хэлнэ.

**ӨӨРИЙН ТУУРВИСАН ШИНЖЛЭХ УХААН, УТГА
ЗОХИОЛ, УРАН САЙХНЫ АЛИВАА БҮТЭЭЛТЭЙ
ХОЛБОГДОН ҮҮССЭН ЁС СУРТАХУУНЫ
БОЛОН ЭД МАТЕРИАЛЫН АШИГ СОНИРХЛЫГ
ХАМГААЛУУЛАХ ЭРХ
RIGHT TO BENEFIT FROM THE PROTECTION OF THE MORAL
AND MATERIAL INTERESTS RESULTING FROM ANY SCIENTIFIC,
LITERARY OR ARTISTIC PRODUCTION OF WHICH HE IS THE
AUTHOR**

“Хүн бүр өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээлийн материал болон

ёс суртахууны эрх ашигаа хамгаалуулах эрхтэй”
(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 27 дугаар зүйлийн 2 дахь заалт)

“Өөрийнхөө туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны аливаа бүтээлтэй холбогдон үүссэн ёс суртахууны болон эд материалын ашиг сонирхлыг хамгаалуулах”
(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 15 дугаар зүйлийн 1 (с) заалт)

“...соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;
(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 8 дахь заалт)

“Шинжлэх ухаан, утга зохиол, урлаг соёлын аливаа бүтээл” гэдгийг Эдийн засаг, нийгэм соёлын хороо тайлбарлахдаа шинжлэх ухааны зохиол бүтээл, шинэ санаа, түүний дотор уугуул иргэдийн болон орон нутгийн ард олны санаачилга, ёс заншил, яруу найраг, тууж, уран зураг, уран баримал, хөгжмийн зохиол, театр киноны бүтээл, тоглолт, аман зохиол гэх мэт утга зохиолын болон урлаг соёлын зэрэг хүний оюун санааны бүтээлийг заана хэмээжээ.

Түүнчлэн “хамгаалуулах” гэдэгт хамгаалалтын арга хэлбэрийг ялгаж онцлолгүйгээр зохиогчийн шинжлэх ухаан, утга зохиол, урлаг соёлын бүтээлийнхээ оюун санааны болон материалаг ашиг сонирхлыг ямар байдлаар хамгаалуулахын үр шимийг хүртэх эрхийг хүлээн зөвшөөрсөн байна. Гэхдээ хамгаалалт нь

тухайн бүтээлээс үүдэн гарах зохиогчийн оюун санааны (ёс суртахууны) болон материаллаг эрх ашгийг баталгаажуулж л байвал хамгаалалт нь зохиогчийн эрх, патент болон бусад оюуны өмчийн хэлбэрүүдэд байдаг хамгаалалтын түвшин, арга замтай адил байх албагүй.

Эдийн засаг нийгэм соёлын хороо шинжлэх ухаан, утга зохиол, урлаг соёлын бүтээлээс бий болох оюуны болон материаллаг ашиг сонирхлоо хамгаалуулахын үр шимийг хүн бүр хүртэх эрхийг хүлээн зөвшөөрснөөр 15 дугаар зүйлийн 1(с) хэсэг нь бусдын эдлэх пактын эрхийг зүй бусаар хязгаарлаагүй бол төр зохиогчийн оюуны болон материаллаг ашиг сонирхлыг хамгаалах талаарх олон улсын гэрээнд буюу дотоодынхоо хууль тогтоомжид илүү өндөр хамгаалах стандарт тогтооход ямар нэгэн байдлаар хориг тавиагүй байна.

Зохиогчийн “Оюун санааны ашиг сонирхол”-ыг хамгаалах нь урлаг соёл, утга зохиол, шинжлэх ухааны бүтээлийн зохиогч, бүтээгчид нь хөдөлмөрийнхөө хөлсөөс гадна бүтээл болон эсвэл алга болохгүй нээлтийнхээ оюун санааны эрхийг уг бүтээл нь нийт хүн төрөлхтний нийтийн өмч болсны дараа ч бас хадгална хэмээсэн утгатай.

Хороо 15 дугаар зүйлийн 1(с) хэсэг дэх “оюун санааны ашиг сонирхол” гэдэгт зохиогчдын шинжлэх ухаан, утга зохиол, урлаг соёлын бүтээлийн бүтээгч гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх болон тухайн бүтээлийн утга санааг гажуудуулах, алдагдуулах буюу бусад хэлбэрээр өөрчлөх, эсвэл үүнтэй холбоотойгоор гутаах, үүгээрээ нэр төр, алдар хүндэд нь хортой аливаа үйлдлийг эсэргүүцэх эрхийг хамааруулсан байна.

Зохиогчийн “Материаллаг ашиг сонирхол”-ыг хамгаалах гэдэг нь Хүний эрхийн Түгээмэл

Тунхаглалын 17 дугаар зүйл болон бүс нутгийн хүний эрхийн баримт бичгүүдэд зааснаар өмчтэй байх эрх, аливаа ажилчны тохирох цалин хөлс авах эрхтэй нягт холбоотойг харуулж байна. Хүний бусад эрхээс ялгаатай нь зохиогчийн материаллаг ашиг сонирхол нь бүтээгчийнхээ зан чанарын илэрхийлэлтэй шууд холбогддоггүй, харин амьжиргааны зохих түвшинд амьдрах эрхээ эдлэхэд хувь нэмэр болдог байна. 15 дугаар зүйлийн 1(с) хэсэг ёсоор материаллаг эрх ашгийг хамгаалах гэдэг нэр томъёо зохиогчийн бүхий л амьдрах хугацааг хамрах албагүй. Харин зохиогчийн амьжиргааны зохистой түвшинд амьдрах эрхээ эдлэх боломж олгох зорилгод нэг удаа төлбөр хийснээр буюу шинжлэх ухаан, утга зохиол, урлаг соёлын бүтээлээ ашиглах онцгой эрхтэйгээр зохиогчид хэсэг хугацаанд хөрөнгө оруулалт хийснээр хүрч болно. “Үүдэн гарах” (холбогдон үүсэх) гэдэг үг нь зохиогч зөвхөн шинжлэх ухаан, утга зохиол, урлаг соёлын бүтээлээсээ шууд үүссэн оюун санааны эрх ашгийг хамгаалуулахаас үр шим хүртэхийг онцолж байна.

СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ RIGHT TO EDUCATION

“Хүн бүр сурч боловсрох эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 26 дугаар зүйлийн 1 дэх заалт)

“Энэхүү пактад оролцогч улс хүн бүр сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрнө.”

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 13 дугаар зүйлийн 1 дэх заалт)

“сурч боловсрох эрхтэй.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 7 дахь заалт)

Боловсрол нь өөрөө хүний эрх бөгөөд бусад эрх, эрх чөлөөг хангах үндэс суурь болдог. Мянганы хөгжлийн зорилтуудын талаарх Нэгдсэн Үндэстний Байгууллагын баримт бичгүүдэд “Боловсрол бол хүний эрх бөгөөд үгээгүй ядуу байдал, хүүхдийн хөдөлмөрийг мөлжих явдлыг багасгах, ардчилал, энх тайван хүлээцтэй байдал, хөгжлийг дэмжих гол хүчин зүйл мөн” гэж тодорхойлсон байдаг.

Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пактын 1 дүгээр зүйл, Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 29 дүгээр зүйлд боловсрол нь дараах зорилгод чиглэгдэх ёстойг заасан байдаг. Үүнд:

Нэгдүгээрт, хүний авьяас чадварыг хөгжүүлэх, соёл иргэншил, хэл, үнэт зүйлс, хүний эрхийн зарчмыг хүндэтгэх, байгаль орчныг хайрлан хамгаалах үзлээр хүмүүжүүлэх,

Хоёрдугаарт, бүх хүмүүсийг нийгэмд илүү үр нөлөөтэйгээр оролцохыг чадваржуулах,

Гуравдугаарт, тэгш эрх, хүн хүнээ хүндэтгэх, үндэстэн ястан, шашны бүлгүүдийн эв найрамдал, хоорондын ойлголцлыг дээшлүүлэх.

Сурч боловсрох эрхийн агуулгад:

- хүн бүрт бага боловсролыг заавал, үнэ төлбөргүй олгох;

- үнэ төлбөргүй боловсрол олгох шаардлагатай арга хэмжээг авах замаар техникийн болон тусгай мэргэжлийн боловсролыг оролцуулан дунд боловсролыг нийтэд хүртээлтэй болгох;

- авьяас чадвартай нь уялдуулан хүн бүрт дээд

боловсрол эзэмших боломж адилхан хүртээлтэй олгох;

- хүүхдэд олгох боловсролын чиглэлийг сонгоход эцэг эх давуу эрх эдлэх;

- төрөөс тогтоосон шаардлагыг хангаж байгаа тохиолдолд хувь этгээд буюу байгууллагаас сургууль байгуулах;

- анхан шатны боловсролгүй буюу бага сургууль төгсөөгүй хүмүүс боловсролын анхны мэдэгдэхүүнтэй болгох явдлыг дэмжих, эрчимжүүлэх зэрэг ойлголт орно.

Сүүлийн жилүүдэд ЮНЕСКО-гийн Бүх нийтийн боловсрол (1990), Боловсролын талаарх Дакарын тунхаглал (2000) зэрэг баримт бичгүүдэд хүн зөвхөн сурч боловсрох эрхтэй төдийгүй чанартай боловсрол эзэмших эрхтэй болохыг заасан байдаг.

Сурч боловсрох эрх нь позитив эрх тул уг эрхийг хангах, хэрэгжүүлэхэд төрийн үүрэг хариуцлага чухлаар тавигддаг. Сурч боловсрох эрхийн талаар төрийн хүлээх үүргийг Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны 13 дугаар зөвлөмжид хүн бүрт боловсрол олгохын тулд боловсрол нь боломжтой, хүртээмжтэй, хүлээж авахуйц, амьдралд тохирхуйц байх гэсэн 4А-гийн зарчмаар тайлбарласан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 7 дахь заалтад сурч боловсрох эрхийг баталгаажуулж, төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгох, иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болохыг заасан. Түүнчлэн Боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай

хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хүрээнд сурч боловсрох эрхийг хангахтай холбогдсон бусад харилцааг зохицуулсан байна. Үүнээс үзэхэд манай улс сурч боловсрох эрхийг минимиум стандартаас давуу байдлаар хуульчлан баталгаажуулжээ. Тухайлбал, хүний эрхийн олон улсын баримт бичгүүдэд наад зах нь бага боловсрол үнэ төлбөргүй байх талаар заасан байна. Манай улсын тухайд ерөнхий боловсролыг иргэн бүр үнэ төлбөргүй эзэмших, үүргийг хүлээдэг.

УЛСДАА ТӨРИЙН АЛБА ХАШИХ ТЭГШ ЭРХ RIGHT OF EQUAL ACCESS TO PUBLIC SERVICE

“Хүн бүр улсдаа төрийн алба хаших тэгш эрхтэй.”
(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 21 дүгээр зүйлийн 2 дахь заалт)

“тэгш эрхийн ерөнхий нөхцөлтэйгээр улсдаа төрийн алба хаших.”
(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 25 дугаар зүйлийн 25(с) заалт)

Хүн бүр улсдаа яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаараа ялгаварлагдахгүйгээр шударга, тэгш эрхийн ерөнхий нөхцөлтэйгөөр төрийн алба хаших боломжтой байхыг улсдаа төрийн алба хаших тэгш эрх гэнэ. Харин тухайн иргэн нь төрийн албан хаагчид тавигдах хууль, журмаар тодорхойлогдсон болзол, шаардлага (нас, мэргэжил, боловсрол, ял шийтгэлгүй байх)-ыг хангасан байх ёстой.

УСААР ХАНГАГДАХ ЭРХ RIGHT TO WATER

Ус бол удаан хугацаанд нөхөн сэргээгдэх боломжтой, байгалийн хязгаарлагдмал нөөц бөгөөд амьдрал, эрүүл мэндийн тулгуур хүчин зүйл гэж болно. Усаар хангагдах эрх бол хүний зэрэгтэй, нэр төртэй амьдрахад зайлшгүй чухал юм.

Усаар хангагдах эрх нь хүн бүр хангалттай хэмжээнд, аюулгүй, бие махбодийн хувьд хүртэх боломжтой усыг хүртээмжтэй байдлаар хувийн болон гэр бүлийнхээ хэрэгцээнд хэрэглэх эрх юм. Харин усыг зохистой хэмжээгээр хүртэх гэдэгт цангаж амь насаа алдах эрсдэлд орохгүй, уснаас үүдэлтэй өвчин тусах магадлал бууруулах хэмжээнд усыг хэрэглэж, хүнсэндээ ашиглан, хувийн болон гэр бүлийн ариун цэврийг сахихдаа ашиглана гэсэн үг.

Хөгжиж буй болон хөгжингүй улсуудын хувьд усаар хангагдах эрхийг хэрэгжүүлэхгүй орхих явдал нийтлэг тохиолддог. Үүний улмаас дэлхий дээр 1 тэрбум гаруй хүн усны наад захын хангамжгүй, 2 тэрбум гаруй хүн ариун цэврээ сахих ус олж чадахгүйгээс бохирын өвчин, уснаас үүдэлтэй халдвар авч байгааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тодорхойлжээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 2010 оны 8 сарын 3-ны өдөр баталсан 64/292 дугаар тогтоолоор цэвэр ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийг хүлээн зөвшөөрч, аюулгүй цэвэр ундны ус, ариун цэврийн байгууламж бол хүний амьдрах, аливаа эрхээ бүрэн эдлэх тулгуур гэж үзсэн байна.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын

пактын 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хүрэлцээтэй хоол хүнс, хувцас, орон сууцыг оролцуулан” амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийг хүлээн зөвшөөрч, олон эрхийг цогц байдлаар илэрхийлсэн гэж болно. Ялангуяа “оролцуулан” гэсэн үгээр зөвхөн хоол хүнс, хувцас, орон сууцыг л ярьсан гэж ойлгох боломжгүй. Иймээс усаар хангагдах эрх нь амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх баталгаанд хамаарч, амьдрахад зайлшгүй шаардлагатай нөхцлийн нэгт тооцогдох болно. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны 4, 6, 14 дэх Ерөнхий Зөвлөмждөө усаар хангагдах эрх бол дээрх пактын 11 зүйлд заасан хүний эрх болохыг, хүн бүрийн бие бялдрын болон сэтгэцийн эрүүл мэнд дээд түвшинд хүрсэн байх эрх болон хүрэлцээтэй хоол хүнс, хувцас, орон сууцтай байх эрхтэй шууд бусаар холбоотойг тодорхойлсон байна.

Мөн 15 дугаар Ерөнхий Зөвлөмжийн 29 дүгээр догол мөрт “Оролцогч улсууд эмэгтэйчүүд, хүүхдийн хэрэгцээг анхаарч, орон нутгийн болон ядуу буурай хотын бус нутгийн эрүүл ахуйн аюулгүй үйлчилгээг дэвшилттэйгээр өргөтгөх үүрэгтэй” гэж зааснаар усаар хангагдах эрхэд ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийг багтаасан байна. Мөн уг эрхийн хүрээнд ариун цэврийн талаар сурч боловсрох эрхийг хөндөх ба хангалттай, хүрэлцэхүйц цэвэр устай байсан ч эрүүл ахуйн шаардлага хангаагүй зан үйлийн улмаас халдварт өвчин тусах магадлалтайг үүнд онцолж байна. Нөгөө талаас усаар хангагдах эрх нь ариун цэврийн байгууламжаар хангагдах эрх, цэвэр усаар хангагдах эрх, ариун цэврийн талаар сурч боловсрох эрхүүдтэй шууд уялдаа холбоотой. Цэвэр ус, эрүүл ахуй, ариун цэврийн асуудлыг ярихгүйгээр

усны чанарт анхаарах нь өрөөсгөл учир дутагдалтай болохыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүй ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрх хариуцсан Тусгай илтгэгч цохон тэмдэглэжээ.

Усаар хангагдах эрхийг Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн 14 дүгээр зүйлийн 2(h), Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 24 дүгээр зүйлийн 2(c), Хүмүүнлэгийн эрх зүйн тулгуур болсон Женевийн конвенцууд, тэдгээрийн нэмэлт протокол, Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан хөтөлбөр, зарчим, зөвлөмж, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан байна.

Улсуудын зүгээс усны эдийн засгийн үнэлэмж харилцан адилгүй байгаагаас гадна тухайн харилцааг бүрэн дүүрэн зохицуулж, мөнгөн дүнгээр илэрхийлж чадахгүй байна. Гэсэн хэдий ч усны гүйцэтгэх чиг үүрэг, үнэ цэнэтэй уялдуулан гурван түвшинд авч үзэх боломжтой. Үүнд:

1. Усыг амьдралд – хүн төрөлхтөн болон бусад амьд биетийг тэтгэхийн тулд усыг ашиглахыг хэлнэ. Усыг хүний эрх хэмээн хүлээн зөвшөөрч, сайн чанарын цэвэр усыг хамгийн бага хэмжээгээр хүн бүрт хүргэх боломжтой эко тогтолцоог тогтвортойгоор хадгалах, баталгаажуулахыг эн тэргүүнд авч үзэхийг ойлгоно.

2. Усыг иргэдэд – иргэний эдлэх нийгмийн эрх болон нийгмийн нийтлэг сонирхолд тулгуурлан нийтийн эрүүл мэнд, нийтийн ашиг сонирхол, тэгш эрхийн үүднээс усыг хоёрдугаарт чухал гэж үзэхийг хэлнэ. Төрийн байгууллага гол үүрэг гүйцэтгэнэ.

3. Усыг хөгжилд – эдийн засгийн чиг үүрэгтэй уялдах аж үйлдвэр, газар тариалангийн усалгаа, усан цахилгаан станц зэрэг үйлдвэрлэлтэй холбоотой хувийн ашиг сонирхлыг гуравдугаарт тооцно.

НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны 15 дугаар Ерөнхий Зөвлөмжийн 2 дахь догол мөрт заасны дагуу усаар хангагдах хүний эрх нь хүн бүрт хамаатай ба хувийн болон гэр бүлийн хэрэгцээндээ хүрэлцээтэй хэмжээгээр усыг хэрэглэх эрхтэйг тусгайлан тодорхойлжээ. Ялангуяа тус хороо “Усыг түгээхдээ хувийн болон гэр бүлийн хэрэгцээнд усаар хангагдах хүний эрхийг чухалчлах ёстой” гэж дүгнэсэн. Үүний зэрэгцээ цэвэр усны байгууламж, түгээлтийн төв, шугам хоолой зэрэг барилга байгууламжийг олон нийтийн эрүүл мэндэд сөрөг нөлөө учрахаас урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн тусгай хамгаалалтад байлгах ёстой.

**ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛ БАЙГУУЛАХ
БУЮУ ТҮҮНД НЭГДЭХ ЭРХ
RIGHT TO FORM AND TO JOIN TRADE UNIONS**

“Хүн бүр эрх ашгаа хамгаалах зорилгоор үйлдвэрчний эвлэл байгуулах буюу үйлдвэрчний эвлэлд нэгдэх эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 23 дугаар зүйлийн 4 дэх заалт)

“... хүн бүр эдийн засаг, нийгмийн ашиг сонирхлоо хамгаалах, хэрэгжүүлэхийн тулд үйлдвэрчний эвлэл байгуулах, журмыг нь сахих үндсэн дээр сонгосон байгууллагадаа элсэн орох эрхтэй. Дээр дурдсан эрхийг эдлэхэд хуульд заасан буюу ардчилсан нийгэмд шаардагдах үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах ашиг сонирхлоос бусад ямарваа хязгаарлалт тогтоохыг хориглоно.”

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 8 дугаар зүйлийн 1(а) заалт)

Үйлдвэрчний эвлэл буюу ажиллагчдын байгууллага нь ажиллагчдын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлыг хамтын ажиллагаагаар дамжуулан хамгаалах, дээшлүүлэх зорилгоор байгуулагддаг. Хөдөлмөр эрхлэлтийн салбарт ажилчид, ажил олгогчдын эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулах болон хамтын гэрээ хэлэлцээр хийх эрхийг олон улсын эрх зүйгээр хамгаалан баталгаажуулсан байдаг. Үүнд Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 20, 23 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 22 дугаар зүйл, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 8 дугаар зүйлд тус тус хүн бүрийн үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрх, үйлдвэрчний эвлэл байгуулах эрхийг баталгаажуулсан байдаг. Мөн эвлэлдэн нэгдэх эрхийн талаар Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай 1948 оны 87 дугаар Конвенц, Зохион байгуулах, хамтын хэлэлцээ хийх эрхийн тухай 1949 оны 98 дугаар Конвенц, Хөдөөгийн ажиллагчдын байгууллагуудын тухай 1975 оны 141 дүгээр Конвенц, 149 дүгээр Зөвлөмж зэргийн хүрээнд нарийвчлан зохицуулсан байдаг.

Үйлдвэрчний эвлэл нь иргэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамтран хамгаалах, хамтын гэрээ хэлэлцээрийн зарчмаар хөдөлмөрийн нөхцөл болон амьдралын түвшингээ дээшлүүлэх, нийгэм болон бусад асуудлаар үзэл бодлоо илэрхийлэхийн тулд өөрсдийнхөө санаачилгаар байгуулсан байнгын

ажиллагаатай, ардчилсан байгууллага юм.

Үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь:

- Ажиллагсдын эрх ашгийг хамгаалах
- Ажиллагсдын ажлын хэвийн нөхцөлийг хангах
- Аливаа асуудлыг хамтаараа хэлэлцэн тохиролцох замаар шийдвэрлэх
- Амьдралын нь нөхцөл байдлыг дээшлүүлэх арга зам эрж хайх, тусламж дэмжлэг үзүүлэх
- Нийгмийн аливаа асуудлаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх нөхцөл бололцоо бүрдүүлж өгөх зэрэг болно.

Бүхий л улс оронд үйлдвэрчний эвлэл нь хуулийн этгээдийн эрхтэй байх бөгөөд төрийн холбогдох байгууллагад албан ёсоор бүртгүүлэх ёстой. Хамт олны нэрийн өмнөөс аливаа асуудлыг шийдвэрлэдэг байгууллага учраас хамт олны хэлэлцүүлэг, ажилчдын сонгууль зэрэгт оролцон манлайлж, ажилчдын итгэл найдварыг нь хүлээсэн төлөөлөгчид энэ байгууллагыг бүрдүүлдэг.

Үйлдвэрчний эвлэл нь ажиллагчдыг идэвхитэй зохион байгуулж, тэдний ашиг сонирхлыг хамтын хэлэлцээгээр дамжуулан хамгаалах механизм юм. Үйлдвэрчний эвлэл, түүний төлөөлөл, гишүүд нь удирдлагатай харьцах харилцаагаараа дамжуулан адил тэгш цалин хөлс, тэгш боломж олгох зэрэг олон асуудлаар ажил олгогчидтой хэлэлцэн тохирч, ажиллагчдын эрхийг хамгаалдаг. Иймд үйлдвэрчний эвлэл нь Засгийн газар болон ажил олгогчдын байгууллагуудын хамт нийгмийн яриа хэлэлцээнд оролцох гурван талт бүтцийн нэг болдог.

Үйлдвэрчний эвлэл нь сайн дураараа чөлөөтэй эвлэлдэн нэгдэж үйл ажиллагаа явуулах тул түүнээс гарах, татгалзах нь мөн сайн дурын байна.

Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасанчлан, иргэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор аливаа зөвшөөрөл авалгүй, гагцхүү өөрсдийн сайн дурын үндсэн дээр ямар нэг ялгаваргүйгээр үйлдвэрчний эвлэлд чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй. Мөн үйлдвэрчний эвлэлд гишүүнээр элсэх буюу гишүүнээс гарахыг тулган шаардаж болохгүй.

**ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА
СААДГҮЙ ЯВУУЛАХ ЭРХ
RIGHT OF TRADE UNIONS TO FUNCTION FREELY**

“... хүн бүр эдийн засаг, нийгмийн ашиг сонирхлоо хатгаалах, хэрэгжүүлэхийн тулд үйлдвэрчний эвлэл байгуулах, журмыг нь сахих үндсэн дээр сонгосон байгууллагадаа элсэн орох эрхтэй. Дээр дурдсан эрхийг эдлэхэд хуульд заасан буюу ардчилсан нийгэмд шаардагдах үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах, бусдын эрх, эрх чөлөөг хатгаалах ашиг сонирхлоос бусад ямарваа хязгаарлалт тогтоохыг хориглоно.”

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 8 дугаар зүйлийн 1(а) заалт)

Ажиллагчид ба ажил олгогчид өөрсдийн сонголтоор байгууллага байгуулах, эсхүл түүнд нэгдэн орох эрхтэй. Уг байгууллагууд нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- өөрсдийн дүрэм журмыг боловсруулан хэрэгжүүлэх;
- төлөөлөгчдөө бүрэн, чөлөөтэй сонгох;
- захиргаа болон үйл ажиллагаагаа зохион байгуулах, хөтөлбөрөө томъёолох;

- ХҮНИЙ ЭРХИЙН ТОВЧ ТАЙЛБАР -

- захиргааны журмаар тараалгах буюу үйл ажиллагаагаа түр зогсоолгохгүй байх;
- эвсэл холбоо байгуулах эсхүл буюу түүнд нэгдэн орох.

Үйлдвэрчний эвлэлийн байгууллага нь тэгш боломж олгох, тэгш хандах тухай дараах чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлбэл зохино. Үүнд:

- Тэгш боломж олгох, ялгаварлан гадуурхлаас хамгаалах, гэр бүлд ээлтэй зохицуулалтын асуудлыг хамтын хэлэлцээний гэрээнд тусган оруулах хэлэлцээ хийх;
- Тэгш боломж олгох, тэгш хандах тухай бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хянахад удирдлагатай хамтран ажиллах;
- Үйлдвэрчний эвлэлийн байгууллага төлөөлөгч, гишүүдийнхээ хүрээнд тэгш боломж, тэгш хандлагыг, хүйсийн тэнцвэртэй төлөөллийг бий болгох ёстой.

**ҮНДЭСНИЙ ХОЛБОО, НЭГДЭЛ БАЙГУУЛАХ
ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ЭРХ
RIGHT OF TRADE UNIONS TO ESTABLISH NATIONAL FEDERATIONS OR CONFEDERATIONS**

“...үйлдвэрчний эвлэлээс үндэсний холбоо, нэгдэл байгуулах эрх, түүнчлэн үндэсний холбоо, нэгдлээс олон улсын үйлдвэрчний байгууллагыг үүсгэх буюу түүнд нэгдэн орох эрхтэй.”

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 8 дугаар зүйлийн 1(b) заалт)

Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрх нь ажиллагчид, ажил олгогчид хөдөлмөрлөх эрхээ чөлөөтэй эдлэх, ашиг сонирхлоо илэрхийлэх,

хамгаалах зорилгоор эвлэлдэн нэгдэхэд чиглэсэн суурь зарчим юм. Тиймээс мэргэжил, үйлдвэрлэлийн шинж болон нутаг дэвсгэрийн харьяаллаар байгуулагдсан Үйлдвэрчний эвлэлүүд нь үндэсний холбоо, нэгдэл байгуулан үйл ажиллагаагаа нэгтгэн зохион байгуулах эрхийг баталгаажуулсан байдаг.

Дэлхийн өнцөг булан бүрт ажилчдын эрх ашгийг хамгаалах шаардлагаар үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөнүүд идэвхтэй ажиллаж, шийдвэр гаргагчид болон ажил олгогчдод хүчтэй нөлөөг үзүүлж, бодлогыг өөрчлөхийг зорьдог.

Ажиллагчдын эрхийг дэмжих, хамгаалахын тулд үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд нэгдэн нийлэх нь илүү үр дүнтэй ажиллах үндэс суурь болдог. Тиймээс хөдөлмөрлөх эрх ашигтай холбоотой гарах зөрчил дутагдлыг арилгахын тулд Үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд салбар хоорондоо төдийгүй улс орны, мөн олон улсын хэмжээнд эвлэлдэн нэгдэж, хамтын үйл ажиллагаа явуулдаг. Ажиллагчид холбоо байгуулахтай холбоотойгоор ялгаварлан гадуурхлаас хамгаалагдсан байх ёстой.

Мөнажиллагсдын болон ажил олгогчдын байгууллагууд нь хэн нэгнийгээ давамгайлах, санхүүжүүлэх болон хянах зорилгоор бие биеийнхээ хэрэгт харилцан оролцох үйлдлээс хамгаалагдсан байна.

Энэхүү эрхийг Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай 1948 оны 87 дугаар Конвенц, Ажилчдын төлөөлөгчдийн тухай 1971 оны 135 дугаар Конвенц, Хамтын хэлэлцээрийн тухай 1981 оны 154 дүгээр Конвенц, 163 дугаар Зөвлөмж зэрэгт тусгайлан зааж, баталгаажуулсан байдаг.

Ажиллагчид ба ажил олгогчид өөрсдийн сонголтоор байгууллага байгуулах, эсхүл түүнд нэгдэн орох

эрхтэй. Байгууллагууд нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- өөрсдийн дүрэм журмыг боловсруулан хэрэгжүүлэх;
- төлөөлөгчдөө бүрэн, чөлөөтэй сонгох;
- захиргаа болон үйл ажиллагаагаа зохион байгуулах, хөтөлбөрөө томъёолох;
- захиргааны журмаар тараалгах буюу үйл ажиллагаагаа түр зогсоолгохгүй байх;
- эвсэл холбоо байгуулах эсхүл буюу түүнд нэгдэн орох.

Үйлдвэрчний эвлэлийн байгууллага нь тэгш боломж олгох, тэгш хандах тухай дараах чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- Тэгш боломж олгох, ялгаварлан гадуурхлаас хамгаалах, гэр бүлд ээлтэй зохицуулалтын асуудлыг хамтын хэлэлцээний гэрээнд тусган оруулах хэлэлцээ хийх;

- Тэгш боломж олгох, тэгш хандах тухай бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хянахад удирдлагатай хамтран ажиллах;

- Үйлдвэрчний эвлэлийн байгууллага төлөөлөгч, гишүүдийнхээ хүрээнд тэгш боломж, тэгш хандлагыг, хүйсийн тэнцвэртэй төлөөллийг бий болгох ёстой.

Гэвч олон орны эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний тухай хууль тогтоомж нь газар тариалангийн салбарт, экспортын бүтээгдэхүүн боловсруулалтын бүс болон албан бус салбарт ажиллагчид, шилжин ажиллагчид, гэрийн үйлчлэгч зэрэг ажиллагчдыг эрх зүйн хамгаалал хүртэх боломжийг олгохгүй байгаа нь өнөөгийн анхаарал татсан асуудал болж байна. Иймд үйлдвэрчний эвлэл өнөөг хүртэл зохион байгуулагдаагүй байгаа ажиллагчдад хүрч, үйл ажиллагааг нь өргөжүүлэх шаардлагатай байна гэж үздэг.

**ХИЙСЭНДЭЭ ТААРСАН, ХҮРТЭЭМЖТЭЙ ШАН
ХӨЛС АВАХ ЭРХ
RIGHT TO JUST AND FAVORABLE REMUNERATION**

“Ажил хөдөлмөр эрхэлж байгаа хэн боловч хувийн болон ал бүлийнхээ ахуй амьжиргааг хүний зэрэгтэй авч явахад хүрэлцэхүйц бөгөөд зайлшгүй тохиолдолд нийгмийн хангамжийн эх үүсвэрээр нэмэн арвижуулсан, хийсэндээ таарсан, хүртээмжтэй шан хөлс авах эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 23 дүгээр зүйлийн 3 дахь заалт)

“Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүр хөдөлмөрийн шударга, таатай нөхцлөөр хангагдах эрхийг хүлээн зөвшөөрөх бөгөөд тухайлбал:

- (с) гагцхүү ажилласан хугацаа, мэргэшилд үндэслэн зохих дээд шатны ажилд дэвших адил боломжийг хүн бүрт олгох;

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйлийн ii(c) заалт)

“...ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт)

Энэ эрхийн хүрээнд амьжиргаагаа хангахуйц цалин хөлс авах, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тодорхойлох, ажиллагсдын нийгмийн баталгааг хангах зэрэг өргөн хүрээтэй асуудлыг хамруулсан

бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлж байдаг.

Цалин хөлс нь ажиллагчийн аж байдал, нийгмийн баталгааны наад захын хэм хэмжээг хангах үндсэн хэрэгсэл тул улс орнуудын хөдөлмөрийн бодлогын гол хэрэгсэл болдог. Цалин хөлсийг тогтоохдоо эрх ашиг нь хөндөгдөж буй ажил олгогч болон ажиллагчдын төлөөллийн байгууллагын аль аль нь зөвшилцөлд эрх тэгш оролцож, тогтоосон хэмжээг дагаж мөрдөх үүрэг хүлээсэн байдаг.

Цалин хөлсийг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 100 дугаар Конвенцийн 1 дүгээр зүйлийн а-д “эрхлэх ажилтай нь холбоотойгоор ажил олгогчоос ажилчинд шууд буюу шууд бусаар, мөнгөн буюу биет байдлаар олгох ердийн, үндсэн буюу доод хэмжээний цалин, эсхүл ажлын хөлс болон бусад нэмэлт шанг хэлнэ” гэж тодорхойлжээ. Цалин хөлсний хэмжээг тогтооход ажиллагчийн болон түүний гэр бүлийн хэрэгцээ, дундаж цалин, амьжиргааны өртгийн өөрчлөлт, нийгмийн хамгааллын тэтгэмжийн хэмжээ, бусад нийгмийн бүлгүүдтэй харьцуулсан түвшин болон эдийн засгийн өсөлт, хөдөлмөрийн бүтээмж зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай байдаг. Энэ эрхийн хүрээнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох тухай асуудал хамрагддаг бөгөөд энэ нь Үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдээгүй, хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэлтэй, мэргэжил, боловсролгүй ажилчдыг хамгаалах зорилготой арга хэмжээ юм. Энэ талаар Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох процедурын тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 26 дугаар конвенц, Хөгжиж буй орнуудад Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 131

дүгээр Конвенц, Хөгжиж буй орнуудад Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 135 дугаар зөвлөмжийг батлан гаргасан байна. Үүнд тодорхойлсноор “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ” нь цалин хөлсний хуваарилалтын хамгийн доод хэсэгт байгаа ажилчдыг хамгаалах зорилгоор тогтоосон цалингийн бүтцийн суурь давхаргын хамгийн бага хэмжээ юм. Олон улсын нийтлэг хандлагыг үзвэл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй холбоотой харилцааг ихэвчлэн хуулиар зохицуулж байна. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын гишүүн орнуудын 90 гаруй хувь нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоон мөрдүүлж байгаа бөгөөд энэ нь цалин хөлсний бодлогын нийтлэг хэрэгсэл болж байна.

Монгол Улс Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийг анх 1998 онд батлан хэрэгжүүлжээ. УИХ-аас 2010 онд уг хуулийг шинэчлэн баталсан бөгөөд түүнд тодорхойлсноор “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ” нь тодорхой боловсрол, тусгай мэргэжил үл шаардах энгийн ажилд хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээгээр ажиллаж байгаа ажилтан болон ажиллагчийн ашиг сонирхлыг хуулиар хамгаалах зорилгоор эрх бүхий этгээдээс тогтоосон цагийн үндсэн цалин (хөлс)-гийн нийтээр дагаж мөрдвөл зохих хамгийн доод хязгаар” ажээ. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох болон өөрчлөхдөө амьжиргааны өртгийн өөрчлөлт, хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн зохистой харьцаа, эдийн засгийн өсөлт болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин болон нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн

хэмжээг харгалзахаар заасан байдаг. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай 1998 оны хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 351 тоот тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг цагийн 642 төгрөг 86 мөнгө, сарын 108000 төгрөгөөр тогтоосон бөгөөд одоогоор мөрдөгдөж байна.

**ХӨДЛӨХ, ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ ШУДАРГААР
ОЛЖ АВАХ, ӨМЧЛӨХ ЭРХ
THE RIGHT TO FAIR ACQUISITION, POSSESSION OF MOVABLE
AND IMMOVABLE PROPERTY**

“Хүн бүр эд хөрөнгийг ганцаараа буюу бусадтай хамтарч өмчлөх эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 17 дугаар зүйлийн 1 дэх заалт)

“хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгалтжуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө;”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт)

Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах эрхийг тайлбарлахаас өмнө өмчлөх эрхийн талаар авч үзэх нь логик дарааллын хувьд оновчтой юм.

Өмч хөрөнгөтэй байх эрх бол хүний үндсэн эрхүүдийн дотроос амьд явах эрхийн дараа бичигдэх нэн чухал эрх

бөгөөд хүний ууж идэх, өмсөх, амьсгалахтай адил төрөлх хэрэгцээ байдаг тул жам ёсны эрх мөн. Тодруулбал, өмчлөх эрх бол хүн төрөхөд л хамт бий болдог эрх бөгөөд ердийн хуулиар хамгаалсан хамгаалаагүйгээс үл хамааран шууд хэрэгжих үндсэн эрх юм.

Хувь хүн хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн, зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүй эдийн баялаг болох эд юмс, эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлсийг шударгаар олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах (худалдах, бэлэглэх, шилжүүлэх, өв залгамжлуулах)-ыг өмчлөх эрх гэнэ. Монгол Улсын иргэн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй гэж Үндсэн хуульд заасан. Хүн бүх өмчлөх адилхан эрхтэй боловч өмчтэй болох нөхцөл, өмчийг бий болгох чадвар нь адил тэгш заяадаггүй болохоор янз бүрийн хэмжээний өмч хөрөнгөтэй байдаг.

Эд хөрөнгийг өмчлөх, эзэмших, ашиглах захиран зарцуулах ерөнхий журмыг иргэний болон салбарын хууль тогтоомжоор зохицуулдаг. Харин үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой хариуцагч үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн, газрын, иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар тусгайлан зохицуулдаг.

Хөдлөх, үл хөдлөх шударгаар олж авч, түүнийгээ өмчлөх эрхийг хүний эрх, эрх чөлөөний салшгүй хэсэг гэдэг утгаар нь хөгжүүлж, тайлбарласан хүн бол Жон Локк юм. Түүнээс өмнө эрх зүйн онолчид өмчлөх эрхийг тайлбарлах оролдлого хийж тодорхой үр дүнд хүрч байсан хэдий ч хязгаарлаж болох зарим эрхүүдээс өмчлөх эрхийг салгаж, үл хязгаарлагдах эрхтэй нэгтгэх алхмыг анхлан санаачилж, төрийн зүгээс өмчлөх эрхийг хүндэтгэх эхлэлийг тавьсан хүн

бол Ж.Локк билээ. Хүний бие махбодиороо бүтээсэн хөдөлмөр, гараараа хийж буй ажил зэргийг түүний өмч гэж ойлгоно хэмээн тэрээр хэлжээ. Өөрөөр хэлбэл ямарваа объектод хөдөлмөрөө шингээж, түүндээ өөрийн ажил хөдөлмөрийн үр дүнг нэгтгэсэн тохиолдолд тухайн хөрөнгө тэр хүний өмч болно гэсэн санааг Ж.Локк хөдөлмөрийн онолын үүднээс дэвшүүлсэн юм. Ж.Локк хөдөлмөрийн үндсэн дээр өмчлөх эрх бий болно гэдгийг хүн бие махбод, оюун санаагаа төрсөн цагаасаа эхлэн өөрөө өмчлөх явдалтай салшгүй холбоотой зүйл гэж үзсэн нь эрх зүйн хөгжлийн өнөөгийн түвшинд өмчлөх эрхийг хүний амьд явах эрхийн дараа орох үндсэн эрх болтлоо үнэлэгдэхэд хүргэжээ.

Монгол Улсын Иргэний хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3 дахь хэсэгт хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийн ялгааг гаргахдаа газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмс үл хөдлөх эд хөрөнгөд хамаарч, үүнээс бусад эд хөрөнгийг хөдлөх эд хөрөнгөд хамаарахаар оруулсан нь иргэний эрх зүй, тэр дундаа эд юмсын эрх зүйн орчин үеийн онолын чиг хандлага дээр суурилсан шинжтэй болжээ.

Дээрх эд хөрөнгийг шударгаар олж авах тухай ойлголт нь өмчлөх эрхийн хөдөлмөрийн онолоос эхлэлтэй бөгөөд хүний өмч олж авсан үйл явц аливаа нөхцөлд зүй ёсны байх ёстой гэсэн үндсэн зарчимд тулгуурладаг. Тодруулбал, зүй ёсны, шударга арга замаар эд хөрөнгийг олж авсан, эзэмшсэн тохиолдолд тэр нь тухайн этгээдийн өмчлөлд орж болох тул Монгол Улсын Үндсэн хуульд өмчлөх эрхийн заалтыг баталгаажуулахдаа өмчлөх эрхийн өмнө "...шударгаар олж авах, эзэмших..." гэж оруулсан нь түүний урьдач нөхцлийг тодорхойлсон шинжтэй болсноороо давуутай юм.

Үндсэн хуулийн энэ заалтад “...өмчлөх...” эрхтэй гэсэн нь өмчөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг бүхэлд нь агуулсан ойлголт боловч эд хөрөнгөө захиран зарцуулснаар түүний хувьд тухайн эд хөрөнгийг өмчлөх эрх дуусгавар болж, харин шинэ өмчлөгчид уг эд хөрөнгийг өмчлөх эрх үүсэх үр дагавар бий болдог.

**ХӨДӨЛМӨРИЙН АЯТАЙ,
ТААТАЙ НӨХЦЛӨӨР ХАНГУУЛАХ
RIGHT TO JUST AND FAVOURABLE CONDITIONS OF WORK**

“... Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах, ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 23 дугаар зүйлийн 1 дэх заалт)

Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүр хөдөлмөрийн шударга, таатай нөхцлөөр хангагдах эрхийг хүлээн зөвшөөрөх бөгөөд тухайлбал:

“ажуулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон ажлын нөхцлийг бүрдүүлэх;”

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйлийн ii(b) заалт)

“... хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах, ... эрхтэй.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт)

Хөдөлмөрлөх эрхийн талаар Нэгдсэн Үндэстний

Байгууллагын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хорооноос 2005 онд гаргасан ерөнхий зөвлөмжид хөдөлмөрийн шударга, таатай нөхцлийг дараах үндсэн хүрээнд авч үзсэн байна. Үүнд:

- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа буюу ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой ажилтнуудын бие махбодь, оюун санааны халдашгүй байдал

- Өөрийн болон гэр бүлийн амьжиргааг тэтгэж хүрэлцэхүйц хэмжээний цалин хөлс авах

Энэхүү эрх нь ажилчдад болон тэдний гэр бүлд амьдралын аятай таатай нөхцлийг баталгаажуулахын тулд бага цалинтай ажилчдыг хамгаалах, цалингийн доод хэмжээг тогтоож өгөх, ижил төрлийн ажилд адил цалин олгох зарчмыг хэрэгжүүлэх, ажлын байран дээр нас, хүйс, шашин шүтлэг, угсаа гарал зэрэг хүний хувийн шинжээр нь ялгаварлан гадуурхахаас хамгаалах зэрэг олон ойлголтыг хамаардаг.

Ажиллагсдад хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд орохоос өмнө тэдний цалин хөлс, холбогдох зүйлсийг мэдээлэх ёстой.

ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХ RIGHT TO WORK

“... Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах, ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 23 дугаар зүйлийн 1 дэх заалт)

“... Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүр аж төрөхдөө чөлөөтэй сонгох, чөлөөтэй тохиролцох боломжийг олгосон хөдөлмөрлөх эрхийг хүлээн

зөвшөөрч, энэ эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зохистой алхам хийнэ.”

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 6 дугаар зүйлийн 1 дэх заалт)

“...ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, алрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт)

Хөдөлмөрлөх эрх нь хүний суурь эрхийн нэг бөгөөд маш өргөн утгатай ойлголт юм. Хөдөлмөрлөх эрхийн хүрээнд хөдөлмөрийн харилцаа, түүн дэх ялгаварлан гадуурхалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нийгмийн хамгаалал, ажлын цаг, цалин хөлс, нийгмийн яриа хэлэлцээ, хууль бус хөдөлмөр эрхлэлт, хүүхдийн хөдөлмөр зэргээс гадна сүүлийн үед ХДХВ-ДОХ болон албадан хөдөлмөр зэрэг өргөн хүрээний асуудлуудыг хамруулж үздэг байна.

Хувь хүн ажлынхаа төрөл, хэлбэрийг хэний ч дарамт шахалтгүйгээр зөвхөн өөрөө шийдвэрлэх эрхийг ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрх гэнэ. Хувь хүн ажлаа чөлөөтэй сонгож, хийсэн ажлынхаа үр шимийг хүртэхийг хөдөлмөрлөх эрх гэнэ. Хэнийг ч албадан хөдөлмөрлүүлж үл болно. Өөрөөр хэлбэл хүн хөдөлмөрлөхгүй ч байж болно.

Хөдөлмөрийн харилцаа нь эдийн засгийн хөгжил, улс төрийн үзэл баримтлал, үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэл зэргээс хамаарч улс орон бүрт өөр өөрөөр зохион байгуулагдаж байдаг. Олон улсын хөдөлмөрийн байгууллага нь 1919 онд үүсэн

байгуулагдсанаасаа эхлэн хөдөлмөрлөх эрхийн суурь зарчим, шаардлагуудыг тодорхойлж, хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Тиймээс Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хөдөлмөрийн харилцааг зохицуулсан конвенц, зөвлөмжүүдийг улс орнууд өргөн хүрээнд соёрхон баталсан байдаг.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо, Ерөнхий тайлбар No.18-д Хөдөлмөрлөх эрхийг дэлгэрүүлэн тайлбарласан байдаг. (E/C.12/GC/18, 2006 оны 2-р сарын 6) пактын 2 дугаар зүйлд эрх тэгш байдлын үндсэн дээр хөдөлмөрлөх эрхийг нь хангах, улмаар хөдөлмөрийн харилцаанд яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, эд хөрөнгийн байдал, угсаа гарал, биеийн болон оюуны хөгжлийн бэрхшээл, ХДХВ/ДОХ-ыг оролцуулан эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг баримжаа зэргээр ялгаварлан гадуурхахыг хориглодог байна.

Монгол Улсын Үндсэн хуульд “Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрлөх, цалин хөлс авах, амрах” хэмээн хүний хөдөлмөрлөхтэй холбоотой эрхийг баталгаажуулж заасны зэрэгцээ Монгол Улсын нэгдэн орсон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт болон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 10 гаруй гэрээ, конвенцийн заалтууд, хөдөлмөрлөхтэй холбоо бүхий л хүний эрхийн олон улсын суурь зарчмуудыг Хөдөлмөрийн хууль, тогтоомжид үндсэндээ тусгасан байна. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1-д ажилтан нь “Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хөдөлмөрийн нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, өөрөө болон төлөөллийн байгууллагаараа дамжуулан эрх,

хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор эвлэлдэн нэгдэх, хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж авах, хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээрт заасан бусад эрх, хөнгөлөлт эдлэх эрхтэй” гэж хөдөлмөрлөх эрхийн ерөнхий стандартыг тодорхойлж өгсөн байна.

Үндсэн хуульд заасан “Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрх”-ээ хэрэгжүүлэх үндсэн арга зам бол өөртөө хөдөлмөрлөхөөс гадна Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ажил олгогчтой “хөдөлмөрийн гэрээ” байгуулан ажиллах явдал юм. Монгол Улсын иргэн, Гадаадын иргэн (Гадаад улсын харьяат мөн болохыг гэрчилсэн хууль ёсны нотолгоотой хүн), Харьяалалгүй хүн (Аль ч улсын иргэн биш хүн) ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулж ажилд орсноор хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан болно. Ажилтан ажил олгогч хөдөлмөрийн гэрээ бичгээр байгуулснаа ажилтан эрхээ хамгаалах, ажил олгогч гэрээнд заасны дагуу ажил үүргээ гүйцэтгэхийг шаардах эрх үүснэ.

Хөдөлмөрлөх эрхийн талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хорооноос 2005 онд гаргасан ерөнхий зөвлөмжид хөдөлмөрийн шударга, таатай нөхцлийг дараах үндсэн хүрээнд авч үзсэн байна. Үүнд:

- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа буюу ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой ажилтнуудын бие махбодь, оюун санааны халдашгүй байдал

- Өөрийн болон гэр бүлийн амьжиргааг тэтгэж хүрэлцэхүйц хэмжээний цалин хөлс авах.

Энэхүү эрх нь ажилчдад болон тэдний гэр бүлд амьдралын аятай таатай нөхцлийг баталгаажуулахын тулд бага цалинтай ажилчдыг хамгаалах, цалингийн

доод хэмжээг тогтоож өгөх, ижил төрлийн ажилд адил цалин олгох зарчмыг хэрэгжүүлэх, ажлын байран дээр нас, хүйс, шашин шүтлэг, угсаа гарал зэрэг хүний хувийн шинжээр нь ялгаварлан гадуурхахаас хамгаалах зэрэг олон ойлголтыг хамаардаг. Ажиллагсдад хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд орохоос өмнө тэдний цалин хөлс, холбогдох зүйлсийг мэдээлэх ёстой.

**ШИНЖЛЭХ УХААНЫ ДЭВШЛИЙН ҮР ДҮНГ
АШИГЛАХ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЛЭХ ЭРХ
RIGHT TO ENJOY THE BENEFITS OF SCIENTIFIC PROGRESS
AND ITS APPLICATIONS**

“Хүн бүр нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох, урлагийн цэнгэлийг эдлэх, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 27 дугаар зүйлийн 1 дэх заалт)

“шинжлэх ухааны дэвшлийн үр дүнг ашиглах, түүнийг хэрэглэх”

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 15 дугаар зүйлийн 1(b) заалт)

“соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар халгаална;”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 8 дахь заалт)

Уг эрхийн тухай анхны ойлголтыг 1948 онд гарсан Иргэний эрх, үүргийн тухай Америкийн тунхагт “хүн бүр оюуны бүтээл, нэн ялангуяа шинжлэх ухааны

нээлтийн үр шимийг хүртэхэд оролцох эрхтэй” гэж анхлан тодорхойлон заасан байна.

Шинжлэх ухаан, технологийн үсрэнгүй хөгжлийн эрин үед энэхүү эрх нь дан ганц хувь хүнд хамаарах төдийгээр хязгаарлагдахаа больж, олон нийтийн амьдралд шинжлэх ухааны дэвшлийн үр дүнг ашиглах явдал чухлаар тавигдах болсон билээ.

Энэ эрх нь Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай пактад дурдагдсан бусад эрхүүд, соёлын амьдралд оролцох; өөрийнхөө туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны аливаа бүтээлтэй холбогдон үүссэн ёс суртахууны болон эд материалын ашиг сонирхлыг хамгаалуулах зэрэг эрхтэй салшгүй холбоотойгоор хэрэгжих учиртай.

“Шинжлэх ухааны дэвшил” гэдэг нь шинжлэх ухааны тодорхой арга зүйн тусламжтайгаар асуудлыг шийдвэрлэх чадвараа дээшлүүлэх тухай ойлголт юм. Шинжлэх ухаан нь олон талтай цогц систем учраас шинжлэх ухааны дэвшил түүнийг дагаад олон хэлбэртэй.

ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ THE RIGHT TO HEALTHY AND SAFE ENVIRONMENT

“эрүүл, аюулгүй орчинд амьдрах ... эрхтэй.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь заалт)

Орчин гэдэг нь байгалиас түүнчлэн хүний гараар бүтсэн тухайн хүний болон хүний олонлогийн эргэн тойрныг хамруулсан ойлголт юм.

Тэр дундаа эрүүл, аюулгүй орчин нь дан ганц хүн бус, бусад амьд амьтан, ургамал зэрэгт хамаарах өргөн

хүрээтэй ойлголт юм. Хүмүүс эдгээрийг зааглахдаа “хүний эрүүл, аюулгүй орчин” гэх ойлголтыг бий болгожээ.

Эрүүл, аюулгүй орчин нь хүмүүс өдөр тутмын амьдралдаа амь бие, эрүүл мэнддээ халтай аливаа нөлөөлөлд өртөхгүй байх, түүнээс ангид байх боломж юм.

Эрүүл орчин нь гол төлөв байгалийн тэнцэл, хүрээлэн буй орчны төлөв байдал дээр яригддаг бөгөөд агаар, ус, газар болон үүнтэй холбоотой бусад өргөн хүрээний хүчин зүйлсийг авч үздэг.

Аюулгүй орчин нь нийгэм-улс төрийн шинжтэй ойлголтыг илэрхийлэх бөгөөд үүний наад заахын шаардлага нь нийгэм-улс төрийн шинжтэй хүчирхийллээс ангид байх, хүчирхийллийн үед төрийн онцгой бүрэн эрхийг хууль ёсны хүрээнд хэрэгжүүлэх, олон нийтийн хэв журмыг хангах, бие махбодийн аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг бүрдүүлэхэд оршино.

Үндсэн хуульт ёс тогтсоноор хүний үндсэн эрх, эрх чөлөөг улс орнууд Үндсэн хуульдаа баталгаажуулсан нь хүний эрхийн хөгжлийн эхний үе шатанд хамаардаг. Харин эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь хүн амьд явах эрхээ эдлэхтэй нягт холбоотой агаад орчин үеийн нийгэм, эдийн засаг, соёлын хөгжилтэй уялдан хүний эрхийн хөгжлийн гурав дахь үе шатанд бий болжээ. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1966 онд баталсан Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад “...орчны болон үйлдвэрлэлийн эрүүл ахуйг бүх талаар сайжруулах...”-ыг оролцогч улс бүрт үүрэг болгосон нь цаашлаад хүрээлэн буй орчны гэгдэх энэхүү эрх бий болох үндсийг тавьсан байна.

1972 оны 6 дугаар сард Хүний хүрээлэн буй орчны талаар хуралдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын

чуулга уулзалт Шведийн нийслэл Стокольм хотноо болж, уг чуулга уулзалтаар Хүрээлэн буй орчны тухай Стокольмын тунхагийг баталсан байна. Энэхүү баримт бичгийг хүрээлэн буй орчны эрхийн үндсийг тавьсан анхны баримт бичиг гэж үздэг. Тунхагийн суурь зарчмуудын 1 дүгээрт: “Хүн бүр эрхэмсэг, сайн сайхан амьдрах нөхцлийг бүрдүүлдэг дээд зэргийн орчинд эрх чөлөөтэй, эрх тэгш байх, амьдралын таатай нөхцлөөр хангагдах үндсэн эрхтэй агаад одоо ба хойч үеийнхээ төлөө хүрээлэн буй орчноо хамгаалах, хөгжүүлэх журамт үүргийг хүлээнэ.” гэж заажээ.

Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг онцлон хамгаалах болсон шаардлага бол нийгмийн хөгжлийн аж үйлдвэржилтийн байгууллын үр дагавар бөгөөд техникийн болон мэдээллийн зууны соёл иргэншлийн гарцаагүй үр дагавар мөн ажээ.

Өнөөдөр Хүрээлэн буй орчныг хамгаалах төрийн үүргийг 140 улсын Үндсэн хуульд, хүрээлэн буй орчны эрхийг 86 улсын Үндсэн хуульд баталгаажуулсан байна.

Эрх зүйн онолын үүднээс үзвэл энэ нь хүний үндсэн эрхийн шинжийг агуулж байна. Иргэний болон улс төрийн эрх буюу шүүхийн албадлагаар сэргээх боломжтой хүний үндсэн эрхийг негатив эрхэд хамааруулдаг. Харин төрийн зүгээс тухайн эрхийг эдлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх замаар хэрэгжилтийг хангах эрхэд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хамааруулах нь бий. Эдгээр эрхийг позитив эрх гэж үздэг.

Харин Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2-т заасан эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх нь негатив болон позитив эрхийн аль алиных нь шинжийг агуулснаараа

- ХҮНИЙ ЭРХИЙН ТОВЧ ТАЙЛБАР -

онцлог юм. Тодруулбал, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах явдал нь угаас негатив эрхийн шинжийг илэрхийлж байгаа бол, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь төрийн оролцоотойгоор хэрэгжих позитив эрхийн шинжийг хадгалж байна.

- IV -
БҮЛГИЙН ЭРХ
COLLECTIVE RIGHTS

БЭЛГИЙН ЦӨӨНХИЙН ЭРХ
RIGHTS OF SEXUAL MINORITY

Хүн бүр төрөлхийн онцлог байдлаараа дахин давтагдашгүй бөгөөд угсаа гарал, арьс үндэс, шашин шүтлэг, хэл, соёл, хүйс, нийгмийн байдал, улс төрийн үзэл бодол, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл зэрэг олон зүйлээрээ ялгаатай.

Бэлгийн чиг баримжаа гэдэг нь хүмүүс өөр хоорондоо бие махбод, сэтгэл санаа, бэлгийн дур хүсэл, зан үйл болон хайр дурлалаар татагдах явдал юм. Хүний бэлгийн чиг баримжааг “гетеросексуал” буюу эсрэг хүйсийнхээ хүнд татагддаг, “гомосексуал” буюу ижил хүйсийнхээ хүнд татагддаг, “бисексуал” буюу эр, эм хүйсийн хүний аль алинд нь татагддаг хүн гэж ангилдаг. “Хүйсийн баримжаа илэрхийлэл” гэж хүн бүр хувь хүний үүднээс өөрийн хүйсээ төрөхөд өгөгдсөн хүйстэйгээ адилаар эсвэл өөрөөр гүн гүнзгий мэдрэх мэдрэмж, хүйсийн шилжилт, хувцаслалт, үг яриа, биеийн хөдөлгөөн гэх мэт илэрхийллийг багтаасан ойлголт хэмээн тодорхойлдог.

Хүмүүс эрэгтэй, эмэгтэй байхаасаа үл хамаарч ижил хүйсийнхээ, эсвэл эрэгтэй, эмэгтэй хүний аль алийг нь сонирхон тэдэнд татагдаж, хүсэн тэмүүлж, хайрладаг бөгөөд ийм хүмүүсийг бэлгийн ижил чиг баримжаатай хүмүүс буюу Лесбиян, гей, бисексуал, трансжендэр хүмүүс (ЛГБТ) гэж нэрлэдэг.

19 дүгээр зуунаас барууны орнуудад лесби, гей, бисексуал болон трансжендер хүмүүсийг цөөнхийн бүлэг гэдгээр ойлгох болж, олонд ил болж эхэлжээ. ЛГБТ хүмүүс зөвхөн орчин цагт бий болоогүй ба хүн төрөлхтний түүхийн бүхий л үед ил, далд байдлаар амьдарч ирсэн юм. Тухайн хүний бэлгийн дур хүсэл нь өөрийн сонголтын асуудал биш, харин тухайн хүний төрөлхийн, өөрчлөх боломжгүй шинж чанар гэдгийг анагаах ухаан гэх мэт шинжлэх ухааны бүхий л баримтаар тодорхойлсон байна. Одоо хэрэглэгдэж буй Лесби, Гей, Бисексуал, Трансжендер гэх товчлол нь эдгээр хүмүүсийн ижил шинж байдлыг нэгтгэж байгаа явдал юм.

Лесбиян: Эмэгтэй хүнд татагддаг эмэгтэй хүн (энэ үг дан эмэгтэйчүүд амьдарч байсан эртний Грекийн “Лесбос” арлын нэрнээс гаралтай), Гей: Эрэгтэй хүнд татагддаг эрэгтэй хүн. Бисексуал: Эрэгтэй, эмэгтэй хүний аль алинд нь татагддаг хүн (“би” нь хоёр гэсэн утгатай Латин үг);Трансжендэр: Эхээс төрсөн биологийн хүйсээсээ өөрөөр өөрийн хүйсийг тодорхойлж нийгмийн амьдралд оролцдог хүн. Тухайлбал, эрэгтэй хүн болж төрсөн ч өөрийгөө эмэгтэй, эсвэл эмэгтэй хүн болж төрсөн ч өөрийгөө эрэгтэй гэж тодорхойлж илэрхийлдэг хүн. Өөрөөр хэлбэл, тэд өөрсдийгөө “буруу хүйс”-тэй төрчихсөн гэж үздэг.

Ихэнх нийгэмд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тоо бараг тэгш байхад, “хараат” бүлэгт орох эмэгтэйчүүдийн нийгмийн байр сууринаас үүдэн зарим нэг хүмүүс (феминист болон Эмэгтэйчүүдийн эрхийн хөдөлгөөнүүд) эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурийг цөөнхийн бүлэгтэй тэнцүүлж үздэг. Түүнчлэн, янз бүрийн жендэрийн ялгаатай хүмүүс цөөнхийн бүлгийг бүрдүүлдэг.

ДҮРВЭГСЭДИЙН ЭРХ RIGHTS OF REFUGEES

“Хүн бүр аливаа орныг, түүний дотор эх орноо орхин явах эрхтэй.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 12 дугаар зүйлийн 2 дахь заалт)

Иргэний дайн, олон улсын зэвсэгт мөргөлдөөн, олныг хамарсан байгалийн гамшигт үзэгдлийн үед дүрвэгсэдийн тоо ямагт нэмэгддэг. Нэгдсэн Үндэстний Байгууллага байгуулагдсан цагаасаа эхлэн Дэлхийн II дайны улмаас хохирогч болж, дүрвэж байсан хүмүүст туслах, эрхийг нь хамгаалах үйл ажиллагааг өргөнөөр явуулж эхэлсэн байдаг.

Дүрвэгсэдийн нөхцлийн талаарх конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1951 онд батлах үед дэлхий дээр ойролцоогоор нэг сая дүрвэгч байсан бол одоо гуч орчим саяд хүрсэн байна. Энэ конвенц нь дүрвэгчийг тодорхойлсон эрх зүйн үндсэн баримт бичиг болохоос гадна тэдний эрх, түүнийг хамгаалах талаар заасан. Анх 1951 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө Европын нутаг дэвсгэрт болсон үйл явдлын үр дүнд дүрвэгч болсон хувь хүмүүст хамаарч, Дэлхийн II дайнаас болон дайжсан хүмүүсийг эргэн төвхнөхөд дэмжих зорилготой байсан.

Энэ конвенцийн нэмэлт өөрчлөлт бүхий 1A(2) дугаар зүйлд дүрвэгч гэдэг нь “арьс үндэс, шашин, иргэний харъяалал, тодорхой нийгмийн бүлгийн гишүүн буюу улс төрийн үзэл бодлын улмаас мөрдөн мөшгигдөж байсан айдас бүхий, өөрийн харъяалах улсын гадна байгаа, тухайн улсын хамгаалалтыг үл хүсч байгаа, эсвэл иргэний харъяалалгүй буюу тус үйл явдлаас

шалтгаалан өөрийн байнга оршин сууж байсан улсын гадна байгаа буюу ийм айдастай, буцахыг хүсэхгүй байгаа этгээдийг хэлнэ” гэжээ. Харин дээрх конвенцийн 1F дүгээр зүйлийн дагуу дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, Нэгдсэн Үндэстний Байгууллагын зорилго, зарчмын эсрэг үйлдэл хийсэн хүнд энэ нь хамаарахгүй байна.

Дүрвэгчид гадаадын иргэний нэгэн адил эрх эдлэх бөгөөд Дайны цагт энгийн хүмүүсийг хамгаалах тухай Женевийн дөрөвдүгээр конвенцийн дагуу дүрвэсэн, дайжсан хүмүүсийг хамгаалах төдийгүй харьяалалгүй хүний талаарх Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан 1954 оны Харьяалалгүй хүмүүсийн нөхцлийн талаарх конвенц, 1961 оны Харьяалалгүй байдлыг бууруулах тухай конвенцийн дагуу олон харьяалалгүй хүн дүрвэгчдэд хамаарна. Мөн 1967 онд баталсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Газар нутгийн орогнолын тухай тунхаглалыг ашиглах боломжтой ч заавал биелэгдэх шинжгүй эрх зүйн баримт бичиг билээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрвэгсэдийн дээд комиссарын газар нь дээр дурдсан хүмүүнлэгийн чиглэлээрх тулгуур конвенцтой адил дэлхийн хэмжээний хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын нэг болсон юм. Энэ байгууллагыг 1949 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 319 А (IV) тогтоолд үндэслэн байгуулжээ. Швейцарь Улсын Женев хотод төвтэй тус байгууллага нь одоо зуу гаруй улсад өөрийн салбартай болсон.

ҮНДЭСТНИЙ ЦӨӨНХИЙН ЭРХ NATIONAL MINORITY RIGHTS

“Угсаатан, шашны ба хэлний цөөнх оршдог орнуудад эдгээр цөөнхөд багтдаг хүмүүст тухайн цөөнхийн бусад гишүүний халтаар өөрийн соёлыг эзтших, шашнаа шүтэх, ёслолоо үйлдэх, түүнчлэн эх хэлээрээ ярих эрхийг хорьж болохгүй.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 27 дугаар зүйл)

Үндэстний цөөнх гэдэг нь тухайн улсын хүн амын дийлэнхтэй харьцуулахад тооны хувьд цөөнх болох хэл, арьсны өнгө, соёл иргэншлийнхээ хувьд ялгарах, өөрсдийн өвөрмөц байдлыг хадгалах хүсэл эрмэлзлэл бүхий тодорхой бүлэг хүмүүсийг хэлнэ.

Ихэнх улс оронд угсаатны болон хэлний цөөнх бий. Тэдний амьдралын хэв маяг, хэл, соёл болон үндэс угсаа нь олонхиос ялгаатай. Цөөнхийн нийгэмд эзлэх байр суурийг дан ганц тооны харьцаагаар тооцохгүй, мөн тэдний улс төрд эзлэх эрх мэдлээр тодорхойлно. Зарим газруудад, тухайлбал арьс өнгөөр ялгаварлан гадуурхагддаг Өмнөд Африк дахь үндэстний хараат цөөнх нь өөрөө тооны хувьд олонх цөөнхийн бүлгийг бүрдүүлдэг. Түүнчлэн, “уламжлалт” (удаан хугацааны оршин суугч) цөөнхөд цагаачид, уугуул иргэд болон өөрсдийн газар нутаггүй нүүдэлчид орно. Олон улсын эрх зүйд үндэстний (угсаатны) цөөнх гэх тодорхойлолт байдаггүй. Гагцхүү Европын Бүсийн болон Цөөнхийн хэлний тухай Европын Тунхаг болон Европын Зөвлөлийн Парламентийн Ассамблейн Тогтоол 1201 (1993 оны)-д тодорхойлсон байна. Гэсэн ч онолын хувьд үндэстний цөөнх гэж дараах бүлэг хүмүүсийг хэлнэ. Үүнд:

1. Тухайн улсын бусад хүн амаас тооны хувьд бага
2. Дийлэнх байр суурийг эзлээгүй

3. Тухайн улсын хүн амын олонхоос соёл, хэл, шашин шүтлэг, арьс өнгө зэргээр ялгаатай
 4. Цөөнхийн бүлгийн гишүүд нь өөрсдийн онцлог байдлыг хадгалах хүсэл эрмэлзэлтэй
 5. Цөөнхийн бүлгийн гишүүд нь тухайн амьдарч буй орондоо цөөнх гэсэн нийгмийн байр суурьтай бөгөөд тухайн улсынхаа иргэншилтэй
 6. Удаан хугацааны туршид тухайн газар нутагт амьдарч ирсэн хүмүүсийг хэлнэ.
- Олон улсын хүний эрхийн эрх зүйд үндэстний болон угсаатны цөөнхийн эрхийг хэд хэдэн аргаар хамгаалдаг ба үүний нэг өөрийгөө тодорхойлох эрх юм. Үндэстний (угсаатны) цөөнхийн эрхийг хамгаалдаг байдлаараа Европын орнууд дээгүүр ордог. Монгол улсад үндэстний цөөнхийн 2 том төлөөлөл оршин амьдардаг ба казах, тува (цаатан) үндэстнүүд өөрийн хэл, соёл, зан заншил, шашин шүтлэг, угсаатны цөөнхөө өнөөдрийг хүртэл хадгалж ирсэн байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХ RIGHTS OF PERSONS WITH DISABILITIES

Дэлхийн хүн амын 10 хувь орчим нь буюу 650 сая хүн хөгжлийн бэрхшээлтэй гэсэн тооцоог Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан. Энэ тоон дээр хөгжлийн бэрхшээлтэй хэн нэгэн дотны хүнээ харж хандахын тулд суралцаж, хөдөлмөрлөж, нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцож чадахгүй байгаа гэр бүлийн гишүүд, асран хамгаалагчдын тоог нэмбэл ойролцоогоор 2 тэрбум орчим хүн хөгжлийн бэрхшээлээс үүдсэн асуудалтай амьдардаг байна. Дэлхийн хүн ам өсөхийн хэрээр хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо мөн өсөн нэмэгдэж байна. Нөгөө талаас,

ядуурал, байгалийн гамшиг, тогтворгүй байдал, осол гэмтэл, эмнэлгийн байгууллагын үйл ажиллагаанд гарсан алдаа дутагдлаас хүн хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол өссөөр байна. Ялангуяа, ийм байдал хөгжлөөр буурай болон хөгжиж буй улс орнуудад харьцангуй өндөр хувьтай байдаг.

Дэлхийн аль ч улс оронд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмээс тусгаарлагдсан, хязгаарлагдмал орчинд амьдарч байна. Тэд бусдын адил амьдрах, хийж бүтээх хүсэл, тэмүүллээр дүүрэн байдаг боловч сурах, хөдөлмөрлөх, нийгмийн үйл хэрэгт орлцох, найзалж нөхөрлөх, гэр бүл зохиох, үр хүүхдээ өсгөх найдвар бага, эмнэлэг, сургууль, дэлгүүрээр үйлчлүүлэх, тээврийн хэрэгслээр зорчих, хэрэгцээтэй мэдээллээ бүрэн дүүрэн хүлээж авах боломж хязгаарлагдмал амьдарч байна.

Амьдралын хүнд хэцүү нөхцөл, хоол хүнсний дутагдал, эмнэлгийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүйгээс ядуу хүн хөгжлийн бэрхшээлтэй болох нь элбэг байхад сурч боловсрох, ажиллаж хөдөлмөрлөх боломж, орчин хязгаарлагдмал учраас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олонх нь ядуу амьдарч байна.

Нийгмийн бусад гишүүдийн үл тоомсорлол, боломж, чадавхийг үгүйсгэх хандлагын улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх зөрчигдөхөд хүрч байна. Өнгөрсөн хугацаанд дэлхийн улс орнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн харилцаанд эрүүл иргэдийн нэгэн адил оролцох эрхтэй болохыг нь үл хүлээн зөвшөөрч, тэднийг гагцхүү “төрийн тусламж, дэмжлэг хүртэгч”, “эмнэлэг, нийгмийн халамжийн үйлчилгээний объект” мэтээр хандаж ирсэн. Ийм ч учраас утга зохиол, соёл урлаг, нийгмийн шинжтэй сурталчилгаанд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг өрөвдөж

энэрэх, туслахыг уриалсан өнгө аяс зонхилж, харин сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгмийн амьдралд оролцохыг нь дэмжих, тэгш боломжийг бий болгох утга агуулга төдийлөн хөндөгддөггүй байв. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тохуурхах, нэр төрийг доромжлох, элдэв нэр хоч өгөх, цэрвэх, цээрлэх хандлага ч нийгэмд байдгийг үгүйсгэх аргагүй. Хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээсээ ичиж зовох, ил гаргахаас нуух нь бидний эргэн тойрон байдаг асуудал боловч ингэснээрээ тэдгээр дотны хүмүүсийнхээ “хүн хэмээх” эрхэм чанарыг үгүйсгэж байгаа болохоо хүмүүс тэр бүр анзаардаггүй. Тэргэнцэртэй, таягтай гэх зэргээр хүнийг нь биш, тусгай хэрэглэгдэхүүн, согоогоор онцлон нэрлэж, тахир дутуу гэх мэт нэр томьёогоор дуудах нь ч мөн хүнлэг бус харьцаа болно.

Хүн зөвхөн согог, гэмтлийнхээ улмаас хөгжлийн бэрхшээлтэй болдоггүй бөгөөд бие эрхтний согог, гэмтэл нийгмийн орчин, хязгаарлалттай нэгдэн нийлж хөгжлийн бэрхшээлийг үүсгэдэг. Өөрөөр хэлбэл, тэргэнцэр ашигладаг хүн ямар нэг ажил хийх чадваргүйдээ биш, гагцхүү түүний ажлын байр тэргэнцэртэйгээ орох гарах, ажиллах нөхцөлийг бий болгож чадаагүй учраас тэдний ихэнх нь хөдөлмөр эрхэлж чадахгүй байна. Үүний нэгэн адилаар сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд эрүүл хүүхдүүдийн нэгэн адил суралцах оюуны чадавхгүйдээ биш, харин тэдний сургалтын орчин, гарын авлага, багш байхгүй, сургууль тэдэнд хүртээмжгүйгээс тэр бүр амжилттай суралцаж чаддаггүй.

Хөгжлийн бэрхшээл нь нийгмийн орчин, хөгжлийн түвшнээс хамаарч үргэлж өөрчлөгдөн хувьсаж байдаг ойлголт юм. Шинжлэх ухаан, технологийн хөгжлийг дагаад хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай

хэрэгцээг хангах тоноглол, хэрэглэгдэхүүн улам бүр боловсронгуй болж байна. Жишээлбэл, сул харааг (хурц миофиа зөвхөн мөрөө л хардаг) нөхөх линзийг хэрэглээнд нэвтрүүлсэн хөгжингүй улс оронд сул хараатай хүнийг хөгжлийн бэрхшээлтэйд тооцохгүй болж байгаа нь хөгжлийн бэрхшээл орчин нөхцөл, улс орны хөгжлөөс хамаарч болохыг харуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нэр төр, эрхэм чанарыг хүндэтгэн харьцаж, бусадтай адил тэгш эрх эдлэх боломжийг олгох нь хүний эрхийн зарчим юм. Чухам энэ зарчмын үүднээс хөгжлийн бэрхшээлийн асуудалд хандахыг хүний эрхийн хамгаалагчид чухалчилдаг. Азгүй тохиолдлоор хэн нэгэн хөгжлийн бэрхшээлтэй болж болох ч түүнийг золгүй хувь тавилан угтах ёсгүй юм.

ХҮҮХДИЙН ЭРХ CHILDREN'S RIGHTS

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенц, болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд “шүүхийн шийдвэрээр 18 наснаас өмнө насанд хүрсэнд тооцогдоогүй бол 18 нас хүрээгүй бүх хүнийг хүүхэд гэнэ” хэмээн тодорхойлсон. Насанд хүрээгүй хүмүүс (хүүхэд) нь бие бялдар, оюун санаа, боловсрол, амьдралын туршлагын хувьд бүрэн гүйцэд төлөвшөөгүй, тусгай хэрэгцээ, хамгаалалт шаардагддаг тул тэдний эрхийг тусгайлан авч үзэж хамгаалдаг. Хүүхдийн эдлэх ёстой эрх, эрх чөлөө, төрөөс болон эцэг эхээс нь үзүүлэх ёстой халамж, үйлчилгээний цогцыг хүүхдийн эрх гэж нэрлэж болно. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр олон тооны гэрээ, конвенцийг батлан гаргасны дотор

хүүхдийн эдлэх эрхийг тодорхойлж, баталгаажуулсан хамгийн чухал баримт бичиг нь 1989 онд батлагдсан “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай” конвенц юм. Энэхүү конвенцид 2012 оны байдлаар 120 орон нэгдэн орсон байна. Монгол Улс уг конвенцид 1990 онд нэгдэн орсон.

Монгол Улсад Хүүхдийн эрхийг хамгаалах тухай тусгай хуулийг батлан мөрдүүлж, хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиг үүрэг бүхий дагнасан байгууллага (Хүүхдийн төлөө газар, аймаг, нийслэлд хүүхдийн төлөө хэлтэс) үйл ажиллагаа явуулдаг. Мөн хөдөлмөрийн, эрүүгийн байцаан шийтгэх, гэр бүлийн, иргэний, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай зарим хуулиар хүүхдийн эрхийг тусгайлан зохицуулсан байдаг. Хөдөлмөрийн тухай хуулиар хүүхдийг эрүүл мэнд, оюун санаа, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлэх хөдөлмөр эрхлүүлэхийг хориглож, хүүхдийн хөдөлмөрийг илүү хөнгөлөлттэй нөхцлөөр тогтоож өгсөн байдаг.

Хүүхдийн эрхийн тухай олон улсын баримт бичгүүд, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд зааснаар хүүхэд төрмөгцөө бүртгүүлэх, нэр авах, иргэний харъяалалтай болох, эцэг, эхээ боломжийн хирээр мэдэх, хайр халамжийг нь хүртэх, амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, халдашгүй чөлөөтэй байх, тоглож, наадах, сурч боловсрох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл олж авах, эвлэлдэн нэгдэх, эрх, эрх чөлөөгөө хамгаалах байгууллага байгуулах, тайван замаар хуран цуглах, зохиол бүтээл туурвих, нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдах, хүчирхийлэл, дарамт шахалтаас хамгаалуулах, өөртэй нь холбоотой асуудлыг шийдвэрлэхэд оролцох, шашин шүтэх, эс

шүтэх эрхтэй.

Олон улсын болон үндэсний баримт бичгүүдэд хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд ашиглах, садар самуунд уруу татах, садар самууны сурталчилгаанд ашиглах, биеийг нь үнэлүүлэх, зодож шийтгэх, эрүүл мэнд, бие бялдар, оюун санаа, ёс суртахуунд нь сөрөг нөлөө үзүүлэх хөдөлмөр эрхлүүлэхийг хатуу хориглодог.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ WOMEN'S RIGHTS

Эмэгтэйчүүдийн эрх гэдэг нь эмэгтэйчүүдэд шууд болон шууд бусаар хамаарах бүх эрхийг тодорхойлсон ойлголт юм. Үүнд хүйсээр ялгаварлан гадуурхах ба хүчирхийллээс ангид байх, нөхөн үржихүй, улс төр, эдийн засгийн нийгэм, соёл, гэр бүлийн амьдралд эрэгтэйчүүдийн адил тэгш оролцох, хөдөлмөрлөх, сурч боловсрох зэрэг хүний бүхий л эрхүүд хамаарна. Эмэгтэйчүүдийн эрхийг бусад хүний эрхээс онцгойлон авч үзэх нь эмэгтэйчүүдийн бие махбод, физиологийн ялгааг хүлээн зөвшөөрч, ялгаварлан гадуурхахгүй байх, тэднийг хүйсийнх нь хувьд дорд үзэхгүй байх, тэд эрхээ эдлэх боломж бололцоог тэгш бүрдүүлж, эрхийн хэрэгжилтийн баталгааг эрэгтэйчүүдийн адил түвшинд хүргэх явдал юм

Эмэгтэйчүүдийн эрхийн баталгааг хангах чиглэлээр олон улсын олон тооны гэрээ, конвенцууд батлагдан гарснаас хамгийн чухал нь Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц юм. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей 1979 оны 12 дугаар сарын 8-ны өдөр уг конвенцийг баталж 1981 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон ба Монгол Улс 1981 онд нэгдэн орж түүний

Нэмэлт Протоколыг 2001 оны 12 дугаар сарын 14-ний өдөр соёрхон баталсан.

Энэхүү конвенц нь дэлхийн өнцөг булан бүрт эмэгтэйчүүд эрхээ эдлэх боломж, бололцоо харилцан адилгүй, эмэгтэйчүүдийг алагчлах үзэл оршсоор байгаа өнөө үед эмэгтэйчүүдийн эрхийг бусад хүний эрхээс тусгайлан баталгаажуулж, эмэгтэйчүүдэд хамаарах хүний эрхийн асуудлыг иж бүрэн, цогц байдлаар баталгаажуулж өгсөнөөрөө чухал ач холбогдолтой баримт бичиг болсон юм.

Ялангуяа эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хоорондын тэгш эрхийн үндсэн зарчим, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах тухай зарчмуудыг хэрэгжүүлэх, энэ зорилгоор ялгаварлан гадуурхах бүх хэлбэр, илрэлийг устгахад шаардагдах арга хэмжээг тусгаж өгснөөрөө чухал баримт бичигт тооцдог.

Эмэгтэйчүүдийн эрхийг уг конвенцоор баталгаажуулж өгснөөрөө эмэгтэйчүүдийн эрхийн тухай олон нийтийн ойлголтыг улам өргөжүүлж, эмэгтэйчүүдийг үндсэн эрхээ эдлэхэд нь саад тотгор болж буй соёл зан заншилд нөлөөлөх эрх зүйн үндсийг бий болгосон юм.

Монгол Улс Эмэгтэйчүүдийн эрхийг хангах тухай төрийн бодлогыг 1924 оны анхдугаар Үндсэн хуулиас эхлэн одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Үндсэн хууль” болон Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон бусад хуулиар баталгаажуулж өгсөн.

1996 онд УИХ-аас баталсан Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлогод эмэгтэйчүүдийн эрх, хамгааллын асуудлыг тусгай бүлэг болгон авч үзсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газраас

“Эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах Үндэсний хөтөлбөр” (1996-2002), “Жендерийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр” (2002-2015), “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр”-ийг тус тус батлан хэрэгжүүлж байна. Түүнчлэн охид эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр Монгол Улс “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенц”-д 2008 онд нэгдэн орсон бөгөөд “Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна.

ЦӨӨНХИЙН БҮЛГИЙН ЭРХ MINORITIES' RIGHTS

“Цөөнхийн бүлэг” хэмээх нэрийг янз бүрийн нөхцөл байдалд болон түүхэн хөгжлийн явцад өөр өөр утгаар хэрэглэдэг. Ерөнхийдөө, нийгмийн шинжлэх ухааны салбарт, “цөөнх” гэх нэр томъёог нийгэмд цөөн байр суурь эзлэх хүмүүсийг олонхиос ялгаж үзэхэд хэрэглэдэг. “Цөөнхийн бүлэг” гэх нэр томъёо нь 20 дугаар зуунд түрэн гарч ирсэн иргэний эрх болон хамтын эрхийн тухай яригдах болсноор өргөн хэрэглэгдэх болжээ.

Цөөнхийн бүлгийн гишүүдийн амьдарч буй улс орон, нийгэм тэдэнд өөр өөрөөр ханддаг. Энэхүү хандлага нь тухайн хувь хүний ололт амжилтыг эс харгалзан, цөөнхийн бүлгийн гишүүдийг хүлээж авах хувь хүний хандлагаас шууд хамааралтай бөгөөд олонх тохиолдолд ялгаварлан гадуурхалтад хүргэдэг. Социологич Луи Вирт цөөнхийн бүлгийг “бие махбодын болон соёлын онцлогоосоо болж тухайн

амьдарч буй нийгэм нь тэдэнд ялгавартай, тэгш бус байдлаар хандаж, нийгэмдээ бусдаас ялгагдсан хэсэг бүлэг хүмүүс” гэж тодорхойлсон байдаг. Энэхүү тодорхойлолтод объектив болон субъектив хоёр шалгуур зэрэг багтана. Үүнд: хувь хүний бие махбодын болон биеэ авч явах шинж байдалд тулгуурлан, нийгэм тухайн хүнийг цөөнхийн бүлгийн гишүүн гэж бодитойгоор авч үздэг. Мөн цөөнхийн бүлгийн гишүүд бүлгийнхээ өвөрмөц шинж байдал, хамтын эв нэгдэл дээр тулгуурлан өөрсдийн нийгэмд эзлэх байр сууриа илэрхийлж болох ба энэ нь субъектив байдлаар илэрдэг.

Нийгэм дэх ялгаа гэдэг нь нэг юмуу түүнээс дээш хувь хүний онцлог шинж дээр тулгуурласан, тухайлбал, үндэс угсаа, арьс өнгө, жендер, хөрөнгө чинээ болон хүйсийн илэрхийлэл зэрэг өвөрмөц шинжийг хэлнэ. Тухайлбал, аливаа цөөнхийн бүлэгт харьяалагдах хувь хүний бие махбодын болон биеэ авч явах байдал нь тухайн бүлгийнхээ гишүүдийн үйл байдалтай нийцэж байх бөгөөд бусад гишүүдээс түүнд хандах хандлага нь мөн адил байдаг.

- V -

ХҮНИЙ ЭРХИЙН МЕХАНИЗМ
HUMAN RIGHTS MECHANISMS

А. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ
МЕХАНИЗМ
NATIONAL HUMAN RIGHTS MECHANISMS

Хүний эрхийг хамгаалах үндэсний механизмын тухай ойлголтыг хуульчилж буюу албан ёсоор тодорхойлоогүй. Харин эрдэмтэд судлаачдын зохиол бүтээлд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн, нутгийн захиргааны болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудыг хүний эрхийг хамгаалах үндэсний механизмд хамруулан авч үздэг. Эндээс дүгнэвэл хүний эрхийг хамгаалах үндэсний механизм нь нийгмийг бүхэлд нь хатарсан цогц систем юм.

Хүний эрхийг хамгаалах үндэсний механизмын хүрээнд хамрагдах байгууллагуудыг үйл ажиллагааных нь онцлог, байгуулагддаг зарчмыг нь харгалзан дор дурдсан 4 ангилалд авч үзэж болох юм.

- 1. Төрийн байгууллага*
- 2. Орон нутгийн өөрөө удирдах байгууллага (бүх шатны иргэдийн хурал, засаг дарга)*
- 3. Хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллага (Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс)*
- 4. Иргэний нийгэм*

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг

бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө харууцна.” гэж заасан байдаг. Тиймээс төр бол хүний эрхийг хамгаалах хамгийн анхдагч механизм байх ёстой ба тус механизм хангалттай ажиллаж чадахгүй бол ажиллахыг шаардах, хөндлөнгөөс нөлөөлөх үүргийг хуулиар хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллага, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхээр байгуулагдсан иргэний нийгмийн байгууллага тус тус хүлээнэ.

Хүний эрхийг хамгаалах төрийн механизмыг ард түмнээс хууль ёсоор олж авсан эрх мэдлийн хүрээнд төр өөрөө бүрдүүлдэг бөгөөд тус механизм нь шударга ёсны, хууль ёсны, хүний эрхийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээнд нийцсэн байх учиртай.

Хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, хүн бүрт хүртээмжтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх механизм бол төр юм. Төр нь хүний эрх, эрх чөлөөг хуульчлан баталгаажуулахаас эхлээд зөрчигдсөн тохиолдолд хамгаалах, хүний эрхийг хангах талаар хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Төр бол хүний эрхийг хамгаалах механизм болохын хувьд хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангах эдийн засаг, нийгэм соёл, улс төрийн баталгааг хангах, нийгмийн зохион байгууллалтын бүх асуудлыг зохион байгуулдаг.

Хүний эрхийг хамгаалах төрийн механизмд хууль тогтоох эрх мэдлийн байгууллага (Монгол Улсын Их Хурал), гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд (Монгол Улсын Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүрэг, багийн засаг захиргааны нэгж гэх мэт), шүүх эрх мэдлийн байгууллагууд (Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, бүх шатны шүүх, бүх шатны прокурорын газар) хамаардаг.

ЗАСГИЙН ГАЗАР

GOVERNMENT

Засгийн газар нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллагын хувьд олон улсын гэрээ, Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг хангахын тулд төв болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, төсвийг үр дүнтэй хуваарилах, хянан шалгах чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

GREAT KHURAL OF MONGOLIA

Хууль тогтоох эрх мэдлийн байгууллага нь хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах, бодлого тодорхойлох замаар хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулдаг. Монгол Улсын Их Хурал нь өөртөө хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой бүтцийг бий болгон Хууль зүйн байнгын хорооны бүрэлдэхүүнд Хүний эрхийн дэд хороо үйл ажиллагаа явуулж байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА

NATIONAL HUMAN RIGHTS INSTITUTION

Төр өөрөө байгуулсан боловч төрийн үүрэг функцийг хэрэгжүүлдэггүй хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хараат бусаар үйл ажиллагаа явуулдаг, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих замаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чиг үүрэг бүхий Хүний эрхийн үндэсний байгууллагыг төрийн механизмд оруулдаггүй онцлогтой.

1991 онд Парис хотноо НҮБ-ын Хүний эрхийн Комисс (НҮБ-ын Хүний эрхийн Хороо болж өөрчлөгдсөн) Хүний эрхийн үндэсний байгууллагуудын анхдугаар

уулзалтыг зохион байгуулж, Хүний эрхийн үндэсний байгууллагын үндсэн зарчмыг боловсруулсан байдаг. Энэ нь түүхэнд “Парисын зарчим” хэмээн нэрлэгдэх болсон. Тус зарчим ёсоор хүний эрхийн үндэсний байгууллага нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус байх учиртай. Ялангуяа Засгийн газраас хараат бус байж, санхүүгийн хяналтаас ангид байхад Парисын зарчмын мөн чанар оршдог. Энэхүү зарчим нь Хүний эрхийн үндэсний байгууллагаас хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихтэй холбоотой асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газар болон төрийн бусад байгууллагад санал, зөвлөмж, шаардлага, илтгэл хүргүүлэх бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаа болдог. Тиймээс Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд тус зарчмыг баталгаажуулсан байдаг.

Монгол Улсын төр иргэнийхээ өмнө төдийгүй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний эрхийг хангах, зөрчигдсөн тохиолдолд хамгаалах үүргийг хүлээдэг. Тиймээс төр нийгмийн орчинд, эдийн засгийн түвшинд, хууль зүйн хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа хэн ч бай айх аюулгүй, гачигдах зовлонгүй байх наад захын баталгааг бүрдүүлсэн байх учиртай.

Хүний эрх хэзээ, хаана, яаж зөрчигдөж байна вэ гэдгээс хамааран эрх нь зөрчигдсөн хүн тодорхой нэг төрийн байгууллага, албан тушаалтанд гомдлоо гаргах боломж, шийдвэрлэж буй байдлаас хүний эрхийг хамгаалах төрийн механизм хэрхэн ажиллаж байгаад үнэлгээ өгөх боломжтой. Хэрэв төрийн байгууллага, албан тушаалтан иргэний зөрчигдсөн эрхийг сэргээхгүй, хамгаалахгүй, өөрөөр хэлбэл төрийн механизм хангалттай ажиллахгүй бол иргэд эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, жагсаал цуглаан зохион байгуулах байдлаар

төрийн бодлого, үйл ажиллагаанд хууль ёсоор нөлөөлж болно. Мөн хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах үүргээ биелүүлэхгүй, зохих ёсоор биелүүлэхгүй байгаа тохиолдолд хүний эрхийг хамгаалах үндэсний механизм болох Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргах бүрэн боломжтой юм.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл дангаар буюу хамтарч энэ хуульд заасны дагуу Комисст гомдлоо гаргах эрхтэй.” гэж заасны дагуу зөрчигдсөн эрхийнхээ талаар хүн бүр гомдлоо гаргах боломжтой. Гэхдээ тус хуулиар захиргааны журмаар шийдвэрлүүлсэн байх шаардлагыг тавьдаг. Энэ нь зөрчигдсөн эрхийнхээ талаар төрийн механизмд хандаад, зөрчигдсөн эрх нь сэргээгдээгүй бол Комисст хандана гэсэн үг юм.

Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмын тухай хуульд заасан тухайн төрийн байгууллага, албан тушаалтны эрхлэх асуудлын хүрээнд өргөдөл, гомдол, хүсэлт гаргах эрхээ мэдэхгүйн улмаас хүмүүс ихээхэн хохирдог. Тиймээс иргэд аливаа асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтанд хандах гэж байгаа бол дээрх хуультай танилцаж, төрийн байгууллага албан тушаалтны үүрэг болон өөрийн эрхийг тодорхой мэдэж авсан байх шаардлагатай. Ингэснээр иргэн өөрөө өөрийнхөө эрхийг хамгаалах, бусдаар зөрчүүлэхгүй байх наад захын баталгааг бий болгох юм.

ШҮҮХ COURTS

Шүүх эрх мэдлийн байгууллага нь Үндсэн хууль

бусад хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө зөрчигдвөл хамгаалах, сэргээн эдлүүлэх үүргийг хүлээдэг. Шүүхийн шийдвэр нь эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг хэн ч бай заавал дагаж мөрдөх, биелүүлэх учиртай. Бүтцийн хувьд аймаг, нийслэл, сум, сум дундын, дүүргийн гэж ангилахаас гадна анхан шатны, давж заалдах, хяналтын шатны гэж үйл ажиллагаагаар нь ангилдаг. Үүний зэрэгцээ Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага болох Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болж, үйл ажиллагаа явуулдаг онцлогтой.

Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хуулийг тус тус баталж улмаар Шүүхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх, түүний бүрэн эрх, ерөнхий шүүгчийн бүрэн эрх, дагнасан шүүхийн үйл ажиллагааг зохицуулсан бусад асуудлыг нэмэлт, өөрчлөлтөөр оруулсан нь Монгол улсад Захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулагдан ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн юм. Захиргааны хэргийн шүүх нь төр, захиргааны байгууллага, албан тушаалтнуудын зүгээс хуулийг хэрхэн сахин биелүүлж, хүний эрхийг хэрхэн хангаж байгааг иргэд, хуулийн этгээдийн нэхэмжлэлийн үндсэн дээр хянан шалгадаг, эдгээр байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагаа (үйлдэл, эс үйлдэхүй), гаргасан шийдвэрээс хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох зорилготой шүүх байгууллага юм.

Тус шүүх нь хянан шийдвэрлэх хэргийн бие даасан харъяалалтай, хэргийн оролцогчийн өвөрмөц бүрэлдэхүүнтэй нэхэмжлэгч нь иргэд, хуулийн этгээд, хариуцагч нь заавал захиргааны байгууллага, албан тушаалтан, эцсийн дүнд төр байх), урьдчилан хянан шийдвэрлэх ажиллагаа гэсэн угтуулсан процессын өвөрмөц журамтай, нотолгооны үүргийг өөрөө хариуцан биелүүлэх тусгай зарчимтай, захиргааны чиглэлээр дагнан мэргэшсэн шүүгчдээс бүрддэг.

**Б. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ
БҮС НУТГИЙН ТОГТОЛЦОО
REGIONAL SYSTEM FOR
PROTECTING HUMAN RIGHTS**

Хувь хүний эсрэг гарсан хүний эрхийн зөрчлийг харъяалан шийдвэрлэх, хохирлыг нөхөн төлөх бүс нутгийн шинжтэй, гэрээнд тулгуурласан хүний эрхийн тогтолцоог Америкийн Улсуудын байгууллага, Европын зөвлөл, Африкийн холбоо гэсэн томоохон засгийн газар хоорондын байгууллагуудын удирдлаган дор Европ, Америк, Африк тивд байгуулсан.

Дундад Ази, Зүүн Өмнөд Ази дахь бүс нутгийн хүний эрхийн байгууллагыг шинээр байгуулсан Арабын хүний эрхийн хороо (Арабын Улсуудын лигийн харьяа байгууллага), Зүүн Өмнөд Азийн Үндэстнүүдийн Холбоо буюу АСЕАН-ы Хүний эрх хариуцсан засгийн газар хоорондын котисс байгуулсан ч хувь хүний гомдлыг шийдэхгүй тул хагас шүүхийн шинжтэй гэж тооцдоггүй. Тогтолцоо бүрийн гол шинж бол шүүхийн, эсвэл хагас шүүхийн шинжтэй шийдвэр гаргах байгууллага нь нотолгоо бүхий хүний эрхийн зөрчлийг хүлээн авах,

тухайн Улсуудын олон улсын хариуцлагыг тогтоох үүрэг хүлээсэн байдаг. Тодруулбал, Америк хоорондын хүний эрхийн шүүх, Америк хоорондын хүний эрх хариуцсан котисс, Европын хүний эрхийн шүүх (өтнө нь Европын хүний эрхийн котисс байсан), Европын нийгмийн эрхийн хороо, Африкийн хүний болон ард түмний эрх хариуцсан котисс, Африкийн хүний болон ард түмний эрх хариуцсан шүүх (зөвхөн гурван улс холбогдох протоколыг соёрхон баталвал Африкийн Шударга ёс, хүний эрхийн шүүх болж, өөрчлөн байгуулна) зэрэг болно. Тогтолцоо бүр дэх байгууллагуудын төн чанар, үүрэг, төн тэдний тайлбарлах, ашиглах хэм хэмжээг бүс нутгийн шинжтэй гэрээгээр тогтоосон.

Европын Холбоо, Баруун Африкийн Улсуудын Эдийн засгийн нийгэмлэг зэргээс бүс нутгийн эдийн засгийн нэгдсэн санаачлага өрнүүлж, гишүүн улсуудын хооронд үүссэн, эсвэл нийгэмлэгийн худалдааны гэрээ, бус хууль тогтоомжийн дагуу маргааныг шийддэг шүүх байгуулан ажиллаж байна. Эдгээр тусгай шүүхийн үндсэн бүрэн эрх нь хүний эрхийг хамгаалах биш учраас гол төлөв хүний эрхийн шүүх гэж тооцдоггүй. Гэхдээ зарим шүүхэд үндсэн эрх чөлөөг хөндсөн хувийн гомдлыг хүлээн авах, хүний эрхийн олон улсын гэрээг шууд ашиглах эрх хэмжээг олгосон байдаг.

Бүс нутгийн механизмын нийтлэг шинж

Америк, Африк, Европ тив дэх бүс нутгийн хүний эрхийн механизмууд нь дараахь нийтлэг шинжтэй. Үүнд:

1. Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоонд туслах шинжтэй

- Хэм хэмжээний хүрээнд ажилладаг (улс төрийн зөвшилцөл, конвенц, тунхаглал гэх мэт):*
- Олон улсын стандартуудаас доогуур биш*

- *Хараат бус, тал үл харах хүний эрхийн шинжээчид*
- 2. *Бүс нутгийн түвшинд улс орон, гишүүдийг сонгох затаар нэр дэвшүүлэх үйл явц*
 - *Улс орнуудын зүгээс нэр дэвшүүлэх, бүс нутгийн түвшинд гишүүдээ сонгох үйл явц*
 - *Хөндлөнгийн нөлөөгүй, өөрийн хувийн чадавх, нөөц бололцоогоор ажил үүргээ гүйцэтгэх*
 - *Гишүүнчлэлийг олон ургальч байдлаар бүрдүүлэх*
 - *Гишүүдийн онцгой эрх, халдашгүй байдал*
 - *Шаардлага хангахгүй хэргийг буцаах журам*
- 3. *Хөхиүлэн дэмжих, хатгаалах ажиллагаа явуулах*
 - *Хувь хүний болон улс хоорондын голдлыг зэрэг хүлээн авах, шийдвэрлэх*
 - *Хүний эрхийн зөрчлийг зарлах, заавал биелэх шинжтэй шийдвэр гаргах, хохирол нөхөн төлүүлэх арга хэтжээ авахуулахаар бүс нутгийн шүүхэд хандах боломжтой байх*
 - *Тухайн улсын түвшин үйл ажиллагаа явуулах, тухайн улсад айлчлах*
 - *Харилцан адилгүй гишүүн улсуудтай уулзалт хийх*
 - *Сонсголыг олон нийтэд түгээдэг байх*
 - *Хөхиүлэн дэмжих, хатгаалах үйл ажиллагаагаа явуулахаар бусад механизмуудыг боловсруулах (жишээлбэл, тусгай илгээгч гэх мэт)*
 - *Урьдчилан сэргийлэх механизмууд (жишээлбэл, онц байдлын үеийн журам)*
 - *Олон нийтэд тараасан шийдвэр, зөвлөмжтэй холбоотой баримт бичгийн ил тод байдал*
- 4. *Хангалттай эх үүсвэр (санхүүгийн болон хүний нөөц) бүхий зохих, бүтэн цаг ажиллах ажлын албатай*
- 5. *Иргэний нийгэм болон хүний эрхийн үндэсний байгууллагуудтай харилцан ажиллахаар тогтоосон журам*

6. Олон улсын хүний эрхийн механизмтай халтран ажиллах

АМЕРИК ХООРОНДЫН БҮС НУТГИЙН МЕХАНИЗМ
INTER-AMERICAN REGIONAL MECHANISM

Америк хоорондын хүний эрхийн шүүх, Америк хоорондын хүний эрх хариуцсан комисс нь дэлхийн бөмбөрцөгийн баруун хагасыг хамарч ажилладаг. Комисс нь Америкийн Хүний эрхийн болон үүргийн тунхаглалд заасны дагуу Америкийн Улсуудын байгууллагын бүх 35 гишүүн, Америкийн хүний эрхийн тухай конвенцийг баталсан 25 улсын эсрэг хэргийг шийдвэрлэж болно. Шүүх нь гагцхүү Америкийн шүүхийн харьяаллыг хүлээн зөвшөөрсөн (одоогоор 21 улс), хоёул Америкийн конвенцийг соёрхон баталсан Улсуудын эсрэг маргасан хэргийг шийдэх боломжтой.

ЕВРОПЫН БҮС НУТГИЙН МЕХАНИЗМ
EUROPEAN REGIONAL MECHANISM

Европын хүний эрхийн шүүх нь Европын зөвлөлийн бүх 47 гишүүн, Европын хүний эрхийн тухай конвенцийн дагуу үүрэг хүлээсэн талуудын эсрэг гаргасан гомдлыг харьяалан шийддэг. Европын нийгмийн эрхийн хороо нь Европын нийгмийн хартийг соёрхон баталсан Европын зөвлөлийн 43 гишүүн хэрхэн биелүүлж байгааг хянадаг. Мөн тус хорооны хамтын маргааныг шийдвэрлэх журмыг хүлээн зөвшөөрсөн 15 улсын эсрэг гаргасан гомдлыг шийдэж болно.

АФРИКИЙН БҮС НУТГИЙН МЕХАНИЗМ
AFRICAN REGIONAL MECHANISM

Африкийн Хүний болон ард түмний эрх хариуцсан комисс нь Африкийн холбооны бүх 53 гишүүн,

Африкийн Хүний болон ард түмний эрхийн тухай хартийн гарын үсэг зурагч талуудын эсрэг гомдлыг шийдэх эрх бүхий байгууллага юм. Африкийн Хүний болон ард түмний эрх хариуцсан шүүх нь зөвлөх шинжтэйгээр байр сууриа илэрхийлэх, тус шүүхийн харьяаллыг хүлээн зөвшөөрсөн 26 улсын хэрэг маргааныг шийдэх бүрэн эрхтэй.

**В. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ
ОЛОН УЛСЫН МЕХАНИЗМ
INTERNATIONAL HUMAN RIGHTS MECHANISM**

Нэгдсэн Үндэстний Байгууллага, Европын Холбоо, Америкийн Улсуудын Холбоо, Африкийн Холбооны хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд, тэдгээрийн баталсан гэрээ конвенциуд, тусгай горилын цогцыг олон улсын хүний эрхийг хамгаалах механизм гэж нэрлэдэг. Хэдийгээр хүний эрхийг хамгаалах олон улсын механизмд сонгодог утгаараа засгийн газар хоорондын байгууллагуудыг багтаах боловч Эмнести Интернэшнл (Amnesty International), Хүний эрхийн Олон Улсын Хяналт (Human Rights Watch) зэрэг олон улсын хэтжээнд үйл ажиллагаа явуулдаг Засгийн газрын бус байгууллагууд хүний эрхийн асуудалд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Энэ хэсэгт НҮБ-ын болон бүс нутгийн хүний эрхийг хамгаалах үндсэн байгууллагууд, гэрээ конвенциуд болон тэдгээртэй холбоотой түгээмэл хэрэглэгддэг нэр томъёог тайлбарлах болно. Түүнчлэн хүний эрхийн үндэсний байгууллагуудын олон улсын үүрэг өсөн нэмэгдэж буйг харгалзан холбогдох нэр томъёог багтаааа.

**АРЬС ӨНГӨӨР ЯЛГАВАРЛАН
ГАДУУРХАХ ҮЗЛИЙГ УСТГАХ ХОРОО
COMMITTEE ON THE ELIMINATION OF
RACIAL DISCRIMINATION**

Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийг устгах хороо (АӨЯГҮУХ) нь Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцид нэгдэн орсон гишүүн улсууд уг конвенцийг хэрхэн хэрэгжүүлж буйд хяналт тавих бие даасан шинжээчдээс бүрдсэн байгууллага юм.

Нэгдэн орсон гишүүн бүх улс уг конвенцид тусгагдсан эрхүүд хэрхэн хэрэгжиж байгаа талаар тухайн конвенцийг хариуцсан хороонд илтгэл тогтмол хүргүүлэх үүрэгтэй. Конвенцид нэгдэж орсноос хойш 1 жилийн дотор гишүүн улс эхний тайлангаа хүргүүлж, түүнээс хойш 2 жил тутамд хороонд илтгэлээ тогтмол хүргүүлэх үүрэгтэй. Хороо нь илтгэл бүрийг хянан үзэж, асуудлуудыг гарган тавьж, “дүгнэлт зөвлөмж” нэртэйгээр гишүүн улсад зөвлөмж хүргүүлдэг.

Илтгэл хүргүүлэх үйл явцаас гадна, тус конвенцоор (1) өмнө нь сануулах үйл ажиллагаа, (2) улс-хоорондын гомдлыг шалгах үйл явц, (3) хувь хүний гомдлыг шалгах үйл явц гэсэн гурван өөр механизмыг байгуулжээ. Уг механизмын дагуу хороо нь хяналт шалгалт явуулах чиг үүргээ хэрэгжүүлдэг.

Тус хороо нь жилд 2 удаа хуралдах бөгөөд хурал тус бүр нь гурван долоо хоног үргэлжилдэг. Мөн хороо нь ерөнхий зөвлөмж гэж нэрлэгддэг сэдэвчилсэн асуудлаарх хүний эрхийн заалтын тайлбарыг хэвлэн нийтэлдэг бөгөөд сэдэвчилсэн асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулдаг.

**НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН
ДҮРВЭГСДИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ДЭЭД
КОМИССАРЫН ГАЗАР**

**THE OFFICE OF THE UNITED NATIONS
HIGH COMMISSIONER FOR REFUGEES**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын газар нь Ерөнхий Ассамблеин шийдвэрийн дагуу 1950 оны 12 дугаар сарын 14-нд байгуулагдсан бөгөөд дүрвэгсдийг хамгаалах олон улсын үйл ажиллагааг тэргүүлэх, уялдан зохицуулах, дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэх эрх хэмжээ бүхий байгууллага юм. Энэ байгууллагын үндсэн зорилго нь дүрвэгсдийн болон харъяалалгүй хүмүүсийн эрхийг хамгаалах, тэдний сайн сайхан амьдрах нөхцөлийг хангах, энэ талаар олон улсын түвшний хамтын ажиллагааг бүрдүүлэхэд оршдог.

Одоогоор Монгол Улс Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай 1951 оны Конвенц, түүний 1967 оны Протоколд нэгдэн ороогүй боловч Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын газрын Монгол Улс дахь төлөөлөгч нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд дүрвэгчийн статус тодорхойлох, дүрвэгсдийн асуудлыг урт хугацаанд шийдвэрлэх буюу гуравдагч оронд шилжүүлэх үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМ

UNITED NATIONS CHARTER

Уг дүрмээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтын үндсийг тодорхойлдог. Дүрмийг 1945 оны 06 дугаар сарын 26-ны өдөр НҮБ-ын гишүүн 51 улсын 50 нь байлцаж гарын үсэг зурснаар баталсан бөгөөд энэ цагаас эхлэн Нэгдсэн Үндэстний Байгууллага байгуулагджээ.

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЕРӨНХИЙ АССАМБЛЕЙ

UNITED NATIONS GENERAL ASSEMBLY

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын удирдан чиглүүлэх, хянан шалгах, зөвлөлдөх гол байгууллага. Өөрөөр хэлбэл Ерөнхий Ассамблей нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын төсвийг хянах, Аюулгүйн Зөвлөлд байнгын бус гишүүдийг томилох, Нэгдсэн Үндэстний Байгууллагын бусад салбараас илтгэл хүлээн авах болон Ерөнхий Ассамблейн Тогтоолоор зөвлөмж гаргах эрх бүхий байгууллага юм. Энэ нь тус бүрдээ нэг саналын эрхтэй бүх гишүүн улсын төлөөллөөс бүрддэг цорын ганц байгууллага юм. Одоогийн байдлаар 193 гишүүн улс байдаг байна. Энгийн олонхи нь ихэнх шийдвэрүүдийг гаргадаг. Энхтайвны асуудал, шинээр гишүүн элсүүлэх, төсөвтэй холбогдсон чухал асуудлууд үнэмлэхүй олонх буюу 2/3-ын саналыг шаарддаг.

Ерөнхий Ассамблейн хүний эрхийн талаарх гол чиг үүрэгт олон улсын улс төрийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжихэд чиглэгдсэн судалгаа санаачлах; зөвлөгөө өгөх; олон улсын эрх зүйг хуульчлан эмхтгэх, боловсруулах; хүний эрх, үндсэн эрх чөлөөг бүх нийтэд эдлүүлэх явдлыг биелүүлэх; эдийн засаг, нийгэм, соёл, боловсрол, эрүүл мэндийн салбар дахь олон улсын хамтын ажиллагааг хангахад чиглэгдсэн асуудлууд хамаардаг. Ерөнхий Ассамблейн байгуулсан олон тооны хороод, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн Бичгийн Дарга нарын Газар болон Ерөнхий Ассамблейгаас зарлан хуралдуулдаг олон улсын бага хурлаар эдгээр ажлыг хийж гүйцэтгэдэг.

Ерөнхий Ассамблей нь жилд тогтмол хуралддаг бөгөөд хурал нь 9 дүгээр сараас 12 дугаар сар хүртэл үргэлжилнэ. Мөн онцгой, яаралтай үед дахин хуралдуулж болно. Ерөнхий Ассамблейн бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх мэдэл, санал өгөх эрх болон үйл ажиллагааны талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тунхагийн 4 дүгээр бүлэгт заасан байдаг.

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

UNITED NATIONS SECRETARY GENERAL

Ерөнхий нарийн бичгийн дарга нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын захиргааны дээд албан тушаалтан бөгөөд Ерөнхий Ассамблейн хуралдаанаас томилогдоно. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Ерөнхий Ассамблей, Аюулгүйн Зөвлөл, Эдийн засаг, нийгмийн зөвлөл, Итгэлцлийн зөвлөлийн (Trusteeship Council) бүх хуралдаанд оролцох бөгөөд эдгээр байгууллагаас түүнд хүлээлгэх чиг үүргийг хэрэгжүүлнэ. Ерөнхий нарийн бичгийн дарга Нэгдсэн Үндэстний Байгууллагын ажлын тухай жил тутам тайлан гаргаж Ерөнхий Ассамблейд танилцуулж хэлэлцүүлдэг байна. Мөн Ерөнхий нарийн бичгийн дарга нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулдаг Нарийн бичгийн дарга нарын газрыг тэргүүлдэг. Ерөнхий нарийн бичгийн дарга болон уг газрын тухай Нэгдсэн Үндэстний байгууллагын дүрмийн 15 дугаар бүлэгт заасан байдаг. Дүрэмд заасанчлан ажилтнууд нь үүрэгт ажлаа гүйцэтгэхдээ аливаа засгийн газраас буюу Нэгдсэн Үндэстний Байгууллагад үл хамаарах ямарваа захиргаанаас зааварчилгаа хүсэх буюу хүлээн авах, олон улсын албан тушаалтны хувьд байр суурьт нь нөлөөлж

болох аливаа үйлдэл хийхээс зайлсхийх ёстой байдаг. Ерөнхий Нарийн Бичгийн Даргыг Аюулгүйн Зөвлөл санал болгосны үндсэн дээр Ерөнхий Ассамблей томилно. Ерөнхий Нарийн Бичгийн Дарга нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын бусад байгууллагуудаас гаргасан хөтөлбөр, бодлогыг удирдан явуулдаг. Ерөнхий Нарийн Бичгийн Дарга нь энх тайвны үйл ажиллагааг сахиулах, захиргааны ажлаас авахуулаад бусад улс орнуудын эдийн засаг болон нийгмийн хандлагын талаарх судалгаа явуулах зэрэг олон төрлийн албан ажлыг хийж гүйцэтгэдэг.

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАРЫН ГАЗАР

UNITED NATIONS SECRETARIAT

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн Бичгийн Дарга нарын Газар нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын үндсэн байгууллагуудын нэг бөгөөд олон улсын энх тайван, аюулгүй байдлыг гишүүн улсууд хамтаар бэхжүүлэхэд тусламж дэмжлэг үзүүлэхийг хөхиүлэн дэмжих үүрэг бүхий засгийн газар хоорондын байгууллага юм. Тус байгууллага нь гишүүн улсууд олон улсын салбарт тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэхэд гол цөм болдог.

Нарийн Бичгийн Дарга нарын Газар нь 170 гаруй улсын 44,000 гаруй ажилтан болон Ерөнхий Нарийн Бичгийн Даргаас бүрдэнэ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тунхагт Нарийн Бичгийн Дарга нарын Газрын эрх мэдлийг нарийвчлан тодорхойлоогүй байдаг. Гэсэн ч Нарийн Бичгийн Дарга нарын Газар болон Ерөнхий Нарийн Бичгийн Дарга нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын амин чухал бүрэлдэхүүн хэсгүүд билээ. Нарийн Бичгийн Дарга

нарын Газар нь ерөнхий-нарийн бичгийн даргын уулзалт, хурлыг зохион байгуулах, зарлах үүрэгтэй. Мөн Нарийн Бичгийн Дарга нарын Газар нь НҮБ-аас гаргаж буй бүх л гэрээ, олон улсын хэлэлцээрүүдийг хэвлэн нийтлэх үүрэгтэй.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөтөлбөрөөс хамааран Нарийн Бичгийн Дарга нарын Газрын үүрэг роль янз бүр байдаг. Зарим тохиолдолд тус газар нь холбогчийн үүрэг гүйцэтгэж байхад зарим үед энхийг сахиулагч үйл ажиллагааг удирдан явуулж байх жишээтэй. Нарийн Бичгийн Дарга нарын Газрын өөр нэг чиг үүрэг бол илтгэл, баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын албан ёсны хэл рүү орчуулах явдал юм. Мөн Нарийн Бичгийн Дарга нарын Газар нь ерөнхий үйлчилгээний хангамж, цалин хөлсийг баталж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын бусад агентлагуудад зөвлөгөө өгдөг болно.

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

UN DEVELOPMENT PROGRAMME

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ) нь хөгжил, өөрчлөлт шинэчлэлтийг хөхиүлэн дэмжих, хүн төрөлхтөний сайн сайхны тусын тулд улс орнуудыг мэдлэг, туршлага, санхүүгийн эх үүсвэрээр дамжуулан холбоход туслалцаа үзүүлэх зорилго бүхий Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн агентлагийн нэг юм. 1966 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж буй бөгөөд Мянганы Хөгжлийн зорилтууд болон улс орны үндэстний хөгжлийн зорилтуудад хүрэхэд тулгарч буй сорилтуудыг даван туулах, тухайн орны нөхцөл байдалд тохирсон хөгжлийн бодлогыг боловсруулах чиглэлээр засгийн газрууд, хувийн

хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. 1973 онд Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газраа нээсэн бөгөөд Монголын ард түмэнд хүний эрхэд суурилсан, тогтвортой хөгжлийн үндэс суурийг бүрдүүлэх, Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх талаар мэдлэг туршлага хуваалцах, хамтын ажиллагааг баталгаажуулах, бодлогын хэлэлцүүлгийг өрнүүлэх чиглэлээр тусалж байна.

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ МЕХАНИЗМ

UN HUMAN RIGHTS MECHANISM

Нэгдсэн Үндэстний Байгууллага нь олон улсын хууль, эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал, нийгмийн асуудлууд болон хүний эрхийн талаар хамтран ажиллах зорилго бүхий олон улсын байгууллага юм. Нэгдсэн Үндэстний Байгууллага нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд хүний эрхийг хангах, хамгаалах, ахиц дэвшил гаргах зорилгоор олон тооны хүний эрхийн баримт бичиг, гэрээ конвенцийг батлан гаргадаг. Мөн эдгээр баримт бичгийг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий олон улсын, бүс нутгийн болон үндэсний хүний эрхийн механизм, тогтолцоог бий болгохыг зорьж иржээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийг хамгаалах тогтолцоог ерөнхийд нь:

1. Дүрэмд үндэслэсэн - Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмээр шууд ба шууд бусаар хүний эрхийн хэм хэмжээг тогтоож, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Ерөнхий ассамблей, Итгэлцлийн зөвлөл, Эдийн засаг, нийгмийн зөвлөл, Эмэгтэйчүүдийн байдлын тухай комисс зэрэг байгууллагуудыг хамааруулдаг.

2. Гэрээнд үндэслэсэн – Хүний эрхийн гэрээний дагуу түүнд нэгдэн орсон, гарын үсэг зурсан орнууд гэрээний дагуу хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянах эрх бүхий хороо, комиссыг хэлнэ.

3. Төрөлжсөн байгууллага–Тодорхой асуудлаар буюу боловсрол, хоол хүнс, үйлдвэржилт, хүүхдийн эрхийн чиглэлээр дагнан ажилладаг байгууллагуудыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллага гэж ангилна. Засгийн газар хоорондын хэлэлцээрээр байгуулагдсан бөгөөд үүсгэн байгуулах гол баримт бичгийнхээ дагуу эдийн засаг, нийгэм, соёл, боловсрол, эрүүл мэндийн болон тэдгээртэй холбогдох салбаруудад олон улсын өмнө үүрэг хариуцлага хүлээсэн байгууллагууд юм.

Эдийн засаг, нийгмийн зөвлөл нь олон улсын эдийн засаг, нийгэм, соёл, боловсрол, эрүүл мэнд болон тэдгээртэй холбогдох асуудлаар судалгаа хийх, тайлан боловсруулах буюу санаачлах, түүнчлэн эдгээр аль ч асуудлын талаар Ерөнхий Ассамблей, Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүд болон холбогдох төрөлжсөн байгууллагуудад зөвлөмж гаргах эрхтэй. Мөн уг Зөвлөл хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн сахих явдлыг дэмжих зорилгоор зөвлөмж гаргах эрхтэй. Зөвлөл эрх хэмжээнийхээ асуудлаар Ерөнхий Ассамблейд хэлэлцүүлэх конвенцийн төсөл бэлтгэх эрхтэй байдаг.

Хүний эрхийг хамгаалах бүс нутгийн байгууллага

1. Африк дундын харти
2. Европын хүний эрхийн зөвлөл
3. Америк дундын харти гэх мэт бүс нутгийн хүний эрхийн механизм байдаг.

Одоогоор Ази тивд бүс нутгийн хүний эрхийн механизм хараахан байгуулагдаагүй байна.

Хүний эрхийн олон улсын механизмын үйл ажиллагааг зохицуулсан журмыг дараах байдлаар 2 ангилна.

1. Гомдол гаргах журам: Энэ нь хүн амын нэлээд хэсгийг хамарсан эсхүл тэдний нийтлэг ашиг сонирхлыг зөрчсөн хүний эрхийн зөрчлүүдийг тогтооход чиглэгдэнэ.

2. Хянан тайлагнах журам: Хүний эрх эрх чөлөөг хангаж хамгаалах талаар гишүүн орнууд, засгийн газрын үйл ажиллагааны тайлан, мөн тухайн улсад хүний эрхийн чиглэлээр хийсэн хяналт шалгалтын үр дүнг нэгтгэн хэлэлцэж албан ёсны зөвлөмж гаргах үйл ажиллагааг ойлгодог.

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ ЭРХИЙН ДЭЭД КОМИССАРЫН ГАЗАР

OFFICE OF THE UNITED NATIONS HIGH COMMISSIONER FOR HUMAN RIGHTS

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд Комиссарын Газар (ХЭДКГ) нь олон улсын хууль болон 1948 оны Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалд тусгагдсан хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих зорилготой ажилладаг Нэгдсэн Үндэстний Байгууллагын агентлаг билээ. 1993 онд болсон Хүний эрхийн Дэлхийн Бага Хурлын дараа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей Хүний Эрхийн Дээд Комиссарын Газрыг 1993 оны 12 дугаар сарын 20-нд байгуулсан.

Тус газрыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Нарийн Бичгийн Даргын дор Хүний эрхийн дээд комиссар удирддаг бөгөөд тэрбээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын тогтолцоогоор дамжуулж хүний эрхийн үйл ажиллагааг зохицуулдаг ба Швейцарийн Холбооны Улсын Женев хотод байрлах Хүний эрхийн Зөвлөлийг хариуцдаг. Одоогийн дээд комиссараар Өмнөд Африкийн хуульч Наванетем Пиллау 2008 оны

9 дүгээр сарын 1-нээс эхлэн 4 жилийн хугацаатайгаар томилогдон ажиллаж байна.

2008 оны байдлаар, тус газар нь 120 сая ам. долларын жилийн төсөвтэй, 1000 орчим ажилтан Женев хотноо байрлан ажиллаж байна.

Дээд комиссар нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд Комиссарын Газрын бүх л үйл ажиллагаа болон захиргааны асуудлыг хариуцан ажилладаг. Ерөнхий Ассамблейн тогтоол болон бодлого боловсруулагчдын тогтоолд дээд комиссарт тусгайлан заасан чиг үүргийг хэрэгжүүлж, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн асуудлаарх бодлого боловсруулахад Ерөнхий Нарийн Бичгийн Даргад зөвлөгөө өгөх, хүний эрхийн төсөл, үйл ажиллагаа болон хүний эрхийн хөтөлбөрийн байгууллагуудад захиргааны болон бодит дэмжлэг үзүүлэх явдлыг хангах, хүний эрхийн байгууллагуудын хурал чуулган болон бусад хүний эрхийн үйл ажиллагаанд Ерөнхий Нарийн Бичгийн Даргыг төлөөлөн оролцох болон Ерөнхий Нарийн Бичгийн Даргын даалгасан тусгай үүрэг даалгавруудыг хэрэгжүүлдэг.

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛ

UNITED NATIONS HUMAN RIGHTS COUNCIL

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөл (ХЭЗ) нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын тогтолцоон дахь засгийн газар хоорондын байгууллага юм. Хүний Эрхийн Зөвлөл нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Комиссын залгамж халаа бөгөөд Ерөнхий Ассамблейн салбар байгууллага билээ. Тус зөвлөл нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссарын газартай ойр ажилладаг

бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тусгай журмыг хариуцан ажилладаг юм. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Зөвлөлийг Ерөнхий Ассамблей А/RES/60/251 тогтоолоор, өмнөх Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Комиссыг орлуулах зорилгоор 2006 оны 3 дугаар сарын 15-нд байгуулсан. Учир нь өмнөх Хүний эрхийн Комисс хүний эрхийн талаар тааруухан үзүүлэлттэй улсуудыг гишүүн улсаар оруулж байсан гэдгээрээ ихээхэн шүүмжлэлд өртөж байжээ.

Ерөнхий Ассамблейн гишүүд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Зөвлөлийн дөчин долоон суудлыг эзлэх гишүүдийг сонгодог байна. Гишүүд нь 3 жилийн хугацаатай томилогдох бөгөөд ямар ч гишүүн 2-оос дээш удаа сонгогдож болохгүй. Гишүүдийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүдээс газарзүйн байрлалаар сонгоно. Тухайлбал, Африкаас 13, Азиас 13, Зүүн Европоос 6, Латин Америк болон Карибаас 8, Баруун Европ болон бусад газраас тус тус 7 хүнийг гишүүнээр сонгодог.

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ ЭРХИЙН КОМИСС

THE UNITED NATIONS COMMISSION ON HUMAN RIGHTS (ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛ БОЛЖ ӨӨРЧЛӨГДСӨН)

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн комисс нь 1946 онд байгуулагдсан бөгөөд эрдэмтэн судлаачид хүний эрх, эрх чөлөөг хамгаалах олон улсын эрх зүйн эх сурвалжийг нэгэн даавуутай адилтгавал, нэхмэлчин нь Хүний эрхийн комисс гэж тодорхойлсон байдаг. Комисс нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын 53 гишүүн улсуудын төлөөлөгчдөөс бүрддэг бөгөөд хүний эрхийн янз бүрийн асуудлуудад хариулт өгч,

гишүүн улсуудын удирдлагыг чиглүүлэх хэм хэмжээг тогтоодог байв. Мөн тус Комисс нь дэлхийн өнцөг булан бүрт буй том, жижиг улс орнууд, төрийн бус байгууллагууд болон хүний эрхийн хамгаалагчдын дуу хоолойгоо нэгтгэх чуулган нь болж байлаа. Гишүүн болон ажиглагч улс орнуудын 3000 гаруй төлөөлөгчид, төрийн бус байгууллагууд оролцдог хурлыг Женев хотноо жил бүр зохион байгуулж, уг хурлаар Комисс зуу орчим тогтоол, шийдвэр болон бүх бүс нутгийн хувь хүнтэй холбоотой асуудал, нөхцөл байдлын талаарх хурлын даргын мэдэгдлийг баталсан байна.

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮҮХДИЙН САН UNICEF

НҮБ-ын Хүүхдийн Сан нь Хүүхдийн эрхийн тухай Конвенцийг мөрдлөг болгон бүхий л хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, ахиц дэвшил гаргах чиглэлээр дэлхийн 150 гаруй оронд үйл ажиллагаагаа явуулж байна. НҮБ-ын Хүүхдийн Сан нь “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” бодлогын хүрээнд нийгмийн хамгаалал, нийгмийн бодлого, эх, хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, ус, ариун цэврийн байгууламж, боловсрол, хүүхэд хамгаалал, хүүхдийн хөгжил, оролцоо зэрэг олон төрлийн төсөл, хөтөлбөрүүдийг улс орнуудад хэрэгжүүлдэг.

НҮБ-ын Хүүхдийн Сан нь олон улсын хөгжлийн байгууллагын хувьд хүүхдийн эрх ба хөгжлийн төлөөх хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, эрх тэгш байдлыг хангах, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох зэрэг чиглэлээр Засгийн газруудтай хамтран

ажиллаж байна.

НҮБ-ын Хүүхдийн сан нь 1963 оноос эхлэн дархлаажуулалт, хөхөөр хооллох, иод дутлын эмгэгийг бууруулах зэрэг хөтөлбөрүүдийн хүрээнд Монгол Улсын засгийн газарт техникийн туслалцаа үзүүлж, хамтын ажиллагаа эхлүүлсэн. Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газраа 1991 оноос байгуулан ажиллуулж байна.

НҮБ-ЫН СЭДЭВЧИЛСЭН МЕХАНИЗМ

UN THEMATIC MECHANISMS

Хүний эрхийн зөрчлийн тодорхой төрлийг хариуцан ажилладаг Тусгай илтгэгч, Ажлын хэсгийг ойлгох ба бүрэн эрхийг нь дан ганц улсаар эсвэл газар зүйн бүсээр хязгаарладаггүй. Мөн онолын түвшинд тодорхой асуудлыг судлахын зэрэгцээ өөрийн хариуцсан судалгааны хүрээнд багтах хүний эрхийн зөрчилтэй холбоотой хувь хүнд хамаарах тохиолдлыг нягтлан шалгах, хариу арга хэмжээ авах бүрэн эрхтэй илтгэгч бий.

Ерөнхий Ассамблей нь Зэвсэгт мөргөлдөөн дэх хүүхдийн асуудал хариуцсан Ерөнхий нарийн бичгийн даргын тусгай төлөөлөгчийг байгуулсан.

Хүний эрхийн комисс нь Дотооддоо шилжин суурьшсан хүмүүсийн асуудал хариуцсан Ерөнхий нарийн бичгийн даргын тусгай төлөөлөгчийг болон дараах тооны чухал сэдвийг хамарсан бүрэн эрхийг бий болгожээ. Үүнд:

- Албадан баривчлах
- Орчин үеийн расизм, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, гадаад хүмүүсийг үзэн ядах, үл хүлцэн тэвчсэн хэлбэрүүд
- Хорт хаягдал, аюултай бүтээгдэхүүнийг хууль бусаар

хаясны улмаас хүний эрхийн хэрэгжилтэд үзүүлж байгаа нөлөө

- Хүчээр буюу сураггүй алга болох
- Шүүхээс гадуур, бөөнөөр, албадан цаазаар авах
- Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө
- Хүний эрх ба туйлын ядуурал
- Шүүгч, хуульчдын хараат бус байдал
- Шашны шинжтэй үл тэвчих байдал
- Хөгжих эрх
- Сурч боловсрох эрх
- Хүүхдийн худалдаа, хүүхдийн биеийг үнэлүүлэх, садар самуунд уруу татах
- Бүтцийн шинжтэй тохируулах бодлого
- Эрүү шүүлт
- Хөлсний цэргүүдийг хэрэглэх, өөрөө засан тохинох ард түмний эрх
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл

Цөөнхийг ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах асуудал хариуцсан дэд комисс нь ажлын хэсгээс гадна дараах судалгааг хийх Тусгай илтгэгч, хараат бус шинжээчдийг томилдог. Үүнд:

- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхэд хамаарах
- Иргэний болон улс төрийн эрхэд хамаарах
- Хүн амын шилжилт хөдөлгөөний хүний эрхийн хэмжигдэхүүн
- Хүний эрх ба орлогын хувь нэмэр
- Охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд нөлөөлөх уламжлалт зан үйл
- Зэвсэгт мөргөлдөөний үед зохион байгуулалттай хүчиндэх үйлдэл, бэлгийн боолчлол
- Хүний эрх ба онц байдал
- Хорих ангийг өмчлүүлэх ажиллагаа

- Шилжин нүүх эрх чөлөө
- Хүний эрх ба терроризм
- Хүний эрх ба шинжлэх ухааны ахиц дэвшил

Хүний эрхийн комисс болон Дэд комиссын түвшинд Ерөнхий нарийн бичгийн дарга дараах сэдэвчилсэн бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- ХДХВ/ДОХ-ын хүрээн дэх хүний эрх
- Хүний эрх ба шүүхийн шинжилгээ
- Хүний эрх ба үй олноор дүрвэн зугтах явдал
- Хүний эрх ба терроризм
- Хуучин Югослав дахь зэвсэгт мөргөлдөөний бүсэд эмэгтэйчүүдийг хүчиндэх, зүй бус харьцах явдал
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн байгууллагуудтай хамтран ажилладаг хүмүүсийн эсрэг чиглэсэн маргаан зэрэг болно.

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЗӨВЛӨЛ

UNITED NATIONS ECONOMIC AND SOCIAL COUNCIL

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, Нийгмийн Зөвлөл (ЭЗНЗ) нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын зургаан гол байгууллагын нэг билээ. Энэ нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын 14 тусгай агентлаг, тэдгээрийн үйл ажиллагааны комиссууд болон бүсийн 5 комиссын эдийн засаг, нийгэм болон холбогдох ажлыг зохицуулах үүрэгтэй. Тус Зөвлөл нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгээс томилогдсон, 3 жилийн хугацаагаар ажиллах 54 гишүүн улсаас бүрдэнэ. Зөвлөлийн төлөөлөгчдийн суудлыг газарзүйн байрлалаар хуваарилсан ба Африкт 14, Азид 11, Зүүн Европт 6, Латин Америк болон Карибын улс орнуудад 10, Баруун Европ болон

бусад орнуудад тус тус 13 суудал хуваарилсан байна. Зөвлөл нь жил бүрийн 7 дугаар сард дөрвөн долоо хоног үргэлжлэх хурал зохион байгуулдаг. 1998 оноос хойш тус Зөвлөл нь Дэлхийн Банк болон Олон улсын Валютын Сангийн гол хороодын сангийн сайдуудтай жил бүрийн 4 дүгээр сард уулзалт зохион байгуулж байна. Эдийн засаг, Нийгмийн Зөвлөл нь олон улсын эдийн засаг болон нийгмийн асуудлыг хэлэлцэх гол чуулган болж байгаа бөгөөд гишүүн улсууд болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын тогтолцоонд гаргасан бодлогын санал зөвлөмжийг гүйцэтгэдэг.

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН КОМИСС

UNITED NATIONS COMMISSION ON THE STATUS OF WOMEN

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эмэгтэйчүүдийн асуудалэрхэлсэн Комисснь (ЭАЭК) нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, Нийгмийн Зөвлөлийн үйл ажиллагааны комисс бөгөөд эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаархи гол байгууллагуудын нэг билээ. Гишүүн улсуудын төлөөлөгчид жендэрийн эрх тэгш байдалд гарч буй ололт амжилтад дүгнэлт хийх, тулгамдаж буй бэрхшээлийг тодорхойлох, нэгдсэн хэм хэмжээг тогтоох, жендэрийн эрх тэгш байдлыг хөхиүлэн дэмжих болон дэлхий дахин дахь эмэгтэйчүүдийн хөгжил, тэмүүллийн тухай бодит бодлогыг гаргаж ирэхийн тулд Нью-Йорк дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байранд жил бүр цугладаг.

Эмэгтэйчүүдийн асуудал эрхэлсэн Комиссын хурлыг зөвхөн гишүүн улсуудаар хязгаарладаггүй Нэгдсэн Үндэстний Байгууллагын комиссуудын нэг юм. Тухайлбал, тус хорооны хуралд иргэний нийгмийн байгууллагууд оролцох боломжтой байдаг.

Комисс нь 45 гишүүн улсаас нэг төлөөлөгчийг газар зүйн байрлалын тэнцвэрт байдалд тулгуурлаж Зөвлөлөөс сонгоно. Тухайлбал, Африкаас 13, Азиас 11, Латин Америк болон Карибаас 9, Баруун Европ болон бусад улсаас 8, Зүүн Европоос тус тус 4 төлөөлөгчийг сонгодог байна. Гишүүдийг дөрвөн жилийн хугацаатайгаар томилдог. Тус хороо нь үйл ажиллагааныхаа хүрээнд, 1967 оны Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах үзлийг устгах тунхаг гэх хэд хэдэн конвенц, тунхагийг боловсруулсан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын бусад салбар Комиссуудыг нэрлэвэл:

- Нийгмийн Хөгжлийн Комисс
- Хар тамхи, мансууруулах бодис хариуцсан комисс
- Шинжлэх ухаан, технологийн хөгжлийн комисс
- Тогтвортой хөгжлийн комисс
- Хүн ам ба хөгжлийн комисс
- Статистикийн комисс
- Ой мод хариуцсан Чуулган зэрэг болно.

ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГА INTERNATIONAL LABOUR ORGANISATION

Олон улсын хөдөлмөрийн байгууллага нь нийгмийн шударга ёс, зохистой хөдөлмөрийг дэмжих зарчмыг үндсэн зорилгоо болгосон Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн агентлагийн нэг юм. Олон улсын хөдөлмөрийн байгууллага нь зохистой хөдөлмөр эрхлэх боломжоор хангах, ажлын байран дахь хүний эрхийг дээдлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр төр, ажил олгогч, ажиллагсдын хоорондын нийгмийн түншлэлийг бэхжүүлэх, хөдөлмөрийн харилцааны суурь зарчим, хууль эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд гол анхаарлаа хандуулдаг.

Хөдөлмөрийн насны хүн ам, бизнес эрхлэгчдийг дэмжсэн хөдөлмөр, эдийн засгийн тааламжтай нөхцөл, зохистой хөдөлмөрийн харилцааг улс нийгэмд хэвшүүлснээр дэлхий нийтийн энх тайван, хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулна гэж үздэг байна. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенц, зөвлөмжийг жил бүрийн Олон улсын хөдөлмөрийн бага хурлаар баталдаг. Засгийн газар, ажиллагчдын болон ажил олгогчдын төлөөлөл Женевт жил бүр цуглан хөдөлмөрийн салбарт мөрдөгдөх стандартыг хэлэлцэн баталж, хяналт тавьдаг. Монгол Улс нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагад 1968 онд гишүүнээр элссэн бөгөөд тус байгууллагын Хятад улс, Монгол Улсын асуудлыг хариуцсан товчоо Бээжин хотноо ажиллаж байна.

ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХ INTERNATIONAL CRIMINAL COURT

Олон улсын эрүүгийн шүүх нь төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг шүүх зориулалттай, байнгын үйл ажиллагаа явуулдаг, эрүүгийн шүүн таслах үндэсний шүүх байгууллагад нэмэлт хөшүүрэг болдог байгууллага юм.

2002 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр болсон Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмээр Олон улсын эрүүгийн шүүхийг байгуулах шийдэлд хүрсэн ба дүрэмд зааснаар тус шүүх нь байгуулагдсан цагаасаа хойшхи нэр дурдсан эрүүгийн гэмт хэргүүдийг шүүн таслах ажиллагаа явуулна.

Олон улсын эрүүгийн шүүх Нидерланд Улсын Гаг хотноо байрлан үйл ажиллагаагаа явуулдаг. 2012 оны 07 дугаар сарын байдлаар 121 улс Олон улсын

эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд нэгдэн ороод байна.

ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХИЙН РОМЫН ДҮРЭМ

ROME STATUTE OF THE INTERNATIONAL CRIMINAL COURT

1998 оны 07 дугаар сарын 18-ны өдөр баталж, 2002 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрэм нь Олон Улсын Эрүүгийн Шүүхийг үндэслэн байгуулсан гол баримт бичиг юм. Олон Улсын Эрүүгийн Шүүх нь уг дүрэмд заасны дагуу үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд оролцогч улсууд 2010 онд Уганда улсын Кампала хотноо Ромын дүрмийн Дүгнэлт хэлэлцүүлгийг анх удаа явуулжээ.

ОМБУДСМЕН

OMBUDSMEN

XIX зууны үед энэ ойлголтыг Скандинавын орнууд анхлан бий болгож, 1960 онд Шинэ Зеланд улс анхны омбудсменийг томилсон байна. Омбудсмен нь төрийн удирдлагын үйл ажиллагааны талаарх санал гомдлыг бие даан хүлээн авч судалдаг институт бөгөөд аливаа захиргааны акт, шийдвэр хуульд нийцэж буй эсэх, эрх мэдэл бүхий албан тушаалтан хүнд суртал гаргах, сонирхлын зөрчил гаргаж буй эсэхийг хянах чиг үүргийг гүйцэтгэдэг. Омбудсмен нь шүүх байгууллага шиг хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дээр үндэслэн шийдвэр гаргадаггүй бөгөөд харин тухайн тогтоогдсон нөхцөл байдлыг илтгэж дүгнэлт гаргадгаараа онцлогтой юм.

ТАЙЛАН/ТАЙЛАГНАХ ЖУРАМ REPORT/REPORTING PROCEDURE

Аливаа гэрээний дагуу гэрээнд нэгдэж орсон гишүүн улсууд тухайн гэрээнд тусгагдсан эрхийн хэрэгжилтийн явц, дэвшил, учирч буй саад бэрхшээлийн талаарх илтгэлийг тодорхой хугацаанд гишүүн улс тайлагнах тухай хүний эрхийн олон улсын гэрээнд заасан үүргийг хэрэгжүүлэх журам юм. Үүнд дараах нэгдсэн журам үйлчилдэг.

- Гэрээний гишүүн улс бүр ээлжит тайлангаа Хороонд хүргүүлэх ёстой байдаг.

- Төрийн бус байгууллагууд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын агентлагууд, шинжээчид зэрэг янз бүрийн эх сурвалжуудаас хүлээн авсан мэдээллийг түшиглэн гэрээний байгууллагууд тайланг шалгадаг. Зарим гэрээний байгууллагууд, төрийн бус байгууллага болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын агентлагуудаас мэдээлэл ирүүлэхийг тусгайлан хүсдэг.

- Мэдээллийг дүгнэж үзсэний дараа гэрээний байгууллагаас холбогдох гэрээний хэрэгжилтийг сайтар хангах үйл ажиллагаа явуулахад чиглэгдсэн дүгнэлт зөвлөмжийг гэрээний гишүүн улсад хандан гаргадаг. Дараагийн тайланг шалгах явцад өмнөх дүгнэлт зөвлөмжийн дагуу гэрээний гишүүн улсын зүгээс хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааг гэрээний байгууллага хянаж үздэг.

ТУСГАЙ ИЛТГЭГЧИД

SPECIAL RAPPORTEURS

Тусгай илтгэгч гэдэг нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлөөс тусгай эрх олгодог “Тусгай Журам”-ын механизмын хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын нэрийн өмнөөс ажиллах бие даасан хүмүүст олгодог албан тушаал билээ. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас олгосон

эрхийн дагуу, тусгай илтгэгч нь хувь хүний гомдолд холбогдуулан хариулт өгөх, судалгаа явуулах, тухайн улсын түвшинд техникийн хамтын ажиллагаанд зөвлөгөө өгөх зэрэг тусгай журмын дагуу хийгдэж буй үйл ажиллагаагаар дамжуулан хүний эрхийн асуудлыг хянаж шалгах, мониторинг хийх, зөвлөгөө өгөх болон хүний эрхийн асуудлыг олон нийтэд мэдээлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэдэг. Ерөнхий Нарийн Бичгийн Даргын нарын Газрын Тусгай Төлөөлөгч аль эсвэл “Бие даасан шинжээч” болон ажлын хэсэг нь гол төлөв бүс бүрээс томилогдсон таван гишүүнээс бүрддэг.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХИЙГ ХАРИУЦСАН ХОРОО

COMMITTEE ON THE RIGHTS OF PERSONS WITH DISABILITIES

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хариуцсан хороо нь Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Эрхийн тухай Конвенцид нэгдэж орсон гишүүн улсууд уг конвенцийг хэрхэн хэрэгжүүлж буйд хяналт тавих бие даасан шинжээч мэргэжилтнүүдээс бүрдэнэ. Гишүүн бүх улс уг конвенцид тусгагдсан эрхүүд хэрхэн хэрэгжиж байгаа талаар тухайн хороонд илтгэл тогтмол хүргүүлэх үүрэгтэй. Конвенцид нэгдэж орсноос хойш 2 жилийн дотор гишүүн улс эхний тайлангаа хүргүүлж, түүнээс хойш 4 жил тутамд хороонд илтгэлээ тогтмол хүргүүлэх үүрэгтэй. Хороо нь илтгэл бүрийг хянан үзэж, анхаарч авч үзвэл зохистой гэсэн асуудлын дагуу санал, зөвлөмж гаргаж, тухайн гишүүн улсад хүргүүлдэг.

Хороо нь тус Конвенцийн Нэмэлт Протоколд нэгдэн орсон гишүүн улсуудаас конвенцид тусгагдсан эрхийн зөрчлийн талаар хувь хүний гомдол хүлээн авч, хянаж авч үзэх эрхтэй. Хороо нь жилд 2 удаа Женев хотод

хурал зохион байгуулдаг.

**ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ХӨХИҮЛЭН
ДЭМЖИХ АСУУДАЛ ХАРИУЦСАН ДЭД КОМИСС
SUBCOMMISSION ON THE PROMOTION AND
PROTECTION OF HUMAN RIGHTS**

Хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих асуудал хариуцсан дэд комисс бол 1947 онд 12 гишүүнтэй байгуулагдаж байсан, хуучнаар Хүний эрхийн комиссын гол туслах байгууллага юм. Анх Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн удирдлаган дор 1947 онд “Цөөнхийг ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах асуудал хариуцсан дэд комисс” гэж байгуулагдсан бол 1999 онд нэрээ сольсон.

Хүний эрхийн комиссыг 2006 онд Хүний эрхийн зөвлөл болгож өөрчилсөнтэй холбогдуулан, Дэд комиссын үүрэг хариуцлага өөрчлөгдсөн. 2006 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Зөвлөлөөс Дэд комиссын бүрэн эрхийг нэмэлт нэг жилийн хугацаатай сунгах шийдвэр гаргаж, Зөвлөлийн хяналтад багтах байгууллага болгосон. Дэд комиссын 2006 оны 8 сард хийсэн хуралдааны үеэр Хүний эрхийн зөвлөлд бие даасан байдлаар туслах чиг үүрэгтэй хүний эрхийн зөвлөх хороо болгох шийдвэр зөвлөмжүүдэд тусгалаа олжээ. Одоо тус байгууллага нь газар зүйн байрлалаас хамааран тэгшитгэн сонгодог, бие даасан 26 шинжээчээс бүрдэх ба өөрийн хувийн чадавх, нөөц бололцоондоо тулгуурлан ажилладаг. Гишүүнчлэл нь 2006 оны байдлаар Азиас 5, Африкаас 7, зүүн Европоос 3, баруун Европ болон бусад улсаас 6, Латин Америкаас 5 Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн улсын төлөөлөл байжээ.

Уг дэд комиссын гол чиг үүрэг нь хүний эрхийн

асуудлын талаарх судалгаа хийх, хүний эрх, суурь эрх чөлөөтэй холбоотой аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, арьсны, үндэсний, шашны, хэлний зэрэг цөөнхийг хамгаалах тухай зөвлөмж гаргах, мөн шилжүүлэн өгсөн бусад чиг үүргийг гүйцэтгэдэг. Гол төлөв “НҮБ-ын Хүний эрхийн комиссын бодлогын хүрээлэн” гэж нэрлэх тус байгууллагаас хийсэн судалгаа нь хүний эрхийн хэрэгжилт, шүүх тогтолцооны удирдлага, ялгаварлан гадуурхалттай тэмцэх, цөөнх, уугуул хүмүүс, бусад эмзэг бүлгийн хүний эрхийг хамгаалах талаарх төрөл бүрийн асуудлыг хамарсан байдаг онцлогтой.

Мөн ялгаварлан гадуурхсан үйл ажиллагааны тухай судалгаа хийх, хуулиар арьсны, үндэсний, шашны, хэлний цөөнхийг хамгаалах тухай зөвлөмж боловсруулдаг 8 ажлын хэсэг байдаг. Үүнд:

- Шүүх тогтолцооны удирдлага хариуцсан ажлын хэсэг
- Харилцаа холбоо хариуцсан ажлын хэсэг
- Орчин үеийн боолчлолын хэлбэр хариуцсан ажлын хэсэг
- Уугуул хүн ам хариуцсан ажлын хэсэг
- Цөөнх хариуцсан ажлын хэсэг
- Нийгмийн хэлэлцүүлэг хариуцсан ажлын хэсэг
- Үндэстэн дамнасан корпорациуд хариуцсан ажлын хэсэг
- Терроризм хариуцсан ажлын хэсэг

ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨХ ХОРОО

HUMAN RIGHTS COUNCIL ADVISORY COMMITTEE

Хүний эрхийн Зөвлөлийн үйл ажиллагааны бодлого, чиглэлийг тодорхойлох үүрэг бүхий Зөвлөх Хороо нь өөрийн итгэл үнэмшлийн үндсэн дээр ажиллах 18 шинжээчдээс бүрдэж ажилладаг. Зөвлөх хороо нь судалгаа, шинжилгээний ажилд төвлөрөн судалгаанд үндэслэсэн Хүний эрхийн Зөвлөлийн эрх хэмжээнд

хамаарах асуудлаар арга зүйн зөвлөмж өгдөг. Зөвлөх хорооны гишүүдийг бүс нутгийн харъяалал, хүний эрхийн мэдлэг туршлага, ёс зүй зэргийг нь харгалзан Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн улсуудаас өөрийн орны хүний эрхийн үндэстний байгууллага болон иргэний нийгмийн байгууллагуудтай зөвшилцөн нэр дэвшүүлж Хүний эрхийн Зөвлөлийн хуралдаанаас нууц санал хураалтаар сонгоно. Зөвлөх хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛИЙН ТУСГАЙ ЖУРАМ

SPECIAL PROCEDURES OF THE HUMAN RIGHTS COUNCIL

“Тусгай Журам” гэдэг нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын цаг үеийн шинжтэй, мэдээ баримт цуглуулах бие даасан нэмэлт механизмыг хэлнэ. Энэ нь тодорхой нэг улсын хүний эрхийн нөхцөл байдал, аль эсвэл дэлхийн өнцөг булан бүрт байгаа хүний эрхийн тухай сэдэвчилсэн асуудлыг авч хэлэлцдэг механизм юм. Одоогийн байдлаар, 36 сэдэвчилсэн асуудлаар, 12 улс орны хүний эрхийн нөхцөл байдлын дагуу хэлэлцэх мандаттай ажиллаж байна. Хүний эрхийн Дээд Комиссарын Газар нь энэхүү механизмыг хэрэгжүүлэхийн тулд боловсон хүчин, бодлого, судалгаа болон арын албаар дэмжлэг үзүүлдэг.

Тусгай журмын хувьд цаг үеэс хамаарч авдаг арга хэмжээ нь гэрээнд суурилсан байгууллагуудыг бодвол хүний эрхийн ноцтой зөрчилд илүү уян хатан ханддаг онцлогтой. “Тусгай Журам”-д ажилладаг шинжээчид нь хүний эрхийн асуудлаар тусгай мандаттайгаар бие даан ажилладаг байна. Үүнд тусгай илтгэгч, төлөөлөгч, бие даасан шинжээч орох бөгөөд бүлэг болон ажиллах тохиолдолд ажлын хэсэг гэж нэрлэнэ. Тэд Хүний эрхийн Зөвлөлөөс томилогдон, сайн дураар

ажиллах, бие даасан шинжээч нар юм.

ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ ДҮГНЭЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

UNIVERSAL PERIODIC REVIEW (UPR)

Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (Universal Periodic Review) нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын 192 гишүүн орны хүний эрхийн төлөв байдлыг 4 жил тутам дүгнэн хэлэлцдэг цоо шинэ механизм юм.

Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг нь Хүний эрхийн Зөвлөлийн удирдлага дор зохион байгуулагддаг. Энэ үйл ажиллагааны хүрээнд хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах, хүний эрхийг хангах үүргээ хэрэгжүүлэх талаар гишүүн улс ямар арга хэмжээ авсан тухай мэдээлэх боломжийг олгодог. Хүний эрхийн Зөвлөлийн нэг өвөрмөц онцлог бол Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн хүрээнд хүний эрхийн нөхцөл байдалд үнэлгээ хийхдээ бүх улс орнуудад эрх тэгш, ялгаваргүй хандахад оршино. Энэ нь хамтран ажиллах үйл явц бөгөөд 2011 он гэхэд бүх гишүүн орны хүний эрхийн төлөв байдлыг хэлэлцэж авч үзсэн байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2006 оны 3-р сарын 15-ны өдрийн 60/251 тоот тогтоолоор Хүний эрхийн Зөвлөлийг байгуулж Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн тогтолцоог бий болгосон. Дүгнэлт хэлэлцүүлэг нь гишүүн бүх улс орнуудад хүний бүхий л эрх, эрх чөлөөг хүндлэн дээдэлж, хэрэгжүүлэх талаар хүлээсэн үүргийг нь сануулдагаараа шинээр байгуулагдсан Зөвлөлийн нэгээхэн чухал хэсэг болно. Энэхүү шинэ механизмын

туйлын зорилго нь бүх улс орнуудын хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах, зөрчигдсөн хүний эрхэд анхаарлаа хандуулахад оршино.

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН АЗИ НОМХОН ДАЛАЙН ЧУУЛГАН

THE ASIA PACIFIC FORUM OF NATIONAL HUMAN RIGHTS INSTITUTIONS

Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Ази-Номхон далайн чуулган нь Ази-Номхон далайн бүсийн хүний эрхийн голлох байгууллага бөгөөд 1996 онд бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын бие даасан байдлыг бэхжүүлэхэд туслалцаа үзүүлэх зорилгоор гишүүн улсууд байгуулсан.

Одоогоор тус байгууллагад 15 улсын хүний эрхийн үндэсний байгууллага үндсэн гишүүний, 3 улсын хүний эрхийн үндэсний байгууллага ажиглагч гишүүний статус эдэлж байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ПАРИСЫН ЗАРЧИМ

THE PARIS PRINCIPLES

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, эв нэгдлийг хангаж, хамгаалах, хөхиүлэн дэмжих үүрэг бүхий Хүний эрхийн үндэсний байгууллагуудын статусыг тодорхойлох зарчмуудыг 1993 онд батлан гаргасан нь “Парисын зарчмууд” хэмээн нэрлэгдэх болжээ. Улмаар мөн онд Австрийн Вена хотод болсон Хүний эрхийн Дэлхийн бага хурлаар хүний эрхийн үндэсний байгууллагуудыг Парисын зарчмуудад нийцүүлэн байгуулахыг гишүүн орнууддаа уриалсан билээ

Уг зарчимд зааснаар Хүний эрхийн үндэсний

байгууллагуудын үйл ажиллагаа нь:

- Үндсэн хуулиар эсвэл хуулиар байгуулагдсан байх
- Хараат бусаар, бие даан үйл ажиллагаа явуулах
- Олон ургальч төлөөлөлтэй байх
- Санхүүгийн болон хүний хангалттай нөөцтэй байх
- Хүний эрхийг хамгаалахад чиглэгдсэн эрх хэмжээ нь аль болох өргөн хүрээтэй байх
- Иргэний нийгэмтэй хамтран ажиллах зарчмын үндсэн дээр явагдах ёстой хэмээн тодорхойлж өгчээ.

ХҮНИЙ ЭРХИЙН ХОРОО

HUMAN RIGHTS COMMITTEE

Хүний эрхийн Хороо нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактыг гишүүн улсууд хэрхэн хэрэгжүүлж байгаа буюу тус пактын хэрэгжилтэд хяналт тавьдаг бие даасан шинжээчдээс бүрдсэн байгууллага юм. Бүх гишүүн улсууд өөрсдийн улс оронд тухайн пактад тусгагдсан эрхүүд хэрхэн хэрэгжиж байгаа талаар хороонд илтгэл тогтмол хүргүүлэх үүрэгтэй.

Гишүүн улсууд тухайн пактад нэгдэж орсноос хойш нэг жилийн дараа, түүнээс хойш хороог шаардсан үед буюу гол төлөв дөрвөн жил тутамд илтгэл хүргүүлэх үүрэгтэй. Хороо нь илтгэл тус бүрийг хянан үзэж, тулгамдсан асуудлуудыг гарган ирж, тухайн гишүүн улсад тавьсан асуудлын дагуу зөвлөмж хүргүүлдэг. Илтгэл хүргүүлэхээс гадна уг пактын 41 дүгээр зүйлээр хороо нь улс хоорондын гомдлыг хүлээн авч үзэх боломжтой. Түүнчлэн, Пактын нэгдүгээр нэмэлт протоколын дагуу тухайн протоколд нэгдэж орсон гишүүн улс пактад заасан эрхийг зөрчсөн гэж мэдэгдсэн хувь хүний гомдлыг шалгаж үзэх эрхтэй.

Пактын хоёрдугаар нэмэлт протоколын дагуу уг протоколд нэгдэж орсон гишүүн улс цаазын ялыг

халах тухай байдаг.

Хороо нь жилд гурван удаа Женев аль эсвэл Нью-Йорк хотод хуралддаг. Хороо нь мөн ерөнхий зөвлөмж гэх нэртэй сэдэвчилсэн асуудлаар хүний эрхийн заалтын агуулгын тайлбар аль эсвэл өөрсдийн ажлын арга барилын талаар тайлбар ном хэвлэн нийтэлдэг.

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХОРОО

COMMITTEE ON THE RIGHTS OF THE CHILD

Хүүхдийн эрхийн Хороо (ХЭХ) нь Хүүхдийн эрхийн тухай конвенцид нэгдэж орсон гишүүн улсууд уг конвенцийг хэрхэн хэрэгжүүлж буйд хяналт тавих бие даасан шинжээч мэргэжилтнүүдээс бүрддэг. Мөн хороо нь уг конвенцийн хоёр нэмэлт протоколын хэрэгжилтэд хяналт тавьдаг. Үүнд: зэвсэгт мөргөлдөөнд хүүхдийг татан оролцуулах болон хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, болон хүүхдийг садар самуунд сурталчилах асуудалд хяналт тавьж ажилладаг. 2011 оны 12 дугаар сарын 19-нд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей Мэдээлэл, гомдол гаргах үйл явцын асуудлаарх тус конвенцийн гурав дахь протоколыг баталсан. Уг протоколын дагуу, Хүүхдийн эрхийн тухай конвенц болон конвенцийн нэг, хоёрдугаар протоколд тусгагдсан тодорхой эрхийн зөрчлийн дагуу хүүхдүүд тус хороонд гомдол гаргаж болно. Гурав дахь протоколд 2012 оноос гарын үсэг зурж эхлэх бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын 10 Гишүүн улс соёрхон баталсаны дараа хүчин төгөлдөр болно.

Гишүүн бүх улс уг конвенцид тусгагдсан эрхүүд хэрхэн хэрэгжиж байгаа талаар тус хороонд илтгэл тогтмол хүргүүлэх үүрэгтэй. Конвенцид нэгдэж орсноос хойш 2 жилийн дотор гишүүн улс эхний тайлангаа хүргүүлж, түүнээс хойш 5 жил тутамд хороонд илтгэлээ тогтмол

хүргүүлэх үүрэгтэй. Хороо нь илтгэл бүрийг хянан үзэж, асуудлуудыг гарган тавьж, “дүгнэлт зөвлөмж” нэртэйгээр гишүүн улсад зөвлөмж хүргүүлдэг.

Конвенцийн нэмэлт протоколд нэгдэн орсон гишүүн улсууд хороонд нэмэлт илтгэл хүргүүлэх үүрэгтэй бөгөөд хороо нь илтгэлийг мөн авч хэлэлцдэг.

Хороо нь удахгүй хүүхдүүдээс гомдол хүлээн авах эрхтэй болно. Түүнчлэн, хувь хүний гомдол хүлээн авдаг бусад хороодоос хүүхдийн эрхийн зөрчлийг нэн тэргүүнд гаргаж тавьж байх юм.

Хороо нь жилд 3 удаа Женев хотод хуралдах ба заалтад тусгагдсан хүний эрхийн агуулгын тайлбар буюу сэдэвчилсэн асуудлаар ерөнхий зөвлөмж хэвлэн нийтэлж, өдөр тутам ерөнхий хэлэлцүүлэг зохион байгуулдаг.

ХҮЧЭЭР СУРАГГҮЙ АЛГА БОЛОГСДЫН АСУУДЛААРХ ХОРОО

COMMITTEE ON ENFORCED DISAPPEARANCES

Хүчээр сураггүй алга бологсдын асуудлаарх хороо нь Хүчээр сураггүй алга болохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенцид нэгдэж орсон гишүүн улсууд конвенцийг хэрхэн хэрэгжүүлж буйд хяналт тавих бие даасан шинжээч мэргэжилтнүүдээс бүрддэг. Гишүүн бүх улс уг конвенцид тусгагдсан эрхүүд хэрхэн хэрэгжиж байгаа талаар хороонд илтгэл тогтмол хүргүүлэх үүрэгтэй. Конвенцид нэгдэж орсноос хойш 2 жилийн дотор гишүүн улс эхний тайлангаа хүргүүлэх үүрэгтэй. Хороо нь илтгэл бүрийг хянан үзэж, анхаарч авч үзвэл зохистой гэсэн асуудлын дагуу санал, зөвлөмж гаргаж, тухайн гишүүн улсад хүргүүлдэг. Хороо нь жилд 2 удаа Женев хотод хуралддаг.

**ЦАГААЧ АЖИЛЧДЫН ЭРХИЙГ
ХАРИУЦСАН ХОРОО
COMMITTEE ON MIGRANT WORKERS**

Цагаач ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах хороо нь Цагаач ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенцид нэгдэж орсон гишүүн улсууд тухайн конвенцийг хэрхэн хэрэгжүүлж буйд хяналт тавих бие даасан шинжээч мэргэжилтнүүдээс бүрдэнэ. Тус хороо нь 2004 оны 3 дугаар сард анхны хурлаа зохион байгуулсан.

Гишүүн бүх улс уг конвенцид тусгагдсан эрхүүд хэрхэн хэрэгжиж байгаа талаар уг хороонд илтгэл тогтмол хүргүүлэх үүрэгтэй. Конвенцид нэгдэж орсноос хойш 1 жилийн дотор гишүүн улс эхний тайлангаа хүргүүлж, түүнээс хойш 5 жил тутамд хороонд илтгэлээ тогтмол хүргүүлэх үүрэгтэй. Хороо нь илтгэл бүрийг хянан үзэж, асуудлуудыг гарган тавьж, “дүгнэлт зөвлөмж” нэртэйгээр гишүүн улсад зөвлөмж хүргүүлдэг.

Тус хороо нь тодорхой нөхцөл байдлын дагуу уг конвенцид тусгагдсан эрхийн зөрчлийн талаарх хувь хүмүүсээс гомдол хүлээн авах боломжтой болно. Конвенцийн 77 дугаар зүйлийн дагуу хэрэв энэхүү үйл ажиллагааг 10 гишүүн улс хүлээн зөвшөөрвөл, хороо нь хувь хүмүүсээс гомдол хүлээн авах боломжтой болно. Одоогийн байдлаар энэхүү үйл ажиллагааг 2 гишүүн улс хүлээн зөвшөөрөөд байна. Хороо нь жилд 2 удаа Женев хотод хурал зохион байгуулдаг байна.

Тус хороо нь өдөр тутам ерөнхий хэлэлцүүлэг зохион байгуулж, өөрсдийн ажилтай холбоотой сэдэвчилсэн асуудал, мэдэгдэл болон конвенцийн заалтад тусгагдсан агуулга, өөрөөр хэлбэл ерөнхий зөвлөмжийн тайлбарыг хэвлэн нийтэлдэг.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ СОЁЛЫН ЭРХИЙН ХОРОО
COMMITTEE ON ECONOMIC, SOCIAL
AND CULTURAL RIGHTS

Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн хороо (ЭЗНСЭХ) нь Эдийн Засаг, Нийгэм Соёлын Эрхийн тухай Олон Улсын Пактад нэгдэж орсон гишүүн улсууд уг пактыг хэрхэн хэрэгжүүлж буйд хяналт тавих бие даасан шинжээчдээс бүрдсэн байгууллага юм. Тус хороо нь пактын IV хэсэг дэх Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгэм соёлын зөвлөлд ногдсон хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор ЭЗНСЗ-ийн тогтоол 1985/17-гийн дагуу 1985 оны 5 дугаар сарын 28-нд байгуулагдсан.

Гишүүн бүх улс тухайн пактад тусгагдсан эрхүүд хэрхэн хэрэгжиж байгаа талаар тус хороонд илтгэл тогтмол хүргүүлэх үүрэгтэй. Пактад нэгдэж орсноос хойш 2 жилийн дотор гишүүн улс эхний тайлангаа хүргүүлж, түүнээс хойш 5 жил тутамд хороонд илтгэлээ тогтмол хүргүүлэх үүрэгтэй. Хороо нь илтгэл бүрийг хянан үзэж, асуудлуудыг гарган тавьж, “дүгнэлт зөвлөмж” нэртэйгээр гишүүн улсад зөвлөмж хүргүүлдэг.

Хувь хүний гомдолтой холбогдуулан, 2008 оны 12 дугаар сарын 10-нд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей нь Эдийн засаг, Нийгэм Соёлын Эрхийн тухай Олон Улсын Пактын Нэмэлт Протоколыг баталжээ. Уг протоколын дагуу хороо нь хувь хүний гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх эрхтэй болсон. Тус хорооноос гадна, бусад хороод уг гэрээнд тусгагдсан эдийн засаг, нийгэм, соёлын эрхтэй холбоотой хувь хүний гомдлыг хүлээн авч болно.

Хороо нь Женев хотноо жилд 2 удаа хуралдана. Мөн хороо нь тухайн пактын зүйл заалтын тайлбар буюу

ерөнхий зөвлөмжийг хэвлэн нийтэлдэг.

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

AMNESTY INTERNATIONAL

Дэлхий даяар 3 сая гаруй гишүүд, дэмжигчдийг эгнээндээ нэгтгэсэн төрийн бус байгууллага юм. Тус байгууллагыг 1961 онд Английн Лондон хотноо хуульч Петр Бененсон үндэслэн байгуулсан бөгөөд хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсооход чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах, судалгаа хийх зорилгоор үйл ажиллагаа явуулдаг. Тус байгууллагын бүтцэд хамаарах “Эмнести Интернэшнл Монгол” төрийн бус байгууллага 1994 оноос эхлэн Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж байна.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ ҮЗЛИЙГ УСТГАХ ХОРОО (ЭЯГҮУХ)

THE COMMITTEE ON THE ELIMINATION OF DISCRIMINATION AGAINST WOMEN

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах үзлийг устгах хороо (ЭЯГҮУХ) нь Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах конвенцийн хэрэгжилтэд хяналт тавих бие даасан шинжээчдээс бүрдэх байгууллага юм.

Тус хороо нь эмэгтэйчүүдийн эрхийн асуудал хариуцсан дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн 23 шинжээч мэргэжилтнээс бүрдэнэ. Энэ конвенцид нэгдэж орсон гишүүн улс нь конвенцид тусгасан эрхүүд хэрхэн хэрэгжиж байгаа талаар хороонд илтгэл тогтмол хүргүүлэх үүрэгтэй. Хороо нь хурлынхаа үеэр, гишүүн улс бүрийн илтгэлийг хянан үзэж, асуудлыг гарган тавьж, тухайн гишүүн улсад зөвлөмж хүргүүлдэг.

Конвенцийн нэмэлт протоколын дагуу, хороо нь:

(1) Уг конвенциар хамгаалагдсан эрх нь зөрчигдсөн талаар хувь болон бүлэг хүмүүсээс гомдол хүлээн авах эрхтэй бөгөөд (2) эмэгтэйчүүдийн эрхийн ноцтой зөрчлийн болон системийн зөрчлийн нөхцөл байдалд нээлттэй хянан шалгалтыг явуулж болно. Энэхүү үйл ажиллагаа нь сайн дурынх бөгөөд гагцхүү тухайн гишүүн улс зөвшөөрсөн тохиолдолд уг нээлттэй хянан шалгалтыг явуулж болно. Хороо нь мөн ерөнхий санал, зөвлөмжийг гишүүн улсад хүргүүлдэг.

ЭРҮҮ ШҮҮЛТИЙН ЭСРЭГ ХОРОО **THE COMMITTEE AGAINST TORTURE**

Эрүү шүүлтийн эсрэг хороо (ЭШЭХ) нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцид нэгдэж орсон гишүүн улсууд уг конвенцийг хэрхэн хэрэгжүүлж буйд хяналт тавих бие даасан 10 шинжээч мэргэжилтнээс бүрдэнэ.

Гишүүн бүх улс уг пактад тусгагдсан эрхүүд хэрхэн хэрэгжиж байгаа талаар тус хороонд илтгэл тогтмол хүргүүлэх үүрэгтэй. Пактад нэгдэж орсноос хойш 1 жилийн дотор гишүүн улс эхний тайлангаа хүргүүлж, түүнээс хойш 4 жил тутамд хороонд илтгэлээ тогтмол хүргүүлэх үүрэгтэй. Хороо нь илтгэл бүрийг хянан үзэж, асуудлуудыг гарган тавьж, “дүгнэлт зөвлөмж” нэртэйгээр гишүүн улсад зөвлөмж хүргүүлдэг.

Илтгэл хүргүүлэх үйл явцаас гадна, конвенцийн дагуу гурван өөр механизмыг байгуулжээ. Уг механизмын хүрээнд хороо нь тодорхой нөхцөл байдлын дагуу уг конвенцид тусгагдсан эрх нь зөрчигдсөн гэж үзсэн хувь хүний гомдлыг хүлээн авч болох бөгөөд нээлттэй хянан шалгалт явуулж, улс хоорондын гомдлыг авч үзнэ.

Конвенцийн нэмэлт протокол нь 2006 оны 6 дугаар сард хүчин төгөлдөр болсон бөгөөд Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх дэд хороог байгуулсан. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь гишүүн улсууд дахь цагдан хорих газруудад очин хяналт шалгалт хийх эрхтэй. Нэмэлт протоколын дагуу, гишүүн улс нь дотооддоо эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх, мөн цагдан хорих газруудад шалгалт явуулах эрх бүхий бие даасан урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг байгуулах ёстой.

Эрүү шүүлтийн эсрэг хороо нь жилд 2 удаа Женев хотод хуралдах ба Хороо нь конвенцид тусгагдсан заалтын агуулгад буюу сэдэвчилсэн асуудлаар ерөнхий зөвлөмжийн тайлбарыг хэвлэн нийтэлдэг.

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДЭД ХОРОО

THE SUBCOMMITTEE ON PREVENTION OF TORTURE

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн тогтолцоон дахь цоо шинэ байгууллага юм. Хорооны үйл ажиллагаа 2007 оны 2 дугаар сард эхэлсэн.

Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн Нэмэлт Протоколын заалтын дагуу Хороог байгуулсан. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгээр Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн Нэмэлт Протоколыг 2002 оны 12 дугаар сард баталсан бөгөөд 2006 оны 6 дугаар сард хүчин төгөлдөр болсон.

Хороо нь дэлхийн янз бүрийн бүсээс, янз бүрийн мэргэжилтэй 25 бие даасан, шинжээч мэргэжилтнээс бүрдэнэ. Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн Нэмэлт

Протоколын буюу Хорооны гишүүдийг 4 жилийн хугацаатай, дахин нэг удаа сонгогдох эрхтэйгээр гишүүн улсууд томилдог.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь гишүүн улсуудын цагдан хорих бүх газруудад хаалтгүйгээр нэвтэрч, холбогдох бүх мэдээллэлтэй танилцах бүрэн эрхтэй билээ. Мөн тус хороо нь гишүүн улсууд болон Урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулахад тусламж дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх чиг үүрэгтэйгээр ажилладаг. Түүнчлэн, Хороо нь эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үүднээс Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох байгууллага болон механизм, олон улсын, бүсийн болон үндэсний байгууллагуудтай хамтран ажилладаг. Хороо нь өөрсдийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн илтгэлийг жил бүр Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд танилцуулдаг бөгөөд Женев хотод байрлах Нэгдсэн Үндэстний Байгууллагын байранд жилд 3 удаа хуралдана.

ЭШУСДХ нь цагдаагийн байгууллага, шорон (цэргийн болон иргэний), цагдан хорих газрууд (урьдчилан цагдан хорих газар, цагаачдын байр, насанд хүрээгүйчүүдийн цагдан хорих төв гэх мэт), сэтгэцийн эмнэлэг, нийгмийн халамжийн байгууллага болон эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүсийн байрлах бусад газруудад хяналт шалгалт хийдэг.

Хороо нь эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүстэй, ямар нэгэн гэрч, харгалзагчгүйгээр хувийн ярилцлага хийх эрхтэй байдаг.

- VI -

ХҮНИЙ ЭРХИЙН ЗАРИМ НЭР ТОМЬЁО
HUMAN RIGHTS GLOSSARY

АЖИГЛАЛТ, САНАЛ

OBSERVATIONS AND SUGGESTIONS

Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний байгууллагууд чуулган бүрийнхээ эцэст дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулсан ажиглалт гаргадаг. Үүнд:

- тухайн гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой эерэг хүчин зүйлсийн талаарх товч хэсэг; - тухайн гэрээний хэрэгжилтэд саад болж байгаа хүчин зүйлс; - анхаарал хандуулах асуудлууд; - зөвлөмжүүд.

Ажиглалт нь тухайн улсын илтгэлийг хамтын байдлаар үнэлж, асуудал бүхий хүний эрхийн хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой зөвлөмжийг гаргадаг онцлогтой. Тоо хэмжээ болон чанарын хувьд эцсийн ажиглалт нь гэрээний байгууллагаас хамааран харилцан адилгүй байдаг. Ажиглалтын чанарт нөлөөлдөг хүчин зүйлст тухайн оролцогч улс, төрийн бус байгууллагууд болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын агентлагууд зэрэг бусад этгээдээс хүлээн авсан дэлгэрэнгүй мэдээллийн түвшин, хамрах хүрээнээс гадна тухайн гэрээний оролцогч улсын эрх хэмжээ хүртэл багтана.

Үүний зэрэгцээ хүний эрхийн салбарт мэргэшсэн шинжээчдээс тухайн асуудлыг хэрхэн шийдэх, ямар зүйл хийвэл зохилтой талаар санаагаа хуваалцах, төлөвлөгөө гаргах, эсвэл боломж байгаа талаар зөвлөх,

өөрийн байр сууриа илэрхийлэн санал гаргадаг.

АРЬСНЫ ӨНГӨ

RACE

Хүмүүсийн арьсны өнгө болон бие махбодийн бусад онцлог шинжээр хувааж болох бүлэглэсэн ангилалд ашиглах нэр томъёо юм. Заримдаа албан бус байдлаар ямар нэгэн ижил бүлэг хүмүүсийг илэрхийлэхэд хэрэглэдэг. Гол төлөв нийт хүн амаас тодорхой бүлэг этгээдийг уламжилсан эсвэл төрөлхөөс холбоотой байгалийн болон газар зүйн гарвал, яс үндэс, гадаад төрх, угсаатны шинж, нийгмийн статусаар цагаан, шар, өнгөт гэх мэтээр ангилна.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ

SECURITY

Ямарваа нэгэн аюул занал эсвэл гэмт хэргээс хувь хүн, бүлэг этгээд, улс орныг ангид байлгах нөхцөлийг ойлгоно.

Хувь хүний аюулгүй байдал: 1994 оны Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний хөгжлийн илтгэлд хүний аюулгүй байдал гэх ойлголтыг тусгасан ба энэхүү ойлголтын хүрээнд дор дурдсан 7 зүйлд учирч буй хор хөнөөлийг багасгах талаар эрчимтэй ажиллахыг уриалсан юм. Үүнд:

1. Эдийн засгийн аюулгүй байдал
2. Хүнсний аюулгүй байдал
3. Эрүүл мэндийн аюулгүй байдал
4. Хүрээлэн буй орчны аюулгүй байдал
5. Хувь хүний аюулгүй байдал
6. Нийтийн аюулгүй байдал
7. Улс төрийн аюулгүй байдал зэрэг болно.

Хувь хүний аюулгүй байдал аливаа хүнийг бусдын

зүгээс ирэх бие махбодын халдлага, хүчирхийллээс ангид байлгах, түүнээс хамгаалах, ялангуяа гэмт хэргийн хохирогч болох явдлаас сэргийлэх явдлаар хангагддаг гэж үздэг.

Улсын Их Хурлын 2010 оны 7-р сарын 15-ны өдрийн 48-р тогтоолоор шинэчлэн батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3 дугаар зүйлийн 3.4-т “Хүний аюулгүй байдал”-ыг үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг мөн гэж үзээд “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн.” гэж тодорхойлжээ.

Үндэсний аюулгүй байдал: Тодорхой эрхийг хязгаарлах арга хэмжээг тухайн үндэстэн оршин тогтнох, эсвэл газар нутгийн бүрэн бүтэн байдал, хүч хэрэглэхийн эсрэг улс төрийн хараат бус байдалд халдсан, бусад этгээд хүч хэрэглэхээр заналхийлж байгаа үед хамгаалсан бол үндэсний аюулгүй байдлын үүднээс зөвтгөж болно. Үндэсний аюулгүй байдлыг тодорхой бус эсвэл дур зоргын шинжтэй хязгаарлалт тогтоохын тулд үндэслэл болгон ашиглаж болохгүй. Хүний эрхийн зөрчил давтагдан гарах нь үндэсний аюулгүй байдлыг дордуулж, олон улсын энх тайван, аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй. Хүний эрхийн зөрчилд хариуцлага хүлээх улс нь үндэсний аюулгүй байдлыг тухайн зөрчилд үзүүлэх эсэргүүцлийг далдлах, эсвэл хүн амын эсрэг залхаан цээрлүүлэх үйлдэлд чиглэсэн арга хэмжээг зөвтгөхөд ашиглаж болохгүй.

Нийтийн аюулгүй байдал: Нийтийн аюулгүй байдал гэдэгт хүмүүсийн аюулгүй байдал эсвэл тэдний амь

нас, бие махбодийн бүрэн бүтэн байдал, тэдний өмчид ноцтой хохирол учрах аюулаас хамгаалахыг хэлнэ. Нийтийн аюулгүй байдлыг хамгаалах хэрэгцээ нь хуулиар тогтоосон хязгаарлалтыг зөвтгөж болно.

БАРИВЧЛАХ

ARREST

Төрийн үйл ажиллагаанаас илрэх албадлагын шинжтэй, хүний эрхэд халдаж, хүний эрх чөлөөг хязгаарлан хүнийг нийгмээс тусгаарлах үйлдэл. Цагдаа зэрэг тодорхой төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа эрх бүхий албан тушаалтан мөрдөн байцаах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор баривчлах ба хуульд заасан үндэслэлийг удирдлага болгоно. Дур мэдэн баривчлах, хорих үйлдэл нь хүний эрхийн ноцтой зөрчилд хүргэх учир олон улсын гэрээ болон үндэсний хууль тогтоомжоор шууд хориглодог.

БЭЛГИЙН ДАРАМТ

SEXUAL HARASSMENT

Бэлгийн дарамт бол хүний эрхэд халдаж буй халдлага бөгөөд ялангуяа эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж байгаа хүчирхийллийн нэг хэлбэр гэж үздэг. Бэлгийн дарамт гэж бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

Нас, гэр бүлийн байдал, биеийн галбир, гадаад төрх, мэргэжлийн байр суурь, ур чадвараас үл хамааран

эрэгтэй, эмэгтэй хэн ч бэлгийн хүчирхийлэл үйлдэгч, хохирогч болж болох ч бодит байдал дээр хүчирхийлэл үйлдэгчдийн 80 гаруй хувь нь эрчүүд байдгийг судалгаагаар тогтоосон байдаг. Энэ нь эмэгтэйчүүд эрчүүдэд захирагдах байдлыг бий болгож, өөгшүүлж буй хэлбэр бөгөөд ялгаварлан гадуурхлын нэг шинж юм.

Бэлгийн дарамт нь үг яриа буюу дохио зангаа, үйл хөдлөл, хүч хэрэглэн хурьцал үйлдэх, биеийн эмзэг хэсэгт хүрэх, оролдох, шүргэх зэрэг биеэр үйлдэх хэлбэрээр илэрч болдог.

Бэлгийн дарамт хаана ч, ямар ч нөхцөлд гарч болох бөгөөд эдгээрийн нэг нь ажлын байран дахь бэлгийн дарамт юм. Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх тухай 111 дүгээр конвенцид "...Ажлын байран дахь бэлгийн дарамт нь хувь хүний халдашгүй дархан байдал, ажилтны аж байдалд аюул занал учруулж, ажлын байран дахь тэгш байдлыг үгүй болгож, хөдөлмөрийн харилцааны үндэс суурийг сулруулж, үйлдвэрлэлийн үр ашгийг бууруулдаг тул ноцтой үр дагавар, уршгийг нь харгалзан улс орнууд хариуцлага ногдуулах эрх зүйн актыг иргэний болон эрүүгийн хуулиараа батлан гаргах боллоо" гэж тэмдэглэсэн байдаг.

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ DOMESTIC VIOLENCE

Гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь нөгөөгөө хүч, эрх мэдлээр давамгайлж бие болон сэтгэл санаа, бэлгийн харилцаа, эдийн засгийн хувьд хохирол учруулах үйлдэл, эс үйлдлээр илэрдэг. Энэ нь гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь

буюу гэрлэсэн, урьд нь гэр бүлийн харилцаатай байсан, эсхүл хэзээ нэгэн цагт хамт амьдарч байсан бусад ойр дотны хүмүүсийн зүгээс бусдыгаа хүч, эрх мэдлээр далайлгаж, эрхшээлдээ оруулах зорилгоор хяналтаа тогтоож, өөрийн хамааралд оруулж буй тэгш бус харилцаа юм.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д “гэр бүлийн хүчирхийлэл гэж гэр бүлийн хүрээнд энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан аль нэг этгээд нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг.

Гэр бүл дэх хүчирхийлэл нь нэг удаагийн санаандгүй үйлдэл бус харин дахин давтагдах, даамжирах шинж чанартай, далд үйлдэл болохынхоо хувьд нийгмийн бусад хэлбэрийн хүчирхийллээс ялгагддаг.

НҮБ-ын Хүний Эрхийн Хорооноос хүлээн зөвшөөрснөөр дээрх элементүүд нь гэр бүлийн хүчирхийлэлд илэрч байдаг. Тухайлбал:

Нэгдүгээрт, гэр бүлийн хүчирхийлэл нь биеийн болон сэтгэл санааны асар их дарамтыг учруулж, бие хүнийг хохироож байдаг.

Хоёрдугаарт, төлөвлөгдсөн ухамсарт үйлдлээр илэрдэг. Ойр дотны хүмүүсээ хүчирхийлж байгаа энэ зан үйлээ бусдад гаргадаггүй нь хүчирхийлэл үйлдэгч өөртөө хяналт тавих чадвартайг харуулж байна.

Гуравдугаарт, тодорхой зорилгод хүрэх үүднээс хүчирхийлэл үйлдэгч айлган сүрдүүлэх, шийтгэх, хохирогчийг өөрөөсөө хамааралтай гэдэгт итгүүлэн үнэмшүүлэх тактик хэрэглэдэг.

Гэр бүлийн хүчирхийллийг хэн нэгэн хүний ганц нэгэн удаагийн, санамсаргүй, тохиолдлын зан үйл биш

бөгөөд тодорхой зорилгод хүрэх үүднээс төлөвлөгдсөн ухамсарт үйлдэл төдийгүй бусдыг зовоон тарчилгах нэг хэлбэр болдог байна.

ГЭРЭЭ

TREATY

Гэрээ нь тодорхой дүрэмд захирагдах тухай улс орон хоорондын тохиролцоо юм. Ерөнхий утгаараа гэрээ нь хоёр болон түүнээс дээш улс орны хоорондын хэлэлцэн тохирч бичгээр үйлдсэн тохиролцоо бөгөөд түүнийг эрх олгогдсон этгээд албан ёсоор үзэглэж, төрийн хууль тогтоох байгууллага нь соёрхон баталсан байдаг. Олон улсын гэрээ нь пакт, дүрэм, протокол, конвенц, зөвшилцөл, тохиролцоо, байгууллагын дүрэм, статут зэрэг олон төрлийн хэлбэртэй байна.

ДОРОМЖЛОЛ

HUMILIATION

Доромжлол гэдэг үгийг монгол хэлний тайлбар тольд доромжлох үйлийн нэр хэмээн тайлбарласан байдаг. Доромжлол гэдэг нь хэн нэгэн хүнийг нэр төр, үзэл бодол зэргээр гутааж, дорд үзэхийг хэлнэ.

Доромжлох нь бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд хууль бусаар халдах, түүнийг гутаах явдал байдаг. Мөн энэхүү үйлдэл нь үзэл бодол, гомдол, санал, шаардлагаа чөлөөтэй илэрхийлэх нь хүний оюун санааны эрх чөлөө бөгөөд үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхтэй холбоотой гардаг эрх зүйн нэг зөрчил юм.

Доромжлох гэдэг нь хууль зүйн хувьд нийтээр тогтсон ёс суртахуун, зан үйлийн хэм хэмжээг үл хүндэтгэн, хүнийг доог тохуу болгох зорилгоор сөргөөр буюу зүй бус, зохисгүй байдлаар нэрлэж, дуудаж, үнэлж,

бичих, хүний зан үйл, зан төлөвийн үнэн бодит байдал, хүний алдар хүндэтгэлийг гуйвуулан үгүйсгэж буй явдал юм.

Олон улсын хэмжээнд болон Монгол Улсын хууль тогтоомжоор энэхүү үйлдлийг хориглосон байдаг.

Хүний нэр төр, алдар хүндийг доромжлох хэлбэр: үг хэл буюу амаар (олон нийтийн дунд утсаар чанга ярьж доромжлох зэрэг); бичгээр (нийтэд зориулсан зарлал гэх мэт); үйлдлээр гэсэн хэлбэрээр доромжлох нь бий. Доромжлол нь хохирогч өөртөө гутрах сэтгэл төрүүлдэг байна. Мөн зарим тохиолдолд хүмүүс хохирогчоос зайлсхийх, уулзахгүй байх, дайжих зэрэг үр дагавар бий болгож болно. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлгийн “Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг” гэсэн бүлэгт 110, 111 зүйл ангиудад доромжлох гэмт хэргийн талаар хуульчилсан байдаг.

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

GENERAL COMMENTS

Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлэх талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний байгууллагууд болох Хүний эрхийн Хороо, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо зэрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн гэрээний байгууллага тус бүр Ерөнхий Зөвлөмж гэдэг баримт бичиг тогтмол хэвлэн гаргадаг. Уг Ерөнхий Зөвлөмжид холбогдох хороонд авч үзэх хүний эрхийн гэрээнд тусгасан тодорхой нөхцөл байдлын талаарх тайлбар хийсэн чиглэл, удирдамжийг гишүүн улсад зориулан гаргадаг.

Ерөнхий Зөвлөмжөөр тухайн Пактад тусгасан эрхийн агуулгыг илүү дэлгэрэнгүй тайлбарлаж, эдгээр

эрхүүдийг зөрчиж болохуйц зөрчлүүдийг тоймлон гаргаж, гэрээний дагуу хүлээсэн үүргээ гишүүн улсууд хэрхэн биелүүлэх тухай зөвлөгөө өгдөг. Ерөнхий Зөвлөмж нь гагцхүү тайлбар өгдгөөс бус заавал мөрдөх хуульчилсан хэм хэмжээ биш юм.

Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хорооноос Хүүхдийн эрхийн тухай конвенцтэй холбогдуулан дараах 12 Ерөнхий зөвлөмжийг боловсруулсан байна. Үүнд:

1. Боловсролын зорилгын тухай (2001)
2. Хүүхдийн эрхийг хангах, хамгаалахад хүний эрхийн үндэсний, хараат бус байгууллагуудын үүрэг (2002)
3. Хүүхдийн эрх ба ХДХВ/ДОХ өвчин (2003)
4. Хүүхдийн эрхийн тухай конвенц дахь өсвөр үеийнхний эрүүл мэнд, хөгжил (2003)
5. Хүүхдийн эрхийн тухай конвенцийг хэрэгжүүлэх ерөнхий арга хэмжээнүүд (2003)
6. Асран хамгаалагчаасаа тусгаарлагдан эх орноосоо гадна амьдарч буй хүүхэдтэй харьцах тухай (2005)
7. Бага насанд нь хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх (2006)
8. Бие махбодь, сэтгэл санааны болон хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс хүүхдийг хамгаалах (2006)
9. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх (2006)
10. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн эрх (2007)
11. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хүрээн дэх уугуул хүүхдүүд, тэдгээрийн эрх (2009)
12. Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх (2009)

Ерөнхий зөвлөмжийг боловсруулах үйл явц нь ойролцоогоор 18 сарын хугацаанд үргэлжилдэг. Хорооны зүгээс хүний эрхийн олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу тайлагнаж буй улс орнуудын

тайлан, мэдээллүүдэд үндэслэн гэрээний холбогдох заалтуудад дүн шинжилгээ хийх, тайлбарлах, мэргэшсэн байгууллага, шинжээчдээс санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулсны үндсэн дээр эдгээр зөвлөмжүүдийг гаргадаг. Мөн зөвлөмжийн төсөлд холбогдох агуулгаар хүний эрхийн олон улсын болон төрийн бус байгууллагууд, бие даасан шинжээчид зэрэг олон эх сурвалжаас санал зөвлөмж, байр суурийг нь авч нэгтгэдэг байна. Иймд Ерөнхий зөвлөмжүүд нь тухайн конвенцийг илүү сайн ойлгох, хэрэгжүүлэх, улмаар үндэсний хэмжээний бодлого, эрх зүйн нөлөөллийн ажил хийхэд бүх оролцогч талуудад дэмжлэг болно. Ялангуяа Ерөнхий зөвлөмжүүд дээр үндэслэн холбогдох асуудлаар эрх зүйн шинэтгэл хийх, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, мөн шүүхийн практикт ашиглах талаар Хороодоос зөвлөмж өгсөн байдаг.

ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ

GENDER EQUALITY

Жендэр эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурь, хүлээх хариуцлага, гүйцэтгэх үүргийн уламжлагдан тогтсон түүхэн явцад өөрчлөгддөг ойлголт, үзэл хандлага юм. Үүнийг “нийгмийн хүйс” гэж нэрлэх нь бий.

Жендэр гэдэг үгээр эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн байгалиас заяасан, үл өөрчлөгдөх хүйсийн буюу биологийн ялгааг илэрхийлсэн хүйс хэмээх ойлголтыг илэрхийлдэггүй. Энэ нь цаг хугацаанд хувьсан өөрчлөгдөхөөс гадна, соёл бүрт харилцан адилгүй байдаг эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийг илэрхийлсэн, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгмийн харилцааны тухай ойлголтыг илэрхийлдэг.

Жендэрийн тухай ойлголт нь анх эмэгтэйчүүдийн эрх, эрх чөлөөг хангах асуудалтай холбогдон ХХ зууны эхэн үеэс эхлэн бий болжээ. Эмэгтэй хүн бүр эрэгтэйчүүдийн нэгэн адил тэгш эрхтэй байхыг шаардаж эхэлсэн тэр цагаас хойш, ялангуяа 19 дүгээр зууны сүүлээр Европ, Америкт хүйсийн тэгш эрхийн тухай асуудал хүчтэй яригдах болжээ. Ялангуяа 1960-аад онд феминист хөдөлгөөн эрчимжиж улмаар ялгаварлан гадуурхах чиглэлийг хориглосон хуулийн хэм хэмжээнд хүйсийн тэгш эрхийг баталгаажуулжээ. Гэвч энэ ойлголт хөгжлийнхээ шатанд нийгмийн бүхий л бүтцийг жендэрээр хэмжих хандлагаар өргөжсөн байна.

Аливаа хүн жендэрийн ялгаварлан гадуурхалтад өртсөнөөс үүдэн тэгш бус байдал, ядуурал, ажилгүйдэл, хүчирхийлэл, боловсрол ба ухамсарын доройтол, хариуцлагагүй үйлдлүүд зэрэг тухайн улс орны хөгжилд саад бэрхшээлийг дагуулдаг.

Энэ эрхийн агуулга нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс бүх талаар адил байх гэдэгт бус, харин үнэт зүйлс, үнэлэмжийн хувьд тэгш байх тухай авч үздэг. Адил ажил хөдөлмөрт адил хэмжээний цалин хөлс авах, сонгуульд ижил тэгш оролцох эрх зэрэг нь хүйсийн тэгш эрхийн хүрээнд хамаарна.

ЗАН ЗАНШИЛ CUSTOM

Эрх зүйн зан заншил нь тодорхой нийгмийн бүтэц дотор объектив байдлаар хүлээн зөвшөөрөгдсөн тогтсон зан үйлийн хэм хэмжээ юм. Зан заншил нь “ямагт хийсээр ирсэн, хуулиар баталгаажсан” зүйлсээр илэрдэг онцлогтой. Заншлын хэм хэмжээ нь дагаж мөрддөг тодорхой хууль зүйн туршлага бөгөөд

холбогдох этгээдийн зүгээс хууль гэж тооцогддог онцлогтой байдаг.

Олон жилийн турш тасралтгүй мөрдөж ирсний дүнд улс орнуудын зүгээс ямар нэгэн асуудалд тодорхой хариуцлага хүлээж, заавал биелэх шинжтэй хэм хэмжээ (жишээлбэл, боолчлол, төрлөөр устгах явдлыг түгээмэл байдлаар хориглосон) болсон байдаг. Хэдийгээр олон улсын гэрээний эрх зүй нь олон улсын зан заншлын эрх зүйгээс ялгаатай боловч өмнө үеийн заншлын хэм хэмжээг олон улсын гэрээнүүдэд төрөлжүүлэн нэгтгэх замаар хариуцлага хүлээлгэх оролдлого хийсээр байна. Жишээлбэл, тухайн улсын биет төлөөлөгчид халдахгүй байх, аюулгүй байдлыг хангах зэрэг тогтсон жишгийг хамааруулж болно.

ЗОХИМЖИТ БАЙДАЛ

COMPETENCE

Төрийн зүгээс ямарваа нэгэн зүйлийг хийх эсвэл шүүхийн хувьд ямар нэгэн асуудлыг хэлэлцэж шүүх, шийдвэр гаргах хууль ёсны эрх мэдлийг илэрхийлсэн ойлголт. Мөн тухайн асуудлыг хамрах хүрээг тодорхойлох, харьяалах эсэхийг шүүхээс тогтоох эрх хэмжээг хамруулдаг.

ЗӨВЛӨМЖ

RECOMMENDATIONS

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн конвенцийн дагуу байгуулагдсан хороод нь конвенц болон түүний нэмэлт протоколуудын хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй бөгөөд засгийн газруудын тайланг хэлэлцэх, дүгнэлт зөвлөмж өгөх үйл явцаар дамжуулан хүний эрхийг ханган хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээний талаарх заавар удирдамжийг өгдөг.

- ХҮНИЙ ЭРХИЙН ТОВЧ ТАЙЛБАР -

Иймд тэдгээр хороодын зөвлөмжүүд нь тухайн хүний эрхийн гэрээ, конвенциор баталгаажсан эрхийг тайлбарлах албан ёсны тайлбар бөгөөд конвенцийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд хангах, зохих ёсны дагуу тайлагнах үүргээ биелүүлэхэд нь гишүүн орнуудад дэмжлэг үзүүлэх зорилготой албан баримт бичиг юм. Хороодын зөвлөмжүүд нь олон улсын хүний эрхийн эрх зүйн хөгжил, үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ихээхэн чухал хэрэглэгдэхүүн болдог гэж үздэг.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн хороодоос хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар сүүлийн жилүүдэд Монгол Улсад дараах зөвлөмжүүдийг өгсөн байна. Үүнд:

- Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн хэрэгжилтийн талаарх зөвлөмж, 2006 он

- Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн хэрэгжилтийн талаарх зөвлөмж, 2006 он

- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийн талаарх зөвлөмж, 2009 он

- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх зөвлөмж, 2010 он

- Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх зөвлөмж, 2011 он

- Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх зөвлөмж, 2010 он

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцийн хэрэгжилтийн талаарх зөвлөмж, 2011 он

ИЛТГЭЛ

REPORT

Олон улсын гэрээний заалтуудыг хэрхэн биелүүлж байгаа, түүнд тулгарах бэрхшээл, саадын талаарх илтгэлийг тухайн гэрээнд оролцогч талууд тогтоосон хугацаанд багтаж гаргах тухай олон улсын гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлэх журмыг хэлнэ.

КОММУНИТИ

COMMUNITY

Энэ нэр томъёогоор өөрийн гэсэн нийтлэг үнэт зүйлтэй хүн амын хувьд тосгоноос том нийгмийн нэгжийг илэрхийлж, зарим тохиолдолд “үндэстэн”, “олон улсын хамтын нийгэмлэг” гэсэн нэр томъёотой адилтгах нь бий. Мөн биологийн шинжид тулгуурлан, тодорхой орон зайг хуваан зэрэгцэн оршиж байгаа хоорондоо харилцагч хүмүүсийн бүлгийг нэрлэдэг.

Гэхдээ хүний коммунити нь сэдэл, итгэл үнэмшил, хэрэгцээ, эрсдэл зэрэг тухайн бүлгийнхээ гишүүдийг тодорхойлогч хүчин зүйлсээр биологийн организмуудаас ялгаатай. Тодруулбал коммунити буюу нийгмийн бүлэг нь шинжлэх ухааны талаас “нийтлэг орчинд оршин, нэг нэгэнтэйгээ харилцагч организмууд” гэж тодорхойлсон боловч хүний нийгмийн бүлэгт байдаг баялаг, ялгаатай, нарийн түвэгтэй шинжийг бүрэн илэрхийлээгүй байна. Эдгээр шинжийг харгалзан ангилахгүй бол бүрэн ойлгогдохгүй төдийгүй нийгмийн бүлэг нь хүнд амь чухал болохыг онцлох нь зүйтэй. Судлаач М.Скотт Пек “Ямар нэгэн эрсдэлгүйгээр эмзэг байдал гэж үгүй, эмзэг байдалгүй нийгмийн бүлэг ч байхгүй. Харин нийгмийн бүлэггүйгээр энх тайван, цаашилбал

амьдрал гэж үгүй” тодорхойлсон байна.

Коммунити буюу нийгмийн бүлгийг дараах байдлаар ангилах боломжтой:

- Газар зүйн шинжтэй нийгмийн бүлэг (байрлалаас хамааран хөрш, хот айл, суурин, тосгон, хотоос тэлж, бүс нутаг, үндэстэн, бүхэл гараг хүртэл хамарна)

- Соёлын шинжтэй нийгмийн бүлэг (угсаатан, ястан, шашны, олон соёлын шинжит, олон ургалч соёл иргэншлийн бүлэг гэх мэт)

- Нийгмийн бүлгийн байгууллагууд (бага хэмжээний, үндэсний, эсвэл олон улсын хүрээг хамарсан албан бус гэр бүлийн эсвэл ураг төрлийн хэлхээ холбооноос албан ёсны аж ахуйн нэгжийн сүлжээ, улс төрийн шийдвэр гаргах бүтэц, мэргэжлийн байгууллага хүртэл хамарна)

КОНВЕНЦ CONVENTION

Заавал дагаж мөрдөх шинжтэй, улс хоорондын олон талт гэрээ бөгөөд олон улсын эрх зүйгээр зохицуулагдах улс гүрнүүдийн хоорондын харилцааны асуудлыг зохицуулах зорилгоор байгуулдаг.

Конвенц гэдэг нэр томъёо нь гэрээ, пакт, хэлэлцээр зэрэг олон улсын эрх зүйн баримт бичигтэй адил төстэй утга илэрхийлнэ. Конвенц нь гол төлөв хоёроос дээш улс оролцсон олон талт баримт бичиг бөгөөд соёрхон баталсан улсуудын хувьд заавал дагаж мөрдөх хүний эрхийн хэм хэмжээг тогтоосон байдаг.

НИЙГМИЙН ЁС СУРТАХУУН PUBLIC MORAL

Нэг соёлоос нөгөө соёлын хооронд удаан хугацаанд нийтийн ёс суртахуун нь үнэт зүйл болтлоо өөрчлөгдөж

ирсэн тул хүний эрхийг хязгаарлах үндсийн нэг болгосон. Тухайн улсын хувьд тодорхой сонголтын хүрээг эдлэхдээ нийгэм дэх тодорхой бүлэг хүмүүсийн суурь үнэт зүйлсийг хүндэтгэх баталгааг ойлгоно. Үүн дээр тулгуурлан хүний эрхийн хязгаарлалтад зүй ёсоор харгалзаж үзэхийг шаарддаг. Үүнийг ямар нэгэн ялгаварлан гадуурхсан шинжгүйгээр нэг мөр ойлгохыг улсууд өөрсдөө хариуцдаг онцлогтой.

НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ PUBLIC ORDER (ORDRE PUBLIC)

Нийгмийн чиг үүрэгтэй уялдах аливаа үйл ажиллагааг гүйцэтгэх явдлыг баталгаажуулах дүрэм журмын нийлбэр буюу нийгмийг бий болгож байгаа суурь зарчмуудын цогц. Хүний эрхийг хүндэтгэх нь нийтийн дэг журмын бүрдэл хэсэг юм. Нийтийн дэг журам нь хүний эрхийн хязгаарлалттай холбоотой төдийгүй тодорхой хүний эрхийг хязгаарлах зорилготой холбож тайлбарлах нь бий. Нийтийн дэг журмыг сахиулах хариуцлага хүлээсэн төрийн байгууллагууд буюу агентлагууд нь парламент, шүүх, холбоо хамаарал бүхий бусад хараат бус этгээдээр дамжуулан, өөрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хяналт тавих субъект болдог.

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД PUBLIC HEALTH

Нийгмийн эрүүл мэнд нь хүн амын эсвэл хүн амын тодорхой бүлгийн эрүүл мэндэд ноцтой аюул заналхийлсэн эсвэл заналхийлэх магадлалтай тохиолдолд хариу эсрэг арга хэмжээ авахыг төрд зөвшөөрөхийн тулд тодорхой эрхийг хязгаарлах үндэслэл болдог. Эдгээр арга хэмжээ нь өвчин эсвэл гэмтлээс урьдчилан сэргийлэх, эсвэл өвчтэй, гэмтсэн

хүмүүст халамж үзүүлэхэд тусгайлан чиглэх ёстой. Энэ нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын олон улсын эрүүл мэндийн зохицуулалтыг мөн агуулна.

НЭГДЭН ОРОХ ACCEDE/ACCESSION

Аливаа улс урьдчилан гарын үсэг зуралгүйгээр гэрээний баримт бичгийг дагаж мөрдөхийг зөвшөөрөх ажиллагаа.

Нэгдэн орох үйл явц нь гэрээг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, нэгдэн орох баримт бичигтэй нэгэн адил бичгээр үйлдсэн олон улсын эрх зүйн баримт бичиг юм. Тухайн улс нэгдэн орсон баримт бичгийг гардуулсан буюу хадгалуулснаар гэрээний заалтыг дагаж мөрдөх үүрэг хүлээнэ.

НЭХЭМЖЛЭЛ PETITION

Төрийн байгууллага дахь эрх бүхий албан хаагчаас ямар нэгэн үйлдэл хийхийг шаардсан олон хүний гарын үсэг бүхий бичмэл шаардлага, мөн тодорхой нэгэн эрх зүйн маргааны талаарх асуудлыг хөндсөн шүүхэд гаргасан албан ёсны баримт бичгийг хэлнэ. Иргэд гол төлөв шүүхэд өөрийн зөрчигдсэн эрх, эрх чөлөөг сэргээх, учирсан хохирлоо барагдуулах, гэмт этгээдэд хариуцлага тооцох зорилгоор нэхэмжлэл гаргадаг.

ОЛОН УЛСЫН ЗӨӨЛӨН ХЭМ ХЭМЖЭЭ INTERNATIONAL SOFT LAW

Зөөлөн хэм хэмжээ гэдэгт хууль зүйн хувьд заавал биелэх шинжгүй, эсвэл уламжлалт хэлбэрийн хууль тогтоомжтой харьцуулбал биелэхдээ сул хэм хэмжээг ойлгох ба уг ойлголтыг ямагт “хатуу хэм хэмжээ”

гэсэн ойлголттой эсрэгцүүлэн авч үздэг. “Зөөлөн хэм хэмжээ” нь олон улсын эрх зүйтэй холбоотой ч зарим улс үндэснийхээ хууль тогтоомжийн зарим салбарт ашиглах явдал гарч байна. Заавал биелэгдэх шинжгүй зарим зөөлөн хэм хэмжээг дурдвал:

- НҮБ-ын Ерөнхий Ассамблейн ихэнх тогтоол, тунхаглал (Жишээлбэл, Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал)
- Олон улсын шинжтэй гэрээний хэсэг болсон мэдэгдэл, зарчим, ёс зүйн дүрэм, үйл ажиллагааны дүрэм гэх мэт
- Үйл ажиллагааны төлөвлөгөө
- Гэрээгээр хүлээгээгүй бусад үүрэг зэргийг дурдаж болно.

Хэдийгээр эрдэмтэн судлаачдын дунд харилцан адилгүй байр суурьтай ч зөөлөн хэм хэмжээг боловсруулах нь олон улсын эрх зүйн тогтолцооны өдөр тутам хийх зайлшгүй ажлын нэг бөгөөд олон улсын түвшинд амлалт өгөхдөө “дурамжхан” улс орнуудын зүгээс санаачлага өрнүүлэх боломж олгодог онцлогтой. Мөн биелэгдэх шинжгүй байсан зөөлөн хэм хэмжээ нь ирээдүйд хатуу хэмж хэмжээ болж хувирах бүрэн боломжтой. Тодруулбал тунхаглал, зөвлөмж нь олон улсын гэрээ боловсруулах эхний алхам болж, тухайн зөөлөн хэм хэмжээнд хэдийнэ дурдсан зарчмыг тусгах нэг арга зам бий. Өөр нэг боломж нь олон улсын гэрээний шинжгүй хэлцлээр дамжуулан тухайн улсын үйл ажиллагаанд шууд нөлөөлж, үр нөлөө үзүүлбэл заншлын хэм хэмжээ тогтооход хүргэж болно.

Зөөлөн хэм хэмжээ нь уян хатан, сонголт хийх, хэлэлцэн зөвлөлдөх, нөөц болон нөхцөл байдлаа эргэн харах боломж олгодог давуу талтай. Гэхдээ тухайн улс бодлого боловсруулахдаа шинэ, бүтээлч санааг туршиж, нөлөөг нь тодорхойлж байна гэдгээр

удаан хойрго байх, улс төрийн шийдэлд хүрэхгүй байх, цаг алдах, ач холбогдолгүй болгох сөрөг үзэгдэл гарч болно.

Үүний зэрэгцээ Олон улсын шүүхийн Дүрмийн 38 дугаар зүйлийн дагуу заавал биелэгдэх шинжтэй эрх зүйн эх сурвалжид олон улсын гэрээ, зан заншил, олон улсын эрх зүйн ерөнхий зарчмуудыг дурдсан. Мөн хоёр “туслах” эх сурвалжийг нэрлэсэн нь шүүхийн шийдвэр, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэлчийн бүтээл юм. Иймээс зөөлөн хэм хэмжээг хатуу хэм хэмжээ болон заавал биелэгдэх шинжтэй эх сурвалж болох боломжтой.

ОЛОН УЛСЫН МӨРДӨН ШАЛГАХ ЖУРАМ

PROCEDURES FOR FACT-FINDING MISSION

Хүний эрхийн зөрчлийг үндэсний, бүс нутгийн, олон улсын хэмжээнд хэрхэн ямар хор уршиг үзүүлж байгааг тодорхойлох, тухайн зөрчлийн эсрэг хариу арга хэмжээ авах, учирсан хохирлыг барагдуулах, хохирогчийн эрхийг сэргээхэд нөлөө үзүүлэхийн тулд удирдлага болгох эрх зүйн зохицуулалтын нарийвчилсан дүрэм журам юм. Олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс олон улсын хүний эрхийг хамгаалах механизмыг ашиглахын тулд тодорхой журмыг мөрддөгөөс жишээ дурдвал Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1235, 1503 дугаар журмыг нэрлэж болно.

ОЛОН УЛСЫН ХАТУУ ХЭМ ХЭМЖЭЭ

INTERNATIONAL HARD LAW

Хатуу хэм хэмжээ гэдэгт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа, заавал биелэгдэх шинжтэй эрх зүйн гэрээ хэлцэл, хууль тогтоомжийг ойлгоно. Хатуу эрх зүйг зөөлөн эрх зүйтэй эсрэгцүүлэн ойлгох төдийгүй

төр, олон улсын байгууллагад эрх олгохын зэрэгцээ хариуцлага ногдуулдаг. Уг нэр томъёог олон улсын эрх зүйд ямар нэгэн бие даасан удирдах байгууллагагүй үед ашиглах нь нийтлэг байдаг.

Хатуу хэм хэмжээ нь хууль тогтоомжийг биелүүлэх асуудлыг хамрах ба ямарваа нэгэн хууль, дүрэм, гэрээ хэлцэл, шийдвэр нь захирангуй, зааварласан шинжтэй байх ёстой гэж үздэг. Олон улсын эрх зүйд хатуу хэмжээ нь өөрөө хэрэгжих шинжтэй олон улсын гэрээ хэлцэл, зан заншлын хэм хэмжээнүүдийг агуулдаг. Эдгээр баримт бичиг улс орны зүгээс болон олон улсын бусад байгууллагаас хуулийн дагуу биелүүлэхийг зорьдог онцлогтой. Жишээлбэл, пакт, конвенц зэрэг олон улсын гэрээ, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн тогтоолууд, олон улсын заншлын хэм хэмжээ багтдаг.

Хатуу хэм хэмжээний давуу тал нь:

- Тохиролцоонд хүрэх үйл ажиллагааны зардлыг багасгах
- Улс төрийн стратегийг тодорхойлох
- Тодорхой бус байдал үүсэхээс зайлсхийх зэрэг болно.

ОНЦ БАЙДАЛ

CASE OF EMERGENCY

Төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн зарим чиг үүргийг түдгэлзүүлэх, иргэдийн өдөр тутмын хэвийн зан үйлээ өөрчлөх, төрийн холбогдох байгууллагууд урьдчилан бэлдсэн онцгой байдалд зориулсан бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухай төрийн зүгээс авч байгаа арга хэмжээ юм. Шаардлагатай тохиолдолд онц байдлын үеэр Үндсэн хуулиар баталгаажуулсан эрх, эрх чөлөөг ч хязгаарладаг. Гэхдээ төрийн зүгээс биелүүлэхээс татгалзаж болохгүй эрхүүдэд энэ нөхцөл хамаарахгүй.

ӨРШӨӨЛ

AMNESTY

Өршөөл, уучлал үзүүлэх нь олон зуун жилийн турш уламжилж ирсэн түүхэн үзэгдэл бөгөөд эрх зүйн харилцааны өвөрмөц хэлбэр гэж үздэг. Судлаачид өршөөл үзүүлэх асуудлыг төрийн энэрэл, төрийн үйл ажиллагааны болон эрүүгийн хуулийн энэрэнгүй ёсны зарчимтай холбон тайлбарладаг.

Өршөөл гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн иргэддээ төрийн энэрэл хайрыг үзүүлж гэмт хэрэг үйлдсэний төлөө төрөөс хүлээлгэж буй эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх, эдлээгүй үлдсэн ялыг хасах зэргээр гэмт хэрэг үйлдсэнтэй холбогдон үүсэж байгаа эрүүгийн эрх зүйн үр дагаврыг хүчингүй болгож, хөнгөрүүлж буй эрх зүй, зохион байгуулалтын тусгай үйл ажиллагаа юм.

Аливаа улс оронд өршөөл үзүүлэх нь хууль тогтоох байгууллагын бүрэн эрхийн асуудал байдаг. Манай улсын энэхүү эрхийг хууль санаачлагчид хэрэгжүүлдэг бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 14 дэх хэсэг, Эрүүгийн хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр өршөөлийн тухай хуулийг батлан гаргадаг.

ПАКТ

COVENANT

Хэлцэл, тохиролцоо гэсэн утгыг илэрхийлэх ба олон улсын гэрээ, конвенц, хэлэлцээр, харти зэрэг олон улсын эрх зүйн баримт бичигтэй адил утгатай. Заавал биелэгдэх шинжтэй, олон улсын эрх зүйн субъект болох улсуудын хоорондын харилцааг бүхэлд нь хамарсан асуудлыг зохицуулах зорилгоор байгуулсан олон улсын гэрээ. Гол төлөв хоёр болон түүнээс дээш

талуудыг хамарсан, хэм хэмжээ тогтоосон онцлогтой байхаас гадна нэгдэн орсон, соёрхон баталсан улсууд гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаарддаг. Пакт нь заавал дагаж мөрдөх олон улсын баримт бичигт тооцдог.

ПРОТОКОЛ

PROTOCOL

Энэ нэр томъёо нь хүчин төгөлдөр олон улсын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах эрх зүйн баримт бичгийг тодорхойлоход хэрэглэнэ. Протокол нь хүний материаллаг эрхүүдийг нэмж тусгах буюу хүчин төгөлдөр үйлчилж буй олон улсын эрх зүйн хэм хэмжээг өөрчлөх, аль эсвэл хүний эрхийг хэрэгжүүлэхэд хяналт тавих үүрэг бүхий хяналтын байгууллагыг байгуулах буюу илтгэх тогтолцоог бий болгох зэрэг хэрэгжилтийн механизмыг өөрчлөх үүрэгтэй байдаг. Протоколыг ихэвчлэн гэрээ байгуулсны дараа үйлддэг боловч нэгэн зэрэг байгуулж бас болно. Протокол нь өөрөө олон улсын гэрээ бөгөөд хүчин төгөлдөр болохоос өмнө бусад бүх олон улсын гэрээний нэгэн адил холбогдох бүх журмын дагуу батлуулах, соёрхон батлуулах, хадгалаулах ёстой.

САЛШГҮЙ ЭРХ

INALIENABLE RIGHTS

Салшгүй эрх гэдэг нь ямар нэгэн байдлаар бусдад шилжүүлэх, дамжуулах боломжгүй, салгахыг оролдсон тохиолдолд шинж чанараа алдах тэрхүү эрхүүд юм. Уг эрх хүний төрөлхөөс заяасан нэр төр, алдар хүнд дээр үндэслэгддэг тул салгаж авах боломжгүй юм. Салшгүй эрхийг шилжүүлэх, дамжуулахаар гэрээ, хэлцэл байгуулсан тохиолдолд энэ нь хүчин төгөлдөр

бус байна гэсэн үг.

СОЁРХОН БАТЛАХ RATIFY/RATIFICATION

Соёрхон батлах гэдэг нь гэрээг дагаж мөрдөхөөр хүлээн зөвшөөрснөө тухайн улс албан ёсоор илэрхийлэхийг хэлнэ. Гэрээнд урьдчилж гарын үсэг зурсан улс л тухайн гэрээг соёрхон баталж болно. Соёрхон батлах үйл явц хоёр хэсгээс бүрддэг. Үүнд:

- Үндэсний түвшинд Үндсэн хуулиар эрх олгогдсон этгээд түүнийг баталсан байх шаардлагатай бөгөөд энэ нь гол төлөв тухайн улсын тэргүүн, эсвэл хууль тогтоох байгууллага байдаг.

- Олон улсын түвшинд тухайн гэрээний холбогдох заалтын дагуу соёрхон батлах тухай баримт бичгийг гэрээний эх хадгалагч улс, эсвэл Нэгдсэн Үндэстний Байгууллагатай адил олон улсын байгууллагад албан ёсоор хүргүүлсэн байх шаардлагатай.

Гэрээг соёрхон батлахдаа тухайн гэрээний дийлэнх заалтыг дагаж мөрдөх боловч, тодорхой зарим заалтад тайлбар хийж дагаж мөрдөхөөс татгалзаж болдог. Гэхдээ уг тайлбар нь гэрээний зорилго, үзэл санааг үгүйсгэсэн байж болохгүй. Цаашилбал аливаа улс гэрээнд нэгдээгүй, эсвэл гэрээнд тайлбар хийж нэгдсэн хэдий ч олон улсын хэмжээнд заавал биелэгдэх шинжтэй хэм хэмжээг тодорхойлсон тухайн гэрээний заалтуудыг гарцаагүй дагаж мөрдөх үүрэгтэй.

ТӨРЛӨӨР УСТГАХ ГЭМТ ХЭРЭГ GENOCIDE

Тодорхой нэгэн бүлгийг эсвэл арьсны өнгө ижил хүмүүсийг санаатайгаар, олноор бүрэлгэн устгах үйлдэл. Үүнийг олон улсын эрүүгийн шүүхийн

харьяалах гэмт хэрэгт тооцсоны зэрэгцээ олон улсын эрх зүй болон олон улсын заншлын хэм хэмжээгээр хориглосон төдийгүй 1948 онд баталсан Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шийтгэх тухай конвенцид анх удаа тус үйлдлийг эрх зүйн үүднээс тодорхойлж өгсөн. Уг конвенцийн 2 дугаар зүйлд “үндэсний, угсаатны, арьсны өнгөний, эсвэл шашны бүлгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн устгах зорилготой дараахь аливаа үйлдлийг ойлгоно: (а) тухайн бүлгийн гишүүдийг алах; (б) тухайн бүлгийн гишүүдэд бие махбодийн болон сэтгэл зүйн ноцтой хор уршиг учруулах; (в) тухайн бүлгийн амьдралын нөхцөл байдлыг бүхэлдээ эсвэл хэсэгчилсэн байдлаар шууд бусаар дордуулах; (г) тухайн бүлгийн дотор төрөлтөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг тулгах; (д) тухайн бүлгийн хүүхдүүдийг өөр бүлэг үрүү хүчээр шилжүүлэх.” гэжээ.

ТУНХАГЛАЛ DECLARATION

Тунхаглал гэдэг нэр томъёог улс төрийн баримт бичиг болон гэрээний баримт бичгийн хувьд өөр өөрөөр тайлбарлана. Тухайлбал улс төрийн баримт бичгийн хувьд, Засгийн газар хоорондын байгууллагаас гаргасан аливаа асуудлын гол зарчмуудыг илэрхийлсэн баримт бичиг байх бөгөөд энэхүү зарчмыг заавал дагаж мөрдөх албагүй байдаг. Хэрэв улс орон эдгээр гол зарчмыг хуулийн заалт мэт ойлгон тогтмол хэрэглэдэг практик тогтсон бол тэдгээр нь тодорхой хугацааны дараа заавал дагаж мөрдөх олон улсын заншлын эрх зүйн хэм хэмжээ болно.

Тунхаглалыг эрх зүйн баримт бичиг болгох үүднээс гаргадаггүй. Түүнийг Засгийн газар хоорондын олон

улсын байгууллагаас боловсруулж, тогтоолоор баталдаг. Жишээ нь: Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал. Гэрээний баримт бичгийн хувьд гэрээг соёрхон батлахдаа гэрээний зарим заалтын үйлчлэх цаг хугацаа болон газар зүйн хүрээг хязгаарласан эсвэл маргааныг шүүн шийдвэрлэх байгууллагын эрх хэмжээг хязгаарласан зэрэг тухайн гэрээний заалтын үйлчлэх хүрээг тогтоож өгсөн баримт бичиг юм. Энэ нь ихэвчлэн тодорхой заалтын талаар хийсэн тайлбар байдаг.

ТҮР ЗОХИСТОЙ АРГА ХЭМЖЭЭ **TEMPORARY APPROPRIATE MEASURES**

Үүссэн нөхцөл байдлыг арилгах эсвэл хэвийн гэж тооцох хүртэл тухайн асуудалд тусгайлан чиглэсэн үйл ажиллагааг олон улсын хамтын нийгэмлэгээс болон олон улсын түвшинд эсвэл үндэсний хэмжээнд явуулахыг ойлгоно. Ялангуяа хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, зөрчигдсөн эрхийг сэргээх, холбогдох этгээдтэй хариуцлага тооцох, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор холбогдох арга хэмжээг нэн даруй авах шаардлагатай.

ТЭГШ ЭРХ **RIGHT TO EQUALITY**

Тэгш эрх гэдэг нь юуны өмнө хүн бүр хуулийн өмнө тэгш байх тухай үзэл санаатай холбогддог. Энэ бол ардчилсан эрх чөлөөний зарчмын салшгүй нэг хэсэг билээ. Тэгш эрхийн тухай ойлголт анх эртний грек, ромын сэтгэгчдийн үзэл санаанд илэрч байсан боловч нийгмийн зайлшгүй институт болсон үе нь 17, 18 зууны үеийн Америк болон Францын хувьсгалтай холбоотой юм.

Францын “Хүний ба иргэний эрхийн тунхаг”-ийн 1 дүгээр зүйлд: “Хүн бүр төрсөн цагаасаа эрх чөлөө

хийгээд эрхийн хувьд адил тэгш байна. Нийгмийн ялгаа нь зөвхөн нийтлэг ашиг сонирхолд тулгуурлана” хэмээн заасан нь хожим эрх зүйн зайлшгүй зарчим болон дэлхий даяар түгэн тархаж, орчин үеийн хүний эрхийн хэм хэмжээнүүдэд тусгалаа олжээ.

Хууль болоод шүүхийн өмнө эрх тэгш байх гэдэг нь үндсэндээ парламент аливаа тохиолдолд хүнийг ялгаварлан гадуурхсан хууль батлахгүй байх, шүүх хэрэг маргааныг шийдвэрлэхдээ маргагч талуудад адил тэгш боломж олгох явдал юм.

Тэгш эрхийн зарчим нь нэгдүгээрт, хуулиас гадуур ямар ч эрх мэдэлтэн, гэмт бүлэглэл байхыг хориглож, бүхий л этгээдийг хуулийн хүрээнд адил захируулахыг эрмэлздэг. Иргэн нь төрийн байгууллага, албан тушаалтантай адил боломжоор хангагдаж, шүүхийн өмнө адил эрх эдэлж, үүрэг хүлээх явдлаар илэрдэг. Хоёрдугаарт, ямар нөхцөл байдал нь тухайн этгээдүүдийг адил хандахыг шаардаж байна, тэр нөхцөлд адил хандаж, ямар нөхцөлд ялгаатай хандахыг шаардаж байна, тэр нөхцөлд ялгаатай хандахыг хуулийн өмнө эрх тэгш байх зарчим гэдэг. Гэхдээ зарчмын эхний агуулга нь тэгш эрхийн зарчмын үндсэн санаа бөгөөд хоёр дахь санаагаа хөтөлж, түүнийг захирах шинжтэй. Харин хоёр дахийг хэрэглэхийн тулд зайлшгүй үндэслэлтэй байх ёстой бөгөөд эс бөгөөс тэгш үр дүнгийн зарчим адил эрх чөлөөг үгүйсгэх аюултай байдаг.

УУЧЛАЛ

PARDON

Уучлал үзүүлэх нь эрх зүйн зохицуулалтын өвөрмөц харилцаа юм. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т “Монгол Улсын иргэн нь ...

уучлал хүсэх эрхтэй” хэмээн уг эрхийг баталгаажуулсан байдаг. Уучлал үзүүлэх үндэслэл, журмыг Эрүүгийн хуулиар бус бусад эрх зүйн актуудаар зохицуулдаг. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд уучлал үзүүлэх асуудал ордог бөгөөд уучлал үзүүлэх үндэслэл, журмыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 156 тоот зарлигаар батлагдсан “Ялтанд уучлал хүссэн өргөдлийг хянан шийдвэрлэх журам”-аар зохицуулж байна. Уучлал үзүүлэх асуудлыг ялтны өөрийнх нь аль эсвэл байгууллага, хүмүүсийн санал хүсэлтээр хэлэлцэн шийдвэрлэнэ. Ялтанд уучлал үзүүлэх эсэхийг шийдвэрлэхдээ үйлдсэн хэргийн нийгмийн аюулын хэмжээ, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн байдал зэрэг олон хүчин зүйлсийг харгалздаг байна.

ХАМГААЛАХ PROTECT

Хүний эрхийг хамгаалах гэдэгт төр аливаа хувь хүний эрх нь зөрчигдөхгүй байх явдлыг хангах болон хүний эрхийг хамгаалах механизмаар дамжуулан эерэг алхам хийх байдлыг ойлгоно. Ялангуяа аливаа этгээдийн зүгээс хүний эрхэд халдсан, үл ойшоосон, зөрчсөн тохиолдолд тухай бүр эрхийг сэргээх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нь хамгаалах арга хэмжээний салшгүй хэсэг юм.

ХАРИЛЦАН АШИГТАЙ БАЙХ ЗАРЧИМ PRINCIPLE OF MUTUAL BENEFIT

Олон улсын гэрээг байгуулахад тодорхой улс, бүс нутаг, эсвэл олон улсын давамгай байдалтайгаар бус, харин тухайн талууд харилцан санал солилцож

хэлэлцсэний үндсэн дээр шийдвэр гаргах, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, энхийг сахиулах арга хэмжээг зохион байгуулахад талуудын байр суурийг хүндэтгэх, санал тавьж байгаа болон саналыг хүлээн авсан талуудыг харилцан хүндэтгэх, тэгш байдлаар өөрийн ашиг сонирхлыг илэрхийлэх журмыг агуулсан ойлголт юм.

ХАРИУЦЛАГА RESPONSIBILITY

Хүний эрх, эрх чөлөө нь ямагт үүрэг хариуцлагатай холбоотой байдаг. Учир нь нэг хүний эрх нөгөө хүний эрхээр хязгаарлагддаг. Тиймээс хүний эрхийг тодорхой үүрэг, хариуцлагын хүрээнд авч үзэх шаардлагатай бөгөөд тухайн хязгаарыг давсан тохиолдолд бусдын эрх, эрх чөлөөг хөндөх, түүнд халдахад хүрч болно. Нөгөө талаас хүний эрхийг хангах, хамгаалах, баталгаажуулах талаар төр, засгийн газар олон улсын өмнө үүрэг хариуцлага хүлээдэг. Тиймээс хүний эрхтэй холбогдуулан хариуцлагын тухай асуудал хэд хэдэн түвшинд тавигддаг. Тухайлбал төрийн, хувь хүний, иргэний нийгмийн хүлээх хариуцлага гэх зэргээр ангилан үздэг. Эдгээр байгууллага, иргэд нь хүний эрхийг хүндэтгэх, сурталчлах, хөхиүлэн дэмжих, хамгаалах болон хүний эрхийн зөрчил, дутагдалтай тэмцэх болон эрхээ эдлэх нөхцөл бололцоогоор хангах үүрэг хариуцлага хүлээдэг байна. Хувь хүний хувьд хүн бүр бусдын эрхийг хүндэтгэх, хүний эрхийг сурталчлан таниулах, хүний эрхийг зөрчиж буй байгууллага, хүмүүстэй тэмцэх зэрэг үүрэг хүлээнэ. Төр, хувь хүнээс гадна хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн байгууллагууд, сангууд, боловсролын байгууллага зэрэг нийгмийн бусад бүх хэсгүүд хүний

эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үүрэг хүлээдэг.

ХОХИРОГЧ ХАМГААЛАЛ

VICTIM PROTECTION

Хохирогч гэдэгт гэмт хэрэг, эрх мэдлээ хортойгоор ашигласан болон хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн үйлдэл, эс үйлдлийн улмаас бие эрхтэн, оюун сэтгэхүйн хэвийн үйл ажиллагаа алдагдсан, сэтгэл санааны зовлон шаналалд автсан, эд материалын хохирол хүлээсэн, үндсэн эрх, эрх чөлөө нь ноцтой зөрчигдсөн хувь хүн болон бүлэг хүмүүсийг хэлнэ. Үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн хохирогч гэсэн ойлголтод хохирогчийн гэр бүл болон ойр дотны хүмүүс, хохирогчид туслах буюу гэмт үйлдэлд саад болох явцад хохирсон хүнийг хохирогчоор тооцож болно. Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах нь нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн дүүрэн тодорхойлох, дахин хүний эрхийн зөрчил, гэмтэл гарахаас урьдчилан сэргийлэх, гэмт этгээд ял шийтгэлгүй өнгөрөхгүй байх зэрэг давуу байдлыг олгохын зэрэгцээ хувь хүний нууц, халдашгүй байдлыг хамгаалахад чухал ач холбогдолтой.

ХӨНДЛӨНГӨӨС ОРОЛЦОХ

INTERFERENCE/INTERVENTION

Олон улсын баримт бичгүүдэд хөндлөнгөөс оролцох асуудлыг харилцан ялгаатай авч үздэг боловч монгол хэлнээ нэг үгээр илэрхийлдэг.

Хөндлөнгөөс оролцох (Interference):

Нэг улс нөгөө улсын дотоод хэрэгт ямар нэг хэлбэрээр оролцохыг ойлгодог. Хоёр дахь улсын дотоод хэрэгт тэр тусмаа түүний эрх мэдлийн хүрээнд байгаа

хэрэгт хөндлөнгөөс оролцохыг олон улсын эрх зүйд цээрлэдэг. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн 2.7-д хөндлөнгөөс үл оролцох зарчмыг тогтоосон. Энэ зарчмыг төрөөс хүний эрх зөрчих тохиолдолд хэрэглэдэггүй.

Хөндлөнгөөс оролцох (Intervention):

а/ Улс төр: Олон улсын буюу нэг улсын зүгээс нөгөө улсын эсрэг янз бүрийн хэлбэрээр албадлага хэрэглэхийг хэлнэ. Улс болон олон улсын байгууллага нь нэг улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох эрхгүй. Дээрх зарчим үндсэндээ хүний эрх зөрчих тохиолдолд үйлчлэхгүй.

б/ Төрийн бус байгууллага: Эдийн засаг, нийгмийн зөвлөл, эсвэл түүний туслах байгууллагын олон улсын нээлттэй хуралдаанд төрийн бус байгууллагаас бичгээр буюу амаар мэдэгдэл гаргахыг хэлнэ. Энэ нь төрийн бус байгууллагуудаас нотлох баримт гаргах болон үзэл бодлоо илэрхийлэн тухайн асуудлаар уг байгууллагын гаргах шийдвэрт нөлөөлөхийг хэлнэ.

ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ PROMOTION

Хувь хүнээс эхлэн нийгмийн тодорхой бүлэг, улсын хэмжээнд хүртэл хүний эрхийн талаар таниулан сурталчилах, хүний эрхийг хүлээн зөвшөөрүүлэх, үйл хэрэг болгох замаар хөгжүүлэх үйл ажиллагаа юм. Хүний эрхийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх, ухуулан сэнхрүүлэх, сайн дурын байдлаар олон улсын гэрээг хүндэтгэх, дагаж мөрдөх, үндэсний хууль тогтоомжийг олон улсын гэрээтэй нийцүүлэх, туслалцаа дэмжлэг авах, зөвлөгөө өгөхөд чиглэсэн үйл ажиллагаа мөн багтана.

ХҮНДЭТГЭХ

RESPECT

Хүний эрхийг хүндэтгэх гэдэг нь төр гэрээгээр баталгаажсан аливаа эрхэд харшлах аливаа үйлдэл гаргаж, аль эсвэл арга хэмжээ авч болохгүй. Өөрөөр хэлбэл, тухайн эрхийг эдлэхэд ямарваа нэгэн саад учруулахгүй, зөрчихгүй байхыг ойлгодог.

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ

HUMAN RIGHTS EDUCATION

Олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс хүний эрхийн боловсролын бүрдэл хэсгүүдийг зөвшөөрсөн олон улсын хүний эрхийн гэрээнд заасны дагуу хүний эрхийн боловсролыг дараах зорилтод чиглэсэн мэдлэг хуваалцах, ур чадвар олгох, хандлага төлөвшүүлэх замаар хүний эрхийн түгээмэл соёлыг бий болгоход чиглэсэн боловсрол, сургалт мэдээлэл гэж тодорхойлж болно. Үүнд:

- Хүний эрх, суурь эрх чөлөөг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх;
- Хүний хувийн онцлог шинж, хүний нэр төрийн буюу эрхэм зэргийн мэдрэмжийг бүрэн дүүрэн хөгжүүлэх;
- Бүх үндэстэн, уугуул хүмүүс болон арьсны, үндэсний, угсаатны, шашны, хэлний бүлгүүдийн дунд ойлголцол, хүлцэн тэвчихүй, жендэрийн тэгш байдал, нөхөрлөлийг хөхиүлэн дэмжих.

Хүний эрхийн боловсрол нь хувь хүнээс эхлэн нийгмийн бүхий л түвшинг багтаасан нийгмийг хувирган өөрчлөх үйл явц юм. Хүний эрхийн боловсролын зорилго нь эрх мэдэлжүүлэх билээ. Үр дүн нь нийгмийн өөрчлөлт болно. Хүний эрхийн боловсролоор хүний эрхийн зарчмууд, олон улсын гэрээг танин мэдэж, шүүмжлэлт байдлаар нийгмийг эргэн харах, эргэцүүлэх явдлыг хөхиүлэн дэмждэг.

ХҮНИЙ ЭРХИЙН ЗАРЧИМ

HUMAN RIGHTS PRINCIPLES

Хүний эрх нь хувь хүмүүс хоорондын, хувь хүн ба бүлэг, нийтлэгийн, иргэн ба төрийн хоорондын харилцаанд зарчим болон хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ юм. Иймд хүн эрх, эрх чөлөөгөө эдлэх, нөгөө талаас хүн бүрийн эрхийг хангах, хамгаалахын тулд хүний эрхийн зарчмуудыг томъёолж, мөрдлөг болгон дагаж ирсэн байна. Хүний эрхийн зарчмууд нь хүний эрхийн тухай олон улсын гэрээ, конвенц, үндэсний хууль тогтоомжид тусгалаа олсон бөгөөд эдгээр зарчмыг бодитой хэрэгжүүлэх нь хүний эрхийг хангах, хамгаалах гол үндэс болдог.

Хүний эрхийн зарчмуудыг түгээмэл байх хүний эрхэм зэргийг хүндэтгэх, салшгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх, хуваагдашгүй байх, харилцан хамааралтай байх, тэгш байх, хариуцлагатай байх гэж ангилж болох юм.

- Түгээмэл байх зарчим: Хүний эрх нь хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлс болохынхоо хувьд дэлхийн аль ч улс орон, бүс нутагт адилхан хүлээн зөвшөөрөгдсөн байна. Хүний эрхийн түгээмэл байх зарчим нь дэлхийн өнцөг булан бүрт байгаа улс орон, ард түмэн, иргэд нь хүний эрх, чөлөөний талаар нэгдмэл ойлголт, үзэл санаатай байх, олон улсын хүний эрхийн хэм хэмжээг нэг мөр ойлгох явдлыг хэлнэ.

- Хүний эрхэм зэргийг хүндэтгэх зарчим: Хүн бүр "хүн" болж төрснийхөө хувьд хамгийн эрхэм, үнэ цэнэтэй. Хүмүүс нас, хүйс, соёл, итгэл үнэмшил, арьс үндэс, бэлгийн чиг баримжаа, эсвэл нийгмийн анги давхраа зэргээс үл хамааран хүн болон мэндэлснийхээ хувьд өөрийн эрхэм зэрэгтэй байж, түүнийгээ бусдаар

хүндэтгүүлэх ёстой. Тиймээс ямар нэгэн ялгаа бүхий байдлаас үл хамааран хүн бүрт хүндэтгэлтэй хандах ёстой.

- Салшгүй байх зарчим: Хүний эрх нь аль нэгэн төр, засаг, албан тушаалтнаас олгож буй “хишиг” биш бөгөөд хүн бүрт төрж мэндлэхэд нь хамт заяадаг түүний төрөлх чанар юм. Тиймээс хүний эрх нь хүн бүрийн амьдралын салшгүй нэгэн хэсэг байна.

- Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим: Хүн бүрийн эрхэм зэргийг хүндэтгэн үзэж, ямар нэгэн байдлаар алагчлан үзэх, ялгаварлан гадуурхахгүй байх шаардлагыг энэхүү зарчим илэрхийлдэг. Тухайлбал, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, ахмад ба өсвөр үеийнхэн, эмзэг бүлгийн гишүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд бүгд хүн болохын хувьд адил эрх, үүрэгтэй бөгөөд тэдний нийгэмд гүйцэтгэх үүрэг, байр сууриас үл хамааран тэгш, ялгаварлан гадуурхахгүй харьцахад энэхүү зарчмын мөн чанар оршино.

- Хуваагдашгүй байх зарчим: Хүний бүхий л эрхүүд тухайлбал, иргэний, улс төрийн, нийгэм, эдийн засаг, соёлын болон хамтын эрхүүд нь нэгдмэл, хуваагдашгүй байдаг бөгөөд хүнээс хүчээр булаан авч, салгах боломжгүй байдаг. Тиймээс улс орны хөгжлийн байдал, улс төрийн үзэл суртал зэргээс хамааран тодорхой эрх, эрх чөлөөг хаан боогдуулах, иргэд эрхээ эдлэх нөхцөл бололцоог бүрдүүлэхгүй байх зэргээс сэргийлэх, хүн бүрт олон улсын хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн эрх, эрх чөлөөг бүрэн эдлүүлэхэд энэхүү зарчмын агуулга оршино.

- Харилцан хамааралтай байх зарчим: Хүний нэг эрх зөрчигдөхөд бусад эрх нь мөн зөрчилд орох, хэн нэгний эрх зөрчигдөх нь бусдын эрх зөрчигдөх эхлэл болох байдлаар харилцан хамааралтай байдаг. Тиймээс хүний эрхийн бүхий л асуудлыг өөр хооронд нь

харилцан хамаарал бүхий цогц байдлаар шийдвэрлэх, хэрэгжүүлэх нь энэхүү зарчмын гол үндэс юм.

- Тэгш байх зарчим: Хүний бүхий л эрх, эрх чөлөө нь хүний эрхэм зэргийг хүндэтгэн, түүний сайн сайхан байдлыг хангах, баталгаажуулахад чиглэдэг. Тиймээс хүний бүхий л эрх, эрх чөлөө адил тэгш хүчинтэй байх бөгөөд аль нэг эрх нь илүү чухал, давуутай мэтээр ойлгох, мөн аль нэгэн эрхийг шаардлагагүй, ач холбогдолгүй хэмээх ойлголт төрүүлэхээс болгоомжлоход энэхүү зарчим үйлчилдэг.

- Хариуцлагын зарчим: Төр үндэсний хууль тогтоомж, стандарт, хэм хэмжээг хүний эрхийн баримт бичгүүдэд нийцүүлэх, эрх эдлэгчдийг эрхээ шаардах, үүрэг хүлээгчдийг үүрэг хариуцлагаа биелүүлэх нөхцлийг бүрдүүлсэн тогтолцоо, механизмыг бий болгох үүрэгтэй. Хариуцлагын тогтолцооны сул талыг арилгах үр дүнтэй арга хэмжээ авах, засгийн газрын бүхий л түвшинд хүний эрхийн талаар хүлээсэн үүргээ биелүүлэх нь энэ зарчимд мөн хамаарна. Энэхүү зарчим нь чөлөөт, бие даасан хэвлэл мэдээллийн хэрэгсэл, гадуурхагдсан, эрх мэдэл багатай эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг төлөөлсөн хүний эрхийн хамгаалагчид байхыг шаарддаг. Идэвхтэй, эрхэд мэдрэмжтэй иргэний нийгэм нь төр хүний эрхийн чиглэлээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих, нийгмийн тулгамдаж буй асуудлыг илэрхийлэх, хүний эрхийн тогтолцооны төлөө нөлөөллийн үйл ажиллагааг явуулах үүргийг хүлээж байдаг.

ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

ENTRY INTO FORCE

Соёрхон батлагч талуудын хувьд гэрээ бүрэн хүчин төгөлдөр болж, үйлчилж эхлэх цаг хугацааны процессыг

хэлнэ. Гэрээний тусгай заалтад тодорхой тооны улс соёрхон баталсан баримт бичгээ хадгалуулахаар гардуулснаар гэрээ хүчин төгөлдөр болно гэж заасан байдаг.

ХЯЗГААРЛАЛТ LIMITATIONS

Хүний эрхийг хуулийн хүрээнд болон хууль бусаар хязгаарлах гэсэн хоёр ойлголт бий. Зайлшгүй нөхцөл байдал үүссэн, бусад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгын үүднээс гагцхүү хуулиар хүний эрхийг хязгаарлах нь ардчилсан нийгэмд төрөөс хүний эрхийг хамгаалах, хүний эрхийг хангах чухал зарчим болдог. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах хууль зүйн баталгаа нь хөндөгдсөн эрхийг сэргээх хууль зүйн боломжийг бүрдүүлэх, бусдын эрх, эрх чөлөөг зөрчих явдалтай тэмцэх, зөрчигчдөд хууль зүйн хариуцлага оногдуулах зэргээр илрэлээ олдог. Өөрөөр хэлбэл, хүний эрхийг хуульд заасан үндэслэл журмын дагуу хязгаарлах нь бусдын эрх, эрх чөлөөг хөндөгдөхөөс урьдчилан сэргийлэх зорилготой байдаг тул зарим тохиолдолд хүний эрхийн баталгаа болдог.

Тодруулбал, гоц халдварт өвчин дэгдлээ гэхэд тухайн орон нутагт байгаа хүмүүсийн дунд хөл хорио тогтоож, өөр зүг зорчихыг тодорхой хугацаанд хязгаарладаг. Энэ нь олон нийтийн дунд өвчин тарж, хүмүүсийн эрүүл мэнд доройтох, ноцтой байдалд орохоос урьдчилан сэргийлж байгаа арга хэмжээ юм.

Ардчилсан нийгэмд хүний эрхийн хязгаарлалтыг хоёр тохиолдолд хийдэг. Эхнийх нь бусдын эрх, эрх чөлөөг зөрчсөн этгээдийн тодорхой эрхийг хууль тогтоомжид заасан үндэслэлээр шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр хязгаарладаг бол, удаах нь үндэсний аюулгүй байдал, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах

зорилгоор онцгой нөхцөл байдал үүссэн үед зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэлээр хүний позитив эрхийг хязгаарладаг билээ.

Эдгээрээс хамгийн чухал нь хуулиар эрх олгосон тохиолдолд төрийн зүгээс иргэний үндсэн эрхийг хөндөж болно гэсэн ойлголт юм. Үндсэн хуулийн эрх зүйд жам ёсны аливаа эрхийг ямарч тохиолдолд хязгаарлахыг хориглодог.

Мөн хүний эрхийг хязгаарлах нь олон улсын стандартаар хүлээн зөвшөөрсөн байх ёстой. Тухайлбал, нийтийн аюулгүй байдлыг хамгаалахад шаардлагатай онцгой нөхцөл байдал үүссэн, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах гэх мэт. Гэхдээ хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах арга хэмжээ нь зохистой түвшинд буюу хэтрэхгүй байх зарчимд нийцэх учиртай. Онц байдал тогтоосон үед хүний эрх зөрчигдөх магадлал өндөр байдаг тул төрөөс онц байдал тогтоосон үед тухайн нөхцөл байдалд тохируулан хязгаарлалтыг зохистой хэмжээнд, түр зуурын хугацаанд хийх нь чухал байдаг.

ШАЛГАЛТ

INQUIRY

Хүний эрхийн шалгалт нь тухайн улс дахь тодорхой нэг асуудлыг сайтар танин мэдэх, түүний талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй болох үйл явц бөгөөд нийгмийн бүхий л салбар, хүрээг хамрах боломжтой.

ШУДАРГА ЁС

JUSTICE

Шударга ёс бол хувь хүнд хамаарахаас илүүтэй нийгмийн тогтолцоо хэр шударга байх ёстой вэ гэдэг тухай ойлголт юм. Нийгмийн тогтолцоо шударга

байна гэдэг нь уг нийгмийн тогтолцоо гишүүдийнхээ үйлдлүүдийг бүгдэд таарахуйцаар зохицуулахыг, өөрөөр хэлбэл бүх хүн тэр нийгэмд аз жаргалтай байхыг хэлнэ. Шударга ёсны төлөө тэмүүлэл нь аз жаргалын төлөөх хүмүүсийн хүсэл эрмэлзэл юм гэж ч үздэг. Гүн ухаантан Платон шударга ёсыг аз жаргалтай адилтган зөвхөн шударга хүн л аз жаргалтай, шударга бус хүн аз жаргалгүй гэж үзэж байв. Гэвч аз жаргал гэдгийг хувь хүний аз жаргал гэсэн явцуу хүрээнд ойлговол “шударга ёс” буюу бүх хүний сайн сайхныг хангасан тогтолцоо оршин байх аргагүй болно. Ийм тохиолдолд нэг хүний аз жаргал заримдаа нөгөө хүнийхийг шууд хаах явдал зайлшгүй үүснэ. Үүнээс үүдэн туйлын шударга ёс, харьцангуй шударга ёс гэх ойлголт бий болох бөгөөд өнөө үед харьцангуй шударга ёсоор сэтгэл ханах ёстой гэж үздэг.

Эрх зүй онолоор шударга ёсыг ардчилсан Үндсэн хуульд суурилсан эрх зүйн тогтолцоо гэж үздэг. Ардчилсан Үндсэн хуульд суурилсан эрх зүйн тогтолцоо бол ардчилал, эрх зүйт ёсыг баталгаажуулж, үндсэн эрхийг хамгаалсан хамгийн дээд хүчин чадалтай Үндсэн хуулиас авахуулаад түүнд нийцүүлэн гаргасан бүхий л хууль тогтоомжийг багтаасан өргөн хүрээтэй ойлголт юм. Төрийн үйл ажиллагаа шударга ёсны зарчмын дагуу явагдана гэдэг нь хууль тогтоох байгууллага Үндсэн хуульд, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага Үндсэн хуулийн дагуу батлагдсан хууль тогтоомжид, шүүх эрх мэдлийн байгууллага эрх зүйд захирагдахыг хэлнэ.

ЭМНЭЛГИЙН БУЮУ ШИНЖЛЭХ УХААНЫ ТУРШИЛТ

MEDICAL OR SCIENTIFIC EXPERIMENTATION

Хүний бие махбодод халдаж болохгүй гэсэн үзэл

баримтлал нь бие махбодын бүрэн бүтэн байдал гэсэн ойлголттой салшгүй холбоотой. Хувь хүн бүр бие даасан бодьгалынхаа хувьд бие даан, өөрийгөө залж чиглүүлэх боломжтой тул ямар нэгэн этгээдийн зүгээс амьд явах, албадан хөдөлмөрлүүлэх, аюулгүй байдалд халдах, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандаж болохгүйг онцолж, олон улсын гэрээгээр баталгаажуулсан. Үүний дунд тухайн этгээдийн зөвшөөрөлгүйгээр түүний бие махбодийг туршилт, шинжилгээ, судалгааны зүйл болгох нь хүний нэр төр, эрхэм зэрэгт халдсан үйлдэл болох тул хориглодог. Ялангуяа хоригдол, өвчтөн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, цөөнх зэрэг тодорхой бүлэг этгээдийг эмнэл зүйн, цэргийн, зэвсгийн зэрэг шинжлэх ухааны туршилтад оруулж байсан хүн төрөлхтний гашуун түүхийг дахин давтахгүйн тулд уг ойлголтыг цохон тэмдэглэдэг.

ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ

REMEDY

Эх газрын буюу Ром – Германы эрх зүйн тогтолцоотой улсуудын хувьд эрхийг баталгаажуулж, ял шийтгэл оноох байдлаар шүүхээс хариуцлага тооцох шийдвэр гаргах үйл явцыг хэлнэ. Далайн буюу Англи – Америкийн эрх зүйн тогтолцоотой улсын хувьд учруулсан хохирлоос хамааран харилцан адилгүй арга хэмжээ авах боловч эрх зүйн номлолын хувьд “эрх бүрт эрх зүйн хамгаалалт байна, эрх зүйн хамгаалалтгүй тохиолдолд эрх байна гэх боломжгүй” гэж үздэг. Үүний зэрэгцээ хүний эрхийн зөрчлийн улмаас учирсан бодитой хор уршиг, хохирол гэмтэлд зориулсан нөхөн төлбөр буюу эрх сэргээх арга хэмжээ гэж тодорхойлох нь бий.

ЭРХ ХЭМЖЭЭНИЙ ДАГУУ ОЛОН УЛСЫН АРГА ХЭМЖЭЭ

ADVISABILITY OF INTERNATIONAL MEASURES

Хүний эрхийн хэрэгжилтэд эерэгээр нөлөөлөх боломжтой, цаашид тухайн улсын нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг ойлгох ба үндэсний асуудалд шууд оролцохоос илүүтэйгээр олон улсын гэрээний дагуу хүлээн зөвшөөрсөн бүрэн эрх эсвэл үүргийг гүйцэтгэх замаар тодорхой ахиц дэвшил бүхий үйл ажиллагаа явуулахыг хэлнэ. Ямар нэгэн салбарын асуудлыг тухайн улсын зүгээс онцлон илтгэсэн үед түүнд дэмжлэг, туслалцаа үзүүлэх буюу чадавх бэхжүүлэх зэргээр нөлөөлж болно. Засгийн газар хоорондын, олон улсын хөгжлийн, тусгай төрлийн төрийн болон төрийн бус олон улсын байгууллагуудын зүгээс зохион байгуулсан хүмүүнлэгийн болон хүний эрхийн үйл ажиллагаанаас гадна эдийн засаг, энхийг сахиулах арга хэмжээ хамардаг.

ЭРХИЙГ САХИУЛАХ

OBSERVANCE OF THE RIGHTS

Олон улсын гэрээний дагуу үүрэг хүлээсэн оролцогч улс нь өөрийн нутаг дэвсгэр дээрх иргэд, гадаадын иргэд, харьяалалгүй хүнийг үл хамааран эрхийг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Зарим тохиолдолд сонгох, сонгогдох, төрийн алба хаших, өмчлөх зэрэг улс төр, нийгэм, эдийн засгийн эрхүүдийг гагцхүү өөрийн иргэддээ эдлүүлэх нь бий. Харин эдгээр эрхийг эдлүүлэх ажиллагаа нь хууль ёсны дагуу, шударга, ялгаварлан гадуурхахгүй, тэгш байдлыг хангаж байгаа эсэхэд шүүх, засгийн газрын болон иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс хяналт тавьж ажилладаг. Тухайн

эрхийг баталгаажуулсан олон улсын гэрээг хэрхэн хэрэгжүүлсэн талаар үндэсний илтгэл илгээх, тусгай илтгэгч урих, хувь хүний гомдлыг хянан шийдвэрлэхийн зэрэгцээ олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлсэн, ямар санал санаачлага гаргасан бэ гэдгээр тухайн улсын төрийн байгууллагуудын үйл ажиллагааг тодорхойлж, ахиц дэвшил, ололт амжилт, алдаа дутагдалд тулгуурлан хүний эрхийг хэрэгжүүлдэг онцлогтой.

ЭРХИЙГ ХАНГАХ

FULFIL

Хүний эрхийг хангах гэдэг нь төр зөвхөн хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлээд зогсохгүй, үүнээс илүүтэйгээр үр дүнтэй, эерэг алхам хийх үүрэгтэй. Тухайлбал, олон нийтийн боловсрол болон мэдээллийн аянаар дамжуулан хүний эрхийг хөхиүлэн дэмжих хууль тогтоомжийг батлаад зогсохгүй, хүний эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн баталгааг бий болгох эерэг алхамуудыг дэвшилтэт байдлаар авах ёстой.

ЭРХИЙГ ХАНГАХ БАТАЛГАА

GUARANTEES ON FULFILLMENT OF THE RIGHTS

Хүний эрхийн өмнө үүрэг хариуцлага хүлээх зарчмын дагуу төр нь иргэнийхээ эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалах үүргийг хүлээдэг. Энэ нь Монгол Улс Үндсэн хуулиараа хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, түүнийг хэрэгжүүлэх эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг төрд даалгасан байдгаар илэрнэ.

1992 оны Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн хоёрдугаар бүлэгт 80 орчим эрх, эрх чөлөөг тусгайлан нэрлэж, баталгаажуулсан байх бөгөөд Үндсэн хуулийн оршил хэсгээс бусад бүлгүүдэд хүний эрхтэй

холбогдолтой олон заалт, зарчмуудыг тусгасан байдаг. Хүний эрхийн олон улсын суурь баримт бичиг болох Хүний эрхийн Биллд тусгагдсан, үндсэн эрхүүдийг манай улсын Үндсэн хуульд бүрэн хэмжээгээр тусгаж чадсан гэж судлаачид үздэг байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн заасан байдаг нь манай улсын хувьд хүний эрхийг хангах хамгийн гол баталгааг тодорхойлж буй хэрэг юм. Энэхүү зорилтыг биелүүлэхийн тулд 2003 онд Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах баталгаа, механизмыг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг тууштай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх, төрөөс хүний эрхийг хангах зохион байгуулалт, эрх зүйн баталгааг өргөтгөн, зохистой механизмыг бүрдүүлэх зэрэг нь энэхүү үндэсний хөтөлбөрийн гол зорилтууд юм.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

DISCRIMINATION

“Ялгаварлан гадуурхалт гэдэгт хүний арьс, өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, гарал үүсэл, хөрөнгө чинээ, төрсөн газар, нийгмийн байдал, бусад байдалд нь үндэслэн ямарваа нэгэн зайлуулах, гадуурхах, хориглох эсвэл дорд болон илүүд үзэх зэрэг үйлдлүүдийг ойлгох бөгөөд эдгээр нь хүн бүрт адил тэгш оноогдсон хүний эрх, эрх чөлөөг үгүйсгэх буюу устгах зорилго агуулсан байна”

- ХҮНИЙ ЭРХИЙН ТОВЧ ТАЙЛБАР -

гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн хороо тодорхойлсон байна. Ялгаварлан гадуурхалт нь эрх тэгш байдлыг үгүйсгэж, хүний эрх зөрчигдөхөд хүргэдэг.

- VII - ХАВСРАЛТ

Энэхүү хэсэгт тус номын өмнөх хэсгийн нэр томъёонуудтай шууд холбоотой хүний эрхийн талаарх баримт бичиг, үндсэн хуулийн шинжтэй хэм хэмжээ, судлаачийн бүтээлээс түүвэрлэн орууллаа.

Хүний эрхийн түгээмэл баримт бичгийн жагсаалт

1. Магна Карта (Magna Carta, 1215 он); Эх сурвалж: http://www.archives.gov/exhibits/featured_documents/magna_carta/translation.html

2. Эрхийн билл буюу жагсаалт (Bill of Rights (Англи), 1689 он); Эх сурвалж: <http://www.fordham.edu/halsall/mod/1689billofrights.asp>

3. Эрхийн билл буюу жагсаалт (Bill of Rights (АНУ)); Эх сурвалж: http://www.archives.gov/exhibits/charters/bill_of_rights_transcript.html

4. Хүний болон иргэний эрхийн тунхаглал, 1789 оны 8 сарын 26-ны өдөр (Declaration of the Rights of Man and of the Citizen); Эх сурвалж: http://www.constitution.org/fr/fr_drm.htm

5. Францын Дөрөвдүгээр Бүгд Найрамдах Улсын Үндсэн хуулийн оршил (Preamble to the Constitution of the French Fourth Republic); Эх сурвалж: <http://www.assemblee-nationale.fr/english/8ab.asp>

6. ХБНГУ-ын Гол хууль (Basic Law for the Federal Republic of Germany, 1949 он); Эх сурвалж: http://en.wikisource.org/wiki/Basic_Law_for_the_Federal_Republic_of_Germany

7. Канад Улсын Эрх, эрх чөлөөний харти (Canadian Charter of Rights and Freedoms, 1982 он); Эх сурвалж: http://laws-lois.justice.gc.ca/eng/Const/Const_index.html

8. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948 он (Эх сурвалж: <http://mn-nhrc.org/31>)

9. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1966 он (Эх сурвалж: <http://mn-nhrc.org/31>)

10. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол, 1966 он(Эх сурвалж: <http://mn-nhrc.org/31>)
11. Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, 1966 он(Эх сурвалж: <http://mn-nhrc.org/31>)
12. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, 1966 он(Эх сурвалж: <http://mn-nhrc.org/31>)
13. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол, 1966 он(Эх сурвалж: <http://mn-nhrc.org/31>)
14. Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1989 он(Эх сурвалж: <http://mn-nhrc.org/31>)
15. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 43 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулах нэмэлт өөрчлөлт, 1995 он(Эх сурвалж: <http://mn-nhrc.org/31>)
16. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчилахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол, 2000 он(Эх сурвалж: <http://mn-nhrc.org/31>)
17. Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол, 2000 он(Эх сурвалж: <http://mn-nhrc.org/31>)
18. Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, 1979 он(Эх сурвалж: <http://mn-nhrc.org/31>)
19. Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн нэмэлт протокол, 1999 он(Эх сурвалж: <http://mn-nhrc.org/31>)
20. Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт оруулсан нэмэлт өөрчлөлт, 1995 он(Эх сурвалж: <http://mn-nhrc.org/31>)
21. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц, 1984 он

22. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протокол, 2002 он(Эх сурвалж: <http://mn-nhrc.org/31>)
23. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, 2006 он(Эх сурвалж: <http://mn-nhrc.org/31>)
24. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протокол, 2006 он(Эх сурвалж: <http://mn-nhrc.org/31>)
25. Цагаач ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн бүх гишүүдийг хамгаалах тухай конвенц, 1990 он; Эх сурвалж:<http://www2.ohchr.org/english/law/cmw.htm>
26. Хүчээр сураггүй алга болохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенц, 2006 он; Эх сурвалж:<http://www2.ohchr.org/english/law/disappearance-convention.htm>
27. Европын Хүний эрхийн тухай конвенц (European Convention on Human Rights, 1950 он); Эх сурвалж:<http://www.echr.coe.int/ECHR/EN/Header/Basic+Texts/The+Convention+and+additional+protocols/The+European+Convention+on+Human+Rights/>
28. Европын Нийгмийн харти (European Social Charter, 1965 он); Эх сурвалж:<http://www.coe.int/T/DGHL/Monitoring/SocialCharter/>
29. Унгар Улсын Үндсэн хууль (Hungarian Constitution, 1949 он); Эх сурвалж:<http://www.wipo.int/wipolex/en/details.jsp?id=7315>
30. Үндсэн эрх, эрх чөлөөний харти (Чехословак Улс) (Charter of Fundamental Rights and Freedoms (Czechoslovakia), 1991 он); Эх сурвалж:http://www.concourt.cz/view/czech_charter
31. Израиль Улсын Гол хуулиуд (Israeli Basic Laws); Эх сурвалж:http://www.knesset.gov.il/description/eng/eng_mimshal_yesod1.htm
32. Өмнөд Африк Улсын Эрхийн билл буюу жагсаалт (South African Bill of Rights, 1996 он); Эх сурвалж:www.hsr-press.ac.za/downloadpdf.php?pdffile=files/PDF/2200/c

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ БОЛ ЭДИЙН ЗАСГИЙН АМЖИЛТ, НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН БАТАЛГАА МӨН

Эдийн засгийн ёс зүй

Эдийн засгийн ёс зүй нь ихэвчлэн олон улсын чанартай бөгөөд өрсөлдөөнд суурилсан орчин үеийн зах зээлийн эдийн засгийн нөхцөлд ёс суртахууны хэм хэмжээ ба үлгэр дууриаллыг хэрхэн хэрэгжүүлэх тухай асуудлыг судална. Чингэхэд эдийн засгийн ёс зүйд эн тэргүүнд тавигддаг байгаль орчны бохирдол, авилга хээл хахууль, ажилгүйдэл эсвэл ядуурал гэх мэт асуудлыг “эдийн засгийн салбар”-аас халилгүйгээр шийдвэрлэх боломжгүй болох нь харагдаж байна. Иймд шинэ үзэл санаанууд нь эдийн засгийн ёс зүйг эдийн засгийн ёс суртахууны онол хэмээн үзэж, эдийн засгийн аргачлалын талаарх ойлголтыг нийгмийн харилцан шүтэлцээ ба институтцэд ерөнхий дүн шинжилгээ (Rational Choice) хийхэд ашиглаж болно гэж үзэн энэхүү ухагдахууныг тэлэн өргөжүүлж байна.

Хувь хүн буюу аж ахуйн нэгжүүдийн ёс суртахууны үүднээс гаргасан хүчин чармайлт нь өрсөлдөөний нөхцөлд тэднийг ноцтой хохиролд хүргэх, тэр атугай зах зээлээс шахагдан гарах хүртэл эрсдэлд оруулах бөгөөд улмаар илүү зардлыг нөхөж чадахуйц ашиг

орлого үгүйлэгдэх тохиолдолд нэлээд хэмжээний ашгийн алдагдалд хүргэж болзошгүй явдал нь эдийн засгийн ёс зүйн үндсэн асуудал болдог. Тийм учраас ёс суртахуун ба хувийн ашиг сонирхол нь өрсөлдөөний нөхцөлд хоорондоо байнга дуалист зөрчилдөөнд оршин буй мэт харагддаг.

Асуудлыг ингэж ойлгох нь хувийн эрх ашигт суурилсан аливаа үйлдлийн ёс суртахууны үндсийг нэхэн шаардахад хүргэж байна. Эл үндэслэлийг эш болгосон энэ загварын хүрээнд оношлогоо ба эмчилгээг гагцхүү эдийн засгийн оролцогсод өөрсдөө “хүссэн” тохиолдолд хийх боломжтой. Уг сөрөг үзэгдлийн шалтгаан нь үнэт зүйлс үнэгүйтэх, хувиа хичээх, ашиг хонжооны хойноос улайран хөөцөлдөх явдал бөгөөд энэ асуудлыг шийдэхийн тулд ухамсарт мөн үзэл бодолд өөрчлөлт оруулахыг зөвлөмж болгодог байна. Асуудлын гол нь хүмүүсийн эрхэмлэн дээдэлдэг зүйлст орших бөгөөд энэ эрхэмлэн дээдэлдэг зүйлсийг засаж залруулах шаардлагатай ч байж магадгүй юм.

Үүний нэг альтернатив боломж нь оролцогсдын “хүсэл”-ийг биш харин “чадвар”-ыг дэмжих явдал юм. Ийм тохиолдолд анхаарлын төвд оролцогчдын давуу тал бус, харин тэдгээрийн үйл ажиллагааг хязгаарлах, тодруулбал, өрсөлдөөний ашиг сонирхлыг хязгаарлах явдал байх болно. Тухайн хүн ёс суртахуунтай байхыг хичээвч үүнд өрсөлдөөний ашиг сонирхол саад тотгор болж байдаг.

Асуудлыг ийм альтернатив байдлаар авч үзэх нь эртний уламжлалтай юм. Энэ нь эдийн засгийн онолыг шинжлэх ухааны нэгэн төрөл гэдгийг анх удаа гаргаж

тавьсан ёс суртахууны гүн ухаантан Адам Смит-ээс үүдэлтэй юм. Үүний гол санаа нь өрсөлдөөний үүднээс үйлдлийн сэдэлтийг үйлдлийн үр дүнгээс ялгаж салгах явдал байв. Түүний бичсэн зүйлээс иш татвал: “Бидний хоолтой байх нь мал нядлагч, шар айраг үйлдвэрлэгч буюу талх нарийн боов баригчийн сайн санаанаас биш харин тэдний хувийн ашиг сонирхлоос хамаарна” гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, олон нийтийн сайн сайхан амьдрал хувь хүний сайн санаанаас үл хамаарна.

Энэ үүднээс авч үзвэл, энэ нь үйлдлийн сэдэлт болон оролцогсдын хувийн ашиг сонирхлын төвшингөөс бус, харин энэхүү хувийн ашиг сонирхлыг нийгэмд тустайгаар хэрхэн чиглүүлэх вэ, нийгмийн хэрэгцээнд хэрхэн нийцүүлэх вэ гэдгээс илүү хамаарах юм.

Дэг журмын хүрээнд хэрэв үйлдлийн дэг журам болон үйллийн хоорондын ялгааг авч үзэх үед, эсхүл спортын хэллэгээр, тоглолтын дүрэм болон тоглолтын үйлдэл хоорондын ялгааг авч үзэх үед асуудал ойлгомжтой байх болно. Хэрэв эдийн засгийн оролцогсод өрсөлдөөнт тоглолтын үйлдлээ ашиг хонжоо олоход чиглүүлвэл тэдгээрийн хувийн ашиг сонирхол гуравдагч этгээдэд хохиролтой эсхүл ашигтай байх эсэх нь тоглоомын дүрмээс шалтгаална. Тийм учраас эдийн засгийн ёс зүйн үндсэн тезис нь дараахь байдлаар тодорхойлогдоно. Үүнд, орчин үеийн өрсөлдөөний нөхцөлд институтчилсэн ерөнхий дэг журам нь ёс суртахууны системчилсэн талбар болж эн тэргүүнд тавигдана.

Бүх өрсөлдөгчид адил тэгшээр биелүүлэх журмыг хатуу

тогтоох гол үндэслэл бол ёс суртахуунтайгаар ажиллах нь ядаж өрсөлдөөнд нөлөөлөхгүй байх, өөрөөр хэлбэл, өрсөлдөөнд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхад оршино. Зөвхөн ийм замаар тухайн нэг этгээдийн ёс суртахуунтай зан үйлийг өрсөлдөгчид нь сөргөөр ашиглах явдлаас хамгаалж чадна. Өрсөлдөөний давуу талыг оролцогч бүр бүхий л тохиолдолд ашиглах боломжийг олгож буй дүрэм журам буюу институтэд, тухайлбал, өмчлөх эрх, гэрээ байгуулах эрх чөлөөний баталгаа, гэрээний хэрэгжилтийг сайжруулах институтууд, шударга бус өрсөлдөөнөөс хамгаалах хууль, хариуцлагын тухай хууль зэрэг хамаарна. Ёс суртахуунд үл нийцэх нөхцөл байдлыг оролцогсдын ёс суртахууны доголдолтой бус, харин дэг журмын алдаа дутагдалтай холбож үздэг учир энэхүү дэг журам ба түүний нөлөөллийг шинэчлэхэд чиглэсэн өөрчлөлтүүд нь хийгдэж эхлэх ёстой. Энэ утгаараа эдийн засгийн ёс зүйг дэг журмын ёс зүй буюу сонирхлыг өдөөх ёс зүй гэж тодорхойлж болох юм.

Эдийн засгийн ёс зүйн ийм үзэл баримтлалын үндсэн дээр функцийн ялгааны үр дүнд хувьслын (эволюцийн) замаар нийгмийн дэд бүтцүүдэд бий болсон өөрчлөлтүүдийг харгалзан үзэх боломжтой юм. Хуучин “гэр бүлийн аж ахуй” нь орчин үеийн “улс ардын аж ахуй” болтлоо хөгжиж, улмаар эдүгээ “дэлхийн аж ахуй” болоод байна. Энэ нь хөдөлмөрийн гүн гүнзгий хуваарь, үл мэдэгдэм солилцох үйл явц, олон оролцогсдын оролцоотой явагдах үйлдвэрлэлийн урт шат дамжлага, өсөн нэмэгдэж буй бие даасан байдал, нарийн зохион байгуулалттай иж бүрэн бүтцээр тодорхойлогдоно. Орчин үеийн эдийн засгийн үр дүн нь ганц нэг этгээд, ганц нэг компани, ганц нэг

төрөөс хамаарахгүй бөгөөд иймд үүний төлөө үүрэх хариуцлагыг ганц нэг этгээд хүлээх ёсгүй.

Тийм учраас аливаа үйлдэл нийгэмд ашиг тустай эсэх талаас нь хяналт тавих нь орчин үеийн эдийн засаг ба нийгмийн гол асуудал болоод байна. Цомхон жижиг групп дотор албан бус хяналтыг ёс зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор өдөр тутмын харилцаанд магтан урамшуулах, зэмлэн буруушаах аргыг хэрэглэх замаар гүйцэтгэх үнэхээр боломжтой билээ. Өнөөгийн дэлхийн нийгэмлэгт оршин тогтнож буй нүсэр том бүлгүүдийн дотор хувь хүний зүгээс зан үйлийн хувьд гүйцэтгэх үүрэг ролийг хянах бараг боломжгүй буюу үүний тулд их хэмжээний зардал гаргах шаардлагатай болно. Тийм учраас зайлшгүй хяналтыг хэрэгжүүлэх тогтолцоонд шилжих шаардлагатай юм. Орчин үеийн нийгэмд хяналтыг өөрөө өөртөө тавих байдлаар зарчмын хувьд хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд энэ нь институцилсэн хүсэл сонирхлын дагуу нийгэмд тустай байх хувийн ашиг сонирхолд суурилсан байна. Ийнхүү нийгмийн ашиг тусын тулд тавих хяналтыг өөрчлөхөд хувь хүний бие даасан болон чөлөөт байдал мөн түүнчлэн нийгмийн бүтээмж, соёл иргэншлийн хувьд ихээхэн нөөц боломж агуулагдаж байдаг.

Эдгээр үзэл бодолд үндэслэн авч үзэхэд, альтернатив дэг журмын дүрэм журам нь өрсөлдөөний нөхцөлд ёс суртахууны хэм хэмжээ, үлгэр дууриаллыг хэрэгжүүлэхэд тохирон нийцэж байгаа эсэхийг шалган турших ерөнхий шаардлага эдийн засгийн ёс зүйн өмнө тавигддаг байна. Үүнтэй уялдан хувийн ба хамтын шинж чанартай сайн дурын уялдаа холбоо нь ихээхэн сонирхол татдаг. Учир нь тэдгээр нь үр

бүтээлтэй хамтын ажиллагаанд шаардагдах зан үйлийн харилцан холбоонд итгэх итгэл найдварыг бий болгодогт оршино.

Нэгэнт тогтоосон журмыг бусад хүмүүс миний нэгэн адил сахин мөрдөнө гэдэгт хувь хүн итгэлтэй байх нөхцөлд л ийм дэг журам үйлчилж чадна. Гэвч энэ нь зөвхөн дараах нөхцөлд биелэх бөгөөд хэрэв хүн бүр дүрэм журмыг сахих нь тэд үүнийг зөрчиж байхаас илүүтэйгээр хувь хүний ашиг сонирхолд нийцэж, улмаар дүрэм журмыг хэрэгжүүлэх явдлыг бүгдээрээ дэмжин зөвшөөрөх тохиолдолд биелэж чадах болно. Тодруулбал, дүрэм журам нь хэрэгжих чадамжийг өөртөө агуулж байх эсхүл түүнийг ийм чадамжтай болгох ёстой юм.

Орчин үед нэн ялангуяа, хил хязгаар дамнасан асуудлууд улам бүр олон талтай болж байгаа тул дүрэм журам тогтоох үйл явцыг зөвхөн үндэсний улсад даатган орхих боломжгүй болж байна. Төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор бүрэлдэх боломжтой болж буй улс төрийн бүтцүүд дөнгөж бий болох үе шатандаа байна. Тэгсэн хэдий боловч аж ахуйн нэгжүүд нь иргэний байгууллагуудын нэгэн адил “нийгмийн гишүүн” (corporate citizens) болохын хувьд тухайн институцийн ерөнхий орон зайг бий болгоход чиглэсэн дүрэм журмыг тогтооход тэдний хүлээх үүрэг хариуцлага үндэсний улсын төвшинд ч мөн олон улсын төвшинд ч өсөн нэмэгдэж байна. Тийм учраас эдийн засгийн ёс зүйн талаарх альтернатив санал, төслүүдийг харьцуулан үзэхдээ тэд оролцогсдын дунд яриа хэлэлцээ хийх, харилцан суралцах процесс (үйл явцад)-ийг бүтээлчээр удирдан чиглүүлэхэд

- ХҮНИЙ ЭРХИЙН ТОВЧ ТАЙЛБАР -

ямар хувь нэмэр оруулж чадах вэ гэдгээр нь хэмжин дүгнэх шаардлага гарч ирж байна. Эцсийн эцэст ямар тоглоомын дүрмийг баримтлах вэ гэдэг асуудлыг бид дэлхийн түвшинд хамтран шийдэх ёстой юм.

Инго Фийс

Ingo Pies - Prof. Dr, Chair of Economic Ethics, University of Halle-Wittenberg, academic director of the Wittenberg Centre for Global Ethics; areas of research: economic ethics, institutional economics and economic order policy.

Александра фон Винниг

Alexandra von Winnig - business graduate, associate lecturer at the Wittenberg Centre for Social Ethics.